

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ
СУРГУУЛИЙН
ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР АНАГААХ УХААНЫ
СУРГУУЛЬ



СОРИЛЫН ЭМХЭТГЭЛ

Эх барихуй дэд бакалаврын төгсөх дамжааны оюутнуудад
зориулав.

ГОВЬ-АЛТАЙ АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

1942

АЛТАЙ ХОТ
2024 ОН

СОРИЛ БОЛОВСРУУЛСАН:

1. Г. Ганболор (Сэтгэл судлал, Харилцааны ур чадварын багш)
2. О. Батжаргал (Монголын түүхийн багш)
3. Ш. Батзүсэм (Эдийн засгийн онолын багш)
4. Б. Батпүрэв (Мэдээллийн технологийн багш)
5. О. Мөнхжаргал (Англи хэлний багш)
6. Ц. Ариунзаяа (Биологийн багш)
7. Д. Оюунцэцэг (Анатомийн багш)
8. Л. Нямаа (Биохимийн багш)
9. Ж. Сарантуяа (Химийн багш)
10. Х. Зандармаа (Физиологийн багш)
11. Д. Гүндэгмаа (Нүд судлалын багш)
12. Т.Төрболд (Яаралтай тусламж, дархлаа судлалын багш)
13. Э. Ариунзул (Эмгэг судлалын багш)
14. Б. Ундармаа (Гистологийн багш)
15. Ж. Одонтуяа (Микробиологийн багш)
16. Ч.Мандалсайхан Н.Түмэндэмбэрэл Ж.Түмэнжаргал (Сувилахуйн багш)
17. М. Сүнжидмаа (Нийгмийн эрүүл мэнд судлалын багш)
18. Г. Сарангэрэл (Халдвартын багш)
19. Т. Цэрмаа (Дотрын багш)
20. Л. Отгонтөгс (Хүүхдийн өвчин судлалын багш)
21. Н. Цэрэнлхам (Мэдрэлийн багш)
22. Б. Батнасан (Эх барих, эмэгтэйчүүд судлалын багш)
23. Б. Энх- Амгалан (Чих, хамар, хоолойн өвчин судлалын багш)

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

1. Д. Гүндэгмаа (АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургуулийн захирал, Боловсрол судлалын доктор, дэд профессор)
2. Б. Ундармаа (Эмзүй, Био-Анагаахын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр)
3. Г. Сарангэрэл (Эмнэлзүйн тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны магистр)
4. А. Баянжаргал (Сургалтын албаны арга зүйч, Анагаах ухааны магистрант)

ЭХ БЭЛТГЭСЭН:

1. Б. Ундармаа (Эмзүй, Био-Анагаахын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр)
2. Б. Батнасан (Эмнэлзүйн тэнхимийн багш, Анагаах ухааны магистр)
3. А. Баянжаргал (Сургалтын албаны арга зүйч, Анагаах ухааны магистрант)

ГАРЧИГ

№	Сорилын чиглэл	Сорилын тоо	Хуудасны дугаар
1.	Монголын түүх, соёл, ёс заншил	30	1
2.	Соёл судлал	30	5
3.	Харилцааны ур чадвар	30	10
4.	Эдийн засгийн онол	30	14
5.	Мэдээллийн технологи	30	18
6.	Англи хэл	30	23
7.	Анагаахын физик	30	24
8.	Анагаахын хими	30	29
9.	Биохими	50	32
10.	Биологи	100	39
11.	Анатоми	100	52
12.	Физиологи	100	66
13.	Эм судлал	100	78
14.	Бичил амь судлал	30	91
15.	Нийгмийн эрүүл мэндийн үндэс	100	94
16.	Эмгэг судлал	100	108
17.	Сувилахуй	100	120
18.	Нярай судлал	30	133
19.	Хүүхэд судлал	100	137
20.	Дотрын өвчин судлал	100	150
21.	Халдварт өвчин	100	163
22.	Нүд судлал	100	184
23.	Чих хамар хоолой судлал	30	197
24.	Мэдрэл, сэтгэцийн өвчин	50	213
25.	Яаралтай тусламж	100	219
26.	Эх барих, эмэгтэйчүүд судлал	400	231
27.	Ашигласан номын жагсаалт		263
	НИЙТ	2030	

СОРИЛД ХАРИУЛАХ ЗААВАР.

1. **А хэлбэрийн** / хамгийн зөв ганц хариултыг сонгох сорил/ Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, Е гэсэн үсгэн дугаартай байна. Эндээс хамгийн зөв нэг хариуг сонгоно.
2. **К хэлбэрийн** / комплекс сорил/ Энэ хэлбэрийн сорилын хариулт нь 1-5 тоогоор дугаарлагдсан байна.
1, 2, 3-р хариултууд зөв бол А
1,2,3,4-р хариултууд зөв бол В
2 ба 4-р хариултууд зөв бол С
Зөвхөн 4-р хариулт зөв бол D
Бүх хариулт зөв бол Е
3. **Е хэлбэрийн.** Шалтгаан хамаарлын сорилыг дараах кодоор хариулна.

I баталгаа	II баталгаа	Холбоо хамаарал	Хариулт
Зөв	Зөв	Зөв	А
Зөв	Зөв	Буруу	В
Зөв	Буруу	Буруу	С
Буруу	Зөв	Буруу	D
Буруу	Буруу	Буруу	Е

4. **В хэлбэрийн сорил.** Асуулт хариултын хослол

МОНГОЛЫН ТҮҮХ СОЁЛ ЁС ЗАНШИЛ

1. Аль нь түүхийг судлах оновчтой арга зүйн хандлага вэ?
 - A. Түүхийн үйл явцын анги, намч байр сууринаас, улс төрийн үүднээс авч үзэх
 - B. Түүхэн үйл явцыг эдүгээчлэн авч үзэх
 - C. Түүхэн үзэгдэл, үйл явцыг түүхэн тодорхой нөхцөлтэй нь холбож, тухайн үеийн оюунлигийн төвшинд авч үзэх
 - D. Түүхэн үйл явдлыг урьдчилан бэлтгэсэн санаа, томъёололд тохируулан загварчлах үзэл
 - E. Шинэ хандлагыг боловсруулан сургалт судалгаанд нэвтрүүлэх арга
2. Төвд тэмүүлэх хүчийг F_1 төвөөс зугтах хүчийг F_2 хэмээн тэмдэглэвэл дор өгүүлсэн тохиолдлын алинд нь улс үндэстэн нэгдэх боломжтой вэ?
 - A. $F_1 < F_2$
 - B. $F_1 > F_2$
 - C. $F_1 < F_2$
 - D. $F_1 = F_2$
 - E. $F_2 \gg F_1$
3. Ямар хааны үед Монгол гүрэн Батын болон Мөнхийн харьяаны гэсэн хоёр хэсэгт хуваагдаж, улс төрийн бутрал улам гүнзгийрсэн бэ?
 - A. Чингис
 - B. Гүюг
 - C. Өгөдэй
 - D. Мөнх
 - E. Бат
4. Түүхэнд ямар шинж байдлаар “Цагаан толбо” үүсгэж байсан вэ?
 - A. Хэт ангичирхах, хэт үзэл сурталжих хандлага
 - B. Түүхийг мушгин гуйвуулах, зөрчил бэрхшээлтэй талыг орхигдуулах, гоёж чимэх, эзэнгүйдүүлэх
 - C. Монголын нийгмийн үндсэн уур амьсгал болж байсан догматик арга
 - D. Бүтээлч сэтгэлгээний хомсдол
 - E. Монголын түүхийн сэтгэлгээнд зарим дэвшилтэт зүйлийг авчирснийг үгүйсгэх
5. Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойд цэнхэрийн агуйн хадны зураг аль үеийн дурсгал вэ?
 - A. Хуучин чулууны доод шат
 - B. Хуучин чулууны дээд шат
 - C. Хуучин чулууны дунд шат
 - D. Шинэ чулуун зэвсгийн үе
 - E. Төмөр зэвсгийн үе
6. Рашид-Аддины “Судрын чуулганд” тэмдэглэгдсэнээр олон зуун жилийн өмнө монгол овог аймгууд түрэгчүүдэд цохигдон нэгэн бөглүү газарт 400-д жил амьдран суусан газрын нэр аль нь бэ?
 - A. Онон мөрөн
 - B. Туул голын ай сав
 - C. Эргүнэ-кун
 - D. Онон, Хэрлэн, Туул, гурван голын эх
 - E. Бурхан халдун
7. Монгол нэрийн талаар эрдэмтэн Х. Пэрлээ ямар тайлбар хийсэн бэ?
 - A. Газар, усны нэрнээс үүдэн гарсан
 - B. Нийгэм олны амьдралын үзэгдлээс үүдэн гарсан
 - C. Овог аймгийн ерөнхий нэрийдэл
 - D. Угсаатны нэрнээс үүдэн гарсан
 - E. Аман домгоор уламжлагдан гарсан

8. Хэдий үеэс БНМАУ гэдэг нэрийг өөрчилж, Монгол улс хэмээн нэрлэх болсон бэ?
- A. 1990 оноос
 - B. 1992 оноос
 - C. 1994 оноос
 - D. 1995 оноос
 - E. 1996 оноос
9. Монголын цагаан ястан буюу алтан ургийн хаадын эхлэлийг хэн тавьсан бэ?
- A. Есүхэй баатар
 - B. Хабул хаан
 - C. Чингис хаан
 - D. Өгөдэй хаан
 - E. Гүюг хаан
10. Монголын түүхэнд “Бага хаадын үе” гэж аль үеийг нэрлэж байсан бэ?
- A. Мандуулаас Лигдэн хаан хүртэл
 - B. Хубилайгаас Тогоонтөмөр хүртэл
 - C. Мөнхөөс Тогоонтөмөр хүртэл
 - D. Лигдэнгээс Тогоонтөмөр хүртэл
 - E. Тогоонтөмөрийн дараах хаанаас Лигдэн хүртэл
11. Монголд хэдийд хоёр засаг тогтсон вэ?
- A. 1911-1915 онд
 - B. 1915-1919 онд
 - C. 1919-1921 онд
 - D. 1921 оны II сар хүртэлх хугацаанд
 - E. 1921 оны II сараас 1921 оны III сар хүртэлх хугацаанд
12. Төрийн “Хар хайрцаг”-ны, төрийн “Алтан хайрцаг”-ны бодлого гэдэг нэр томъёолол ямар утгатай вэ?
- A. Энэ хоёр томъёолол өөр өөр утгыг илэрхийлж ирсэн
 - B. Энэ хоёр томъёолол их утгатай, нэгэн зүйлийг нэрлэж ирсэн
 - C. Төрийн “Хар хайрцаг”-ны бодлого нь улсын дотоод бодлогыг илэрхийлдэг
 - D. Төрийн “Алтан хайрцаг”-ны бодлого нь улсын гадаад бодлогыг илэрхийлдэг
 - E. Улсын гадаад, дотоод бодлогыг бүхэлд нь илэрхийлдэг
13. “Тэнгэрийн хүү” хэмээх үзлийн тухай ойлголт монголчуудын ухамсарт ямар байдлаар төлөвшсөн байдаг вэ?
- 1. Хаанаа тэнгэрээс заяат
 - 2. Дээд засгийн тухай тулх үзэл
 - 3. Төр ёсоо хүндэтгэх
 - 4. Төрөө бишрэн сүсэглэх
 - 5. Төрийн засаглалын хэлбэр
14. “Хил савлах” гэдэг ойлголт ямар утгатай вэ?
- 1. Улсын дотоод бодлого болох төрийн “Хар хайрцаг” юм.
 - 2. Улсын дотоодод нутаг дэвсгэрийн нэгжийн хилийг улсын хаан төрийн дээд байгууллага, тухайн нөхцөл байдлаас болж өөрчилж болно.
 - 3. Улсын гадаад бодлогыг илэрхийлдэг “Алтан хайрцаг” юм.
 - 4. Монгол улсын газар нутаг хил хязгаарын халдашгүй дархан байдлыг илэрхийлнэ.
 - 5. Монголын төр аливаа асуудалд ухаалаг, уян хатан хандаж ирсэн явдал юм.
15. Гүюг хааны үйл ажиллагааны гол үндсэн чиглэл нь юу байсан бэ?
- 1. Хаан эцгийн зассан төр улсыг хэвээр нь хадгалсан
 - 2. Хууль дүрмийг чангатгасан
 - 3. Хүн амын тооллого явуулсан
 - 4. Албан татварыг журамласан

- 5.Эцгийнхээ гадаад бодлогыг үргэлжлүүлсэн
- 16.Хамаг Монголын гол цөм аймаг нь ямар аймаг байсан бэ?
- 1.Хиян
 - 2.Дарлиган
 - 3.Боржигон
 - 4.Нирун
 - 5.Нукус
- 17.Монголчуудын “Дуун бариулах” гэдэг нь чухам юуг нэрлэж байв.
- 1.Цааз, зарлиг, захиа даалгаврыг шүлэглэн зохиож
 - 2.Түүнийгээ элчээр зарагдах хүнд цээжлүүлэн дамжуулдаг арга
 - 3.Монголчуудын мэдээлэл харилцааны хэлбэр
 - 4.Тоглон наадах хэлбэр
 - 5.Шүлэглэн хэлэлцэх хэлбэр
- 18.Чингис хааны гадагш явуулсан аян дайн ямар үр дагавартай байсан бэ?
- 1.Өрнө дорныг холбосон торгоны замыг нээсэн
 - 2.Өртөө шуудан холбоог бий болгосон
 - 3.Улс түмний харилцааг хөгжүүлэхэд нөлөөлсөн
 - 4.Улс төрийн талаар тархай байсан Оросын вант улсуудыг нэгтгэсэн
 - 5.Хүчирхэг Орос гүрэн байгуулах эхлэлийг тавьж өгсөн
- 19.Аливаа улс орны дипломат ёс журам нь ямар шаардлагад нийцсэн байдаг вэ?
- 1.Өв соёлыг эхэнд тусгасан байх
 - 2.Олон улсын эрх зүйд нийцэж, зохицсон байх
 - 3.Бусад улс орны эрхэм зорилгыг харгалзан үздэг байх
 - 4.Өөрийн орны онцлогийг тусгасан байх
 - 5.Ард түмний хүсэл зорилгыг илүүд үздэг байх
- 20.“Их засаг” хууль эртний үеэс дэлхий дахинд нэрд гарсан ямар хуулиудтай эн зэрэгцэх вэ?
- 1.Үндсэн хууль
 - 2.Хаммурапийн хууль
 - 3.Ганжуур, Данжуур
 - 4.Манугийн хууль
 - 5.“Дөчин дөрвөн хоёрын цааз”
- 21.Манжууд Монголыг захирахдаа шарын шашныг хэрхэн ашиглаж байсан бэ?
- 1.Нөлөө бүхий хутагтуудыг Монгол орныг захирах бодлогод ашиглах
 - 2.Буддын шашны сүм хийдийг бие даасан тархай, олон тоотой байлгах
 - 3.Буддын шашныг дэлгэрүүлэхэд анхаарч номхон хүлцэнгүй байлгах
 - 4.Шарын шашны тэргүүнийг манжийн хаанаас томилох замаар эрх мэдлийг өөрт хадгалах
 - 5.Шашны нэрийн доор язгууртуудыг өөрийн дэргэд байлгах
- 22.Монгол хүний хөгжлийн тулгуур шинжүүдийг нэрлэнэ үү.
- 1.Оюун ухааны хөгжил
 - 2.Хүн амын өсөлт
 - 3.Ёс суртахуун
 - 4.Гэрийн хүмүүжил
 - 5.Зан заншил
- 23.Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны зарчмуудыг нэрлэнэ үү.
- 1.Эх оронч үндэсний үзлийг дээдлэх
 - 2.Төр, иргэний хамтын ажиллагаа
 - 3.Аюулгүй байдлын бодлого цогц байх
 - 4.Мэдлэгт суурилж, бодитой хандах
 - 5.Даяаршлын хүчин зүйлүүдийг харгалзах явдалд тулгуурлах

24. Монгол төрийн бодлогын мөнхийн шинжтэй асуудлуудад чухам юуг багтаан үзэж болох вэ?
1. Нийгмийн бүтцийг боловсронгуй болгох
 2. Үндэсний аюулгүй байдлыг хангах
 3. Залгамж чанарыг уламжлах
 4. Улс орны тусгаар тогтнол
 5. Уламжлал, шинэчлэлийг орхигдуулахгүй байх
25. Монголд хүчтэй хэрэгжиж эхэлсэн “Шинэ засгийн бодлого” нь Монгол дахь Манжийн ноёрхлыг авран тогтоох зорилгыг агуулж байсан учраас эл бодлогын хүрээнд Монголын хүн амыг хятадчилах, нутаг орныг дайны түшиц газар болгон хувиргах аргуудыг хэрэгжүүлж эхэлсэн нь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн өрнөхөд саад тотгор болж байв.
26. Үндэсний ухамсар нь түүхийн ухамсрын тодорхойлогч нь болдог учраас түүхийн ухамсрын үндсэн сурвалж болсон эх түүхээ танин мэдэхгүйгээр үндэсний ухамсар хэзээ ч төлөвшихгүй.
27. Монголчуудын сурган хүмүүжүүлэх сэтгэлгээний гол агуулга нь хүндээ чиглэдэг учраас Өрнөдийн сурган хүмүүжүүлэх сэтгэлгээнээс ялгаатай.
28. Монголын эртний улсууд төрийн тэргүүнээ нэрлэж байсан анхны нэрүүдийг нэрлэнэ үү.
1. Хүннү
 2. Сүмбэ
 3. Нирун
 4. Түрэг
 5. Уйгар
- A. Хагаан
B. Шаньюй
C. Зонхилогч
D. Толгойлогч
E. Зонхилогч
- A. 1A 2B 3C 4E 5D
B. 1B 2D 3A 4C 5E
C. 1C 2B 3E 4D 5A
D. 1D 2E 3B 4A 5C
E. 1E 2C 3D 4B 5A
29. Одоогийн Улаанбаатар хотын өмнөх нэрүүдийг нэрлэгдэж ирсэн он цагаар нь зааглана уу.
1. Өргөө
 2. Их хүрээ
 3. Да хүрээ
 4. Нийслэл хүрээ
 5. Улаанбаатар хот
- A. 1778-1911 он
B. 1639-1706 он
C. 1706-1778 он
D. 1911-1921 он
E. 1921-1924 он
- A. 1C 2D 3E 4A 5B
B. 1A 2B 3C 4D 5E
C. 1B 2C 3A 4D 5E
D. 1D 2C 3B 4A 5E
E. 1E 2A 3D 4B 5C
30. Хиагтад болсон гурван улсын хэлэлцээрт оролцогчид ямар ямар байр суурьтай

байсан бэ?

1. Монгол орны тусгаар тогтнолыг хүчингүй болгох
 2. Ар Монголыг өөрийн нөлөөний эрхшээлд голлосон улс болгох
 3. Тусгаар тогтнолоо баталгаажуулах
- A. Монгол улс
B. Дундад иргэн улс
C. Хаант орос улс
A. 1A 2B 3C
B. 1B 2C 3A
C. 1B 2A 3C
D. 1C 2B 3A
E. 1C 2A 3B

СОЁЛ СУДЛАЛЫН ҮНДЭС

1. Соёлыг судалдаг бие даасан шинжлэх ухааныг “Kulturologie” гэж өөрийн хэлээр нэрлэсэн философичийг нэрлэнэ үү.
A. Л. О. Уайт
B. Освальд
C. Н. Данилевский
D. И. Бахофен
E. К. Ясперс
2. Соёлыг юу юу бүрдүүлдэг бэ?
A. Бэлгэ тэмдэг, сүлд, зан харилцаа, ёс суртахуун, хэм хэмжээ, үнэлэмж, урлаг, өв соёл, хэл, уран сайхан
B. Өв соёл, хэм хэмжээ, ёс суртахуун шашин шүтлэг, салбар шинжлэх ухаанууд
C. Бэлгэ тэмдэг, хэл, мэдлэг, хэм хэмжээ, зан заншил, ёс суртахуун, үнэлэмж, шашин шүтлэг, урлаг утга зохиол
D. Хэл соёл, ёс суртахуун, соёлын 5-н хандлага, соёлын бүтэц, түүнд нөлөөлөх хүчин зүйлсүүд
E. Шашин шүтлэг, зан заншил, ёс суртахуун, соёлын үнэ цэнэтэй бүх зүйлс
3. Бэлгэ тэмдэг гэж юу вэ?
A. Утга нь болзмол шинжтэй дуу авиа болон тэмдгүүдийн оролцоотойгоор хэрэгждэг харилцааны системийг хэлнэ
B. Бэлтгэгдсэн хүмүүсийн хийдэг мэргэшсэн үйл ажил болсон танин мэдэхүйн үр дүнг хэлнэ
C. Субъектийн оюуны үйлдлээр илэрдэг өвөрмөц маягийн харилцаа мөн
D. Ямар нэгэн бодит юмуу хуурмаг үзэл санаанд бат үнэмших, сэтгэл зүрхээрээ үнэнч байх явдал юм
E. Нийгэм, нийгмийн бүлгийн гишүүдийн хувьд нийтээр хүлээн зөвшөөрөн нэг объект, үйлдлээр нөгөөгийн утга учрыг илтгэх, илэрхийлэх объектыг хэлнэ
4. Хэл гэж юу вэ?
A. Утга нь болзмол шинжтэй дуу авиа болон тэмдгүүдийн оролцоотойгоор хэрэгждэг харилцааны системийг хэлнэ
B. Бэлтгэгдсэн хүмүүсийн хийдэг мэргэшсэн үйл ажил болсон танин мэдэхүйн үр дүн юм
C. Субъектийн оюуны үйлдлээр илэрдэг өвөрмөц маягийн харилцаа мөн
D. Ямар нэгэн бодит юмуу хуурмаг үзэл санаанд бат үнэмших, сэтгэл зүрхээрээ үнэнч байх явдал юм.
E. Нийгэм, нийгмийн бүлгийн гишүүдийн хувьд нийтээр хүлээн

зөвшөөрөн нэг объект, үйлдлээр нөгөөгийн утга учрыг илтгэх, илэрхийлэх объектыг хэлнэ

5.Итгэл үнэмшил гэж юу вэ?

- A.Утга нь болзмол шинжтэй дуу авиа болон тэмдгүүдийн оролцоотойгоор хэрэгждэг харилцааны системийг хэлнэ
- B.Бэлтгэгдсэн хүмүүсийн хийдэг мэргэшсэн үйл ажил болсон танин мэдэхүйн үр дүн юм.
- C.Субъектийн оюуны үйлдлээр илэрдэг өвөрмөц маягийн харилцаа мөн
- D.Ямар нэгэн бодит юмуу хуурмаг үзэл санаанд бат үнэмших, сэтгэл зүрхээрээ үнэнч байх явдал юм
- E.Нийгэм, нийгмийн бүлгийн гишүүдийн хувьд нийтээр хүлээн зөвшөөрөн нэг объект, үйлдлээр нөгөөгийн утга учрыг илтгэх, илэрхийлэх объектыг хэлнэ

6.Үнэлэмж гэж юу вэ?

- A.Утга нь болзмол шинжтэй дуу авиа болон тэмдгүүдийн оролцоотойгоор хэрэгждэг харилцааны системийг хэлнэ
- B.Бэлтгэгдсэн хүмүүсийн хийдэг мэргэшсэн үйл ажил болсон танин мэдэхүйн үр дүн юм.
- C.Субъектийн оюуны үйлдлээр илэрдэг өвөрмөц маягийн харилцаа мөн
- D.Ямар нэгэн бодит юмуу хуурмаг үзэл санаанд бат үнэмших, сэтгэл зүрхээрээ үнэнч байх явдал юм.
- E.Нийгэм, нийгмийн бүлгийн гишүүдийн хувьд нийтээр хүлээн зөвшөөрөн нэг объект, үйлдлээр нөгөөгийн утга учрыг илтгэх, илэрхийлэх объектыг хэлнэ

7.Мэдлэг гэж юу вэ?

- A.Утга нь болзмол шинжтэй дуу авиа болон тэмдгүүдийн оролцоотойгоор хэрэгждэг харилцааны системийг хэлнэ
- B.Бэлтгэгдсэн хүмүүсийн хийдэг мэргэшсэн үйл ажил болсон танин мэдэхүйн үр дүн юм.
- C.Субъектийн оюуны үйлдлээр илэрдэг өвөрмөц маягийн харилцаа мөн
- D.Ямар нэгэн бодит юмуу хуурмаг үзэл санаанд бат үнэмших, сэтгэл зүрхээрээ үнэнч байх явдал юм.
- E.Нийгэм, нийгмийн бүлгийн гишүүдийн хувьд нийтээр хүлээн зөвшөөрөн нэг объект, үйлдлээр нөгөөгийн утга учрыг илтгэх, илэрхийлэх объектыг хэлнэ

8.Соёл гэж юу вэ?

- A.“Хүний хүнлэг чанар түүний оюуны баялаг”
- B.Хүний хүрээлэн буй орчинд хүнээр бүтээгдсэн бүх зүйл болох ойлголт, итгэл үнэмшил, ёс зүй, ёс журам, нийгмийн гишүүд, тэдний зан төлөв, хэв зуршлуудын нийлбэр юм.
- C.Оюун ухаант хүн төрөлхтөн буй болсон цагаасаа эхлэн бүтээсэн үнэт зүйл
- D.Техник, технологийн харилцаа эд ахуйн материаллаг бүтээл бүтээгдэхүүн
- E.Хүнээр хүн хийх хамгийн зохистой хэрэгсэл

9.Материаллаг соёл гэж юу вэ?

- A.Техник, технологийн харилцаа эд ахуйн материаллаг бүтээл бүтээгдэхүүн
- B.Оюуны бүх бүтээл
/Философи, шашин, ёс зүй, гоо зүй шинжлэх ухаан, урлаг/
- C.Объектив бодит байдал
- D.Хүний үйл ажиллагааны үр дүн болж үеэс үед өвлөгддөг үнэт зүйлс
- E.Ёс суртахуун, зан заншил болон бусад дадал чадварыг багтаасан цогц ойлголт

10. Оюуны соёл гэж юу вэ?
- A. Техник, технологийн харилцаа эд ахуйн материаллаг бүтээл бүтээгдэхүүн
 - B. Оюуны бүх бүтээл
/Философи, шашин, ёс зүй, гоо зүй шинжлэх ухаан, урлаг/
 - C. Объектив бодит байдал
 - D. Хүний үйл ажиллагааны үр дүн болж үеэс үед өвлөгддөг үнэт зүйлс
 - E. Ёс суртахуун, зан заншил болон бусад дадал чадварыг багтаасан цогц ойлголт
11. Соёлын хэдэн функц байдаг вэ?
- A. 12 функц
 - B. 11 функц
 - C. 14 функц
 - D. 13 функц
 - E. 15 функц
12. Соёлын функцэд аль нь үл хамаарах вэ?
- A. Сигнифик функц
 - B. Дасан зохицох функц
 - C. Зохицуулах функц
 - D. Сэтгэлгээний функц
 - E. Хүмүүнлэг функц
13. Соёл судлалын судлах зүйл, нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү.
- 1. Соёлын үүсэл хөгжил
 - 2. Соёлын бүтэц
 - 3. Элементүүдийн харилцан үйлчлэл
 - 4. Динамик
 - 5. Түүнд нөлөөлөх хүчин зүйлс
14. Соёлыг судалдаг шинжлэх ухааны салбаруудыг нэрлэнэ үү.
- 1. Түүх, археологи
 - 2. Хүн судлал
 - 3. Шашин судлал
 - 4. Сэтгэл судлал
 - 5. Улс төр судлал
15. Үнэлэмжийн элементүүд аль нь вэ?
- 1. Үнэлэгч субъект
 - 2. Үнэлэгдэгч объект
 - 3. Үнэлгээ
 - 4. Үнэлгээний 2 тал
 - 5. Үнэлгээний эсрэг тал
16. Өндөр боловсрол, зориудын бэлтгэл бүхий хүн хүртэх боломжтой соёл аль нь вэ?
- 1. Угсаатны соёл
 - 2. Элитийн соёл
 - 3. Ардын соёл
 - 4. Язгуур соёл
 - 5. Ахуйн соёл
17. Соёл гэдэг үгний зөв илэрхийлэл аль нь вэ?
- 1. "Газрыг эдлэх"
 - 2. "Ургуулах"
 - 3. "Газар тариалан эрхлэх"
 - 4. "Соёолох"
 - 5. "Ногоо соёолох"

18. Соёлын мөн чанар гэж юу вэ?
1. Үндэстний соёл дахь онцлогийг хадгалж байдаг
 2. Өөрчлөгдөшгүй, байнга байдаг
 3. Нийт хүн төрөлхтөнд хамаатай
 4. Соёлын тухай аливаа онолд авч үздэг тэр зүйл болно
 5. Аль ч төрлийн хүрээнд хамаарагддаг
19. Соёлын функцэд аль нь хамаарах вэ?
1. Өөрчлөн байгуулах функц
 2. Хамгаалах функц
 3. Харилцааны функц
 4. Хэм хэмжээний функц
 5. Семиотик буюу тэмдгийн функц
20. Ардын соёлын онцлогт аль аль зүйлийг хамааруулж үзэх вэ?
1. "Нэр"-гүй зохиогчтой
 2. Мэргэжлийн тодорхой бэлтгэл шаарддаггүй
 3. Шидэт домог, хууч үг, туульс, үлгэр, дуу бүжиг зэргийг хамааруулдаг.
 4. Гүйцэтгэлийн байдлаар нь ганцаарчилсан, бүлгийн, нийтийн гэж авч үздэг
 5. Зар суртачилгаа ихээхэн үүрэг гүйцэтгэдэг
21. Нийтийн соёлын онцлогт аль аль зүйлийг хамааруулж үзэх вэ?
1. Ихэвчлэн зохиогчтой байдаг
 2. Радио телевиз, сонин, сэтгүүл, интернет зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүмүүст илүү хүрдэг
 3. Хэрэглэгчдээсээ илүү өндөр боловсрол шаарддаг
 4. Соёлын хамгийн эртний төлөөлөл
 5. Язгууртны тансаг таашаал, ард түмний оюуны эрэл хайгуул зэргийг илэрхийлдэг
22. Шилмэл соёлын онцлогт аль аль зүйлийг хамааруулж үзэх вэ?
1. Нийгмийн шилмэл, хангалуун хэсгийн төлөөлөгчдөд зориулагдсан байдаг
 2. Шинийг эрэлхийлэх, өөрийгөө илэрхийлэх, алдарт хүрэх, өөрийн санааг уран бүтээлдээ шингээхийг эрмэлздэг
 3. Тодорхой мэргэжлийн хүмүүс түүнийг бүтээж буй болгодог
 4. Арилжааны ашиг хонжоо тэдэнд нэг их гол биш ч, орлого олох нэг арга нь яах аргагүй мөн
 5. Мэргэжлийн уран бүтээлчдийн хөдөлмөрийн үр дүн
23. Дэд соёлын онцлогууд нь ямар зүйлсээр илэрхийлэгддэг вэ?
1. Тодорхой дүр байдлыг хэвшүүлэх зорилго бүхий зан үйлийн арга барил, алхаа гишгээ, өвөрмөц дохио зангаагаар илэрхийлэгддэг.
 2. Хувцаслалт
 3. Үс засалтаар
 4. Шашин шүтлэгийн байдлаар
 5. Хэл ярианы соёлоор
24. Залуучуудын соёлын онцлогууд нь ямар зүйлсээр илэрхийлэгддэг вэ?
1. Энэ нь залуу хүмүүсийн өсөлтийн онцлог болон нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаар тодорхойлогдох нийгэм сэтгэл зүйн үндэстэй зүйл
 2. Энэ соёл бол залуу хүмүүс өөрийгөө мэдрүүлэх, илэрхийлэх, эрмэлзлэлд оршино
 3. Шинэ үе бүрийн билгэ тэмдэг нь голдуу хөгжмийн сонголт байдаг
 4. Уг соёлын үндсэн төрөл, хэлбэрүүд дийлэнхдээ мэдрэхүй сэтгэл хөдлөлийн ертөнцөөр нөхцөлддөг
 5. Голлох байр суурийг хөгжил эзэлж тэдэнд сэтгэл хөдлөлийн

- хүчтэй нөлөөллийг үзүүлж байдаг
- 25.Сохрат,Платон нар диалектикийг маргалдах урлаг, ойлголтыг тайлбарлах ба үнэнийг олж авах ярилцлага гэж ойлгож байгаагүй. Учир нь Г.Гегель диалектик бол юмс хөгжил, өөрчлөлт ба холбоо хамааралд оршдогийг нотлодог системтэй шинжлэх ухаан байх ёстой гэдэг арга зүйг баримтлажээ.
- 26.Английн ард түмэн парламентаа байгуулсан учраас тэр мөчид эрх чөлөөтэй байснаа түүний дараа эргээд төрийнхөө боол болон хувирсан.
- 27.Хүмүүст эрх, эрх чөлөөгөө хамгаалуулах, амар тайван амьдрахад нь тодорхой эрх мэдэл бүхий захиргааны байгууллага хэрэгтэй байдаг учраас төр эрх мэдлээ хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны бус албадлагыг хэрэглэдэг.
- 28.Соёлыг судалдаг хандлагуудыг зөв холбоно уу.
- 1.Социологийн хандлага
 - 2.Аксиологийн хандлага
 - 3.Семиотик хандлага
 - 4.Үйл ажиллагааны хандлага
 - 5.Эмпирик хандлага
- A.Соёл бол хүний бүтээсэн тэмдгүүдээр илрэн гарч байдаг зүйл.
- B.Уг хандлагын үүднээс соёл бол хүний зорилгодоо хүрэхийн тулд боловсруулан ашигладаг “технолог”-ийн цогц мөн.
- C.Соёлыг хүний бүхий л үйл ажиллагааны үр дүн, нийлбэр өөрөөр хэлбэл энэ үр дүнг бүрдүүлэх юмс, үнэлэмжийн нийлбэр цогц хэмээн үзнэ.
- D.Иймээс соёл нь хойч үедээ үнэ цэнэтэй, хамгийн эрхэм гэх бүхнийг шингээсэн байдаг хэмээн үзэх хандлага.
- E.Соёлыг нийгмийн тогтвортой тогтолцоот байдлыг хангах социаль институт гэж үздэг.
- A. 1A 2B 3C 4D 5E
 - B. 1E 2D 3A 4B 5C
 - C. 1B 2C 3D 4E 5A
 - D. 1C 2D 3E 4A 5B
 - E. 1D 2E 3B 4C 5A
- 29.Хэм хэмжээнүүдийг зөв холбоно уу.
- 1.Албан ёсны хэм хэмжээ
 - 2.Албан бус хэм хэмжээ
 - 3.Ерөнхий соёлын хэм хэмжээ
 - 4.Бүлгийн хэм хэмжээ
 - 5.Гүйцэтгэх хэм хэмжээ
- A.Нийгмийн тодорхой байр сууринд байгаа хүний зан үйлийн шинж чанар
- B.Зарим анги давхрааны зан үйлийн үлгэрлэл
- C.Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эелдэг тааламжтай харилцааны дүрэм, иргэний эрх болон үүрэг
- D.Төрөөс батлаж гаргасан хууль тогтоомж, олон нийтийн байгууллагын дүрэм, журам
- E.Төрийн хуулиас ч дутуугүй нийтээр дагаж мөрддөг нийтлэг хэм хэмжээ
- A. 1A 2B 3C 4D 5E
 - B. 1B 2C 3D 4E 5A
 - C. 1D 2E 3C 4B 5A
 - D. 1C 2D 3E 4A 5B
 - E. 1E 2A 3B 4C 5D
- 30.Дараах соёлуудыг зөв харгалзуулна уу.
- 1.Материаллаг соёл

2. Материаллаг бус соёл
 3. Ердийн соёл
 4. Тусгай буюу мэргэжлийн соёл
 5. Соёлын хэв маяг
- A. Өдөр тутмын амьдралтай холбоотой соёлын үзэгдэл, зан үйлийн хэм хэмжээ, үзэл санааны цогцыг хэлнэ
 - B. Соёлын үзэгдлийг хуримтлуулах, дамжуулах үйл ажиллагаа юм
 - C. Хүний гараар бүтээгдсэн физик объектууд юм
 - D. Хүний ухамсарт оршиж хүмүүсийн харилцаанд хэрэгждэг
 - E. Соёлын объектуудыг гол шинж тэмдэгээр нь ангилахыг хэлнэ
- A. 1A 2B 3C 4D 5E
 - B. 1B 2C 3D 4E 5A
 - C. 1C 2D 3A 4B 5E
 - D. 1D 2E 3B 4A 5C
 - E. 1E 2A 3C 4D 5B

ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАР

1. Багаар ажиллахын тулд “үүрэг гүйцэтгэгчийг томилдог” Ямар үүрэг бүхий хүнийг эхэлж томилдог вэ?
 - A. Удирддаг
 - B. Чиглүүлдэг
 - C. Захирдаг
 - D. Төлөвлөдөг
 - E. Тэмдэглэл хөтөлдөг
2. Хүн бүрийн биеэ авч яваа байдал, хийж буй үйлдэл бүр бусдад сайхан сэтгэгдэл төрүүлж, халуун дулаан уур амьсгалыг бий болгодог хариуцлагыг оноон нэрлэнэ үү.
 - A. Бодол санаа бүрдээ
 - B. Үг бүрдээ
 - C. Үйлдэл бүрдээ
 - D. Хандлага бүрдээ
 - E. Өөрийгөө хөгжүүлэх бүрдээ
3. Хандлага ямар 3-н зүйлээс бүтдэг вэ?
 - A. Бодол, үг, мэдрэхүй
 - B. Үйл хөдлөл, бодол, үг
 - C. Харилцаа, үг, мэдрэмж
 - D. Бодол, мэдрэхүй, үйлдэл
 - E. Хандлага, үйл хөдлөл, үг
4. Анх удаа таны өрөөнд хэн нэгэн хүн орж ирэв. Эн тэргүүнд хийх үйлдэл аль нь вэ?
 - A. Суухыг урина.
 - B. Инээмсэглэнэ
 - C. Мэндлэнэ
 - D. Анхаарал хандуулна
 - E. Нэрээ хэлнэ.
5. Хандах гэж юу вэ?
 - A. Амьгүй, амьтай зүйл болон хүнд анхаарал хандуулахыг хэлнэ.
 - B. Зөвхөн хүнд анхаарал хандуулахыг хэлнэ.
 - C. Амьтан ба амьгүй зүйлд анхаарал хандуулахыг хэлнэ.
 - D. Ямар ч зүйлд анхаарал хандуулахыг хэлнэ.
 - E. Аливаа зүйлд анхаарлаа хандуулахыг хэлнэ
6. Харилцах гэж юу вэ?

- A. Хүн хүнтэйгээ ойлголцохыг хэлнэ.
 - B. Хүн амьтан, амьгүй зүйлд хандахыг хэлнэ.
 - C. Хүн амьтан болон хүнд хандахыг хэлнэ.
 - D. Хүн зөвхөн амьтантай хандахыг хэлнэ.
 - E. Хүн хоорондын харилцааг хэлнэ.
7. Эрүүл хүн гэж хэн бэ?
- A. Хүн бие махбодийн, сэтгэхүйн, нийгэм соёлын, оюун санааны хувьд эрүүл саруул байх ёстой.
 - B. Хүн бие махбодийн, сэтгэцийн, нийгэм соёлын, оюун санааны хувьд эрүүл байх
 - C. Хүн бие махбодийн, сэтгэхүйн, ухааны санааны, нийгэм соёлын, оюун санааны хувьд эрүүл саруул байх ёстой.
 - D. Хүн бие махбодийн хувьд эрүүл саруул байх ёстой.
 - E. Хүн бие махбодийн, сэтгэхүйн, нийгэм соёлын, сэтгэцийн хувьд эрүүл саруул байх ёстой.
8. Харьцах гэж юу вэ?
- A. Хүн хүнтэйгээ ярилцахыг хэлнэ.
 - B. Хүн, амьтан, амьгүй зүйлд хандахыг хэлнэ.
 - C. Хүн амьтан болон хүнд хандахыг хэлнэ.
 - D. Хүн зөвхөн амьтантай хандахыг хэлнэ.
 - E. Хүн хоорондын харилцааг хэлнэ.
9. Хүмүүстэй харилцаа тогтооход:
- A. Сонсох чадвар 20%, Аливаа юманд хариу өгөх чадвар 30%, Аливаа юманд хандаж буй байдал 50%
 - B. Сонсох чадвар 40%, Аливаа юманд хариу өгөх чадвар 20%, Аливаа юманд хандаж буй байдал 40%
 - C. Сонсох чадвар 30%, Аливаа юманд хариу өгөх чадвар 20%, Аливаа юманд хандаж буй байдал 50%
 - D. Сонсох чадвар 50%, Аливаа юманд хариу өгөх чадвар 20%, Аливаа юманд хандаж буй байдал 30%
 - E. Сонсох чадвар 20%, Аливаа юманд хариу өгөх чадвар 50%, Аливаа юманд хандаж буй байдал 30%
10. Тухайн ажлыг хийхэд шаардагдах чадамжийг оноон нэрлэнэ үү.
- A. Дотоод чадвар
 - B. Гадаад чадвар
 - C. Шаардагддаг чадвар
 - D. Харилцааны чадвар
 - E. Багаар ажиллах чадвар
11. Мэдлэг, чадварыг хөдөлгөгч хүч бол.
- A. Хандлага
 - B. Харилцаа
 - C. Аман харилцаа
 - D. Аман бус харилцаа
 - E. Бичгийн харилцаа
12. Аливаа юманд болон хүнд хандахад хүний дотоод сэтгэлээс шалтгаалан эерэг, сөргөөр илэрхийлэгдэж байдаг үйлийг оноон нэрлэнэ үү.
- A. Хандах
 - B. Хандсан яриа
 - C. Харилцан яриа

- D. Хандлага
E. Харилцаа
13. Хүн амьтнаас ямар зүйлээр ялгагддаг вэ?
1. Ухамсар
 2. Оюун санаа
 3. Бие махбод
 4. Зан үйл
 5. Хандлага
14. Мэргэжилтний үүргийг оноон нэрлэнэ үү.
1. Мэргэшсэн байх
 2. Харилцагч
 3. Мэргэжлийн байх
 4. Хамтрагч
 5. Зохион байгуулагч
15. Харилцааны үүргүүдийг оноон нэрлэнэ үү.
1. Нэгтгэх холбох.
 2. Хөгжүүлэх
 3. Төлөвшүүлэх
 4. Нийгэмшүүлэх
 5. Илэрхийлэх
16. Үгэн бус харилцаанд дараах харилцаа орно. Оноон нэрлэнэ үү.
1. Нүүрний хувирал
 2. Биеийн хэл
 3. Хүрэлцэх
 4. Гадаад үзэмж
 5. Харц
17. Хандлага юу юунаас бүрдэх вэ?
1. Бодол
 2. Мэдрэхүй
 3. Үйл хөдлөл
 4. Ярих дууны өнгө
 5. Харж буй харц
18. Эх орныхоо иргэн байх шинжийг оноон нэрлэнэ үү.
1. Шударга байх
 2. Ажилдаа хариуцлагатай хандах
 3. Шинийг эрэлхийлэх
 4. Эелдэгээр хандах
 5. Өөрийгөө байнга хөгжүүлэх
19. Жижиг бүлгийн сургалт хэдэн хэлбэрээр явагддаг вэ? Оноон нэрлэнэ үү.
1. Чиглүүлэгч
 2. Цаг баригч
 3. Тэмдэглэл хөтлөгч
 4. Илтгэгч
 5. Туслагч
20. Ахлагч бүр ямар төрлийн ухаанд суралцах ёстой вэ?
1. Хандлага
 2. Лидершил
 3. Ёс зүй
 4. Менежмент
 5. Мэдлэг

21. Харилцаа нь сэтгэл зүйн хувьд ямар харилцаагаар зохицуулагдах вэ? Нэрлэнэ үү?

1. Нээлттэй
2. Таатай
3. Хаалттай
4. Таагүй
5. Түгээмэл

22. Ёс зүйн үүргийг оноон нэрлэнэ үү.

1. Хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулах
2. Хүнийг хүмүүжүүлэх
3. Танин мэдэхүйн
4. Олж авсан хүмүүжил
5. Соёл

23. Анхааралтай байдалд аль нь орох вэ?

1. Ам, нүд, чих, гар, хөлөөрөө анхаарлаа сарниулахгүй байх
2. Илүү хөдөлгөөн хийхээс зайлсхийх
3. Зөв сууж, цэх зогсож сурах
4. Хүмүүс танд хандан ярихад өөдөөс нь харах
5. Хэрвээ ойлгомжгүй зүйл байвал асууж тодруулах

24. Эерэг хандлага хэрхэн эзэмших вэ?

1. Сөрөг хандлагын талаар ярилцах
2. Өөрийгөө орлуулан бодох
3. Дүрд тоглох
4. Бусдаар алдаагаа хянуулах
5. Бусдын алдаан дээр суралцах

25. Гурваар бүтэж, Дөрвөөр тэгширч, Таваар цогцолж, Зургаагаар амилдаг. Зурхайн 5 махбодийн онолоор уялдуулан сонгоно уу.

- | | |
|----------|-----------------|
| 1. Элэг | A. Нарийн гэдэс |
| 2. Бөөр | B. Бүдүүн гэдэс |
| 3. Уушга | C. Цөс |
| 4. Дэлүү | D. Давсаг |
| 5. Зүрх | E. Ходоод |

A. 1C, 2D, 3B, 4E, 5A

B. 1D, 2B, 3E, 4A, 5C

C. 1B, 2E, 3A, 4C, 5D

D. 1E, 2B, 3A, 4D, 5C

E. 1A, 2C, 3D, 4B, 5E

26. Эрүүл хүн гэсэн тодорхойлолтод доорх бүгд багтана. Уялдуулан сонгоно уу.

1. Сэтгэхүйн хувьд эрүүл хүн
2. Ухаан санааны хувьд эрүүл хүн
3. Нийгэм, соёлын хувьд эрүүл хүн
4. Оюун санааны хувьд эрүүл хүн
5. Бие махбодийн хувьд эрүүл хүн
 - A. Өөрийгөө өөрчлөхөд бэлэн
 - B. Хүмүүсийг нас хүйс, соёл, шашин шүтлэгээр нь ялгаварлан ханддаггүй
 - C. Аливаа юмыг ухаалаг талаас нь авч үздэг
 - D. Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, хянах
 - E. Эрхтэн бүтэн, зовиур шаналгаагүй чадвартай

A. 1A, 2B, 3C, 4D, 5E

B. 1B, 2A, 3C, 4D, 5E

C. 1D, 2C, 3B, 4A, 5E

D. 1E,2D,3C,4B,5A

E. 1C,2E,3A,4D,5B

27. Хүн бүрийн хүлээх хариуцлага гэж аль үетэй тохирох вэ? Уялдуулан сонгоно уу.

1. Бодол санаа бүрдээ

2. Үг бүрдээ

3. Үйлдэл бүрдээ

4. Хандлага бүрдээ

5. Өөрийгөө хөгжүүлэх бүрдээ

A. Хүний хэлсэн үг бүр үнэ цэнэтэй

B. Сэтгэлээсээ мэргэжилдээ хандаж буй байдал тодорхойлогддог

C. Өдөр бүр мэдлэгээ дээшлүүлэхийг шаарддаг.

D. Бусдад сайхан сэтгэгдэл төрүүлж, халуун дулаан уур амьсгалыг бий болгодог

E. Хүн бүрийн хандаж буй хандлагаас хамаарч ажлын үр дүн гардаг.

A. 1C,2B,3E,4A,5D

B. 1B,2A,3D,4E,5C

C. 1D,2E,3C,4A,5B

D. 1B,2D,3C,4A,5E

E. 1C,2B,3E,4D,5A

28. Ёс зүй нь хувь хүний ёс суртахуунлаг шинж чанарын буюу сайн чанаруудын нийлбэр цогцыг хэлэх бөгөөд нөгөө талаас хүмүүс хоорондын харилцааны хэм хэмжээний нийлбэр цогцыг хамран судалдаг шинжлэх ухаан юм.

29. Хэл ярианы болон хэл ярианы бус хэлбэрээр хүмүүсийн хооронд үүсэн явагдаж байгаа харилцан үйлдлийг харилцаа гэдэг учраас ярьж байгаа болон сонсож байгаа хүн нэгэн зэрэг хоорондоо амаар болон аман бус харилцаанд ордгоос болж харилцаанд хүндрэл гардаг.

30. Мэдлэг чадварыг хөдөлгөгч хүч бол хандлага юм. Хандлага гэдэг нь тухайн хүн аливаа юманд болон хүнд хандахад дотоод сэтгэлээс нь хамаарч янз бүрийн үйлээр илэрхийлэхийг хэлнэ.

ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛ

1. Юуг яаж хэнд зориулж үйлдвэрлэх вэ? Асуудал аль тогтолцоонд хамрагдах вэ?

A. Төвлөрсөн эдийн засгийн тогтолцоонд

B. Зах зээлийн тогтолцоонд

C. Уламжлалт, амиа аргацаасан хоцрогдсон эдийн засагт

D. Бүх эдийн засгийн тогтолцоонд

E. Уламжлалт ба зах зээлийн тогтолцоонд

2. Үйлдвэрлэлийн боломжийн шугам юуг илэрхийлэх вэ?

A. Тухайн аж ахуй үйлдвэрлэх гэж төлөвлөж буй 2 барааны тоо хэмжээ

B. 2 барааны хослон үйлдвэрлэх боломжит хувилбарыг харуулна.

C. Нөөцийн тухайн тоо хэмжээнд 2 барааг хослон үйлдвэрлэх аль нэг сонгосон хувилбарыг илэрхийлнэ

D. Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн бүтээмж буурах хууль үйлчилж эхэлсэн цаг хугацааг илэрхийлнэ.

E. Үйлдвэрлэлийн хүчин чадлын доод хэмжээг илэрхийлнэ.

3. Дараах тодорхойлолтуудын аль нь эдийн засгийн онолын судлах зүйлийг бүрэн илэрхийлэх вэ?

A. Хүний материалын ба оюун санааны хэрэгцээний байнгын өсөлт өөрчлөлтийн тухай шинжлэх ухаан мөн.

B. Хүний зан үйлийн сэдэлтийн тухай шинжлэх ухаан мөн.

C. Материаллаг баялгийн үйлдвэрлэл хуваарилалтын шалгуурын тухай шинжлэх ухаан мөн.

D. Биет баялгийн тухай шинжлэх ухаан мөн.

- Е.Хязгаарлагдмал нөөцөөр хэрэгцээг хангадаг хүний нийгмийн хөгжлийн ерөнхий хуулиудын тухай шинжлэх ухаан мөн.
4. Позитив эдийн засгийн онол юу судалдаг вэ?
 - А.Юу байна, ямар байна вэ?
 - В.Ямар байх ёстой вэ?
 - С.Эдийн засгийг хөгжлийн эерэг хандлага
 - D.Үнэлгээ өгөх
 - Е.Юмс үзэгдлүүдийн хоорондох функцийн уялдаа холбоо
 5. Хэрвээ зэх зээлийн үнэ тэнцлийн үнээс доогуур байвал, ямар үзэгдэл үйл явц үүсгэх вэ?
 - А.Барааны илүүдэл бий болно
 - В.Барааны хомсдол үүснэ
 - С.Худалдан авагчийн зах зээл бүрэлдэнэ
 - D.Нөөцийн үнэ буурна
 - Е.Өрсөлдөөн хүчтэй болно
 6. Зах зээлийн дараах тодорхойлолтуудаас аль нь хамгийн оновчтой вэ?
 - А.Зах зээл гэдэг нь худалдагч, худалдан авагчийн хоорондох уялдаа холбоо чөлөөтэй, ижил барааны үнэ тэгшрэн, нэг түвшинд тогтоодог
 - В.Зах зээл бол эрэлт нийлүүлэлтийн харьцаа, худалдагч худалдан авагчдын харилцан бие биедээ нөлөөлөх механизм мөн
 - С.Зах зээл бол бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг холбон нэгтгэж байдаг улс орны дотоодод ба улс орнуудын хоорондох солилцооны хүрээ
 - D.Зах зээл бол тодорхой нэрийн барааны худалдаа явагддаг орон зай газар нутаг
 - Е.Зах зээл бол таваарын үйлдвэрлэлийн хуулиар зохион байгуулагдсан тогтолцоо, арилжаа солилцооны харилцаа
 - 7.ҮНБ гэж юу вэ?
 - А.ДНБ-ний мөнгөн илэрхийлэл
 - В.Тухайн улсын эцсийн бараа, үйлчилгээний мөнгөн илэрхийлэл
 - С.Нийт нийгмийн өв хөрөнгө
 - D.Хүн бүрийн нийт орлогын нийлбэр
 - Е.Тухайн улсын нутаг дэвсгэр дээр жилийн дотор шинээр бий болсон нийт өртөгийн нийлбэр
 8. Эдийн засгийн уналтанд орсноос ажилгүй болсон хүн ажилгүйдлийн ямар категорт хамрагдах вэ?
 - А.Шилжилтийн ажилгүйдэл
 - В.Бүтцийн ажилгүйдэл
 - С.Мөчлөгийн ажилгүйдэл
 - D.Технологийн ажилгүйдэл
 - Е.Орон нутгийн ажилгүйдэл
 9. Хадгаламж гэж юу вэ?
 - А.Өрхийн аж ахуйнуудын бүх хуримтлагдсан эд хөрөнгө ба хүн амын хадгаламж
 - В.Зах зээлийн бүх субъектуудын кассын бодит үлдэгдэл
 - С.Үнэт цаасанд оруулсан орлогын хэсэг
 - D.Тухайн үед хараахан зарцуулагдаагүй өрх, аж ахуй нэгжүүдийн орлогын хэсэг
 - Е.Эрүүл мэнд ба ажилгүйдлийн даатгалын төлбөр
 - 10.Аль нь шууд албан татварт хамаарагдахгүй вэ?
 - А Нэмэгдэл өртөгийн татвар
 - В.Цалин хөлсний татвар

- C. Үйлдвэрийн газруудын өмчийн татвар
D. Аж ахуй нэгж байгууллагуудын орлогын татвар
E. Корпорацийн ашгийн татвар
11. Мөнгөний үүргийг аль нь бүрэн илэрхийлэх вэ?
A. Мөнгө нь үнэт зүйлсийн хуримтлал ба өртөгийн хэмжүүр болно
B. Мөнгө бол гүйлгээ ба төлбөрийн хэрэгсэл
C. Мөнгө нь дэлхий дахины мөнгөний үүрэг гүйцэтгэнэ
D. Мөнгө нь өртөгийг хэмжих хэрэгсэл болно
E. Мөнгө нь хуримтлал ба гүйлгээний хэрэгсэл болно.
12. Үнэ 5% -р хямдрахад нийлүүлэлтийн хэмжээ нь 8%-р буурч байвал үүнийг ямар нийлүүлэлт гэх вэ?
A. Мэдрэмжгүй
B. Нэгж мэдрэмжтэй
C. Мэдрэмжтэй
D. Хэт мэдрэмжтэй
E. Огт мэдрэмжгүй
13. Инфляцийн тодорхойлолтыг сонгоно уу.
1. Бодит ҮНБ ийн өсөлтөөс үнийн өсөлт түрүүлэх
2. Цаасан мөнгийн х эт ихээр гүйлгээнд гаргаснаар үнэ өсөх
3. Нэрлэсэн ҮНБ –ийн өсөлт нь үнийн өсөлтөөс түрүүлэх
4. Мөнгөний худалдан авах чадварын уналт
5. ДНБ-д улсын төсвийн алдагдлын эзлэх хувь
14. Сангийн бодлого ямар нөлөө үзүүлдэг вэ?
1. Хөхүүлэн дэмжиж урамшуулагч
2. Саатуулах нөлөө
3. Аяндаа өөрөө чиглүүлэгч
4. Ядуурлыг бууруулахад шууд нөлөөлнө
5. Гадаад худалдааны хаалттай бодлого хэрэгжихэд нөлөөлнө
15. Үнэт цаасны зах зээл юунаас бүрэлдэх вэ?
1. Вексель буюу өрийн бичиг
2. Облигаци
3. Хувьцаа
4. Урт хугацааны зээл
5. Банкны тэмдэгт
16. Аль нь зээлийн үндсэн шинж вэ?
1. Зээл нь цаг ямагт хүүтэй байдаг
2. Зээл нь хугацаатай байна
3. Тодорхой зориулалттай бөгөөд эргэн төлөгдөх ёстой
4. Зээл нь хөрвөх чадвар сайтай
5. Зээл нь хөрөнгө оруулалтын үндсэн эх үүсвэр
17. Эдийн засгийн өсөлтийн эрчимтэй хүчин зүйлийг тодорхойл?
1. Үйлдвэрлэлийн хүчин чадлын чанарын өсөлт, нэгж бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ноогдох цагийн бууралт
2. Ажлын цагийн өсөлт
3. Үйлдвэрлэлд шинжлэх ухаан техникийн ололтыг ашиглах
4. Ажиллагсадын тооны өсөлт
5. Түүхий эд материал, цахилгаан эрчим хүчний өсөлт
18. Эдийн засгийн өсөлт гэж юу вэ?
1. Энэ бол тодорхой цаг хугацааны дотор үндэсний үйлдвэрлэлийн бодит хэмжээ өсөлт
2. Нийт бараа, үйлчилгээний зах зээлийн өртгийн өсөлт

3. Энэ бол тодорхой цаг хугацааны хүрээнд нэг хүн амд ноогдох үйлдвэрлэлийн бодит хэмжээний өсөлт
 4. Хүн амын мөнгөн орлогын өсөлт
 5. Аж ахуйн эргэлтэнд орж буй байгалийн баялгийн өсөлт
19. Олон улсын худалдаа ямар үед харилцан ашигтай байх вэ?
1. Улс орон нь нэг нэг барааны үйлдвэрлэлд туйлын давуу талтай байна.
 2. Тухайн улс орон нь ямар ч барааны үйлдвэрлэлд туйлын давуу тал байхгүй
 3. Улс орнууд ямарваа нэг бараануудын үйлдвэрлэлд харьцангуй давуу талтай
 4. Олон улсын хөдөлмөрийн хуваарь өндөр хөгжсөн нөхцөлд
 5. Импортын барааны гаалийн татвар харилцан чиглэгдсэн нөхцөлд
20. Гадаад ажиллах хүчийг илүүтэй ашиглахын шалтгаан юу вэ?
1. Гадаадын мэргэжилгүй ажиллах хүч нь хямд байдаг
 2. Гадны ажилчидад бага хөлс төлөх замаар улс орны хэмжээнд цалингийн ерөнхий түвшинг бууруулах эрмэлзэл
 3. Өөрийн оронд бэлтгэхэд төвөгтэй буюу боломжгүй мэргэжилтэн ашигласнаас нэмэгдэл ашиг олох боломжтой.
 4. Тухай улс оронд ажиллах хүч дутагдалтай байгаагаас
 5. Хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөөн их байгаа тул
21. Төрийн эдийн засгийн үүрэг юу вэ?
1. Шударга ёсыг тогтоох хамгаалах
 2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах
 3. Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх
 4. Эдийн засгийн хямралд оруулахгүй байх ёстой
 5. Эдийн засгийг чанга гараар барьж байх
22. Цэвэр зах зээлийн эдийн засгийн тогтолцоог бүрэлдүүлдэг үндсэн элементүүдийг тодорхойлно уу.
1. Хувийн өмч
 2. Өрсөлдөөн
 3. Аж ахуй эрхлэх сонголт хийх эрх чөлөө
 4. Нийгмийн нийтлэг ашиг сонирхол
 5. Нэгдсэн төлөвлөгөө
23. Макро эдийн засгийн ухаанд аль хууль хамаарах вэ?
1. Өртгийн хууль
 2. Хуримтлалын хууль
 3. Мөнгөн гүйлгээний хууль
 4. Үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн бүтээмж буурах хууль
 5. Эрэлтийн хууль
24. Дараах хүчин зүйлийн аль нь үйлдвэрлэлийн хүчин зүйлд хамаарагдах вэ?
1. Байгалийн нөөц / газар, ашигт малтмал, усны нөөц/
 2. Бараа үйлчилгээний үйлдвэрлэлд зориулагдсан хүний биеийн ба оюуны чадвар
 3. Тоног төхөөрөмж
 4. Эрсдэл хийж оновчтой шийдвэр гаргах хүмүүсийн чанар
 5. Бараа үйлчилгээг үйлдвэрлэх арга технологи
25. Доор дурдагдсан мөнгийг ангилан ямар хэлбэрт хамрагдахыг тохируулна уу.
1. Чекээр дамжин эзэмшигддэг мөнгө
 2. Биет эд юмсын өртөггүй мөнгө
 3. Цалин тооцогддог банкны дансанд байгаа мөнгө
 4. Бүрэн үнэ цэнэтэй мөнгө
 - А. Бутархай мөнгө

- V. Гүйлгээнд байгаа зоосон мөнгө
 - C. Цаасан мөнгө
 - D. Бэлэн бус тооцооны мөнгө
 - A. 1A, 2B, 3C, 4D
 - B. 2A, 1B, 4C, 3D
 - C. 3A, 4B, 1C, 2D
 - D. 4A, 3B, 2C, 1D
26. Дараах зардлуудыг зөв ангилан тодорхойлно уу.
1. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээгээр тодорхойлогддоггүй шатчилсан маягаар өсдөг зардал
 2. Нийт зардлыг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнд хувааж тооцсон зардал
 3. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээнээс хамаардаггүй зардал
 4. Түрээслэн авсан агуулахын зардлыг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнд хувааж тооцсон зардал
 5. Үйлдвэрлэлийн хүчин чадлын ачааллаас хамааран өсч буурч байдаг зардал
- A. Дундаж нийт зардал
 - B. Дундаж тогтмол зардал
 - C. Хувьсах зардал
 - D. Огцом өсөх зардал
 - E. Үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтын зардал
 - A. 1A, 2B, 4C, 3D, 5E.
 - B. 2A, 3B, 5C, 1D, 4E
 - C. 3A, 4B, 2C, 5D, 1E
 - D. 4A, 5B, 2C, 1D, 3E
27. Дараах элементүүд нь эдийн засгийн ямар үе шатанд хамрагдах вэ?
1. Үйлдвэрийн эздүүдийн барааны агуулах хоосорч нийлүүлэлтийн хугацаа нэмэгдэв.
 2. Эдийн засагт цалин ба үнийн аажим өсөлт ажиглагдаж байна.
 3. Эрэлт нь нийлүүлэлтээс давж, үнийн хэлбэлзэлийг бий болгоно.
 4. Барааны мэдрэмжтэй нийлүүлэлт нь өндөр эрэлтийн өөрчлөлтийг буй болгоно.
- A. Өрнөлт
 - B. Сэргэлт
 - C. Уналт
 - D. Зогсонги байдал
 - A. 1A, 2B, 3C, 4D
 - B. 2A, 3B, 2C, 3D
 - C. 3A, 4B, 1C, 2D
 - D. 4A, 1B, 4C, 1D
28. Өмчлөгчийн аж байдал үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнгээс шууд хамааралтай байдаг нь хувийн өмчийн эерэг талыг тодорхойлдог.
29. Сонин хэвлэлд нийтлэгдсэн зар сурталчилгаа нь зах зээлийн бус үйл ажиллагаанд хамаарна.
30. Зах зээлийн эдийн засагт ямар бараа, үйлчилгээ үйлдвэрлэх асуудлыг эцсийн эцэст хэрэглэгчдийн хүсэл сонирхлоор шийддэг.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

1. Үүссэн баримтыг хаах команд аль вэ?
 - A. Office button-Save
 - B. Office button-print

- C.Office button-open
 - D. Office button-Close
 - E.Office button- New
2. Page Layout цэсний Page Setup командын үүрэг юу вэ?
- A.Баримтын хуудасны тохиргоог хийнэ
 - B.Идэвхтэй баримтыг хэвлэнэ
 - C.Баримтыг хэвлэхэд ямар гарахыг урьдчилан харна
 - D.Баримтын нэрийг өөрчилж хадгална
 - E.Баримтанд хүрээ оруулна
3. Сонгосон үгийг доогуур зураастай болгох
- A.Ctrl+C
 - B.Ctrl+V
 - C.Ctrl+Z
 - D.Ctrl+X
 - E.Ctrl+U
4. Дээд индекс хэлбэрт бичих команд аль вэ?
- A.Ctrl+Z
 - B.Ctrl+A
 - C.Ctrl+N
 - D.Ctrl+Shift++
 - E.Ctrl+Y
5. Доод индекс хэлбэрт бичих команд аль вэ?
- A.Ctrl+Z
 - B.Ctrl+=
 - C.Ctrl+N
 - D.Ctrl+Shift++
 - E.Ctrl+Y
6. Хүснэгтийн сонгосон нүднүүдийг мөр, багананд хуваахдаа аль командыг ашиглах вэ?
- A.Layout-Draw Table
 - B.Layout-Split Table
 - C.Layout-Split Cells
 - D.Layout-Merge Cells
 - E.Layout-Text Direction
7. Office Button цэсний Save As командын үүрэг юу вэ?
- A.Идэвхтэй баримтыг хэвлэнэ.
 - B.Баримтын нэрийг өөрчилж хадгална.
 - C.Баримтыг хэвлэхэд ямар гарахыг урьдчилан харна.
 - D.Баримтын хуудасны тохиргоог хийнэ.
 - E.Шинээр хуудас үүсгэнэ.
8. Page Layout-Page setup-Landscape командын үүрэг аль нь вэ?
- A.Цаасыг босоо болгох
 - B.Цаасыг хэвээ болгох
 - C.Хэвлэх тохиргоо
 - D.Цаасны хөл толгойн хэмжээ
 - E.Цаасанд тэмдэглэгээ хийх
9. Үгийг голлуулж бичих командыг сонгоно уу.
- A.Abc
 - B.Ctrl+E

- C.Ctrl+R
 - D.Ctrl+X
 - E.Ctrl+A
- 10.Баримтанд тэмдэгт ба томъёо оруулах командыг сонгоно уу.
- A.Insert –picture
 - B.Insert-Equation
 - C.Insert-Table
 - D.Insert-Clip art
 - E.Insert-Drop
- 11.Word программын цэсийг сонгоно уу.
- A.Reterences
 - B.Mailings
 - C.Review
 - D.Data
 - E.Formulas
- 12.Аль нь word программын цэс биш вэ?
- A.Reterences
 - B.Formulas
 - C.Review
 - D.Data
 - E.View
- 13.Баримтанд хөл толгой ямар командаар оруулах вэ?
- 1.Refences-Header Footer
 - 2.Insert–Header Footer
 - 3.View–Header Footer
 - 4.Review–Header Footer
 - 5.Home–Header Footer
- 14.Insert цэсний Symbol командыг үүрэг аль вэ?
- 1.Баримтад бэлэн текст оруулна
 - 2.Баримтын автоматаар дугаарлана
 - 3.Баримтанд системийн огноог оруулна
 - 4.Баримтанд гар товчлуур дээр байхгүй тэмдэгтүүдийг оруулна
 - 5.Баримтанд хөл толгойн бичлэг оруулна
- 15.Insert цэсийн page number командын үүрэг аль вэ?
- 1.Баримтанд текст оруулна
 - 2.Баримтанд автоматаар дугаарлана
 - 3.Баримтанд системийн огноог оруулна
 - 4.Баримтанд гар товчлуур дээр байхгүй тэмдэгтүүдийг оруулна
 - 5.Баримтанд хөл толгойн бичлэг оруулна.
- 16.Page Layout цэсний Watermark командын үүрэг аль вэ?
- 1.Сонгосон текстийн хүрээ ба дэвсгэрийн өнгийг тохируулна.
 - 2.Сонгосон текстийн фонд тохируулна.
 - 3.Сонгосон цаасны арын дэвсгэрт текст оруулна.
 - 4.Сонгосон параграфын хуудсан дахь байршлыг тохируулна.
 - 5.Мөр хоорондын зайг тохируулна.
- 17.Аль нь Word программын цэс биш вэ?
- 1.References
 - 2.Formulas
 - 3.Mailings
 - 4.Review

5. Page Layout

18. Сонгосон текстийг тод хар болгохын тулд гар товчлуурууд дээрээс ямар команд хийх вэ?
1. Ctrl+I
 2. Ctrl+U
 3. Ctrl+L
 4. Ctrl+B
 5. Ctrl+A
19. Сонгосон текстийг бүгдийн идэвхжүүлэх бол ямар команд хийх вэ?
1. Ctrl+L
 2. Ctrl+R
 3. Ctrl+E
 4. Ctrl+J
 5. Ctrl+A
20. Drawing tools-ийн үүрэг аль нь вэ?
1. Сонгосон объектыг огторгуйд дүрсэлнэ.
 2. Сонгосон объектыг сүүдэртүүлнэ.
 3. Тэгш өнцөгт зурна.
 4. Битүү мужийг будна.
 5. Өгсөн мужийг эргүүлнэ.
21. Shape Fill-дүрсийн үүрэг аль вэ?
1. Сонгосон дүрсийн зураасны өнгийг өөрчилнэ.
 2. Сонгосон текстийн фондны өнгийг өөрчилнэ.
 3. Сонгосон дүрсийн дэвсгэр өнгийг өөрчилнэ.
 4. Сонгосон дүрсийн дотор будна.
 5. Сонгосон үгийн дундуур зураас татна.
22. Хүснэгтийн сонгосон нүднүүдийг нэгтгэхдээ аль командыг ашиглах вэ?
1. Layout-Draw Table
 2. Layout-Split Table
 3. Layout Split Cells
 4. Layout Merge Cells
 5. Design-Draw table
23. Microsoft Word программын гол үүрэг нь юу вэ?
1. Хүснэгтэн мэдээлэлийг боловсруулна.
 2. Өгөгдлийг баазтай ажиллана.
 3. Бичиг баримтыг боловсруулна.
 4. Зургийн дизайн боловсруулна.
 5. Илтгэл бэлдэнэ.
24. Шинэ баримтыг гар товчлуураас хэрхэн хэвлэх вэ?
1. Ctrl+s
 2. Ctrl+N
 3. Ctrl+P
 4. Ctrl+O
 5. Ctrl+A
25. Зөв харгалзуулна уу.
1. Растр зургийн төрөл
 2. Хөдөлгөөнт зураг
 3. Гэрэл зурагт тохиромжтой төрөл, зураг бага зай эзэлдэг ч, чанартай харагддаг.
 4. Веб хэрэглээний файл
 5. Улаан, ногоон, цэнхэр өнгийг 8 бит, 16 битээр хадгалдаг төрөл
- A. *.JPEG, *.JPG

Б.*.TIFF

В.*.GIP

Г.*.PNG

Д.*.BMP

А.1д, 2в, 3а, 4г, 5б

В.1б, 2в, 3а, 4г, 5д

С.1г, 2в, 3а, 4д, 5б

Д.1а, 2в, 3д, 4г, 5б

Е.1в, 2д, 3а, 4г, 5б

26.Зөв харгалзуулна уу.

1.44,1 KHz, 16bit стерео форматад хадгалдаг CD бичлэгийн стандарт хэмжээ юм. Том хэмжээтэй файл үүсгэдэг.

2.Шахагдаагүй аудио файлыг CD –д багтааж бичдэг файлын төрөл

3.Дууны файл болон хатуу дискэнд бичлэгийг хадгалахад ашигладаг. Чанартай, нягтаршуулсан дуу бичлэгт хэрэглэдэг. 1 минутын бичлэгийг 1 мегабайтад хадгалдаг. Бага хэмжээтэй. DVD, CD бичлэгт тохиромжтой.

4.Хөгжим зохиох, программуудыг нэгтгэхэд ашигладаг дижитал хөгжмийн зэвсэгт хэрэглэдэг файлын төрөл

5.Windows-ын аудио файл юм. Чанарыг алдалгүйгээр аудиог шахдаг.

А.1. *.MID

В.2. *.AIF

С.4. *.WAV

Д.5. *.MP3

Е.6. *.WMA

А.1С, 2В, 3D, 4А, 5Е

В.1Е, 2В, 3D, 4А, 5Е

С.1А, 2В, 3D, 4А, 5Е

Д.1D, 2В, 3D, 4А, 5Е

Е.1В, 2В, 3D, 4А, 5Е

27.Зөв харгалзуулна уу.

1.Windows-ын медиа шахалтаар шахдаг. Анимэ Music Video форматаар шахсан видео файлууд байна.

2.Интернэтэд байрлах кино хийхэд зориулсан аудио болон видео файл юм.

3.Интернэт радио, бичлэгт ашигладаг. Файлын хэмжээ жижиг, чанар муутай.

А.*.RM

В.*.AVI

С.*.MOV

А.1А 2В 3С

В.1В 2С 3А

С.1С 2А 3В

Д.1А 2С 3В

Е.1В 2А 3С

28.Олон тооны компаний үйл ажиллагаанд сүлжээнүүд гол үүрэг гүйцэтгэдэг учраас бизнесийн компьютерийн сүлжээний сэдэв нь Мэдээллийн технологитой нягт холбоотой байдаг.

29.Интернетийн видеоны алдартай нь Интернет болон МТ-ийн сүлжээн дэх эрэлтийг ихээхэн нэмэгдүүлдэг учраас График, илүү гүнзгийрүүлсэн интерактив зэргийг дэмждэг программ хангамжийн шинэ төрлийн программууд нь их хэмжээний өгөгдөл үүсгэж, улмаар сүлжээний урсгалыг бий болгодог.

30.IT сүлжээний администраторууд нь уламжлалт компьютер, ажлын станцаас гадна өргөн хүрээний ухаалаг гар утас, таблетуудыг дэмжиж өгөх ёстой учраас МТ-ийн

орчинд роуминг чадвартай өндөр үзүүлэлт бүхий утасгүй халуун цэг шаарддаг.

АНГЛИ ХЭЛ

1. Which suffix means abnormal softening?
A. –malacia B.-megaly C.-sclerosis
2. In the term perinatal, which part is the suffix.
A. peri- B.nat C. -al
3. Which of these suffixes requires the use of the combining vowel.
A. –algia B.-otomy C.-rrhea
4. Which prefix means within or inside?
A. inter- B. intra- C. dia-
5. Postoperative means _____
A. of surgery B. before surgery C. after surgery
6. Which combining form means red?
A. erythr/o B. cyan/o C. leuk/o
7. A vertebra is a bone in the spine. What is the plural of vertebra?
A. vertebrae B. vertebri C. vertebrae
8. Which suffix means a surgical puncture to remove fluid for diagnostic purposes.
A. –scopy B. –clasis C. -centesis
9. Which combining form means both spinal cord and bone marrow?
A. my/o B. myc/o C. myel/o
10. The plural of phalanx is _____
A. phalanxes B. phalanges C. phalanxia
11. Which suffix means the process of recording a picture?
A. –gram B. –graphy C. -ology
12. What suffix means surgical repair?
A. -stomy B. –ectomy C. –plasty
13. Which is the correct meaning of the combining form clavicula/o?

A. clavicle B. pelvis C. fiber

14. Which is the correct meaning of the suffix – porosis ?

A. softening B. porous C. around

15. Which is the correct meaning of the suffix – syn?

A. to break B. union C. pain

MATCHING

- | | |
|------------------|---------------------------------------|
| 16. nephromegaly | A. softening of the bones |
| 17. osteomalacia | B. loosening of nerve |
| 18. cholelith | C. enlargement of the kidney |
| 19. neurolysis | D. fixation of the uterus |
| 20. dermatome | E. pertaining to the chest |
| 21. hysteropexy | F. separation of intestinal adhesions |
| 22. enterolysis | G. without or absence of speech |
| 23. erythropenia | H. instrument to cut skin |
| 24. myorrhaphy | I. suture of a muscle |
| 25. hemorrhage | J. deficiency in red blood cells |
| 26. thoracic | K. any congenital anomaly of the skin |
| 27. aphasia | L. a profuse discharge of blood |
| 28. primigravida | M. pertaining to the armpit |
| 29. nevus | N. gallstone |
| 30. axillary | O. woman during her first pregnancy |

АНАГААХЫН ФИЗИК

1. Рентген хальсны гадаргуу дээр туссан гэрлийн 10% нь хальсыг нэвтэрсэн бол оптик нягт нь хэд байх вэ?

- A. 0,33
- B. 0
- C. 1
- D. 0,5
- E. 2

2. Хийн хувийн дулаан шингээлтийн багтаамжийн зөв харьцаа аль вэ?

$$A. \gamma = \frac{C_p}{C_v}$$

$$B. \gamma = C_p * C_v$$

$$C. \gamma = \frac{P_0}{C_v}$$

$$D. \gamma = \frac{C_p}{C_v}$$

$$E. \gamma = \frac{V}{C_v}$$

3. Сахарын уусмалын концентрацийг тодорхойлох багажийг сонгоно уу.

A. Манометр

A. Полярметр

B. Психрометр

C. Динстметр

D. Гальванизаци

4. Үл мэдэгч уусмалын концентрацийн олох зөв томъёог сонгоно уу.

$$A. C_2 = \frac{\infty_1}{\infty_2} * C_1$$

$$B. C_2 = \frac{\infty_2}{\infty_1} * C_1$$

$$C. C_2 = \frac{\infty_1^2}{\infty_1} * C_1$$

$$D. C_2 = \infty_1 * \infty_2 * C_1$$

$$E. = \sqrt{\frac{\infty_2}{\infty_1}} * C_1$$

5. Шинжлэгч дээр туссан ба нэвтэрсэн гэрлийн эрчим тэнцүү байхад туйлшруулагч ба шинжлэгчийн гол оптик тэнхлэгүүдийн хоорондох өнцөг хэд байх вэ?

A. 0°

B. 40°

C. 25°

D. 45°

E. 90°

6. Хэрэв $\Delta\varphi=0$ бол электрон цацрагийн хөдөлгөөний траектор осциллографийн дэлгэц ямар байх вэ?

A. Эллипс гарна

B. Гантель хэлбэрийн дүрс гарна.

C. Тойрог гарна.

D. Шулуун гарна.

E. Нийлмэл муруй гарна.

7. Гальванизацын аппаратын гаралтын хүчдлийн зөв утгыг заана уу.

A. 220 В

B. 30-80 В

C. 50 мА-аас бага

D. 127 В

E. 50 мА-аас их

- 8.УВЧ - эмчилгээнд ямар физик факторыг ашигладаг вэ?
- Хэт өндөр давтамжийн соронзон оронг
 - Хувьсах соронзон оронг
 - Өндөр давтамжийн тасралтгүй үйлчлэх цахилгаан оронг
 - Хэт өндөр давтамжийн цахилгаан оронг
 - Хэт өндөр давтамжийн цахилгаан соронзон оронг
- 9.Поляриметрт анализатор тавьдгийн учир юу вэ?
- Гэрлийн янз бүрийн хэсгийг сайн харуулахын тулд
 - Гэрлийг туйлшралын хавтгайд параллелаар туйлшруулахын тулд
 - Туйлширсан гэрлийг гарган авахын тулд
 - Гэрэл туйлширсан эсэхийг шалгахын тулд
 - Туйлширлын хавтгайг эргүүлэхийн тулд
- 10.Биеийн нягт оптик нягт хоёр ямар хамааралтай байх вэ?
- Биеийн нягт их үед оптик нягт нь их байна.
 - Биеийн нягт их үед оптик нягт бага байна.
 - Шууд хамааралтай.
 - Урвуу хамааралтай.
28. Хэт томролт кардиомиопатийн үед зүрхний аль хана томордог вэ?

- A. Зүрхний ховдлын чөлөөт хана
 - B. Баруун ховдлын чөлөөт хана
 - C. Ховдол хоорондын таславч
 - D. Тосгуур хоорондын таславч
 - E. Тосгуур-ховдол хоорондын таславч
29. Архаг бронхитын үед амьсгуурт гарах гол өөрчлөлт юу вэ?
- A. Хундаган эсүүд олшрох
 - B. Уурагт найлзуурхай устгах
 - C. Сормууст эсүүд устгах
 - D. Хучуурын метаплази өөрчлөлт
 - E. Дисплази өөрчлөлт
30. Атеросклерозын эхэн шатанд судасны дотор давхарт гарах гол нэг өөрчлөлтийг нэрлэнэ үү.
- A. Өөхөн хуримтлал
 - B. Уян ширхэгийн тасрал
 - C. Кальцийн хуримтлал
 - D. Судасны нүхний нарийсал
 - E. Тромбо үүсэл
31. Хорт даралт ихдэлийн үед судсанд гарах гол өөрчлөлтийг бичнэ үү.
- A. Хиалин хатуурал
 - B. Судасны өөхлөлт
 - C. Судасны шохойжилт
 - D. Ширхэглүүрт төст үхжил
 - E. Судасны хананы зузаарал
32. Зүрхний шигдээс үүссэнээс хойш ямар хугацаанд нас барахад үхжлийн голомт цайвар өнгөтэй тодорч ялгарах вэ?
- A. 2 цагийн дараа
 - B. 8 цагийн дараа
 - C. 7 хоногийн дараа
 - D. 24 цагаас 3 өдрийн дотор
 - E. 5-10 өдрийн дотор
33. Уушги тэлэгдлийн ямар хэлбэр нь цээжний хөндийд агаар хурахад хүргэдэг вэ?
- A. Хэлтэнцрийн төвийн тэлэгдэл
 - B. Хэлтэнцрийн ханын тэлэгдэл
 - C. Таславч орчмын тэлэгдэл
 - D. Жигд бус тэлэгдэл
 - E. Бүх хэлбэрийн үед уг хэлбэр үүсэх боломжтой
34. Барретийн улаан хоолойн үед явагддаг метаплазийн төрлийг сонгоно уу.
- A. Олон давхар хавтгай хучуур эд -дан бортгон хучуур эдээр солигдох
 - B. Дан бортгон хучуур эд -Олон давхар хавтгай хучуур эдээр солигдох
 - C. Булчирхайлаг хучуур эд- Хавтгай хучуур эдээр солигдох
 - D. Шилжвэр хучуур эд -Хавтгай хучуур эд
 - E. Булчирхайлаг хучуур эд -өөр төрлийн булчирхайлаг хучуур эд
35. Архаг гастритийн В хэлбэрийн шалтгааныг заана уу.
- A. Аутоиммун
 - B. H.pylori
 - C. Эмийн бодис
 - D. Химийн бодис
 - E. Цөсний цорго
36. Бөөрний хөхлөгийн үхжил нь ямар эмгэгийн үед ажиглагддаг вэ?
- A. Цочмог түгмэл үржилт гломерулонефрит

- В.Цочмог пиелонефрит
 С.Бөөрний олон уйланхайжилт
 D.Архаг гломерулонефрит
 E.Голомтот сегментийн гломерулонефрит
37. Мембранжилт гломерулонефритийн үед электроны нягт тунадасжилт хаана тодорхойлогддог вэ?
 A.Суурь мембраны дотор
 B.Эндотелийн доогуур
 C.Подоцитийн хөлийн сэртэнгийн доогуур
 D.Подоцитийн хөлийн хоорондуур
 E.Мезангийн матрикст
38. Түүдгэнцрийн ямар эмгэгийн тохиолдол нь ДОХ-ын халдвартай хамааралтай үүсдэг вэ?
 A.Мембран үржилт гломерулонефрит
 B.Голомтот сегментийн гломерулосклероз
 C.IgA-ын нефропати
 D.Чихрийн шижингийн нефропати
 E.Хурдан давших гломерулонефрит
- 39.Бодисын солилцооны хүчилшлийг хэрхэн ангилдаг вэ?
 A.Анионы завсарт ба хэвийн анионы завсарт
 B.Давсний уусмалд хариу урвалтай ба тэсвэртэй
 C.Анхдагч хямрал ба ээнэгшлийн хариу үйлдэл
 D.Анхдагч ба хоёрдогч
 E.Бөөрний ба уушгины шалтгаант
40. Голомтлог ГН-ийн онцлогийг заана уу.
 A. Кресцент хэлбэрийн үржил явагдана
 B. Гуд-Пасчерийн хам шинжийн үед тохиолдоно
 C. Үрэвссэн түүдгийн нэг эсвэл хоёр хэлтэнцэрт өөрчлөлт илэрнэ.
 D. Проксималь тахир сувганцрын эсүүдэд өөхөн дусал үүснэ
 E. Мөнгөлөх аргаар судлахад суурин мембран зузаарч “төмөр зам” мэт зураглал илэрнэ
41. Эмгэг судлалын шинжлэх ухааны судлагдахууныг заана уу.
 1. Шалтгаан
 2. Эмгэг жам
 3. Морфологийн өөрчлөлт
 4. Эмнэлзүйн илрэл
 5. Эмчилгээний менежмент
42. Өвчин үүсгэгч олдмол шалтгааны жишээг сонгоно уу.
 1. Халдвар
 2. Химийн хүчин зүйл
 3. Физикийн хүчин зүйл
 4. Тэжээлийн илүүдэл
 5. Тэжээлийн хомсдол
43. Задлан шинжилгээний ач холбогдолыг заана уу.
 1. Нас баралтын шалтгааныг тогтоох
 2. Эмнэлзүйн оношилгоонд нарийвчилсан хяналт тавих
 3. Төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын оюутнуудын сургалт явуулах
 4. Аливаа өвчин эмгэгийн шалтгаан, механизмыг илрүүлэн судлах

5. Өвчний статистик мэдээ цуглуулах
44. Өвчтөнөөс авсан эдийг гарлаар нь хэрхэн ангилах вэ?
1. Задлан шинжилгээний
 2. Мэс заслын эмчилгээний
 3. Оношилгооны
 4. Аналог загварын
 5. Эсийн өсгөврийн
45. Эсийн гэмтээгч халдвар үүсгэгчдийг нэрлэнэ үү.
1. Вирус
 2. Нян
 3. Шимэгч хорхой
 4. Мөөг
 5. Эгэл биетэн
46. Эсийн эргэх гэмтлийн бүтцийн өөрчлөлтийг нэрлэнэ үү.
1. Митохондрын хөөлт
 2. Эндоплазмын торны хөөлт
 3. Мембраны цэврүүшил
 4. Хроматины бөөгнөрөл
 5. Миелин дүрс
47. Эсийн үл эргэх гэмтлийн бүтцийн өөрчлөлтийг нэрлэнэ үү.
1. Хроматины бөөгнөрөл
 2. Мембран задрал
 3. Митохондрын хөөлт
 4. Лизосомын задрал
 5. Мембраны цэврүүшил
48. Эмгэг дасан зохицолын хэлбэрүүдийг сонгоно уу.
1. Хэт томрол
 2. Хэт үржил
 3. Хатингаршил
 4. Метаплази
 5. Дисплази
49. Хэт томролын үед гарах бүтцийн өөрчлөлтүүдийг заана уу.
1. Бүтцийн уургуудын нийлэгжил ихсэх
 2. Эрхтэнцэрүүд олширно
 3. Эсийн эзэлхүүн ихсэх
 4. Ubiquitin-уургийн бүрдэл ихсэх
 5. Эсийн үржил ихсэх
50. Аль нь хангалтгүй тэжээлээс үүсэх хатингаршлын жишээ вэ?
1. Цэвэршилт
 2. Хөгшрөл
 3. Тураал
 4. Тархины усжил
 5. Бөөрний усжил
51. Цочмог үрэвслийн онцлогийг нэрлэнэ үү.
1. Огцом өрнөдөг
 2. Хүчтэй явагддаг
 3. Шүүрэл ихтэй
 4. Богино хугацаагаар үргэлжилдэг
 5. Мононуклеар эсүүд давамгайлдаг
52. Фагоцитоз нь ямар үе шатаар өрнөдөг вэ?
1. Байтайгаа хүрэлцэх

2. Байгаа таних
 3. Бай залгих
 4. Фаголизосомын цэврүү
 5. Залгисан материаллыг боловсруулах
53. Хавдар үүсгэх шалтгаан хүчин зүйлийг сонгоно уу.
1. Нас
 2. Цацраг туяа энерги
 3. Удамшил
 4. Химийн хүчин зүйл
 5. Хүрээлэн буй орчны хүчин зүйл
54. Хавдрын үсэрхийлэл ямар замаар тархдаг вэ?
1. Хавсарч
 2. Цусны судсаар
 3. Тунгалгийн судсаар
 4. Гялтан хальсаар
 5. Мэдрэлийн судсаар
55. Хавдрыг ургалтаар хэрхэн ангилдаг вэ?
1. Түлхэх
 2. Гадраасаа шилжих ургалт
 3. Эвдрэлт ургалт
 4. Нэг голомтот ургалт
 5. Олон голомтот ургалт
56. Н.Рylogi нь ямар хавдрын шалтгаан болдог вэ?
1. Т эсийн лимфома
 2. В эсийн лимфома
 3. Улаан хоолойн хавтгай эст өмөн
 4. Ходоодны аденокарцинома
 5. Амны хөндийн хавтгай эст өмөн
57. Хоргүй хавдрын онцлогийг сонгоно уу.
1. Үсэрхийлдэггүй
 2. Түлхэж ургадаг
 3. Митоз хуваагдал бага
 4. Орчны эдээсээ эрс зааглагдсан
 5. Нэвчиж ургадаг
58. Атеросклерозын үед ямар судсанд эмгэг өөрчлөлт үүсдэг вэ?
1. Том уян артери
 2. Том булчинлаг артери
 3. Дунд зэргийн голчтой булчинлаг артери
 4. Жижиг булчинлаг артери
 5. Хялгасан судас
59. Атеромын бүтцүүдийг сонгоно уу.
1. Холестролын цөм
 2. Хөөсөрхөг эсүүд
 3. Сорвит бүрхүүл
 4. Тромбоцит
 5. Их нягтралт липопротеин
60. Венийн судасны онцлогийг сонгоно уу.
1. Зузаан ханатай
 2. Том голчтой
 3. Өндөр даралтанд тэсвэртэй
 4. Нимгэн ханатай

- 5.Бага даралттай
61. Атеросклерозын үе шатыг сонгоно уу.
1. Өөхөн толбо
 2. Сорвит товруу
 3. Сэдрэл гэмтэл
 4. Шимэгдэлт
 5. Хөөсөрхөг эсүүд
62. Гуурсан хоолойн архаг үрэвслийн шалтгааныг сонгоно уу.
1. Тамхидалт
 2. Агаарын бохирдол
 3. Халдвар
 4. Хавдар
 5. Харшил
63. Гуурсан хоолойн багтраа өвчинтэй холбоотой зөв ойлголтыг сонгоно уу.
1. Гуурсан хоолойн гөлгөр булчин хэт томрох
 2. Салстын доорх давхаргын булчирхайнуудын хэт үржил
 3. Куршманы мушгиа тодорхойлогдох
 4. Цэрэнд Шаркот-Лейдений талст тодорхойлогдох
 5. Дунд эрэмбийн гуурсан хоолойг хамрах
64. Уушги тэлэгдлийн шалтгааныг сонгоно уу.
1. Агаарын бохирдол
 2. Тамхидалт
 3. Халдвар
 4. α 1-антитрипсины дутагдал
 5. Шалтгаан тодорхойгүй
65. Голомтот хатгаа аль сегментүүдэд голчлон тохиолддог вэ?
1. 2
 2. 6
 3. 8
 4. 9
 5. 10
66. Архаг бронхитийн үед микрод гарах өөрчлөлтийг нэрлэнэ үү.
1. Хундган эс ихэснэ, Сормууслаг эс буурна
 2. Лимфоцит болон сийвэнт эс ихсэнэ
 3. Салсархаг булчирхайн ихсэнэ, уураглаг булчирхай буурна
 4. Гуурсан хоолойн деструкци
 5. Салст бүрхүүлийн хаван
67. Гуурсан хоолойн өмөнгийн шалтгааныг сонгоно уу.
1. Тамхидалт
 2. Агаарын бохирдол
 3. Ионжуулагч цацраг
 4. Асбестоз
 5. Хром
68. Гуурсан хоолойн архаг үрэвслийн үед ямар эмгэг өөрчлөлт бий болдог вэ?
1. Мукоид метаплази
 2. Сормууст эсийн цөөрөл
 3. Гөлгөр булчингийн хэт томрол
 4. Уян ялтасны үрэвсэлт эвдрэл
 5. Салстын доод давхрын булчирхайн хэт үржил
69. Цочмог бронхитийн үед гарах микро өөрчлөлтийг заана уу.
1. Хучуур эдийн гуужилт

2. Нейтрофилийн олшрол
 3. Судасны зогсонгошил
 4. Салсархаг уураглаг шүүрэл ихсэх
 5. Гуурсан хоолойн деструкци (эвдлэл) үүсэх
70. Архаг бронхитийн үед микрод гарах өөрчлөлтийг нэрлэнэ үү.
1. Хундаган эс, сормууст эс
 2. Лимфоцит болон сийвэнт эс
 3. Салсархаг булчирхай, уураглаг булчирхай
 4. Гуурсан хоолойн деструкци
 5. Хучуур эдийн метаплази
71. Голомтот хатгаа ямар хүмүүст голчлон тохиолддог онцлогтой вэ?
1. Архаг тамирдуулагч өвчтэй
 2. Хүүхэд
 3. Настай хүмүүс
 4. Вирусын халдварын дараа
 5. Хэвтэрийн хүмүүс
72. Дэлбэнгийн хатгаан үүсгэгчийн онцлогийг заана уу.
1. II, I хүрээний пневмококк
 2. Ланцетник хэлбэртэй
 3. Гадуураа бүрхүүлтэй
 4. Цэрийг граммаар будахад нейтрофилийн дотор үүсгэгч нь илэрнэ
 5. Диплококк
73. Цочмог бронхитийн шалтгааныг заана уу.
1. Томуугийн вирус
 2. Аденовирус
 3. Риновирус
 4. Корановирус
 5. Микоплазм
74. Архаг гастритийн В хэлбэртэй холбоотой зөв ойлголтыг сонгоно уу.
1. Салстын жинхэнэ ялтаст лимфоцитын нэвчдэстэй
 2. Лимфойд бөөгнөрөл
 3. Салстын цэлмэнд H.pylori тодорхойлогдоно
 4. G-эсийн хэт үржил
 5. Ходоодны ёроол хэсэг
75. Ходоодны өмөнгийн шалтгааныг сонгоно уу.
1. Нитрозамин агуулсан хоол хүнс
 2. Хэт их натрийн хэрэглээ
 3. Архаг гастрит В хэлбэр
 4. Архаг гастрит А хэлбэр
 5. Пепсиний шархлаа
76. Ходоодны өмөнгийн гэдэсний хэлбэрийн онцлогийг нэрлэнэ үү.
1. Ходоодны гарах хэсэг болон нугалуур хэсэгт ургана
 2. Төвдөө үхжил агуулна
 3. Хорт хавдрын эсүүд нь булчирхайлаг бүтэц үүсгэнэ
 4. Хавдрын эсүүд нь салст ялгаруулна
 5. Хавдрын эсүүд тамгат бөгж шиг харагдана
77. Цочмог пиелонефритийн хүндрэлд аль нь хамаарагддаг вэ.
1. Пионефроз
 2. Бөөрний эргэн тойрны өөхөн эдийн халдвар
 3. Хөхлөгийн үхжил
 4. Сувганцрын цочмог үхжил

5. Бөөрний архаг дутмагшил
78. Архаг пиелонефритийн үед ямар эмгэг өөрчлөлт илэрдэг вэ?
1. Тэгш бус хэмтэй гүнзгий сорви
 2. Сувганцарт хүчиллэг уураглаг материал хурах
 3. Завсрын эдийн сорвижил
 4. Сувганцрын хатингаршил
 5. Түүдгэнцрийн хатингаршил
79. Сувганцрын цочмог үхжлийн үед ямар эмгэг өөрчлөлтүүд тодорхойлогддог вэ?
1. Сувганцрын эпителийн голомтлог үхжил
 2. Суурь мембраны задрал
 3. Цуглуулах сувганцарт хүчиллэг хиалин бортого үүсэх
 4. Сувганцар тэлэгдэж, бамбайн фолликултай адил болгох
 5. Сувганцрын шоо дөрвөлжин хучуур эс бортгон эсүүдээр солигдох
80. Lg А-ын нефропатид хүргэдэг эмгэгүүдийг нэрлэнэ үү.
- 1.Томуу төст хамшинж
 - 2.Хенох-Шенлейны пурпур
 - 3.Амьсгалын дээд замын халдвар
 - 4.Ходоод гэдэсний замын халдвар
 - 5.Альпортын хам шинж
81. Эсийн эрхтэнцэрүүдийн гэмтлийн үр дагаврыг уялдуулна уу.
- 1.Эсийн мембран
 - 2.Митохондр
 - 3.Эндоплазмын тор
 - 4.Бөөм
 - 5.Эсийн араг
- A.Мембран гэмтэх
 B.Эсийн амьсгал алдагдах
 C.Удамшлын аппаратын нэгдмэл байдал
 D.Уургийн нийлэгжил алдагдах
 E.Осмосын тэнцвэр алдагдах
- A.1e.2d.3a.4c.5b
 B.1d.2a.3c.4b.5e
 C.1e.2b.3d.4c.5e
 D.1d.2e.3g.4b.5c
 E.1c.2d.3e.4a.5b
82. Дасан зохицолын хэлбэрүүдийг тохирох тайлбартай нь уялдуулна уу.
- 1.Хэт үржил
 - 2.Хэт томрол
 - 3.Хатингаршил
 - 4.Завсрын үржил
- A.Эдийн хувирал
 B.Эсийн тоо олшрох
 C.Эсийн хэмжээ томрох
 D.Эсийн хэмжээ болон үйл багасах
- A.1b.2c.3d.4a
 B.1c.2d.3a.4d
 C.1a.2b.3c.4d
 D.1b.2a.3d.4c
83. Доорх нэршлийг хооронд нь уялдуул.
- 1.Колликваци
 - 2.Гангрена

- 3. Decubitas
- 4. Секвестр
- 5. Коагуляци
- A. Илжрэл
- B. Цоорол
- C. Чийглэг, нойтон үхжил
- D. Тасархайтал
- E. Ээдэх үхжил
- A. 1c.2b.3a.4e.5d
- B. 1c.2a.3b.4d.5e
- C. 1c.2a.3b.4c.5d
- D. 1d.2a.3b.4c.5e
- E. 1e.2b.3a.4d.5c

84. Дараах нэршлийг тайлбарлана уу.

- 1. Calor
- 2. Rubor
- 3. Tumor
- 4. Dolor
- A. Улайх
- B. Хавдах
- C. Өвдөх
- D. Халах
- A. 1a.2b.3c.4d
- B. 1b.2c.3d.4a
- C. 1c.2d.3a.4b
- D. 1d.2a.3b.4c

85. Дараах нэршлийг хооронд нь харгалзуулна уу.

- 1. Метаплази
- 2. Дисплази
- 3. Неоплази
- 4. Атипизм
- 5. Проплази
- A. Боловсорч хөгжсөн нэг эсийн төрөл өөр төрлөөр солигдох
- B. Давхар хавтгай хучуур эд дан бортгон эсээр солигдох
- C. Хавдар
- D. Эсийн гаж хувирал
- E. Хэв шинжгүйдэл
- A. 1a 2c 3b 4e 5d
- B. 1d 2c 3b 4a 5e
- C. 1c 2b 3a 4e 5d
- D. 1a 2d 3c 4e 5b
- E. 1d 2c 3a 4b 5e

86. Дараах хоргүй хавдрууд нь ямар эд эсээс гаралтай вэ?

- 1. Фибром
- 2. Липома
- 3. Остеома
- 4. Хемангиома
- 5. Менингиома
- A. Ясны эд
- B. Цусны судас
- C. Ширхэглэг холбогч эд

- D. Тархины бүрхүүл
- E. Өөхний эд
 - A. 1c 2e 3a 4b 5d
 - B. 1c 2d 3e 4a 5b
 - C. 1e 2d 3a 4b 5c
 - D. 1e 2a 3b 4d 5c
 - E. 1a 2d 3e 4b 5c

87. Зүрхний булчингийн шигдээсийн үед микрод гарах өөрчлөлтийг цаг хугацаатай нь тохируулна уу

1. 4-24 цаг
2. 1-3 хоног
3. 4-7 хоног
4. 1-3 долоо хоног
5. Хэдэн сар

- A. Сорви
- B. Фибробластын бөөгнөрөл, коллаген, цусны судасны ихсэл бүхий мөхлөгт эд
- C. Макрофагийн нэвчдэс
- D. Бүлэгнэх үхжил
- E. Нейтрофилийн нэвчдэс
 - A. 1b 2a 3c 4d 5e
 - B. 1a 2b 3c 4d 5e
 - C. 1e 2a 3b 4c 5d
 - D. 1d 2e 3c 4b 5a
 - E. 1b 2c 3a 4e 5d

88. Дэлбэнгийн хатгааны үе шатыг гарах өөрчлөлттэй нь харгалзуулна уу.

1. Цус зогсонгишил
2. Улаан элэгжил
3. Саарал элэгжил
4. Шимэгдэл
 - a. Цулцангийн хөндий дэх шингэн эргэн шимэгдэж, зарим нь цэрээр гадагшлах
 - b. Цулцангийн хөндийд улаан эс, нейтрофил агуулагдана
 - c. Цулцангийн хөндийд шингэн хурж, уушги хүнд улаан болно
 - d. Цулцангийн хөндийд фибрин, макрофаг агуулагдана
 - A. 1c 2b 3d 4a
 - B. 1b 2c 3a 4d
 - C. 1c 2d 3b 4a
 - D. 1d 2c 3a 4b

89. Морфогенезийн алдаануудыг зөв ухагдахуунтай нь холбоно уу.

- | | |
|---------------|------------------|
| 1. Agenesis | A. Үүсэлгүйтэл |
| 2. Aplasia | B. Дутуу хөгжил |
| 3. Hypoplasia | C. Битүүрэл |
| 4. Ectopia | D. Хөгжилгүйтэл |
| 5. Atresia | E. Гадна байрлал |
- A. 1a 2b 3c 4d 5e
 - B. 1b 2d 3e 4a 5c
 - C. 1b 2a 3d 4e 5c
 - D. 1d 2a 3b 4e 5c
 - E. 1a 2d 3b 4e 5c

90. Доорхи үхжлийн нэршлийг хооронд нь уялдуулна уу.

1. Эдэмцэрт A. Fat necrosis
2. Бүлэгнэх B. Caseous necrosis

- 3.Өөхөн C.Sequester
 4.Тасархай D. Coagulative necrosis
 5.Ширхэглүүр төст E. Fibrinoid necrosis

- A.1b 2d 3a 4c 5e
 B.1d 2b 3a 4c 5e
 C.1d 2b 3a 4e 5c
 D.1a 2b 3c 4d 5e
 E.1d 2a 3b 4e 5c

91. Эсэд энерги дутагдахад протеосом нь эсийн доторх дурын уургуудыг задлах байдлаар энерги үйлдвэрлэдэг. Учраас эсийн бүтцийн болон үйл ажиллагааны уургууд дутагдаж улмаар эс үхнэ.
92. Эсийн эргэх гэмтлийн үед барзгар ЭПТ нь хөөж түүний рибосомууд нь ховхордог Учир уураг нийлэгжүүлэх үйл ажиллагаа нь сулардаг.
93. Умайн гөлгөр булчингийн эсийн хоргүй хавдар болох леймиома нь жмрэмслэлтийн үед нэлээд хурдан ургадаг Учир нь: энэ үед дааврын нөлөөгөөр хортой хавдарт илэрдэг.
94. Хоргүй хавдар томрох тусмаа тэжээж байгаа судсаа дардаг Учраас цус хомсролын үхжилд орох эрсдэлтэй.
95. Цочмог үржилт гломерулонефритийн үед Баумены бүрхүүл цусаар дүүрдэг. Учраас бөөрний гадаргуу нь цэгчилсэн цус харвалттай цоохортож харагдана.
96. Стрептококкын халдварын дараах гломерулонефритийн үед түүдгэнцэр эсжилт ихтэй болдог. Учраас үүнийг эсжилт ихтэй болдог. Үүнийг үржилт гломерулонефрит гэж нэрлэнэ.
97. Барретийн улаан хоолой нь улаан хоолой нь доод 1/3-д үүсдэг. Учир нь энэ нь ходоод-улаан хоолойн архаг сөргөө өвчний хүндрэл юм.
98. Улаан хоолойн ахалазийн үед булчингийн давхар дахь мэдрэлийн сүлжээ үгүй болдог. Учраас улаан хоолой агшилт хийх чадваргүй болдог.
99. Архаг бронхит нь голдуу 20-оос доош насныханд тохиолдоно. Учир нь насанд хүрэгчдэд салстын хамгаалах чадвар сайн хөгжсөн байдаг.
100. Архаг бронхитийн үед аажмаар бага эргэлтийн дутагдалд хүрдэг. Учир нь гиповентиляцын нөлөөгөөр гипокси үүсч, хялгасан судсууд рефлексийн дагуу агшина.

СУВИЛАХУЙ

- 1.Дорж 70 настай эрэгтэй цөсний чулуутай хурц өвдөлтийн үед аль эмийг хэрэглэж болохгүй вэ?
- A. Атропин
 B. Папаверин
 C. Нитроглицерин
 D. Морфин
 E. Анальгин
- 2.Дулмаа 60 настай эмэгтэй хэт авиан шинжилгээгээр цөсны хүүдийд жижиг чулуу илэрсэн ямар эмчилгээ хийж болохгүй вэ?
- A. Булчин сулруулах эмүүд
 B. Новокайны хориг
 C. Антибиотик
 D. Өвчин намдаах эмүүд
 E. Цөс хөөх эмүүд
3. Сорил тарилгыг хэдэн хэмийн өнцөгөөр хийх вэ?
- A. 90 хэм
 B. 45-60 хэм
 C.10-15 хэм
 D. 3-5 хэм

- Е. 5-10 хэм
4. Сувилгааны үйл ажиллагааны “Үнэлгээний” шатлалын үед эх баригч юу хийх ёстой вэ?
- А. Шийдвэрлэсэн асуудалд үнэлгээ өгөх
 - В. Тавьсан сувилгааны оношид үнэлгээ өгөх
 - С. Өвчтөн үзэж үнэлгээ өгөх
 - Д. Сувилгааны төлөвлөгөөний боловсруулалтанд үнэлгээ өгөх
 - Е. Бүгд зөв
5. Арьсан дор тариа хийхэд хэрэглэх тохиромжтой зүүг сонгоно уу.
- А. 18-20G
 - В. 20-22G
 - С. 23-24G
 - Д. 25-26G
6. Халуун жин тавих хугацааг заана уу.
- А. 10-30 мин
 - В. 2-3 цаг
 - С. 30 мин -1 цаг
 - Д. 3-3,5 цаг
 - Е. 4 цагаас дээш
7. Үйлчлүүлэгчийн өтгөн хатсан үед ямар сувилгааг хийх вэ?
- А. Клизм тавих
 - В. Өвчин намдаах эм өгөх
 - С. Үйлчлүүлэгчийг алхаж явуулах
 - Д. Оронд хэвтүүлэх
8. Сувилгааны төлөвлөгөөг боловсруулахдаа хэнд зориулж боловсруулдаг вэ?
- А. Хүнд өвчтөнд
 - В. Ухаангүй өвчтөнд
 - С. Өндөр настанд
 - Д. Бүх өвчтөнд
 - Е. Хөнгөн өвчтөнд
9. Эрэгтэй хүнд шээлгүүрийг ямар хэмжээтэй тавих вэ?
- А. 3-4 см
 - В. 18-20 см
 - С. 5-10 см
 - Д. 10-15 см
 - Е. 15-18 см
10. Орыг ариутгахдаа ариутгалын уусмалыг цэвэрлэгээний хэдийд нь хэрэглэдэг вэ?
- А. Угаалгын эхэнд
 - В. Угаалгын явцад
 - С. Бүгдийг нь угааж цэвэрлэсний дараа
 - Д. Угаалга хийхийн урьд өдөр
11. Сорил тарилгын үед хэрэглэх зүүний хэмжээг заана уу.
- А. 20G
 - В. 22 G
 - С. 26 G
 - Д. 23 G
 - Е. 21 G
12. Нуралтын үед доорх шинж тэмдгүүдийн аль нь илэрвэл хөдөлгөөнийг хязгаарлах вэ?
- А. Улайгаад хорсож эхлэнгүүт
 - В. Улайсан арьс хагарч өнгөц зулгарсан бол

- С. Явахад хөндүүрлэж үрэвслийн шинж илэрвэл
D. Үрэвслийн шинж тэмдэг хүндэрсэн тохиолдолд
13. Гич тавих зөв заалтыг олно уу.
A. Уушигны хорт хавдар өвчний үед
B. Цустай цэр гарч байгаа үед
C. Уушигны үрэвсэлт өвчний үед
D. 38-аас дээш хэм халуунтай үед
14. Тариаг түргэн шахвал ямар хүндрэл өгдөг вэ?
A. Цусны урсгалд хийн бөглөө үүснэ
B. Шокод орж болно
C. Цусан үжил үүснэ
D. Цус эд эсээр бөглөрч болно
15. Гепарин эмчилгээний хүндрэлийг нэрлэнэ үү.
A. Харшил
B. Халуурах
C. Цус алдах
D. Бөөлжих
16. Арьсан дор тариаг ямар давхаргад хийдэг вэ?
A. Торлог давхарга
B. Суурийн давхарга
C. Өөхөн давхарга
D. Өргөст давхарга
17. Зөөлөн эдүүд норж хоорондоо шүргэлцсэний улмаас үүсч байгаа арьсны өөрчлөлтийг юу гэдэг вэ?
A. Нуралт
B. Холголт
D. Цооролт
E. Улайлт
18. Өндөр халууралтанд хэдэн хэм орох вэ?
A. 37,5-38
B. 38-38,5
C. 38,5-39,5
D. 39,5-41
E. 41 дээш
19. Цэвэрлэх бургуй тавихад өвчтөний байрлал ямар байх вэ?
A. Босоо
B. Хэвтээ
C. Баруун хажуугаар
D. Зүүн хажуугаар
E. Өвдөг тохойн байрлал
20. Сорил тариаг зөв хийгдсэн эсэхээ та яаж мэдэх вэ?
A. Өвчтөнд бага зэргийн өвдөлт өгнө.
B. Хэсэг газар улайна.
C. Арьсан дээр жижиг цэврүү үүснэ.
D. Тарих үед халуун оргино.
21. Эх баригч нь сувилгааны төлөвлөгөө боловсруулахдаа хэрэгцээний эрэмбийн онолыг ашигладаг. Хэрэгцээний эрэмбийн онолыг зохиосон хүнийг нэрлэнэ үү.
A. Ричард Калиш
B. Жим Оттери
C. Абрахам Маслоу
D. Доротеа Орем

- Е. Рутвайт
22. Сорил тарилгын үед хэрэглэх уусмалын хэмжээг заана уу.
А. 1-2 мл
В. 0,3-0,5 мл
С. 0,5-1 мл
D. 0,1-0,3мл
E. 0,2-0,3 мл
23. Венийн судсанд тарилга хийх үед асептик зарчим алдагдвал доорхи хүндрэлүүдээс аль нь тохиолдох вэ?
А. Сепсис
В. Абсцесс
С. Шок
D. Эмболи
E. Тромбо
24. Сувилгааны явцын эхний үе шат болох “ Үнэлгээний “ үед сувилагч юу хийх вэ?
А. Ажилдаа шууд орно. (Үйл ажиллагаагаа эхэлнэ)
В. Сувилгааны оношийг тавина
С. Сувилгааны төлөвлөгөөг боловсруулна
D. Сувилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ
E. Өвчтөнөө үзэж үнэлгээ өгөх
25. Гич нь цочроох үйлчилгээгээ хэдэн хэмд алддаг вэ?
А. 50^С
В. 45^С
С. 60^С
D. 55^С
E. 40^С
26. Арьсан дотор тарилга хийх талбайг нэрлэнэ үү.
А. Далны арьсан дор
В. Гуяны арьсан дор
С. Гарын шууны 1/3
D. Бугалганы арьсан дор
E. Хэвлийн хэсгийн арьсанд
27. Цооролт гэж юуг хэлэх вэ?
А. Хэсэг газар удаан хугацаагаар дарагдаж, тэжээлгүйдэж үхжил үүсэх
В. Нимгэн арьстай гэзрын арьс үрэгдэж үрэвсэх
С. Хэсэг газар удаан хугацаагаар үрэгдэж, арьс улайж, хавагнах
D. Удаан хугацаагаар нэг байрлалд хэвтсэн газар улайх
28. Сувилгааны үйл ажиллагаа гэж юу вэ?
А. Сувилахуйн тусламж үзүүлэх дэс дараалалтай үйл ажиллагаа
В. Хүмүүст тусламж үзүүлэхэд чиглэгдсэн сувилахуйн ажлын төлөвлөгөө
D. Хүн нэг бүрд сувилахуйн тусламж үзүүлэх тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм
E. Хүнийг тайвшруулахад чиглэсэн үйл ажиллагаа юм.
29. Даралтны аппаратын манжетийг хэдэн мм секундэнд суллах вэ?
А. 2 мм сек
В. 3 мм сек
С. 4 мм сек
D. 6 мм сек
30. Пульсийн даралтын зөрүү хэд байвал хэвийн гэж үзэх вэ?
А. 20-30
В. 10-15

- С. 15-20
D. 20-25
E. 40-50
31. Бичил бургуйг юугаар тавибал тохиромжтой вэ?
A. Ургамлын тосоор
B. Савангийн уусмалаар
C. Содын уусмалаар
D. Буцалсан усаар
E. Бүгд зөв
32. Цэвэрлэх бургуй тавихад хэдэн литр ус хэрэглэх вэ?
A. 1-2 л
B. 0,3-0,5 л
C. 3 л
D. 5-8 л
33. Биологийн сорил үзэхэд цусыг судсанд яаж явуулах вэ?
A. Урсгаж явуулах
B. 1 минутанд 20-30 дусал
C. 1 минутанд 40-60 дусал
D. 1 минутанд 10-20 дусал
E. 1 минутанд 30-40 дусал
34. Цусны бүлгийг анх хэн хэдэн онд 3 бүлэг гэж нээсэн бэ?
A. 1628 онд эрдэмтэн Гарвей
B. 1832 онд эрдэмтэн Вольф
C. 1901 онд Ландштейнер
D. 1901 онд Ян-Янский
35. Булчин тариа хийх үед яагаад тромбо үүсдэг вэ?
A. Асептик зарчим алдагдснаас
B. Судас дайрсан эсэхийг шалгаагүй хийснээс
C. Тосон тариаг хийтэй шахснаас
D. Тосон тариа хийснээс
E. Тосон тариаг бүлээсгэж хийгээгүйгээс
36. Үйлчлүүлэгч 15 настай өрхийн эмнэлэгт халуурсан өгүүлэмжтэй та халууралтын үед илрэх үндсэн шинж тэмдгийг нэрлэнэ үү.
A. Хүний бие махбодид хүрэхэд хүйтэн байна
B. Судасны цохилт, амьсгалын тоо хэвийн
C. Ам хатаж толгой өвдөнө
D. Хоолны дуршил сайн
E. Нойргүйтнэ
37. Сувилагч гардан ур чадварт хэрхэн суралцах вэ?
A. Үйлдлийг олон дахин давтан, чин сэтгэлээсээ гүйцэтгэх
B. Сувилагч нарын туршлагаас судлах, суралцах, илүү унших
C. Алдаан дээрээ ярилцах, мэтгэлцэх
D. Өөрийн туршлагаа баяжуулах
E. Сургалтын кино үзэж, ном сэтгүүл ашиглах
38. Настан Д. 65 настай. Удаан хугацаагаар хэвтэрт байсны улмаас цооролт үүсч эхэлж байгаа. Сувилагч та цооролт үүсэх эхний үед ямар арга хэмжээ авах вэ?
A. Асаргаа сувилгааг зогсоох
B. Цооролт үүсэж байгаа хэсэгт эмчилгээ хийхгүй
C. Цооролт үүсгэж эхлэхэд иод, марганцийн уусмалаар арчих сувилгааг сайн хийх
D. Янз бүрийн биологийн идэвхит тос хэрэглэх
E. Мэс заслын эмчилгээ

39. Халуун бигнүүрт аль нь хамаарагдах вэ?
- Халуун шүршүүр
 - Халуун ус
 - Бүлээн устай ванн
 - Халуун усанд норгосон алчуур
 - Лааны тос
40. Наран 70 настай элэгний сорвижилт өвчнөөр олон жил өвдөж байгаа та дараах тохиолдолд ямар асаргааны зарчим баримтлах вэ?
- Эмчилгээний хоол №5, хоолны дэглэм сахиулна
 - Хүчтэй хөдөлгөөн хийлгэнэ
 - Өтгөн бөөлжисний өнгө тогтоцыг хянахгүй
 - Өвчтөнд байрлал хамаарахгүй
 - Арьс салстыг өнгө хэвийн
41. Амьсгалын хэлбэрүүдийг нэрлэнэ үү.
- Цээжний
 - Хэвлийн
 - Холимог
 - Тазны
 - Өрцний
42. Монхор 70 настай эрэгтэй сахарын өвчтэй, дархлаа муу, шарх эдгэхгүй, толгой нүүрээр шарх гарна, даралт ихдэнэ, зүрхээр хатгуулна, 5 жилийн өмнөөс өвчилсөн, хөл явахаар өвдөнө гэсэн зовиуртай тул сувилахуйн тусламж үзүүлнэ үү.
- Шээсний сүв бэлэг эрхтний орчмыг цэвэр усаар угааж арчилна.
 - Арьсны идээт үрэвсэл, 2 -догч халдвараас урьдчилан сэргийлэх
 - Хоолонд сахар нүүрс усыг хязгаарлана.
 - Шингэн их хэмжээгээр уулгана.
 - Тодорхой хаяг, нэргүй эмийн бодисыг өвчтний ойр замбараагүй байрлуулахгүй байх
43. Эмийн бодисыг парентераль аргаар хэрэглэх гэж юу вэ?
- Эмийн бодисыг ууж хэрэглэх
 - Эмийн бодисыг арьсан дор тарьж хэрэглэх
 - Эмийн бодисыг шулуун гэдсээр хэрэглэх
 - Эмийн бодисыг судсанд тарьж хэрэглэх
 - Эмийн бодисыг амьсгалын замаар хэрэглэх
44. Бумба тавих талбайг сонгоно уу.
- Цээжний ард багана нурууны 2 талаар
 - Өгзөг, гуяны араар
 - Шилэн хүзүү, мөрөөр
 - Цээжний урд зүүн дээд хэсэгт
 - Нурууны нугалмаар
45. Баатар 65 настай эрэгтэй дотрын тасагт цусны эргэлтийн алдагдлын 3 үе шат гэсэн оношоор олон жил эмчлүүлсэн сувилахуйн тусламжийн аль нь тохирох вэ?
- Өвчтөний хувийн ариун цэврийг сахиулж, амны хөндий шүдийг цэвэрлэх
 - Арьсыг цэвэр байлгах камфорт ургамлын тосоор хоногт 1-с доошгүй арчих
 - Хөл гарын алга эрхтний цусан хангамж сайжруулах
 - Өндөр дэр тавьж хагас суугаа байрлалд байлгана хоолонд давс шингэнийг хязгаарлана
46. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг явуулахын гол зорилго юу вэ?
- Өвчтөнийг хурдан эдгээх
 - Эрүүл аж төрөх
 - Өвчний тухай мэдлэг өгөх

4. Өвчнөөс урьдчилан сэргийлэх
 5. Эмнэлэгтэй холбоо тогтоох
47. Эрүүл мэндийн боловсрол олгосноор ямар амжилтанд хүрэх вэ?
1. Мэддэггүйгээс мэддэг болох
 2. Буруу ойлголтоос зөв ойлголтод шилжих
 3. Тохиромжгүй хандлагаас тохиромжтой хандлагад шилжих
 4. Буруу зуршлаас зөв дадалд төлөвшинө
 5. Эрүүл мэндийн үзүүлэлт нь дээшилнэ
48. Туул 55 настай эмэгтэй хурц хатгалгаатай, өндөр халуунтай эмнэлэгт ирж хэвтсэн тул доорх сувилахуйн тусламжаас аль тохирохыг нь үзүүлнэ үү.
1. Шүлтлэг бүлээн шингэн ихээр уулгана.
 2. Өрөөнд чийгтэй цэвэрлэгээ хийж цаг тутам агаар оруулна.
 3. Бүх биеийг чийгтэй алчуураар арчина.
 4. Халууны хэлбэлзэлийг хянаж тэмдэглэж байх
 5. Хамар, уруулд цэврүү үүсэхээс урьдчилан сэргийлэх
49. Арьсан дор тариа хийх үед ямар хүндрэлүүд гарч болох вэ?
1. Буглаа үүсэх
 2. Судас, мэдрэл гэмтэх
 3. Эд эсийн үхжил үүсэх
 4. Өвдөлт ихээр өгөх
 5. Зүү хугарах
50. Саруул 75 настай уушгины хавдар өвчнөөр өвдөөд жил болж байгаа цустай ханиалгадаг та доорх сувилахуйн үйлдлээс тохирохыг онооно уу.
1. Цээжинд гич, бүлээн жин тавина
 2. Хэт хүчтэй шүрүүн хөдлөхөөс болгоомжлуулна
 3. Их ярих, тамхи татахыг хориглоно
 4. Өвчтөнийг суугаа, хагас суугаа байрлалд байлгана
 5. Цээжинд нь доргих иллэг хийнэ
51. Булчин тарианы үед яагаад бэрсүү үүсдэг вэ?
1. Антибиотикийг шаардагдах хэмжээний уусмалаар найруулаагүйгээс
 2. Тарилга арьсан дор хийгдсэнээс
 3. Булчинд хэрэглэх зүүг буруу сонгосноос
 4. Булчинд буруу эмийн бодисыг хийснээс
 5. Удаан шимэгддэг тариаг булчинд тарьснаас
52. Цус цусан бүтээгдэхүүн судсаар юүлэхэд анхаарах зүйлүүд юу вэ?
1. Үйлдвэрлэсэн он, сар, өдөр, серийн дугаар
 2. Өвчтөний халууныг үзэх
 3. Цусны хувийн тохироо үзэх
 4. Бүлгийн тохироо үзэх
 5. Биологийн тохироо үзэх
53. Үйлчлүүлэгч 35 настай эрэгтэй ходоод гашуу оргино, цанхайна хоол шингэхгүй хийгдэх сувилгааг сонгоно уу.
1. Хүйтэн жин тавина
 2. Халуун жин тавина.
 3. Хоол сойно
 4. Эмчийн заалтаар эмчилгээ хийх
 5. Цэвэрлэх бургуй тавина
54. Хандаа 74 настай элэгний хавдарын сүүлийн шат бөөрний хүндрэлийн шинж илэрч улмаар шээс хаагдаад 1 хонож байгаа та өвчтөнд ямар сувилгаа хийх вэ?
1. Өвчтөнийг ганцааранг нь түр орхих
 2. Бэлэг эрхтэнийг бүлээн усаар угаах

3. Эмчийн заалтаар шээлгүүр тавих
 4. Давсган дээр жин тавих
 5. Спазм тавиулах
55. Шээс хаагдсан өвчтөнд ямар сувилгаа хийх вэ?
- 1.Өвчтөнг ганцааранг нь түр орхих
 - 2.Бэлэг эрхтэнийг бүлээн усаар угаах
 - 3.Эмчийн заалтаар шээлгүүр тавих
 - 4.Давсган дээр жин тавих
 - 5.Спазм тавиулах эм өгөх
56. Эм хэрэглэхэд анхаарах дүрмийг дурьдана уу.
1. Харшил урвал өгдөг эсэхийг лавлана
 2. Тун хэмжээ нь зөв эсэхийг тодруулна
 3. Тухайн өвчтөнд олгох эм мөн эсэхийг тодруулна
 4. Тухайн эмийг ямар замаар хэрэглэхийг мэддэг
 5. Тухайн эмийг өгөх цаг мөн эсэхийг тодруулна
57. Дандар 85 настай олон жил том голомттой хурц шигдээсээр өвдөж байсан та гэрээр эргэж зөвлөгөө өгөх тохиолдолд зөв дарааллыг олно уу.
1. 1-р 7 хоногт 3.4 дахь хоногоос орондоо 2 тийшээгээ өөрөө эргэх
 2. 3-р 7 хоногоос хөлөө орны хажуу руу унжуулж сууна.
 3. 5-р 7 хоногт 1 давхарын шатаар явна
 4. 4-р 7 хоногт өөрөө орон дээрээ өндийж сууна
 5. 2-р 7 хоногоос коридорт явж өөртөө үйлчилнэ
58. Бумба тавих заалтыг тодорхойлно уу.
1. Гуурсан хоолойн үрэвсэл
 2. Уушигны үрэвсэл
 3. Хавирга хоорондын үрэвсэл
 4. Нуруу цээжний өвдөлт
 5. Уушигны сүрьеэгийн идэвхтэй хэлбэрийн үед
59. Баяр 62 настай эмэгтэй амьсгаадана, ханиалгана, цэр ховхрохгүй зовиуртай та цэр ховхлох зорилгоор доорх сувилахуйн тусламж үзүүлнэ.
1. Шингэлэх арга хэмжээ авна
 2. Цээжинд доргиох иллэг хийнэ
 3. Үйлчлүүлэгчийг түрүүлгэн харуулж гударган байрлалд хэвтүүлнэ
 4. Шингэн их хэмжээтэй уулгана
 5. Цэр чөлөөтэй ялгарах байрлалыг тогтоож өгнө
60. Ходоод угааж болохгүй эсрэг заалтыг тодорхойлно уу.
1. Улаан хоолойн венийн судас өргөссөн тохиолдолд
 2. Ходоод улаан хоолойноос цус алдаж буй үед
 3. Жирэмсний сүүлийн саруудад
 4. Эмийн бодисоор хордсон үед
 5. Химийн бодисын хордлогын үед
61. Цооролт үүсэх гадаад шалтгааныг тодорхойлно уу.
1. Асаргаа, сувилгаа муу байснаас
 2. Гадны ямар нэгэн зүйлд удаан хугацаагаар дарагдснаас
 3. Үйлчлүүлэгчийг нэг байрлалд удаан хэвтүүлснээс
 4. Биеийн эсэргүүцэл муу байснаас
 5. Мэдрэл тэжээлийн дутагдал болсноос
62. Эмнэлэг хамгаалалын дэглэмийг сахихгүйгээс гарах үр нөлөө хэнд тусах вэ ?
1. Өвчтөнд
 2. Эмнэлгийн ажиллагсдад
 3. Хамт ажиллагсдад

4. Эмнэлгээр үйлчлүүлэгсдэд
 5. Өвчтөний ар гэрт
63. Ямар зорилгоор арьсан дотор тариаг хийдэг вэ?
1. Эмийн бодисыг амаар ууж хэрэглэж чадахгүй үед
 2. Харшлыг оношлох, тогтоох
 3. Бие махбодид удаан шимэгддэг эмийн бодисыг тарих
 4. Бие махбодид өвчний үүсгэгч байгаа эсэхийг мэдэх
 5. Зүрх, судас, амьсгалын замыг дэмжих эм тариаг хийх
64. Цус сэлбэж болох заалтуудыг нэрлэнэ үү.
1. Цус багадсан үед
 2. Цус алдсан тохиолдолд
 3. Хагалгааны өмнө ба хагалгааны дараа
 4. Бөөрний хурц үрэвслийн үед
 5. Цусны даралт багасах өвчний үед
65. Ямар тохиолдолд мөстэй уут (жин)хэрэглэдэг вэ?
1. Бөөрний колик
 2. Дотуур цус алдалт
 3. Тарианы дараах бэрсүү үүссэн үед
 4. Өндөр халуурах
 5. Ходоод өвдөх
66. Эмийг харж байгаад уулгах нь ямар ач холбогдолтой вэ?
1. Эдийн засгийн
 2. Эмчилгээний үр дүнг хянах
 3. Эмэнд итгэх итгэлийг төрүүлэх
 4. Хариу урвал өгөх эсэхийг хянах
 5. Эмчлүүлэгчийг хянах
67. Шээлгүүр тавих зорилгыг тодорхойлно уу.
1. Давсаг угаах
 2. Давсган дахь шээсийг авах
 3. Давсганд эмийн бодис хийх
 4. Давсаг дурандахын өмнө
 5. Давсганд мэс засал хийхийн өмнө
68. Венийн судсанд тарилга хийх үед юуг анхаарах ёстой вэ?
1. Судсаар хольж болохгүй тарилгуудыг
 2. Тарих эмийн нэр хаяг, хадгалах хугацаа, тун хэмжээ
 3. Тарих талбай хатгах судсыг зөв сонгох
 4. Тариурын зүү судсанд байгаа эсэхийг шалгах
 5. Тарилгыг аажим болгоомжтой шахах
69. Венийн судсанд тарилга хийх үед юуг анхаарах ёстой вэ?
1. Судсаар хольж болохгүй тарилгуудыг
 2. Тарих эмийн нэр хаяг, хадгалах хугацаа, тун хэмжээ
 3. Тарих талбай хатгах судсыг зөв сонгох
 4. Тариурын зүү судсанд байгаа эсэхийг шалгах
 5. Тарилгыг аажим болгоомжтой шахах
70. Хаймсуур ходоодонд орсон эсэхийг шалгах аргыг сонгоно уу.
1. Хаймсуурын тэмдэглэлтэй хэсэг бүрэн орсон эсэхийг шалгана.
 2. Ходоодноос шингэн соруулна.
 3. Ходоод руу хий шахаад чагнана.
 4. Өвчтөний амьсгалын хэмийг шалгана.
 5. Ходоодыг тэмтэрч үзнэ.
71. Булчингийн эдэд ямар эмийн бодисыг хийдэг вэ?

1. Өвдөлт өгдөг, бие мах бодид удаан тархдаг
 2. Булчинд тарих заалт бүхий эмийн бодис
 3. Зарим нэгэн витаминууд
 4. Антибиотикууд
 5. Зүрхний глюкозидууд
72. Цэвэрлэх бургуй тавих эсрэг заалтыг заана уу.
1. Тэжээлийн бургуй тавихын өмнө
 2. Хоол идсэн даруйд
 3. Мэс засалд бэлтгэх үед
 4. Хоол боловсруулах замаас цус алдаж байвал
 5. Хордлогын үед
73. Артерийн даралтыг хэний аргаар хэмждэг вэ?
1. Франкын арга
 2. Риво-Роччийн арга
 3. Кочергений арга
 4. Коротковын арга
 5. Клемансын арга
74. Халуун жин тавих зорилгыг тодорхойлно уу.
1. Дулаацуулах
 2. Булчингийн агшилтыг сулруулах
 3. Үрэвслийн процессийг нэмэгдүүлэх
 4. Өвдөлт намдаах
 5. Цусны судсыг өргөсгөх
75. Бумбаны үйлчилгээг сонгоно уу.
1. Хэсэг газрын цусан хангамжийг сайжруулна.
 2. Бие махбодид өөр төрлийн уургийн бодисын нөлөө үзүүлнэ.
 3. Судасны нэвчимтгий чанарыг ихэсгэнэ.
 4. Үүссэн хаван эргэж шимэгдэнэ.
 5. Ойр орчмын эд эсэд хаван үүсгэнэ.
76. Судсанд тарилга хийх талбайг нэрлэнэ үү.
1. гарын өмнөх венийн судас
 2. Шагайн вен
 3. Гарын шууны вен
 4. Гарын шууны артери
 5. Тохойн өмнөх артерийн судас
77. Хүйтэн жин ямар үйлчилгээ үзүүлэх вэ?
1. Хэсэг газрыг хөргөж цусны судсыг нарийсгана.
 2. Мэдрэлийн төгсгөлийн мэдрэх чадварыг бууруулна.
 3. Өвчин намдаана
 4. Халуун бууруулна
 5. Цусан хангамжийг багасгана.
78. Сувилгааны үйл ажиллагааны 3-р шатлалд хийх ажилбаруудыг сонгоно уу.
1. Сувилгааны үйл ажиллагааг үргэлжлүүлнэ
 2. Оношийг бататгах
 3. Үйлчлүүлэгчээс асуумж авна
 4. Сувилгааны төлөвлөгөөг боловсруулна
 5. Хийгдэх сувилгааны үр дүнг задлан шинжилнэ.
79. Хүйтэн жин, бигнүүрийг ямар зорилгоор тавих вэ?
1. Тархины хавангаас урьдчилан сэргийлэх
 2. Үрэвсэл намдаах
 3. Цус алдалтыг зогсоох

4. Халуун бууруулах
 5. Өвдөлт намдаах
80. Дусал тариа хийх үед хариу урвал ямар байдлаар илрэх вэ?
1. Ууц, нуруугээр хөших
 2. Чичрэх
 3. Толгой өвдөх
 4. Дотор муухайрах
 5. Хүйтэн хөлс гарах
81. Аль сувилгааг хийж болохийг сонгоно уу.
1. Шээс гарахгүй үед
 2. Зүрхээр өвдөх
 3. Амьсгаадах
 4. Бөөлжих
 5. Цэр гарч байгаа
- A. Өндөр дэртэй хэвтүүлэх
 - B. Давс сахарын уусмал уулгах
 - C. Цэр хийх тагтай сав өгөх
 - D. Хөдөлгөөнийг хязгаарлана
 - E. Шээлгүүр тавина.
- A. 1E,2C,3D,4A,5B
 - B. 1A,2B,3C,4E,5D
 - C. 1B,2C,3D,4E,5A
 - D. 1C,2D,3E,4A,5B
 - E. 1E,2D,3A,4B,5C
82. Хийгдэж болох сувилгааг сонгоно уу.
1. Дотор муухайрч байгаа бол
 2. Нойр булчирхайн өвдөлт
 3. Амьсгаадах
 4. Багтраа хөдөлсөн үед
 5. Цэр гарч байгаа
- A. Өндөр дэртэй хэвтүүлнэ
 - B. Дэргэд нь хүнтэй байлгах
 - C. Цэрний савыг ойр ойрхон цэвэрлэх
 - D. Хоол сойх
 - E. Хөдөлгөөнгүй хэвтүүлэх
- A. 1E,2C,3D,4A,5B
 - B. 1A,2B,3C,4E,5D
 - C. 1B,2C,3D,4E,5A
 - D. 1C,2D,3E,4A,5B
 - E. 1E,2D,3A,4B,5C
83. Дараах урьдчилан сэргийлэлтийг тохируулан сонгоно уу.
1. Атеросклероз
 2. Архаг гепатит
 3. Хоол боловсруулалт алдагдах
 4. Архаг гастрит
 5. Архаг панкреатит
- A. Зөв хооллох
 - B. Хеликобактери илэрсэн үед нян устгах эмчилгээ хийлгэх
 - C. Амьдралын зөв хэв маягт хэвших
 - D. Эмнэлгийн болон ахуйн халдвараас сэргийлэх
 - E. Ундны ус хүнсний эрүүл ахуйн дэглэм сахих

- A. 1A,2B,3D,4C,5E
- B. 1C,2D,3E,4B,5A
- C. 1D,2A,3C,4E,5B
- D. 1B,2A,3D,4C,5E
- E. 1A,2C,3E,4D,5B

84.Сувилахуйн боловсролын шатлалыг нэрлэнэ үү.

1. Төгсөлтийн сургалт
 2. Төгсөлтийн өмнөх сургалт
 3. Төгсөлтийн дараах сургалт
 4. Тасралтгүй сургалт
 - A. Мэргэжил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх
 - B. Багцын сургалт
 - C. Магистр докторын сургалт
 - D. Сувилагчийн бакалавр, дипломын сургалт
- A. 1B, 2A, 3C, 4D
 - B. 1A, 2C, 3D, 4B
 - C. 1C, 2D, 3A, 4B
 - D. 1D, 2B, 3A, 4C
 - E. 1C, 2D, 3B, 4A

85.Сувилагч мэргэжилтний боловсролын зэрэг ахиулах ерөнхий зураглалыг тохируулна уу.

1. Сувилахуйн дипломын боловсрол
 2. Сувилахуйн бакалавр
 3. Сувилахуйн магистр
 4. Сувилахуйн доктор
 - A. II, III шатлалын эмнэлэг, сургалтын үйл ажиллагааг чиглүүлэгч
 - B. 2 жил, сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлзүй
 - C. 3 жил, сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлзүй
 - D. Сувилахуйн суурь боловсролын дипломтой сувилагч
- A. 1D, 2B, 3C, 4A
 - B. 1D, 2A, 3B, 4C
 - C. 1A, 2B, 3C, 4D
 - D. 1B, 2D, 3A, 4C
 - E. 1D, 2C, 3B, 4A

86. . Бичил үйл ажиллагааны 5A алхмуудыг зөв тохируулан бичнэ үү.

1. Асуух үнэлэх (Ask/assess)
 2. Зөвлөх (Advise)
 3. Зөвших (Agree)
 4. Туслах (Assist)
 5. Зохицуулах (Arrange)
 - A. Эмчлүүлэгчийн зорилго юу вэ? Түүндээ хэрхэн хүрэх вэ гэдгийг ярилцах
 - B. Эмчлүүлэгчийн итгэл үнэмшил, зан үйл, мэдлэг, сэдэл, өмнөх туршлагыг үнэлэх
 - C.Өөрчлөгдөх гэсэн эмчлүүлэгчийн хүсэл зориг, бие даасан байдлыг хүндлэх, хүчилж шүүмжилж болохгүй
 - D.Эрүүл мэндэд хортой зан үйл болон байнга хувьсаж байдаг асуудлуудыг хянах
 - E. Эмчлүүлэгчид шинэ чадвар эзэмших, зан үйлээ өөрчлөх итгэл олж авахад нь дэмжлэг үзүүлэх
- A. 1B, 2C, 3A, 4E, 5D
 - B. 1A, 2D, 3B, 4C, 5E

- C. 1D, 2A, 3E, 4D, 5B
- D. 1C, 2E, 3D, 4B, 5A
- E. 1E, 2B, 3C, 4A, 5D

87. Масловын хэрэгцээний эрэмбийн онолыг сонгоно уу.

1. Физиологийн хэрэгцээ
 2. Аюулгүй байх хэрэгцээ
 3. Хайрлах, бусадтай харилцах хэрэгцээ
 4. Өөрийгөө хүндлүүлэх хэрэгцээ
 5. Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ
 - A. Хүсэл тэмүүлэл
 - B. Хүмүүстэй харилцаж, энэрэнгүй сэтгэлээр хандана
 - C. Эрхэлсэн ажил албан тушаал
 - D. Ялгаруулах
 - E. Өөрийн хүрч чадах дээд зүйлдээ хүрэх хүсэл
- A. 1A, 2C, 3D, 4E, 5B
 - B. 1D, 2C, 3B, 4A, 5E
 - C. 1B, 2A, 3E, 4D, 5C
 - D. 1E, 2B, 3A, 4C, 5D
 - E. 1B, 2D, 3E, 4A, 5C

88. Сувилахуйн шинжлэх ухааны хөгжиж ирсэн түүхийг бичнэ үү.

1. Балар эртний үеийн нийгэм дэх сувилгаа
 2. Дундад зууны үеийн нийгэм дэх сувилгаа
 3. Сэргэн мандалтын үеийн нийгэм дэх сувилгаа
 4. XVIII-XIX зууны үеийн нийгэм дэх сувилгаа
 5. XX зуун буюу орчин үеийн нийгэм дэх сувилгаа
 - A. 1400-1600 он буюу сэргэн мандалтын үеийн үед сувилах үйл явцад жинхэнэ мэргэжлийн бэлтгэл шаардлагатай гэдгийг хүмүүс ухаарч эхэлсэн үе юм.
 - B. Эмэгтэй хүний нийгэмд эзлэх байр суурь өндөрсөн, эмэгтэйчүүд эрх чөлөөний тухай ярьдаг болсон тэр л үеэс сувилахуйг мэргэжил гэдгийг ойлгон хөгжүүлэх эхлэл тавигдсан
 - C. Эх хүн хүүхэд, гэр бүл, овгийн гишүүдэд тавих анхаарал халамжаас эхлэн үүссэн гэж үздэг
 - D. Шашин шүтлэг маш ихээр дэлгэрч, өвчин зовлон, байгалийн гамшгийг даван туулах байдал нь сүсэг бишрэлийн шинж чанартай болсон
 - E. Сувилахуйн шинжлэх ухаан дэлхийн бүх оронд сонгомол утгаараа тархаж, Сувилагчийн эрхийг хамгаалах нийгэмлэгүүд бий болон тогтмол хэвлэл, ном сэтгүүлүүд олноор гарах болсон.
- A. 1E, 2C, 3D, 4A, 5C
 - B. 1A, 2E, 3C, 4D, 5B
 - C. 1E, 2A, 3B, 4C, 5D
 - D. 1C, 2D, 3A, 4B, 5E
 - E. 1B, 2E, 3C, 4A, 5D

89. Дараах өвчтэй хүмүүст тохирох зөвлөгөөг сонгоно уу.

1. Архаг бронхит
2. Архаг гепатит
3. Архаг гломерулонефрит
4. Тархмал хордлогот бахуу
5. Чихрийн шижин хэв шинж 2
 - A. Удаан хадгалсан хоол хүнс идэхгүй байх.
 - B. Хөл нүцгэн явахгүй байх
 - C. Хүйтэн ус бороонд явахгүй байх

- D. Тамхи татахгүй байх
 E. Наранд нүдний шил зүүж байх.
- A. 1A,2B,3D,4C,5E
 B. 1C,2D,3E,4B,5A
 C. 1D,2A,3C,4E,5B
 D. 1B,2A,3D,4C,5E
 E. 1A,2C,3E,4D,5B
90. Хийгдэх сувилгааг сонгоно уу.
1. Гэдэс дүүрсэн бол
 2. Арьс хуурайшсан бол
 3. Амьсгаадах
 4. Өвчнөөсөө айж сандарсан бол
 5. Хавантай бол
 - A. Өглөө бүр жинг үзэх
 - B. Хэвлийд иллэг хийх
 - C. Биеийг угааж тос түрхэнэ
 - D. Өрөөнд цэвэр агаар оруулах
 - E. Асуултанд зөв хариулах
 - A. 1E,2C,3D,4A,5B
 - B. 1A,2B,3C,4E,5D
 - C. 1B,2C,3D,4E,5A
 - D. 1C,2D,3E,4A,5B
 - E. 1E,2D,3A,4B,5C
91. Асаргаа сувилгааны үндсэн зарчимд орчин хоол, хувцаслалт нь чухал, яагаад гэвэл эмчлүүлэгчийн сэтгэл зүйг дэмждэг учир хүн бүрт энэ үйл ажиллагааг төлөвлөдөг .
92. Зажилдаг эмийг өгөхдөө шингэн зүйлийг сайн өгөх хэрэгтэй, яагаад гэвэл хүүхдийн амьсгалыг боогдуулах аюултай байдаг учраас хүүхдэд хатуу юм иддэг болсон үед өгөх нь илүү үр дүнтэй.
93. Үйлчлүүлэгчдийн ходоодыг хаймсуураар угаахын тул хиймэл шүдтэй тохиолдолд авдаг, энэ нь хүндрэлээс сэргийлдэг бөгөөд, учир нь энэ үед өвчтөн хахаж, цацах магадлалтай байдаг.
94. Булчин тарилгыг бугалганы дунд хэсэгт болон өгзөгний булчинд 60-90 хэмийн өнцгөөр тарьдаг учир шалгах шаардлагагүй байдаг, яагаад гэвэл мэдрэлийн ширхэг багатай байдаг.
95. Өнгөц шарханд наадаг тунгалаг наалт нь шарх руу ус нэвтрүүлдэггүй учир шархыг халдвараас хамгаалах, мөн явцыг ажиглаж байхад тохиромжтой байдаг.
96. Арьс хэвийн бус цайж цонхийх нь хүнд хэлбэрийн цус багадалтын шинж, тиймээс цус сэлбэх шаардлагатай учир зөвхөн цусны бүлгийг шалгасан байхад хангалттай.
97. Эсэд хортой нөлөө үзүүлэх үйлчилгээтэй хаягдлыг шингэн нэвчихгүй саванд хийдэг. Яагаад гэвэл мөнгөн ус болон хортой хүнд метал агуулсан учир эсэд хортой хог хаягдал гэж тэмдэглэдэг.
98. Зайлах бургуйг цэвэрлэх бургуй үр дүнгүй болсон үед тавьдаг учир бага хэмжээний усыг хэрэглэдэг, яагаад гэвэл өмнө нь гэдэс цэвэрлэгдсэн байдаг.
99. Сорил тарилгыг хийхэд уусмалын хэмжээ чухал байдаг. Яагаад гэвэл шууны дотор талын 1/3 –ийн дунд хэсэгт тавьдаг учир өвдөлт үүсгэдэг.
100. Арьсан дор хийгдсэн эмийн бодис бие махбодид хурдан шимэгддэг. Яагаад гэвэл арьс нь цусны судсаар баялаг учир яаралтай тусламжийн эмийн бодисыг ихэвчлэн тарьдаг.

НЯРАЙ СУДЛАЛ

1. Зохицуулалт хийгдсэн сүүн холимог эхийн сүүнээс найрлагын хувьд ялгагдах онцлогийг хэлнэ үү.

- A. Уураг
- B. Нүүрс ус
- C. Өөх тос
- D. Иммуноглобулин
- E. Аминдэм

2. Шилжилтийн сүүний илчлэгийн хэмжээг олно уу.

- A. 1500ккал/л
- B. 750-700ккал/л
- C. 700ккал/л
- D. 660-640ккал/л
- E. 66-64ккал/л

3. Биеийн жингийн хэдэн хувийг алдвал физиологийн жин бууралт гэж үзэх вэ?

- A. 10%
- B. 8%
- C. 7%
- D. 6%
- E. 5%

4. Төрсний дараа хүүхдийг хэдий хугацаанд амлуулах вэ?

- A. 24 цагийн дотор
- B. 4 цагийн дотор
- C. 6 цагийн дотор
- D. 1 цагийн дотор
- E. 12 цагийн дараа

5. Гүйцэд эрүүл нярайн цээжний бүслүүрийн тойрог төрөх үедээ хэд байх вэ?

- A. 32 – 34 см
- B. 35 – 36 см
- C. 37 – 39 см
- D. 40 – 42 см
- E. 43 – 45 см

6. 1 сар 10 хоногтой нярай 2 хоног ханиалгаж байгаа, халуун 38 хэм, амьсгал 1 минутанд 54 байгаа, өөр эмгэг шинж илрээгүй бол юу гэж ангилах вэ?

- A. Ханиад шуухинаа, халууралт
- B. Уушигны хатгалгаа, халууралт
- C. Хүнд халдвар байж болзошгүй
- D. Маш хүнд халууралт өвчин
- E. Уушигны хүнд хатгалгаа

7. Хүнд халдвар байж болзошгүй гэж ангилсан нярайд ямар тусламж үзүүлэх вэ?

- A. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, цусны сахар багасахаас сэргийлээд, эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
- B. Антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасахаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлж эмчилнэ.
- C. Үүсгэгчийн эсрэг 2-р сонголтын эм уулгаад, гэртээ хэрхэн асрах талаар эхэд зааж өгнө.
- D. Эмнэлэгт хэвтүүлнэ.
- E. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын халдварыг генцианвиолетээр гэрт нь эмчилнэ.

8. Хүйнээс нь идээ гарч байгаа, 1 өдөр халуурсан нярайд ямар ангиллаар, ямар тусламж үзүүлэх вэ?

- A. Хэсэг газрын нянгийн халдвар гэж ангилаад үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын эмчилгээ хийгээд, 2 хоноод давтан үзнэ.
- B. Хүнд халдвар байж болзошгүй гэж ангилаад антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасахаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
- C. Үүсгэгчийн эсрэг 2-р сонголтын эм уулгаад, гэртээ хэрхэн асрах талаар эхэд зааж өгнө.
- D. Антибиотик тариад гэрт нь эмчилнэ.
- E. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын халдварыг генцианвиолетээр гэрт нь эмчилнэ.
9. 24 хоногтой нярайн арьсан дээр ганц нэг идээт цэврүү гарсан, өөр өвчний шинжгүй бол ямар арга хэмжээ авах вэ?
- A. Хэсэг газрын нянгийн халдвар гэж ангилаад үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын эмчилгээ хийгээд, 2 хоноод давтан үзнэ.
- B. Хүнд халдвар байж болзошгүй гэж ангилаад антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасахаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
- C. Үүсгэгчийн эсрэг 2-р сонголтын эм уулгаад, эмнэлэгт хэвтүүлнэ.
- D. Яаралтай эмнэлэгт хэвтүүлнэ.
- E. Антибиотик тариад гэрт нь эмчилнэ. 5 хоноод давтан үзнэ.
10. Аль нярайн зааг үед хамаарахгүй вэ?
- A. Биеийн жингийн алдагдал
- B. Физиологийн улайлт
- C. Физиологийн шарлалт
- D. Арьсны идээт тууралт
- E. Шээсний хүчлийн шигдээс шээсний хүчлийн шигдээс
11. Аль нь нярайн сэхээн амьдруулалтанд хамаарахгүй вэ?
- A. Амьсгалын дээд замын цэр салстыг соруулж шулуун байдлыг хангах
- B. Цочроох арга хэрэглэх
- C. Амбугаар амьсгал удирдах
- D. Зүрхэнд шууд бус массаж хийх
- E. Амьсгалын төв цочроох эм хэрэглэх
12. Аль нь нянгийн хүнд халдварын шинж биш вэ?
- A. Халуун 35 хэмээс бага
- B. 2 дахь удаа амьсгал тоолоход 67
- C. Таталт
- D. Хөлрөх, шээс эхүүн үнэртэй байх
- E. Халуурах
13. физиологийн шарлалт амьдралын хэд хоногтойд эхлэх вэ?
- A. 24 цагийн дотор
- B. 1-2 хоног
- C. 2-3 хоног
- D. 3-4 хоног
- E. 4-5 хоног
14. Живхэнд үүссэн улаан толбо нярайн эрүүл эмгэгийн заагийн аль төрөлд хамрагдах вэ?
- A. Бөөрний өөрчлөлт
- B. Бодисын солилцооны өөрчлөлт
- C. Гипертерми
- D. Дааврын хямрал
- E. Физиологийн шарлалт
15. Төрөх өрөөг хэдэн хэм дулаан байлгах вэ?

- A. 20-24 хэм
 - B. 22-24 хэм
 - C. 24-26 хэм
 - D. 22-26 хэм
 - E. 23-25 хэм
16. Нярайг амилуулах тусламжийн үед ходоодны хаймсуурыг ямар тохиолдолд хэрэглэх вэ?
- A. Ходоод угаах
 - B. Хүүхдийг хооллох
 - C. Салиаг соруулах
 - D. Ходоод орсон хийг гадагшлуулах
 - E. Хэрэглэхгүй
17. Биеийн жингийн хэдэн хувийг алдвал эмгэг жин бууралт гэж үзэх вэ?
- A. 10%
 - B. 8%
 - C. 7%
 - D. 6%
 - E. 5%
18. Нярайн хүнд халдвар байж болзошгүй шинж аль нь вэ?
- 1. Татах
 - 2. Хамар сарталзах
 - 3. Амьсгал олшрох
 - 4. Халуурсан эсвэл халуун буурах
 - 5. Хүй улайсан буюу идээ гарсан
19. Аль нярайн өвчнийг ангилахын тулд асуух асуулт вэ?
- 1. Хүй улайсан буюу идээ гарсан
 - 2. Нярайн хөдөлгөөн хэвийнхээс буурсан уу?
 - 3. Арьсны идээт цэврүү байна уу?
 - 4. Нярай татсан уу?
 - 5. Хүйн улайлт арьсруугаа тэлсэн үү?
20. Аль нь хүүхдэд хөхөө зөв үмхэж байгаа шинж вэ?
- 1. Эрүү хөхөнд хүрч
 - 2. Амаа том ангайх
 - 3. Доод уруул цорвойх
 - 4. Хөхний нөсөөт хэсэг дээд талд илүү харагдах
 - 5. Удаан сорох
21. Өөр хоол буюу шингэн өгдөг нярай хүүхдэд өгөх хамгийн зөв зөвөлгөө аль нь вэ?
- 1. Зөв байрлал ба зөв үмхүүлэхийг эхэд заах
 - 2. Хөхөө олон удаа хөхүүлэх ба бусад хоолыг багасгах
 - 3. Аяга халбагаар хоолло
 - 4. 2 хоноод давтан үзүүл
 - 5. Хамрыг цэвэрлэ
22. Нярайд хэзээ үзлэг хийх вэ?
- 1. Төрсний дараах эхний 1 цагт
 - 2. Төрснөөс 12цагийн дараа
 - 3. Эхний 7 хоногийн эргэлтийн үед
 - 4. Өвчилсөн үед
 - 5. Өдөр бүр
23. Нярайн үзлэгээр хэвийн гэж ангилах үзүүлэлтийг заана уу.
- 1. Тээлтийн нас гүйцсэн ба жин 2500 гр-аас дээш
 - 2. Хоногт 8-аас дээш хөхдөг

3. Тусгай эмчилгээ байхгүй
 4. Биеийн халуун 36.4 хэм
 5. Амьсгал 66-аас дээш
- 24 . Аль нь нярайд гэрээр асрах зөвөлгөөнд тохирох вэ?
1. Хөхөөр хооллох ба дулаан байлгах
 2. Усанд оруулах болон хүй арчлах
 3. Хэзээ яаралтай ирэх талаар
 4. Давтан үзлэгийн талаар
 5. Бусад сүү орлуулагчийн талаар
25. Аль нь нярай хооллолтын зөвөлгөөнд тохирох вэ?
1. Өдөр шөнөгүй хүссэн үед хөхүүл
 2. 6 сар хүртэл зөвхөн хөхөөр хоолло
 3. Өөр шингэн бүү өг
 4. Хоногтоо 8-аас дээш удаа хөхүүл
 5. Аягаар хоолло
26. Нярай хүүхдэд яагаад заавал витамин К тарьдаг вэ?
1. Нярай хүүхдэд К аминдэм бага байдаг
 2. Тархинд цус харвахаас сэргийлж
 3. Хоол боловсруулах замд ашигтай нянгууд байдаггүй
 4. Нярайд цус бүлэгнэлт муу байдаг
 5. Нярайн цусархаг хам шинж үүснэ.
27. Хүйн идээт үрэвслийн үед илрэх шинжийг нэрлэнэ үү.
1. Хүйн шарх 14 хоногоос дээш хугацаагаар эдгэхгүй байх
 2. Хүйнээс шүүс гарах
 3. Хүйн эргэн тойронд хавдаж, хүйнээс идээрхэг ялгадас гарах
 4. Хүйн ёроолд үхжил үүссэн байх
 5. Хүй өтгөнөөр бохирлогдсон байх
28. Физиологийн шарлалт шалтгааныг нэрлэнэ үү.
1. Трансфераза эсэг гэмтэх
 2. Ургийн улаан эсийн задрал
 3. Цусны бүлэг үл тохирох
 4. Биллирубины холбон гадагшлуулах элэгний үйл ажиллагааны түр зуурын хязгаарлалт
 5. Ургийн халдвар
29. Эхийн сүүний тослогийн талаарх зөв хариултыг сонгоно уу.
1. Эийн сүүнд ханасан өөхний хүчил их байдаг
 2. хөхөөр хооллож буй үед өөх тос эхлээд ходоодонд задардаг
 3. Эхийн сүүнд ханаагүй өөхний хүчил бага байдаг
 4. Эийн сүүнд липаза эсэг агуулагддаг
 5. Үнээний сүүнд ханасан аахний хүчил бага байдаг
30. Ангир уураг нь найрлага тогтмолжсон сүүтэй харьцуулахад дараах шинжүүдийг хадгалсан байдаг.
1. Иммуноглобулинээр баялаг, цагаан эс ихтэй
 2. Зөөлөн туулгах үйлчилгээтэй тул гэдэс дотрыг цэвэрлэх үүрэгтэй
 3. А-амин дэмээр баялаг
 4. Уургаар баялаг
 5. Нүүрс-усаар баялаг
31. Бусад сүү, хүүхдийн тэжээлийн эхийн сүүнээс ялгагдах онцлог
1. Хүүхдийн тэжээлд липаза байхгүй
 2. Амьтны сүү болон хүүхдийн тэжээлийн алинд нь ч зохистой харьцаатай амин хүчил байдаггүй

3. Амьтны гаралтай сүү А,С амин дэмээр дутмаг
 4. Амьтны гаралтай сүү, хүүхдийн тэжээлд халдварын эсрэг хүчин зүйл байдаггүй
 5. Амьтны гаралтай сүү, хүүхдийн тэжээлд эрдэс бодис зохистой харьцаагаар байна
32. Аль нь окситоцин дааврын үйлчилгээг саатуулах вэ?
1. Эхийн хоол нэг төрөл байх
 2. Хүчтэй өвдөлт
 3. Шингэн бага уух
 4. Цөөн хөхүүлэх
 5. Шөнө хөхүүлэх
33. НАН сүү ямар төрлийн тэжээлд хамрагддаг вэ?
1. Зохицуулалтхийгдээгүй амтлаг сүүн холимог
 2. Зохицуулалт хийгдээгүй исгэлэн сүүн холимог
 3. Зохицуулалт хийгдсэн исгэлэн сүүн холимог
 4. Зохицуулалт хийгдсэн амтлаг сүүн холимог
 5. Сүүн холимог
34. Эрүүл эмгэгийн заагт аль нь орох вэ?
1. Хүй орчмын арьс улайсан
 2. Нүүрээр цагаан батга гарах
 3. Гар хөлийн ул шарлах
 4. Арьс улайх
 5. Төрлөгийн хаван
35. Ургийн улаан эс их хэмжээтэй задрах, нярайн элэгний биллирубин саармагжуулах үйл ажиллагааны дутагдалтай байдаг тул шарлалт үүсдэг.
36. Эхийн цуснаас эстроген цусанд орох нь зогссонтой холбоотой нярайд хөх томрох, үтрээнээс цусархаг ялгадас гардаг.
37. Шээсний хүчлийн шигдээс нь биемахбодид задралын процесс давамгайлж шингэн дутсанаас үүснэ.
38. Дараах хамаарлыг уялдуулан сонгоно уу.
- | | |
|------------------------|---------------------|
| 1. Хэвийн халуун | A. 37.5 хэмээс дээш |
| 2. Халууралт | B. 36.5-37.5 хэм |
| 3. Хүндэвтэр гипотерми | C. 36-36.5 хэм |
| 4. Хүнд гипотерми | D. 32-36 хэм |
| 5. Хүйтний цочрол | E. 32 хэмээс доош |
- A. 1B 2A 3D 4E 5B
 B. 1A 2B 3C 4D 5B
 C. 1B 2A 3C 4D 5 E
 D. 1E 2D 3C 4B 5A
 E. 1C 2A 3B 4D 5E
39. Крамерийн шалгуураар биллирубины хэмжээ хэд байхыг уялдуулан сонгоно уу.
1. Хэвлийн доод хэсэг, ташаа
 2. Цээж, хэвлийн дээд хэсэг
 3. Нүүр
 4. Гарын алга, хөлийн ул
 5. Гар хөл
- A. 68-102 мкмол/л
 B. 204-238 мкмол/л
 C. 255-340 мкмол/л
 D. 255-306 мкмол/л
 E. 136-170 мкмол/л
- A. 1E 2B 3A 4C 5D

- B. 1D 2A 3C 4E 5B
- C. 1E 2C 3D 4B 5 A
- D. 1B 2E 3A 4C 5D
- E. 1E 2B 3A 4D 5C

40. Нярайн хөдөлгөөн сэтгэцийн хөгжлийг зөв харгалзуулна уу.

- 1. 1.5 сар
- 2. биеийн байрлал
- 3. 21 хоног
- A. Толгойгоо даана.
- B. Эхийн хэвлий дэхь байрлал
- C. Гангана.
- A. 1B 2C 3A
- B. 1C 2B 3A
- C. 1A 2C 3B
- D. 1C 2A 3B
- E. 1A 2B 3C

ХҮҮХЭД СУДЛАЛ

1. Рахиттай гэж ангилаад эмчилгээний тунгаар Д аминдэм уулгасан хүүхдийг 30 хоноод давтан үзэхэд рахитын шинжгүй болсон байв, Ямар арга хэмжээ авах вэ?

- A. Д аминдэм давтан уулгахгүй, эмчилгээг зогсооно
- B. Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар залгаад өгнө
- C. Сарын дараа Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар өгнө
- D. 2 сарын дараа Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар өгнө
- E. Өвөл Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар 3 сар өгнө

2. Ханиад шуухинаатай хүүхдэд шингэнийг яаж хэрэглэх вэ?

- A. Эрүүл үеийнхтэй ижил хэмжээний шингэн өгнө
- B. Шингэн уух дуршлаас хамаарна
- C. Эрүүл үеийнхээс илүү шингэн өгнө
- D. Бөөлжиж байгаа үед шингэн өгөхгүй
- E. Шингэн өгөх шаардлагагүй

3. 38,5 хэмээс дээш халуурч буй 4 настай хүүхдэд парацетамолын 500 мг- ын шахмалаас яаж өгөх вэ?

- A. 1\4
- B. 1\2
- C. 1 бүтнээр
- D. 1.5
- E. 2 бүтнээр

4. Уушгины хатгалгаатай 2 настай хүүхдийг 3 хоноод давтан үзэхэд биеийн байдал нь сайжирсан, ханиалга намдсан, амьсгал минутанд 32 байв. Ямар арга хэмжээ авах вэ?

- A. Эмчилгээг зогсооно.
- B. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгнө.
- C. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
- D. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эмийг үргэлжлүүлэн өгнө.
- E. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

5. Чихнээс булаг гарч буй хүүхдийн чихийг чихээсээр хэрхэн цэвэрлэх вэ?

- A. Чихийг хуурайштал чихээсээр цэвэрлэнэ, хоногт 3-аас доошгүй удаа чихийг хуурайштал чихээсээр цэвэрлэнэ.
- B. Өглөө чихээс хийж орхиод орой чихээсийг шинээр солино
- C. Чихээсийг хоногт 2 удаа хийх ба нийт 5 хоног чихээсээр эмчилнэ
- D. Чихийг чихээсээр 3 хоног эмчилнэ.

- Е. Гидрокортизоны тостой чихээс хийгээд 3 хоног орхино.
6. 2 настай хүүхэд ханиалгасан ба түүний амьсгал 1 минутанд 39 байна. Та яаж ангилах вэ?
- А. Уушигны хүнд хатгалгаа
 - В. Уушигны хатгалгаа
 - С. Ханиад шуухинаа
 - Д. Томуу
 - Е. Маш хүнд өвчин
7. 2-12 сар хүртэлх хүүхдийн амьсгал олшрох босго хэд вэ?
- А. 1 минутанд 50 буюу түүнээс дээш
 - В. 1 минутанд 40 буюу түүнээс дээш
 - С. 1 минутанд 60 буюу түүнээс дээш
 - Д. 1 минутанд 30 буюу түүнээс дээш
 - Е. 1 минутанд 70 буюу түүнээс дээш
8. Нүдний халдварыг тетрациклины тосоор эмчлэхдээ хоёр нүдийг хэдэн удаа цэвэрлэх ёстой вэ?
- А. 1 удаа
 - В. 2 удаа
 - С. 3 удаа
 - Д. 4 удаа
 - Е. 5 удаа
9. Ой хүртэлх хүүхдийн хөдөлгөөн-сэтгэцийн хөгжлийг хэдэн шатад хуваадаг вэ?
- А. 2
 - В. 3
 - С. 4
 - Д. 5
 - Е. 7
10. Гэрээр эмчлэгдэж буй ханиад шуухинаатай хүүхдийн давтан үзлэгийг хэзээ хийх вэ?
- А. 3 хоноод
 - В. 5 хоноод
 - С. 14 хоноод
 - Д. 7 хоноод
 - Е. 10 хоноод
11. 2 сартай хүүхдийн амьсгалыг тоолоход хэд байвал олширсонд тооцох вэ?
- А. 40
 - В. 42
 - С. 45
 - Д. 48
 - Е. 50
12. 38,5 хэмээс дээш халуурч буй 8 сартай хүүхдэд парацетамолын 100 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?
- А. 1\4
 - В. 1\2
 - С. 1 бүтнээр
 - Д. 1.5
 - Е. 2 бүтнээр
13. Чихний цочмог халдвартай хүүхдийн чихний өвдөлтийг намдаахаар юу зөвлөх вэ?
- А. Чихэнд фурациллинтэй спирт дусаах
 - В. Парацетамолыг 6 цагаар өвдөлт намдтал уулгах.
 - С. Тарваганы тос халаагаад чихэнд дусаах
 - Д. Чихний ард новокаинтэй блокад хийх

- Е. Анальгин, димедролтой тарих.
14. Улаанбурханы вакцины 1-2-р тунг хэдэн сарын зайтай хийх ёстой вэ?
- А. 1 сарын зайтай
 - В. 3 сарын зайтай
 - С. 6 сарын зайтай
 - D. Жилийн зайтай
 - Е. 8 жилийн зайтай
15. 1 нас 2 сартай, 6 сартай байхад нь хөх А аминдэм өгсөн гэсэн, дахин А аминдэм аваагүй тул та өнөөдөр А аминдэм өгөх үү? Үзлэгээр хүүхэд ХТЦД-гүй, рахитгүй, цус багадалтгүй, ба бусад өвчний шинжгүй.
- А. Эрүүл тул А аминдэм өгөхгүй
 - В. 6 сартайдаа А аминдэм авсан тул давтан өгөхгүй
 - С. 6 сартайдаа А аминдэм аваад сүүлийн 6 сар А аминдэм уугаагүй байгаа тул А аминдэмийн улаан капсулаас нэг ширхэгийг өгнө.
 - D. 6 сартайдаа А аминдэм аваад 8 сар өнгөрсөн байгаа тул А аминдэмийн хөх капсулаас нэг ширхэгийг өгнө.
 - Е. 6 сартайдаа А аминдэм аваад 6 сар өнгөрсөн байгаа тул А аминдэмийн цагаан капсулаас нэг ширхэгийг өгнө.
16. Зөвхөн хөхөөр хооллож буй хүүхдэд зуны халуунд хөхүүлэхийн зэрэгцээ шингэн нэмж уулгах хэрэгтэй юу?
- А. Хэрэгтэй
 - В. Хэрэггүй
 - С. Ус халбагадаж өгөх хэрэгтэй
 - D. Жимсний шүүсээр угжих хэрэгтэй
 - Е. Байхуу цайгаар угжих хэрэгтэй
17. Гэрээр эмчлэгдэж байгаа уушигны хатгалгаатай хүүхдийн давтан үзлэгийг хэзээ хийх вэ?
- А. 3 хоноод
 - В. 5 хоноод
 - С. 14 хоноод
 - D. 7 хоноод
 - Е. 10 хоноод
18. 6 сартай хүүхэд өчигдрөөс халуурсан, тайван биш болсон зовиуртай, үзүүлэхэд чихнээс булаг гарч байв. Эх нь хүүхдийн чихнээс урьд өмнө нь булаг гарч байсныг анзаараагүй, тул хэд хоног гарч байгааг мэдэхгүй. Өөр шинжүүд илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?
- А. Чихний цочмог халдвар
 - В. Халууралт, чихний архаг халдвар
 - С. Халууралт, чихний цочмог халдвар
 - D. Халууралт
 - Е. Маш хүнд халууралт өвчин
19. Улаан бурхны түгээмэл тууралттай хүүхдийн амны шархлааг генцианвиолетээр өдөрт хэдэн удаа эмчлэх ёстой вэ?
- А. 1 удаа
 - В. 2 удаа
 - С. 3 удаа
 - D. 4 удаа
 - Е. 5 удаа
20. 6 сартай 8 кг жинтэй хүүхэд 2 хоног суулгасан зовиуртай, үзлэгээр хүүхдийн нүд хонхойсон, ам нь их цангасан, ховдоглон ууж байв. Өөр шинж илрээгүй. Хүүхдийн биеийн байдлыг үнэлж ямар арга хэмжээ авах вэ?

- А.Хүнд шингэн алдсан гэж үзээд, хураагуур судсанд шингэн юүлэх
 В.Шингэн алдсан гэж ангилаад 4 цагийн дотор 400-600мл ШСД-ны уусмал цайны халбагаар уулга
 С.Шингэн алдсан гэж ангилаад 800-1200мл ШСД-ны уусмал бага багаар уулга
 D.Шингэн алдалтгүй гэж ангилаад А төлөвлөгөөний дагуу эмчилнэ.
 E. Шингэн их алдсан гэж ангилаад 100мл\кг жинд тооцоолон Рингер лактат дуслар хий
21. 5 настай хүүхэд суулгасан зовиуртай боловч орчиндоо идэвхтэй, цангаагүй, нүд хонхойгоогүй, арьсны хуниас хурдан арилж байв.Хүүхдийг үнэлж зохих зөвөлгөөг өгнө үү.
 А.Хүүхэд шингэн алдаагүй тул урьдчилан сэргийлэх зорилгоор суулгалт бүрийн дараа 100-200 мл шингэн уулгана.
 В.Хүүхэд шингэн алдаж болзошгүй тул 4 цагт 1200-2400мл ШСД-ны уусмалыг аягаар бага багаар өгнө.
 С.Хүүхэд шингэн алдаж байгаа тул 75мл\кг жинд тооцоолон 4 цагийн турш ШСД уусмал уулгана.
 D.Хүүхэд шингэн их алдсан тул эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
 E. Хүүхдэд шингэн алдалтгүй тул зөвөлгөө өгнө
22. Сампингийн эрхийн шинжийг хаана тэмтэрч үзэх вэ?
 А.Өвчүүний ирмэгээр
 В.Хавирганы ясан ба мөгөөрсөн хэсгийн уулзвар дээр
 С.Суганы дунд шугамаар
 D.Суганы урд шугамаар
 E. Суганы арын шугамаар
23. Д аминдэмийн урьдчилан сэргийлэлтийг хүүхдэд хэдийнээс хийх вэ?
 А. 14 хоногтойгоос
 В. 1 сартайгаас
 С. 2 сартайгаас
 D.3 сартайгаас
 E. 4 сартайгаас
24. 3 сартай хүүхэд нэг хоног толгойгоо шөргөөж уйлна.Түүний чихэнд хүрэхэд маш ихэмзэглэн чанга уйлж байв. Чихний ард хөндүүр хаван байхгүй байна. Өөр шинжүүд илрээгүй. Хэрхэн ангилах вэ?
 А. Рахит
 В. Хөхлөг ургацын үрэвсэл
 С. Чихний архаг халдвар.
 D. Чихний цочмог халдвар
 E. Менингит
25. 3 настай шингэн алдалтгүй суулгалттай хүүхдэд суулгалт бүрийн дараа ямар хэмжээний шингэн уулгах вэ?
 А. 50-100 мл
 В. 100-200 мл
 С. 500-600 мл
 D. 300-400 мл
 E. 700-800 мл
26. 2 настай ханиадтай хүүхдэд цээж хонхолзох шинж илэрч байв. Түүнд өөр зовиур, эмгэг шинж илрээгүй. Эмч хэрхэн ангилах вэ?
 А. Ханиад шуухинаа
 В. Уушгины хүнд хатгалгаа
 С. Уушгины хатгалгаа
 D. Багтраа
 E. Ларингит

27. Цус багадалттай хүүхдийг өрхийн эмч хэд хоноод давтан үзэх вэ?
- A. 5 хоноод
 - B. 14 хоноод
 - C. 30 хоноод
 - D. 2 хоноод
 - E. 7 хоноод
28. Чихний архаг халдвартай гэж ангилсан хүүхдэд эмч ямар арга хэмжээ авах вэ?
- A. Үүсгэгчийн эсрэг эм, өвдөлт намдаах эм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 - B. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд, өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ.
 - C. Чихээсээр чихийг хуурайшуулахыг зааж өгөөд 5 хоноод давтан үзүүлэхийг ба хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөнө.
 - D. Өвдөлт намдаах эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ.
 - E. Котримоксазол хоногт 2 удаа 5 хоног уулгана.
29. 4 сартай хүүхэд товлолын дагуу вакцинуудаа хийлгэсэн бол өнөөдөр ямар вакцин хийлгэх вэ?
- A. БЦЖ, ВГ, Саа
 - B. Тавт вакцин III, саа IV
 - C. СХХТ III, Саа IV
 - D. СХХТ III, Саа III
 - E. Тавт вакцин III, саа III, пневмококк II
30. Хооллолтын бэрхшээлтэй 1 настай хүүхдийг хэд хоноод үзэх вэ?
- A. 5 хоног
 - B. 14 хоног
 - C. 30 хоног
 - D. 7 хоног
 - E. 2 хоног
31. 9 сартай хүүхэд ханиалгасан ба түүний амьсгал 1 минутанд 42 байна. Өөр эмгэг шинжгүй, Та яаж ангилах вэ?
- A. Уушигны хүнд хатгалгаа
 - B. Уушигны хатгалгаа
 - C. Ханиад шуухинаа
 - D. Томуу
 - E. Маш хүнд өвчин
32. Амны шархлааны үед ямар эмийг хэрэглэх вэ?
- A. Генцианвиолетын уусмал
 - B. Левомецетиний уусмал
 - C. Пенициллины уусмал
 - D. Тетрациклины мазь
 - E. Аньсны ханд
33. Дараахь хүүхдүүдээс хэнд нь рахитыг зайлшгүй -үнэлж, ангилах шаардлагатай вэ?
- A. Баяраа 48 сартай
 - B. Хэрлэн 24 сартай
 - C. Анхаа 26 сартай
 - D. Хонгор 19 сартай
 - E. Дугар 36 сартай
34. Төрсний дараах 7 оос– 12 –р сард хүүхдийн биеийн жин сар тутамд ямар хэмжээгээр нэмэгдэх вэ?
- A. 100 гр
 - B. 200 гр
 - C. 300 гр

- D. 400 гр
E. 500 гр
35. Балчир насанд хүүхдийн биеийн жин жил тутамд ямар хэмжээгээр нэмэгдэх вэ?
A. 1 кг
B. 1,5 кг
C. 2 кг
D. 2,5 кг
E. 3 кг
36. Цэнгүүн 8 настай. Түүний биеийн өндөр одоо хэд байх ёстой вэ?
A. 105 – 110 см
B. 111 – 116 см
C. 117 – 122 см
D. 123 – 128 см
E. 129 – 134 см
37. Цолмон 2 сартай Төрөх үеийн жин нь 2800.0 байсан. Одоогийн байх ёстой жин нь хэд вэ?
A. 3,5 – 4,5 кг
B. 4,5 – 5,5 кг
C. 5,5 – 7,5 кг
D. 7,5 – 8,5 кг
E. 8,5 – 9,5 кг
38. Бугалганы тойргийг хэмжихдээ ямар насанд хийдэг вэ?
A. 6 сараас-5 хүртэлх насанд
B. 5 сараас-1 хүртэлх насанд
C. 1 сараас 1 хүртэлх насанд
D. 1-5хүртэлх насанд
E. 6 сараас 3 хүртэлх насанд
39. Амны аль нэг буланд хуруугаа хүргэхэд тэр талруугаа толгойгоо эргүүлж, амаа ангайлган хэлээ булталзуулах нь ямар рефлекс вэ?
A. Уруул цорвойх рефлекс
B. Хайх рефлекс
C. Хөхөх рефлекс
D. Галантын рефлекс
E. Бауэрийн рефлекс
40. Хяхатнаа амьсгал юугаараа ялгагдах вэ?
A. Амьсгал авахад шуугиантай, зовиуртай
B. Амьсгал гаргахад шуугиантай, зовиуртай
C. Амьсгал авах, гаргах нь шуугиантай, зовиуртай
D. Амьсгал гаргахад хоржигноо сонсогдоно.
E. Уушиг чагнахад гуурсан хоолойн амьсгал сонсогдоно.
41. 2сараас 5 хүртэлх насны хүүхдэд ямар аюултай ерөнхий шинжийг үзлэгийн үед шалгах ёстой вэ?
1.Хүүхэд уух буюу хөхөх чадвартай байгаа эсэх
2.Хүүхэд уусан бүхнээ бөөлжиж байгаа эсэх
3.Хүүхэд татсан эсэх? Хүүхэд унтаарсан буюу ухаангүй байгаа эсэх?
4.Хүүхэд өндөр халуурах эсэх
5.Хүүхэд ханиах үедээ бөөлжиж байгаа эсэх
42. Аль нь хүүхдийг жинлэхэд буруу вэ?
1. Хүүхдийг хооллохоос өмнө жинлэх хэрэгтэй
2. Хүүхдийн наснаас хамааралгүй ямарч төрлийн жин хэрэглэж болно
3. Жинлэхдээ хүүхдийн хувцсыг тайлна

4. Босоо жинг хөхүүл насны хүүхэд жинлэхэд хэрэглэнэ
 5. Өрөө нь дулаан байх хэрэгтэй.
43. 1 хүртэлх насны хүүхдийн хөдөлгөөн сэтгэцийн хөгжлийн 1 шатны онцлогт аль нь орохгүй вэ?
1. Ургийн байрлалтай
 2. Хөдөлгөөн зорилго, чиглэлгүй
 3. Сэтгэл хөдлөл сөрөг
 4. Нугалагч булчингийн чангарал багасна
 5. Өлгий задлахад хүчтэй сундана
44. Залгиурын үрэвслийн үеийн эмчилгээг тогтооно уу.
1. Тохирох антибиотикийг 10 хоног уулгах
 2. Өвдөлтөд парацетамол өгөх
 3. 7 хоноод давтан үзнэ.
 4. Хоолойг давстай усаар зайлах
 5. Эмнэлэгт хэвтүүлэх
45. Цагаан хорхойтой байж болзошгүй үеийн эмчилгээ тогтооно уу.
1. Мебендазол өгөх
 2. Онош тодруулахаар шинжилгээ өгөх
 3. Эмнэлэгт хэвтүүл
 4. Эрүүл ахуйн зөвөлгөө өгөх
 5. Мультивитамин өгөх
46. Рахитыг илэрхийлэх шинж аль нь вэ?
1. Туранхай
 2. Хөлөрдөг
 3. Уцаарладаг
 4. Булчин сул
 5. Татдаг
47. Аль нь эмнэлэгт яаралтай хэвтүүлэх заалт вэ?
1. Уушигны хүнд хатгалгаа
 2. Таталт
 3. Шингэн их алдалт
 4. Хөхлөг ургацгийн үрэвсэл
 5. Халууралт
48. Хүүхдийн хөдөлгөөн-сэтгэц хөгжлийн IV шатанд дараах үйлдлүүдээс хийж чадахгүйг нь сонгоно уу.
1. Юм түшиж өвдөг дээрээ өндийнө
 2. Бусдын үйлдлийг дуурайна
 3. Тоглоомоор зөв тоглож сурна
 4. 10-15 үгийн баялагтай болж богино өгүүлбэрээр ярина
 5. Хуруугаараа жижиг зүйлийг барина
49. Наран, 6 сартай, 8 кг жинтэй, 38,5 хэм халуунтай. 2 хоног ханиалгасан, халуурсан, амьсгал минутанд 44. Өөр зовиур ба эмгэг шинжгүй. Хүүхдийг ангилж эмчилгээ тогтооно уу.
1. Уушгины хатгалгаа гэж ангилна.
 2. Ханиад шуухинаа. Халууралт гэж ангилна.
 3. Котримоксазол талаар хоногт 2 удаа 5 хоног уулгана.
 4. Ханиад зөөлрүүлэх хоргүй зөөлөн эм хэрэглэнэ. Өндөр халуурвал парацетамолын 0,5 шахмалаас дөрөвний нэгээр уулгана. 3 хоноод давтан үзнэ.
 5. 5 хоноод давтан үзнэ.
50. Хүүхдийн хөдөлгөөн-сэтгэц хөгжлийн III шатанд хүүхэд аль үйлдлүүдийг хийж чаддаг болох вэ?

1. Нэрээ мэддэг болно
 2. Сэтгэл хөдлөл эерэг сөрөг байдлаар илэрхийлэх
 3. Дэмжлэгтэйгээр сууж чадна
 4. Дөрвөн хөллөж мөлхөнө
 5. Алив, хаа байна гэдэг үгнүүдийг ойлгож эхэлнэ
51. “Хүнд хүндрэл бүхий улаанбурханыг” ямар шинжүүдээр ангилах вэ?
1. Халуурах
 2. Нүдний эвэрлэг бүдгэрэх.
 3. Амны гүнзгий өргөн шархлаа.
 4. Аюултай ерөнхий шинжээс аль нэг
 5. Одоо эсвэл сүүлийн 3 сарын дотор улаанбурханаар өвчилсөн түүхтэй.
52. 6 сартай хүүг эх нь хөхөө хөхөх, унтаж байхдаа хөлөрдөг, шээс үнэртэй гэсэн зовиуртай эмчид үзүүлэв. ХӨЦМ-ийн дагуу хүүхдийг үнэлэхэд зулайн ирмэг зөөлөрсөн, смпингийн эрхний шинжтэй, хэвлийн булчин суларсан харагдав. Энэ хүүхдэд зохих ангиллын дагуу эмчилгээг хийнэ үү.
1. Д аминдэмийг 2000ед-ээр өдөр бүр 30 хоног уулгах
 2. Нар агаарт гаргах
 3. 30 хоноод давтан үзүүлэх
 4. Дараа нь урьдчилан сэргийлэх тунгаар Д аминдэм өгөх
 5. Эхийг магтах
53. Норов, 9 сартай, 10 кг жинтэй, 2 хоног ханиалгана, амьсгал минутанд 52, цээж нь хонхолзоно. Өөр зовиур ба эмгэг шинжгүй. Ангилж эмчилнэ үү.
1. Уушгины хүнд хатгалгаа буюу маш хүнд өвчин. –гэж ангилна.
 2. Уушгины хатгалаа гэж ангилна.
 3. Тохирох антибиотикийн эхний тунг уулгаад эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ, цусны чихэр багасахаас сэргийлнэ.
 4. Тохирох антибиотикийг 5 хоног уулгаад, ханиад зөөлрүүлэх эм уулгаад гэрээр эмчилнэ.
 5. 2 хоноод давтан үзнэ.
54. Ой хүртэлх хүүхдийн хөдөлгөөн-сэтгэцийн хөгжлийг шалгах үзүүлэлтийг нэрлэнэ үү.
1. Биеийн байрлал
 2. Рефлекс
 3. Хөдөлгөөний эвсэл
 4. Сэтгэл хөдлөл
 5. Хэл яриа, хараа, сонсголын баримжаа
55. ХӨЦМ-ийн дагуу ямар шинжээр нь эмнэлэгт хэвтүүлэх вэ?
1. Гарын алга хувхай цагаан
 2. Хоёр хөлд хавантай
 3. Хүзүү хөшингө
 4. Бүгдийг бөөлжиж байгаа
 5. Насанд тохирсон жин бага
56. Ханиалгаж буй хүүхдэд ямар шинж илрэхэд уушигны хүнд хатгалгаа буюу маш хүнд өвчин гэж ангилах вэ?
1. Амьсгал олшрох
 2. Тайван үедээ хяхтнаж амьсгалах
 3. Цээж хонхолзох
 4. Ямар нэг аюултай ерөнхий шинж
 5. Амьсгал шуугиантай байх
57. Шингэн их алдалттай суулгалтын шинжүүдийг заана уу.
1. Унтаарсан буюу ухаангүй
 2. Нүд хонхойх

- 3.Ууж чадахгүй
 - 4. Уухдаа муу
 - 5.Арьсны хуниас маш удаан арилах
58. Шингэн алдалттай суулгалтын шинжүүдийг заана уу.
- 1.Тайван биш, цочромтгой
 - 2.Нүд хонхойх, цангах ховдоглон уух
 - 3.Арьсны хуниас удаан арилах
 - 4.Уухдаа муу, ууж чадахгүй
 - 5. Арьсны хуниас маш удаан арилах
59. Ханиалга намдаах хоргүй зөөлөн эмийг заана уу.
- 1.Хөхний сүү
 - 2.Аньсны ханд
 - 3.Читамон
 - 4.Уротропин
 - 5.Кодейн
60. Шингэн алдалтгүй суулгалттай хүүхдийг яаж эмчлэх вэ?
- 1. Хүүхдийг гэрт нь хооллон, А төлөвлөгөөний дагуу шингэн өгч эмчилнэ.
 - 2.Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд нь зөвлөнө.
 - 3.Сайжрахгүй бол 5 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө.
 - 4.В төлөвлөгөөний дагуу хооллож шингэн өгнө.
 - 5. Б төлөвлөгөөний дагуу шингэн нөхнө.
61. Цус багадалтгүй, ХТЦД-гүй, рахитгүй 1нас 6 сартай хүүхдэд тохирох зөвөлгөөг өгнө үү.
- 1. Хоололтыг үнэлэн хооллолтын зөвөлгөөг өгнө
 - 2.Д витаминьг урьдчилан сэргийлэх тунгаар өгнө
 - 3.Өнөөдөр А аминдэмийн 1 тунг өгнө
 - 4.Ямар нэг зөвөлгөө шаардлагагүй
 - 5. Төмрийн сироп 14 хоног уулгана
62. Шуугиантай амьсгалтай уушгины хатгалгаагүй ханиад шуухинаатай үед тохирох эмчилгээг зөв тогтооно уу.
- 1. Хоргүй зөөлөн эмээр хоолойн өвдөлт ханиалгыг эмчил
 - 2. Гуурс тэлэгч эм өг
 - 3. Хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг эхэд зөвлө
 - 4. Цусны чихэр багасахаас сэргийлж эмчил
 - 5. Сайжрахгүй бол 2 хоноод давтан үзүүл
63. Нүд буюу амны хүндрэлтэй улаанбурханыг ямар шинжүүдээр ангилах вэ?
- 1. Халуурах ба улаанбурханы түгээмэл тууралт гарах.
 - 2. Нүднээс нуух гойжих.
 - 3. Аманд ганц нэг өнгөц шархлаа бий болох.
 - 4. Аманд өргөн, гүнзгий, олон шархлаанууд үүсэх
 - 5. Нүдний эвэрлэг бүдгэрэх.
64. Хүнд хүндрэл бүхий улаанбурханыг ямар шинжүүдээр ангилах вэ?
- 1. Татах
 - 2. Эвэрлэг бүдгэрэх.
 - 3. Амны гүнзгий өргөн шархлаа.
 - 4. Амьсгал олшрох
 - 5. Суулгах
65. Маш хүнд халууралт өвчнийг ямар шинжүүдээр ангилах вэ?
- 1. 38,5 дээш халуурах
 - 2. Аюултай ерөнхий шинжийн аль нэг илрэх.
 - 3. Эм уухдаа бөөлжих.
 - 4. Хүзүү хөшингө болох.

5. Эм уухдаа бөөлжих.
66. 2 настай Дэмбэрэл Ханиад шуухнаа, халууралт, нүд буюу амны хүндрэлтэй улаанбурхан гэж ангилагдсан байна. Та ямар арга хэмжээ авах вэ?
1. Хоргүй зөөлөн эмчээр ханиалгыг эмчил
 2. Гэртээ хариад өндөр халуурвал парацетамол 0,5 шахмалаас 1\4 –ээр уулахыг зөвлөнө.
 3. Улаан А аминдэмээс өнөөдөр нэг капсулыг өгнө,.
 4. Нүдний халдварыг тетрациклины тосоор эмчлэхийг зааж өгнө.
 5. 3 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө.
67. 2 сараас 5 хүртэлх насны өвчтэй хүүхдийг үнэлж ангилахдаа аюултай ерөнхий шинжүүдээс ямар шинжийг ажиглах ёстой вэ?
1. Хүүхэд уух буюу хөхөх чадвартай байна уу?
 2. Яг одоо татаж байна уу?
 3. Хүүхэд татсан уу?
 4. Унтаарсан буюу ухаангүй байна уу?
 5. Цээж хонхолзож байна уу?
68. 8 сартай 9 кг жинтэй, Шингэн алдалттай суулгалт гэж ангилагдсан хүүхдэд 4 цагийн турш ямар хэмжээний шингэн уулгах вэ?
1. 200-400 мл
 2. 450-800мл
 3. 1200-1400 мл
 4. 75 мл/кг жинд тооцоолон 4 цагийн турш ШСДУ уулгах.
 5. Суулгалт бүрийн дараа 50-100 мл шингэн уулгах.
69. Уушгины хатгалгаатай 6 сартай хүүхдийг 3 хоноод давтан үзэхэд биеийн байдал нь янзандаа, ханиалгасан хэвээр, амьсгал минутанд 52 байв. Ямар арга хэмжээ авах вэ?
1. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эмийг үргэлжлүүлэн өгнө.
 2. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгнө.
 3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 4. 3 хоноод давтан үзнэ.
 5. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
70. 2 сараас 5 хүртэлх насны өвчтэй хүүхдийг үнэлж ангилахдаа эхлээд аюултай ерөнхий шинжүүдийг хэрхэн асууж шалгах вэ?
1. Хүүхэд уух буюу хөхөх чадвартай байна уу
 2. Уусан бүхнээ бөөлжиж байна уу
 3. Хүүхэд татсан уу
 4. Унтаарсан буюу ухаангүй байна уу
 5. Цээж хонхолзож байна уу
71. Чихний цочмог халдвартай гэж ангилсан хүүхдэд ямар арга хэмжээ авах вэ?
1. Үүсгэгчийн эсрэг эм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 2. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгнө.
 3. Чихэнд тарвагны тос дусаана
 4. Өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ. 5 хоноод давтан үзнэ.
 5. 2 хоноод давтан үзнэ.
72. Төрөхөд вакцинуудаа хийлгээгүй 18 хоногтой хүүхдэд ямар вакцинуудыг нөхөн хийж болох вэ?
- 1.БЦЖ
 - 2.Саа
 - 3.ВГ
 - 4.УГУ1

5.СХХТ1

73. Аль тохиолдолд хүүхдийн хооллолтыг үнэлэх естой вэ?
- 1.ХТЦД-тай хүүхдүүдэд
 - 2.Цус багатай хүүхдүүдэд
 - 3.ХТЦД-гүй, цус багадалтгүй ч гэсэн 2 хүртэлх насны бүх хүүхдүүд
 4. ХДХВ-ийн халдвартай хүүхдэд
 - 5.0-5 насны бүх хүүхдэд
74. Хяхтнаа амьсгал илэрсэн хүүхдэд эмч хэрхэн туслах вэ?
1. Гараа эмчилгээнд цусны сахар багасахаас сэргийлнэ.
 - 2.Гараа эмчилгээнд үүсгэгчийн эсрэг эмийн эхний тунг тохирох тунгаар уулгана.
 3. Утлага хийж гэрээр эмчилнэ
 4. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 - 5.Хөлийг гичтэй усанд дүрж гэрээр эмчилнэ.
75. Ханиад шуухинаатай хүүхдийг хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөх вэ?
- 1 Халуурах.
 2. Өвчин хүндрэх
 3. Амьсгал олшрох
 4. Амьсгал саадтай болох
 5. Хөхөндөө буюу хоолондоо муудах
76. ХӨЦМ-ийн дагуу Уушигны хатгалгаа гэдэг ангилалтай хүүхдийг гэрээр эмчлэхдээ ямар шинж илэрвэл яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөх вэ?
- 1.Уух буюу хөхөндөө муудах
 - 2.өвчин хүндрэх
 - 3.Халуурах
 4. Амьсгал олшрох
 5. Уйлагнах
77. 6 сартай хүүхдэд А аминдэмийг ямар тунгаар ямар заалтаар өгөх вэ?
- 1.А аминдэмийн хөх капсулаас 1 ширхэгийг өгнө.
 - 2.Улаан капсулаас талыг буюу 3 дуслыг өгнө
 3. Эрүүл ч гэсэн А аминдэм 6 сар тутамд өгнө.
 - 4.Улаанбурхан ангилагдсан хүүхдэд А аминдэм өгнө
 5. ХТЦД гэсэн ангилалтай хүүхдэд А аминдэм уулгана.
78. Халуурч буй хүүхдэд улаанбурханы ямар шинжүүдийг ажиглах естой вэ?
- 1.Түгээмэл тууралт
 2. Ханиалга
 3. Нус гоожих
 4. Нүд улайх
 5. Халуурах
79. Зөвхөн хөхөө хөхдөг, бор хоолонд ороогүй, 6 сар хүрээгүй хүүхдэд ханиалга намдаах хоргүй зөөлөн ямар эмчилгээ хийх вэ?
1. Шар тостой аарц
 2. Зөгийн балтай сүү
 3. Аньсны ханд
 4. Хөхний сүү
 5. Уротропин
80. 38.5 хэмээс дээш халуурч буй 2.5 настай хүүхдэд парацетамолын 500 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?
1. 1.5
 - 2.1/2-ээр
 - 3.1 бүтнээр
 4. ¼-ээр

5. 2 бүтнээр

81. ХТЦХтэр дуталтай хүүхдийг 14 хоногийн дараа давтан үзлэгээр үзэх ба ХТЦХтэр дутал ангиллаас гарсан бол эхийг магтаж үргэлжлүүлэн хооллохыг зөвлөнө.
82. Хүүхэд 4 сартайд хөрвөөж эхлэх ба 8 сартайд юм түшиж муухан явах ба 10-12 сартайд биеэ даан анхны алхам хийнэ.
83. 2 сар хүртэлх хүүхдийн цээжний хэнхэрцэг уян зөөлөн учраас цээж ялимгүй хонхолзох шинж байж болно.
84. Ханиад шуухинаатай хүүхдэд хяхтнаа амьсгал илрэх учраас шуугиантай амьсгалтай үед гуурс тэлэгч эм өгнө.
85. Хүчилтөрөгчийг хамрын гуурсаар өгөх нь хамгийн тохиромжтой арга ба хэмжихдээ хамрын хажуугаас хөмсөгний дотор ирмэг хүртэл хэмждэг учир шалгах шаардлагагүй.
86. Шингэн алдалтгүй суулгалттай хүүхдэд цайрын бэлдмэл уулгана. Учир нь шингэн алдалтгүй үед нүд хонхойж, цангасан, ховдоглон ууна.
87. Улаанбурхантай 11сартай хүүхдэд А аминдэм 100000ED уулгах учраас А аминдэм тухайн өвчний хүндрэлээс сэргийлдэг.
88. Төмрийн бэлдмэлийг цус багадалттай хүүхдэд уулгана. Учир нь цус багадалтын үед төмөр дутагддаг.
89. Хяхтнаа амьсгалтай үед утлага эмчилгээ хийнэ. Учир нь хяхтнаа амьсгалтай үед амьсгал авалтандаа саадтай болдог.
90. Шуугиантай амьсгалтай үед гуурс тэлэгч эмээр утлага эмчилгээ хийнэ. Учир шуугиантай амьсгалтай үед амьсгал гаргалтандаа саадтай болдог.
91. Хурц тураалын үед Жин өндрийн Z оноогоор -2-3 хооронд байдаг. Учир нь хурц тураалын үед БТ-115 мм буюу түүнээс болдог.
92. Хүүхдийн насны үеийг уялдуулан сонгоно уу.
- | | |
|---------------|--------------------|
| 1. Нярай үе | A. 1 нас хүртэл |
| 2. Хөхүүл үе | B. 4-6 нас |
| 3. Балчир нас | C. 11-18 нас |
| 4. Бага нас | D. 28 хоног хүртэл |
| 5. Өсвөр нас | E. 1-3 нас |
- A. 1B 2E 3A 4D 5C
B. 1E 2D 3B 4C 5A
C. 1A 2E 3B 4C 5D
D. 1C 2E 3B 4D 5A
E. 1D 2A 3E 4B 5C
93. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу.
- 4 сар
 - 5 сар
 - 6 сар
 - 8 сар
 - 10 сар
- A. Гартаа тааралдсан зүйлийг чанга атгаж, амандаа хийнэ. Мөлхөхийг завдана. /элгээрээ/
B. Дэмжлэгтэй сууна, түрүүлгээ харуулахад хөрвөж чадна.
C. Аяганаас асгаж цутгахгүй ууна
D. Гараа тулж өндийнэ.
E. Юм түшиж өндийнэ, өөрөө буцаж сууна.
- A. 1B 2E 3A 4D 5C
B. 1D 2B 3A 4E 5C
C. 1A 2E 3B 4C 5D
D. 1C 2E 3B 4D 5A

E. 1D 2E 3B 4C 5A

94. Давтан үзлэгт тохирсон ангиллыг сонгоно уу.

1. Ханиад шуухианаа
2. Хүндрэлгүй хоол тэжээлийн цочмог хүнд дутал
3. Уушигны хатгалгаа
4. Цус багадалт
5. Рахит

- A. 3 хоноод давтан үзүүл
B. 5 хоноод давтан үзүүл
C. 30 хоноод давтан үзүүл
D. 14 хоноод давтан үзүүл
E. 7 хоноод давтан үзүүл

- A. 1B 2E 3A 4D 5C
B. 1E 2D 3B 4C 5A
C. 1A 2E 3B 4C 5D
D. 1C 2E 3B 4D 5A
E. 1D 2E 3B 4C 5A

95. ХӨЦМ-ийн дагуу дараах шинжүүдийг тохирох ангилалд уялдуулан сонгоно уу.

1. Уусан болгоноо бөөлжих
 2. Нүд хонхойх
 3. Гавлын яс зөөлрөх
 4. Цээж хонхолзох
 5. 2 хөлд хаван
- A. Хоол тэжээлийн цочмог хүндрэлтэй хүнд дутал
B. Рахит

- C. Уушигны хатгалгаа
D. Маш хүнд өвчин
E. Шингэн алдалт

- A. 1B 2E 3D 4C 5A
B. 1E 2D 3B 4C 5A
C. 1A 2E 3B 4C 5D
D. 1C 2E 3B 4D 5A
E. 1D 2E 3B 4C 5A

96. Хүүхдийн хэвийн амьсгалын тоог настай нь уялдуулан сонгоно уу.

1. Нярай хүүхэд A. 25 хүртэл
2. 1-12 сартай B. 30-40 хүртэл
3. 1-2 настай C. 35-50 хүртэл
4. 5-6 настай D. 18-20 хүртэл
5. 10 настай E. 40-60 хүртэл

- A. 1C 2E 3D 4A 5B
B. 1E 2D 3C 4A 5D
C. 1B 2D 3C 4A 5E
D. 1E 2C 3B 4A 5D
E. 1B 2D 3A 4E 5C

97. Ангилал ба эмчилгээний зарчмыг уялдуулан сонгоно уу.

1. Хүндрэлтэй хоол тэжээлийн цочмог хүнд дутал
2. Хүндрэлтгүй хоол тэжээлийн цочмог хүнд дутал
3. Хоол тэжээлийн цочмог хүндэвтэр дутал

- A. Эмчилгээний бэлэн хоол .500ккал/хоногт өгнө
B. Тохирох антибиотиктийн эхний тунг өг

С. Төмөр, цайр, ШСД-ны уусмал хэрэглэхгүй

A. 1A 2 B 3C

B. 1B 2A 3 C

C. 1C 2A 3B

D. 1A 2C 3B

E. 1B 2C 3A

98. Дараах хамаарлыг уялдуулан сонгоно уу.

1. Хэвийн халуун A. 37.5 хэмээс дээш

2. Халууралт B. 36.5-37.5 хэм

3. Хүндэвтэр гипотерми C. 36-36.5 хэм

4. Хүнд гипотерми D. 32-36 хэм

5. Хүйтний цочрол E. 32 хэмээс доош

A. 1B 2A 3D 4E 5B

B. 1A 2B 3C 4D 5B

C. 1B 2A 3C 4D 5 E

D. 1E 2D 3C 4B 5A

E. 1C 2A 3B 4D 5E

99. Дараах асуултыг уялдуулан сонгоно уу.

1. Хяхтнаа амьсгал

2. Шуугиант амьсгал

3. 2 сар хүртэлх хүүхэд

4. 2-12 сар хүртэлх хүүхэд

5. 12-5 нас хүртэлх хүүхэд

A. 1 минутанд 50 буюу түүнээс дээш

B. 1 минутанд 40 буюу түүнээс дээш

C. 1 минутанд 60 буюу түүнээс дээш

D. Амьсгал авах үед сонсогдоно

E. Амьсгал гаргах үед сонсогдоно

A. 1E 2D 3A 4C 5B

B. 1C 2E 3D 4A 5B

C. 1E 2D 3C 4A 5B

D. 1C 2E 3D 4B 5A

E. 1D 2E 3C 4B 5A

100. Хүүхдийн хөдөлгөөн сэтгэцийн хөгжлийн үе шатыг зөв уялдуулна уу.

A. Сэтгэл хөдлөл ялгавартай болж, ээжийгээ таньж баясан танихгүй хүнээс бишүүрхэн уйлдаг болно.

B. Дэмжлэгтэйгээр сууна

C. Харц тогтворжоогүй, дуу авиаг ялгах чадваргүй байна.

D. Бие засах тухайгаа өөрөө хэлнэ.

E. Байнгын шүд ургана.

1. 3-6 сартайд

2. 5-7 настайд

3. 1.5 настайд

4. 1.5 хүртэлх сартайд

5. 5 сартайд

A. 1B 2D 3E 4C 5A

B. 1B 2A 3D 4C 5E

- C.1A 2E 3D 4C 5B
- D. 1A 2E 3C 4D 5B
- E. 1C 2A 3E 4B 5D

ДОТОР ӨВЧИН СУДЛАЛ

1. Уушгины үрэвсэл үүсэх гол шалтгааныг нэрлэ.
 - A. Зохисгүй хооллолт
 - B. Хөдөлгөөний дутагдал
 - C. Дархлаа сулрах
 - D. Нян, вирус
 - E. Архидалт
2. Артерийн даралт ихдэх өвчний үхэлд хүргэх шалтгаан аль нь вэ?
 - A. Тархины цус харвалт
 - B. Толгойн хүчтэй өвдөлт
 - C. Бөөрний дутагдал
 - D. Зүрхний дутагдал
 - E. Чихрийн шижин
3. Хэрэхийн анхдагч урьдчилан сэргийлэлтэнд аль нь орох вэ?
 - A. Зүрхний гажиг батлагдсан бол анхдагч урьдчилан сэргийлэлтийг хийнэ.
 - B. Хэрэх өвчний дахилтаас сэргийлж антибиотик эмчилгээ хийнэ
 - C. Хэрэх өвчний намжилтын үед бензатин пенициллиныг 1 жил үргэлжлүүлэн хийнэ
 - D. Залгиурын стрептококкт үрэвслээс үүдэлтэй амьсгалын дээд замын үрэвслийг антибиотик эмчилгээ хийж эмчлэх
 - E. Үений үрэвсэл батлагдсан үед антибиотик эмчилгээ хийнэ
4. Тогтвортой стенокардийн үйл ажиллагааны ангилалаар 3-р зэргийг заана уу.
 - A. Гэнэтийн эрч хүчтэй ердийнхөөс их ачааллын үед цээжээр өвдөнө
 - B. Тэгш гадаргуу дээр 100-500 метр алхахад цээжээр өвдөнө
 - C. Өгсүүр газар 200-500 метр алхахад цээжээр өвдөнө
 - D. Тэгш гадаргуу дээр 500-1000 метр алхахад цээжээр өвдөнө
 - E. Өгсүүр газар 100-1000 метр алхахад цээжээр өвдөнө
5. Зүрхний бахын өвдөлтийн онцлог ямар байх вэ?
 - A. Өвдөлт 30 минутаас дээш үргэлжилнэ
 - B. Өвдөлт хэдэн секундээс 15 минут
 - C. Өвдөлт 1 цагаас дээш
 - D. Өвдөлт хэдэн өдөр үргэлжилнэ
 - E. Өвдөлт 2 цагаас дээш
6. Ходоодны хүчил дарангуйлах эмийг нэрлэ.
 - A. Церукал
 - B. Урсофальк
 - C. Пантопразол
 - D. Солкосерил
 - E. Мотилиум
7. Ортнерийн шинж гэж юу вэ?
 - A. Цөсний хүүдийн цэгт дарахад эмзэглэлтэй
 - B. Баруун хавирганы нуман дээр доргиоход хөндүүр
 - C. Амьсгал авах үед цөсний цэгт дарахад амьсгал тасалдана
 - D. Өвчүү хөхлөг сэртэнгийн булчингийн 2 хөлийн завсар дарахад цөсний цэгт эмзэглэлтэй
 - E. Аюулхайд тэмтэрхэд эмзэглэлтэй
8. Гломеруланефритийн хүндрэлийг нэрлэ.

- A.Архаг гломеруланефрит
 - B.Архаг пиелонефрит
 - C.Бөөрний архаг дутагдал
 - D.Бөөрний цочмог дутагдал
 - E.Цочмог пиелонефрит
- 9.Гломеруланефритийн урьдчилан сэргийлэлтийн чухал хэсэг нь аль вэ?
- A.Хоёрдогч урьдчилан сэргийлэлт буюу эмчийн хяналт
 - B.Анхдагч урьдчилан сэргийлэлт буюу эмчийн хяналт
 - C.Гуравдагч урьдчилан сэргийлэлт буюу эмчийн хяналт
 - D.Амьсгалын дээд замын халдварыг цаг тухайд нь эмчлэх
 - E.Хөдөлмөр зохицуулалт хийх
- 10.Бөөрний гаралтай хавангийн шинжид аль нь орох вэ?
- A.Цайвар зөөлөн дарахад хонхойно
 - B.Улайвтар хатуу бүлээн
 - C.Цайвар хатуу дарахад хонхойно
 - D.Хатуувтар арьсны өнгө хөхөлбий
 - E.Зөөлөн арьсны өнгө шаравтар
- 11.Зимницкийн сорилоор тодорхойлох үзүүлэлтийг нэрлэ.
- A.1 минутын диурез, бөөрний түүдгэнцрийн шүүх хурдыг үзнэ
 - B.Гурав гурван цагийн зайтай хоногийн турш шээсийг цуглуулж бөөрний үйл ажиллагааг үзнэ
 - C.Шингэний ачаалал өгч бөөрний шингэрүүлэлтийн үйл ажиллагааг үзнэ
 - D.Цүрст элементийн эзэлхүүн тодорхойлох
 - E.24 цагийн шээсэнд дүрст элемент үзнэ
- 12.Тархмал хордлогот бахуу өвчнийг оношилох хамгийн ач холбогдолтой шинжилгээг нэрлэ.
- A.Цусны ерөнхий шинжилгээ
 - B.Биохимийн шинжилгээ
 - C.Бамбайн дааврын шинжилгээ
 - D.Рентген шинжилгээ
 - E.Бамбайн ЭХО
- 13.Төмрөөр баялаг хүнсний бүтээгдэхүүнийг нэрлэ.
- A.Малын элэг
 - B.Өндөг
 - C.Сүү
 - D.Хиам
 - E.Будаа
- 14.Төмөр дутагдлын цус багадалтын үед хийгдэх эмчилгээг сонгоно уу.
- A.Витамин С
 - B.Төмрийн бэлдмэл
 - C.Витамины комплекс
 - D.Глюкоз
 - E.Шингэн сэлбэх
- 15.Төмрийн шимэгдэлтийг сайжруулах бүтээгдэхүүнийг нэрлэ.
- A.Сүү тараг
 - B.Витамин С
 - C.Гурилан бүтээгдэхүүн
 - D.Кальци
 - E.Мах
- 16.Артерийн даралтын түвшингийн ангиллаар, артерийн даралт ихдэлтийн 1-р зэргийг заана уу.

- A.Систол 125-129/ диастол 80 мм.муб
 - B.Систол 130-150/ диастол 80-85 мм.муб
 - C.Систол 140-160/ диастол 85-90 мм.муб
 - D.Систол 130-139/ диастол 80-89 мм.муб
 - E.Систол 150-160/ диастол 90-100 мм.муб
- 17.Артерийн даралт ихдэлтийн цочмог хүндрэлийг нэрлэ.
- A.Криз
 - B.Зүрхний архаг дутагдал
 - C.Бөөрний архаг дутагдал
 - D.Цээжний бах
 - E.Тархины цусан хангамжийн архаг дутагдал
- 18.Зүрхний шигдээсийн үндсэн шинжийг нэрлэ.
- A.Амьсгал давчдах
 - B.Артерийн даралт буурах
 - C.Цээжний өвдөлт
 - D.Зүрхний хэм алдагдах
 - E.Аюулхайд өвдөх
- 19.МОНА эмчилгээний зорилтыг нэрлэ.
- A.Амьсгаадалтыг намдаана
 - B.Хэм алдаглыг засна
 - C.Сэхээн амьдруулах арга хэмжээ болно
 - D.Өвдөлт, амьсгаадалтыг намдааж тайвшруулна
 - E.Тайвшруулна
- 20.МОНА эмчилгээнд аль нь орох вэ?
- A.Морфин, натри хлорид, нитроглицерин
 - B.Морфин, хүчилтөрөгч, нитроглицерин, аспирин
 - C.Нитроглицерин, аспирин, гепарин, хүчилтөрөгч
 - D.Гепарин, морфин, деклоденк, аспирин
 - E.Морфин, лансорбид, нитроглицерин, аспирин
- 21.МОНА эмчилгээний үед морфиныг ямар тунгаар хэрэглэх вэ?
- A.10 мг
 - B.5 мг
 - C.3 мг
 - D.2 мг
 - E.15 мг
- 22.МОНА эмчилгээнд аспирины хэрэглэх заалтыг нэрлэ.
- A.162-325 мг зажлуулж уулгах
 - B.160-260 мг залгиж уух
 - C.140-280 мг зажлуулж уулгах
 - D.150-500 мг залгиж уух
 - E.250-380 мг зажлуулж уулгах
- 23.Багтраа өвчний амь насанд аюултай хүндрэлийг заана уу.
- A.Албадмал байрлал
 - B.Хөшүүн багтраа
 - C.Амьсгал гаргалт удаашрах
 - D.Тархины цусан хангамжийн дутагдал
 - E.Уушги дүрхний хам шинж
- 24.Мэдрэл сульдлын шинжид аль нь хамаарах вэ?
- A.Толгой өвдөх, дотор муухайрах
 - B.Арьс салст шарлах, арьс загатнах

- С.Хөлрөх, хоолонд дургүй болох
 D.Нойр өөрчлөгдөх, ядарч сульдах
 E.Хамар буйлнаас цус гарах, толгой эргэх
- 25.Биж шинжид аль нь хамаарах вэ?
 A.Арьс салст шарлах, дотор муухайрах
 B.Хоолны дуршил өөрчлөгдөх, ядарч сульдах
 C.Бөөлжис цутгах, дотор муухайрах, аюулхайд эвгүй оргих, гэдэс дүүрэх
 D.Гулгих, хөлрөх, толгой өвдөх
 E.Нүдний салст шарлах, шээсний өнгө өөрчлөгдөх
- 26.Элэгний их шинжид аль нь хамаарах вэ?
 A.Хэл улаан гилгэр болох, алга улайх
 B.Элэг томрох, арьс салст шарлах
 C.Элэг багасах, хамар буйлнаас цус гарах
 D.Одлог тууралт гарах, дэлүү томрох
 E.Нүдний салст шарлах, халуурах
- 27.Элэгний архаг үрэвслийн гол хүндрэлийг нэрлэ.
 A.Элэгний хатуурал
 B.Элэгний өмөн
 C.Цус алдалт
 D.Элэг бөөрний хам шинж
 E.Хэвлийд шингэн хурах
- 28.Элэгний В вирусын халдвараас урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй аргыг нэрлэ.
 A.Эмнэлгийн багаж төхөөрөмжийн ариутгал халдваргүйтгэл
 B.Хувийн ариун цэвэр
 C.Вакцинжуулалт
 D.Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт
 E.Эмийн зохистой хэрэглээ
- 29.Бөөрний тэвшинцэрийн үрэвсэл үүсгэх гол шалтгааныг нэрлэ.
 A.Нас хүйсийн онцлог
 B.Ажил амьдралын нөхцөл
 C.Шээс дамжуулах замын гаж хөгжил
 D.Нянгийн халдвар
 E.Бэлгийн замын өвчин
- 30.Өөрчилж болох эрсдэлт хүчин зүйлд аль нь хамаарах вэ?
 A.Нас
 B.Илүүдэл жин
 C.Удамшил
 D.Жирэмсний чихрийн шинжингийн өгүүлэмж
 E.Хүйс
- 31.Өлөн үеийн цусны глюкозын өөрчлөлтийг заана уу.
 A. 6,1-6,9 ммоль/л
 B. 5,6-6,1 ммоль/л
 C. 6,0-7,0 ммоль/л
 D. 5,0-5,6 ммоль/л
 E. 7,0-ммоль/л-ээс дээш
- 32.Тамхинаас гарах таван "З" зөвлөгөөнд аль нь хамаарах вэ?
 A.Зарла, зайлсхий, зөв амьсгалах, зөвхөн ус уу, завгүй бай
 B.Зарла, зайлсхий, зөв дасгал, зөвхөн цэвэр ус уух, завгүй бай
 C.Зарла, зайлсхий, зөв амьдарлын хэв маяг, зөв дасгал, завгүй бай

- D.Зарла, зайлсхий, зөв алхалт, зөв хооллолт, зөвхөн эрдэсжүүлсэн ус уух, завгүй бай
- E.Зарла, зайлсхий, зөв эрүүл мэндийн боловсрол, зөвхөн ус уух, завгүй бай
33. Чихрийн шижингийн үед дасгал хийхийн ач холбогдлыг нэрлэ.
- A.Таргалалтаас сэргийлнэ
 - B.Чихрийн шижингийн хөлний хүндрэлээс сэргийлнэ
 - C.Инсулины мэдрэг чанар сайжирч цусны глюкоз багасна
 - D.Сахар бууруулах эмийн хэрэглээ багасна
 - E.Зүрх судасны өвчнөөс сэргийлнэ
- 34.Зан үйлийн эрсдэлт хүчин зүйлд аль нь орох вэ?
- A.Артерийн даралт ихсэлт
 - B.Таргалалт
 - C.Сэтгэл гутрал
 - D.Эрүүл бус хооллолт
 - E.Гипергликеми
- 35.Нийгэм сэтгэл зүйн эрсдэлт хүчин зүйлд аль нь орох вэ?
- A.Хөдөлгөөний хомсдол
 - B.Стресс бухимдал
 - C.Архи тамхины зохисгүй хэрэглээ
 - D.Илүүдэл жин таргалалт
 - E.Буруу хооллолт
- 36.Тамхины найрлага дахь никотины хорт үйлчлэлийг нэрлэ.
- A.Судас агшааж тромбоцитын бөөгнөрөл үүсгэж цус бүлэгнүүлнэ
 - B.Ходоодны хүчил ихэсгэнэ
 - C.Зүрх судасны өвчин үүсгэнэ
 - D.Микроэлементийн дутагдал үүсгэнэ
 - E.Хорт хавдар үүсгэнэ
- 37.Глюкозын ачаалалтай сорилын дараах глюкозын тэсвэржилт алдагдал гэж юу вэ?
- A. <7.8 ммоль/л
 - B. 7,8-11,0 ммоль/л
 - C. 6,9-7,8 ммоль/л
 - D. <11.0 ммоль/л
 - E. >11.1 ммоль/л
- 38.Шингэний хэмжээ ихэссэн үед ямар арга хэмжээ төлөвлөх вэ?
- A.Шингэний баланс хөтлөх, уух шингэнийг хязгаарлах
 - B.Артерийн даралтыг хянах
 - C.Хаванг хянах
 - D.биеийн жинг үзэх
 - E.Бүсэлхийн тойрог хэмжих
- 39.Глюкозжсон гемоглобины хэвийн хэмжээг нэрлэ.
- A. <5.6%
 - B. 5,6-6,4%
 - C. 6,5-7,0%
 - D. 7,0-7,8%
 - E. > 7.8%
- 40.Төмрийн бэлдмэлийг тариагаар хэрэглэх заалтыг нэрлэ.
- A.Цагаан хоолтой хүмүүст
 - B.Тураалтай
 - C.Ходоод гэдэс тайрагдсан, ходоод гэдэсний шархтай тохиолдолд
 - D.Хоолны шингэц өөрчлөгдсөн
 - E.Хоол тэжээлийн дутагдалтай

- 41.Өөрчилж болох эрсдэлт хүчин зүйлд аль нь орох вэ?
- 1.Цусан дахь өөх тос
 - 2.Артерийн даралт ихсэх
 - 3.Тамхи татах
 - 4.Удамшил
 - 5.Нас
- 42.Гуурсан хоолойн архаг үрэвсэл үүсгэх шалтгааныг нэрлэ.
- 1.Халдвар
 - 2.Харшил
 - 3.Агаарын бохирдол
 - 4.Ажил мэргэжил
 - 5.Цусанд өөх тос ихсэх
- 43.Гуурсан хоолойн архаг үрэвслийн эмнэл зүйн шинжийг нэрлэ.
- 1.Ханиалгах
 - 2.Цэр гарах
 - 3.Амьсгаадах
 - 4.Халуурах
 - 5.Ам цангах
- 44.Гуурсан хоолойн архаг үрэвслээс урьдчилан сэргийлэх арга замуудыг нэрлэнэ үү.
- 1.Тамхи татахгүй, дам тамхидалтаас зайлсхийх
 - 2.Амьсгалын замын цочмог халдвараас сэргийлэх, цаг тухайд нь эмчлэх
 - 3.Ариун цэвэр, эрүүл ахуйн нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлэх
 - 4.Ажлын нөхцөлийг сайжруулах
 - 5.Удамшлын хүчин зүйлийг багасгах
- 45.Гуурсан хоолойн багтраа өвчний тодорхойлолтонд хамаарах ойлголтыг заана уу.
- 1.Амьсгал боогдох, бачуурах
 - 2.Ханиалгах
 - 3.Үе үе багтрах шинжээр илэрдэг
 - 4.Халдвар харшлын шалтгаантай
 - 5.Дархлалын ба дархлалын бус эмгэг жамаар явагддаг
- 46.Багтраа хөдөлснийг илэрхийлэх шинжийг нэрлэнэ үү.
- 1.Исгэрсэн хяхтнасан амьсгал зайнаас сонсогддог
 - 2.Албадмал байрлалд орох
 - 3.Нүүр нь хөхөрсөн, цайсан, хүйтэн хөлс чийхарсан, айж сандарсан
 - 4.Амьсгал гаргалт удаашрах
 - 5.Амьсгал авалт хэвийн
- 47.Гуурсан хоолойн багтрааны үед асуумжаар илрүүлэх гол зовиурыг нэрлэ.
- 1.Шөнийн цагаар хүчтэй бөгшүүлж ханиадаг эсэх
 - 2.Биеийн ачааллын дараа агаар дутагдах мэдрэмж төрдөг эсэх
 - 3.Шөнө амьсгалахад бэрхшээлтэй болж сэрдэг эсэх
 - 4.Өвчтөн айж сандарсан эсэх
 - 5.Амьсгаадсан эсэх
- 48.Гуурсан хоолойн багтраа ямар хүндрэлд хүргэж болох вэ?
- 1.Уушги зүрхний хам шинж
 - 2.Хөшүүн багтраа
 - 3.Пневмоторакс
 - 4.Тархины цусан хангамж дутагдах
 - 5.Уушгины үрэвсэл
49. Гуурсан хоолойн багтраатай үйлчлүүлэгчид сувилагчийн үзүүлэх тусламжийг заана уу.
- 1.Эмч дуудах
 - 2.Үйлчлүүлэгчийг тухтай байрлалд байрлуулах

- 3.Бариу хувцасыг тайлуулах
 - 4.Өрөөнд цэвэр агаар орох нөхцөлийг бүрдүүлэх
 - 5.Халаасны цацлагыг хэрэглүүлэх
- 50.Гуурсан хоолойн багтраатай үйлчлүүлэгч хүлээж авсан тохиолдолд сувилагчийн бэлдэх зүйл юу байх вэ?
- 1.Тариурууд
 - 2.Эуфиллин
 - 3.Преднизолон
 - 4.Эфидрин
 - 5.Адреналин, атрофин
- 51.Гуурсан хоолойн багтрааны үед хийгдэх оношилгооны аргыг сонгоно уу.
- 1.Арьсны сорил
 - 2.Цэрний шинжилгээ
 - 3.Спирограмм
 - 4.Цусны шинжилгээ
 - 5.Иммунологийн шинжилгээ
- 52.Гуурсан хоолойн багтраа өвчний сэдрэлийн үед хийгдэх сувилахуйн тусламжийг сонгоно уу.
- 1.Орны толгойг өндөрлөх
 - 2.Илчлэг хоолыг бага багаар өгөх
 - 3.Амьсгалын өөрчлөлтийг 2-4 цаг тутам үнэлэх
 - 4.Хүйтэн агаараар амьсгалуулахгүй байх
 - 5.Дасгал хөдөлгөөн хийлгэх
- 53.Багтраа өвчний урьдчилан сэргийлэлтэнд хамаарах ойлголтыг нэрлэ.
- 1.Тамхи татахгүй, дам тамхидалтанд өртөхгүй
 - 2.Ажил амралтын дэглэмээ зохицуулах
 - 3.Иргэдэд өвчний тухай мэдлэг олгох
 - 4.Нянгийн эсрэг эмчилгээ хийх
 - 5.Хүчилтөрөгчийг цаг тухайд нь өгч сэдрэлээс сэргийлэх
- 54.Уушгины үрэвслийг үүссэн нөхцөлөөс нь хамаарч хэрхэн ангилах вэ?
- 1.Эмнэлгээс гадуур үүссэн
 - 2.Эмнэлэгт үүссэн
 - 3.Дархлаа дарангуйлагдсан хүмүүст үүссэн
 - 4.Нянгаар үүссэн
 - 5.Вирусээр үүссэн
- 55.Уушгины цочмог үрэвслийн үед илрэх эмнэл зүйн шинжийг нэрлэ.
- 1.Ханиалгах
 - 2.Амьсгаадах
 - 3.Халуурах
 - 4.Цээжээр өвдөх
 - 5.Амьсгал боогдох
- 56.Уушгины үрэвслийн үед үзлэгээр илрэх шинжийг заана уу.
- 1.Амьсгалын тоо олширсон
 - 2.Биеийн халуун ихэссэн
 - 3.Цээжийг тэмтэрхэд эмзэглэлтэй
 - 4.Цээжийг харахад эмгэгтэй тал амьсгалд хоцорч оролцоно
 - 5.Тогшилтоор тогшилтын чимээ ихэссэн
- 57.Уушгины үрэвслийг оношилох лабораторийн шинжилгээний аргыг нэрлэнэ үү.
- 1.Цусны ерөнхий шинжилгээ
 - 2.Цэрэнд үүсгэгч тодорхойлох
 - 3.Цусны өсгөвөрлөх шинжилгээ

- 4.Гадаад амьсгалын үйл ажиллагааны сорил
- 5.Арьсны сорил
- 58.Уушгины үрэвслийн үед тохиолдож болох хүндрэлийг нэрлэнэ үү.
 - 1.Гуурсан хоолойн багтраа
 - 2.Уушгины буглаа
 - 3.Уушгины сүрьеэ
 - 4.Плеврит
 - 5.Уушгины архаг бөглөрөл
- 59.Уушгины үрэвслийн эмчилгээний зарчмыг нэрлэ.
 - 1.Халдварын эмчилгээ
 - 2.Эмгэг жамын эмчилгээ
 - 3.Шинж тэмдгийн эмчилгээ
 - 4.Физик эмчилгээ
 - 5.Нөхөн сэргээх эмчилгээ
- 60.Амьсгалын замын клиренс алдагдсан өвчтөнд үзүүлэх сувилахуйн тусламжийг сонгоно уу.
 - 1.Цэр гадагшлуулах зорилгоор толгойг гударган байрлалд оруулах
 - 2.Цээжинд доргионт массаж хийх
 - 3.Хоногт 2-3л шингэн уулгах
 - 4.Цэрийг залгиулахгүй байх, хлорамины уусмалаар цэвэрлэсэн тагтай сав өгч цэрний өнгө, үнэр, хэмжээг ажиглах
 - 5.Амьсгалын өөрчлөлтийг хянах
- 61.Уушгины хурц үрэвсэл сайжирч байгааг тодорхойлох үзүүлэлтийг сонго.
 - 1.Цусны ерөнхий шинжилгээд лейкоцит $8,0 \times 10^9$ л-ээс ихсэх
 - 2.Амьсгалын тоо 1 минутанд 25-аас ихсэх
 - 3.Чагнахад хуурай нойтон хэржигнүүр тогтвортой байх
 - 4.Ханиахад цэр чөлөөтэй гарч амьсгалын тоо 1 минутанд 18-19 байх
 - 5.Уушгины тогшилтын чимээ богиносч, халуун буурах
- 62.Артерийн даралт ихдэх өвчний эрсдэлт хүчин зүйлийг нэрлэ.
 - 1.Агаарын бохирдол
 - 2.Стресс, сэтгэл зүйн хямрал
 - 3.Гипохолестринемид
 - 4.Зохисгүй хооллолт
 - 5.Биеийн хүчний ачаалал
- 63.Артерийн даралт ихдэх өвчний үед илрэх гол зовиурыг нэрлэ.
 - 1.Толгой өвдөх
 - 2.Нүд бүрэлзэх
 - 3.Чих шуугих
 - 4.Хараа муудах
 - 5.Зүрхээр өвдөх
- 64.Артерийн даралт ихсэлттэй өвчтөний үнэлгээнд аль нь хамаарах вэ?
 - 1.Асуумж
 - 2.Бодит үзлэг
 - 3.Лабораторийн шинжилгээ
 - 4.Багажийн шинжилгээ
 - 5.Нас
- 65.Артерийн даралтыг хэмжихдээ анхаарах зүйлийг нэрлэ.
 - 1.Жирэмсэн эмэгтэйчүүдийн даралтыг анхааралтай хэмжих
 - 2.Артерийн даралтаа хэмжүүлэхдээ багадаа 30 минутын өмнө хүнд дасгал хөдөлгөөн хийхгүй, их идэх, кофей, цай, кола ууж болохгүй

- 3.45-аас дээш насныхны даралтыг жилд 1 удаа хянаж байх
- 4.Артерийн даралтыг 1-2 минутын зайтай доод тал нь 2 удаа хэмжих ба даралтын түвшин зөрүү ихтэй байвал нэмэлт хэмжилтийг дахин хийх
- 5.Өрхийн эмч өвчтөнүүдэд артерийн даралтаа хэмжүүлэх талаар зар хүргүүлэх
- 66.Цусны даралт ихсэх өвчний хүндрэлийн шинж ямар зовиураар илрэх вэ?
 - 1.Дотор эвгүй оргиж бөөлжих
 - 2.Нойрондоо муудах
 - 3.Толгой байнга өвдөж шилэн хүзүүгээр хөших
 - 4.Толгой гэнэт хүчтэй өвдөж огих, зүрх дэлсэх, гар хөл бадайрч эвгүйрэх
 - 5.Өвчүүний араар базаж шахаж байгаа юм шиг өвдөх
- 67.Артерийн даралт ихсэх өвчний эмчилгээний үр нөлөөг хэрхэн сайжруулах вэ?
 - 1.Эмчилгээний талаар ярих
 - 2.Өвчтөнд артерийн даралт ихсэх өвчний хор хөнөөлийн тухай болон зөв тохирсон эмчилгээний үр ашгийн талаар мэдээлэл өгөх
 - 3.Гэртээ АД-аа өөрөө хэмжих ба даралт бууруулах эмийг тогтмол ууж хэвшүүлэх
 - 4.Эмчилгээний дэглэм нь өвчтөний амьдарлын хэв маяг ба түүний хэрэгцээнд тулгуурлах
 - 5.Цусан дахь өөх тосны хэмжээг байнга үзүүлэх
- 68.Амьдарлын хэв маяг өөрчлөх арга замуудыг нэрлэнэ үү.
 - 1.Давсны хэрэглээг бууруулах
 - 2.Биеийн жин бууруулах
 - 3.Идэвхтэй дасгал хөдөлгөөн
 - 4.Архины хэрэглээг хязгаарлах
 - 5.Тамхины хэрэглээг хязгаарлах
- 69.Хэрэх өвчин үүсэх хүчин зүйлийг нэрлэ.
 - 1.Үүсгэгчийн хоруу чанар
 - 2.Удамшил
 - 3.Гадаад орчны хүчин зүйлс
 - 4.Зохисгүй хооллолт
 - 5.Агаарын бохирдол
- 70.Хэрэх өвчний оношилгооны их шалгуурт аль нь орох вэ?
 - 1.Полиартрит
 - 2.Кардит
 - 3.Цагирган тууралт
 - 4.Арьсан доорх зангилаа
 - 5.Хороя
- 71.Хэрэх өвчний хүндрэлийг нэрлэ.
 - 1.Бөөрний дутагдал
 - 2.Зүрхний дутагдал
 - 3.Толгойн өвдөлт
 - 4.Зүрхний гажиг
 - 5.Хамар залгиурын үрэвсэл
- 72.Зүрхний бах үүсэх механизмыг нэрлэнэ үү.
 - 1.Зүрхний титэм судас хатуурч товруу үүсэх
 - 2.Титэм судас агших
 - 3.Титэм судасны хөндийд тромбоцитын бөөгнөрөл үүсэх
 - 4.Удамшил
 - 5.Нас
- 73.Тогтвортой стенокардийн үйл ажиллагааны ангилалааар 2-р зэргийг заана уу.
 - 1.Гэнэтийн эрч хүчтэй ердийнхөөс их ачааллын үед цээжээр өвдөнө
 - 2.Өгсүүр газар100-500 метр алхахад цээжээр өвдөнө

- 3.Тэгш гадаргуу дээр 200-500 метр алхахад цээжээр өвдөнө
 4.Тэгш гадаргуу дээр 500-1000 метр алхахад цээжээр өвдөнө
 5.Өгсүүр газар 100-1000 метр алхахад цээжээр өвдөнө
- 74.Зүрхний бахын өвдөлтийн онцлог ямар байх вэ?
 A.Өвдөлт 30 минутаас дээш үргэлжилнэ
 B.Өвдөлт хэдэн секундээс 15 минут
 C.Өвдөлт 1 цагаас дээш
 D.Өвдөлт хэдэн өдөр үргэлжилнэ
 E.Өвдөлт 2 цагаас дээш
- 75.Зүрхний бахыг сэдрээх хүчин зүйлийг нэрлэ.
 1.Артерийн даралт ихсэх
 2.Биеийн хүчний ачаалал
 3.Хоол хэт их идэх
 4.Сэтгэл догдлох
 5.Хүйтэн салхи, хүйтэн агаар
- 76.Зүрхний бахын өвдөлтийг намдаах хүчин зүйлийг нэрлэ.
 1.Хөдөлгөөнөө зогсоох
 2.Тайван суух
 3.Нитроглицерин хэрэглэхэд 2-3 минутын дараа өвдөлт намдана
 4.Цусан дахь өөх тосны хэмжээг багасгахад
 5.Дасгал хийхэд
- 77.Зүрхний бах өвчний хүндрэлийг нэрлэ.
 1.Артерийн даралт ихсэлт
 2.Зүрхний архаг дутагдал
 3.Бөөрний дутагдал
 4.Зүрхний шигдээс
 5.Хэрэх өвчин
- 78.Зүрхний бах өвчний эмийн бус эмчилгээний зарчмыг сонгоно уу.
 1.Давсны хэрэглээг багасгах
 2.Хэт их идэхээс татгалзах
 3.Артерийн даралтыг хэвийн хэмжээнд байлгах
 4.Өвдөлт сэдрээх хүчин зүйлсээс зайлсхийх
 5.Цусан дахь холестерин, сахарын хэмжээг ихэсгэхгүй байх
- 79.Зүрхний бахын эмийн эмчилгээний зорилгыг заана уу.
 1.Титэм судасны цусан хангамжийг сайжруулах
 2.Цус шингэлэх
 3.Зүрхний бодисын солилцоог сайжруулах
 4.Зүрхний өвдөлт намдаах
 5.Артерийн даралтыг бууруулах
- 80.Ходоодны архаг үрэвсэл үүсэх шалтгааныг нэрлэ.
 1.Халдвар
 2.Удмын хүчин зүйл
 3.Хооллолтын дэглэм алдагдах
 4.Эмийн бодис
 5.Хорт зуршил, архаг хордлого
- 81.Зүрхний ишеми өвчний үед зүрхний минутын эзэлхүүн буурдаг Учир нь зүрхний булчингийн хүчилтөрөгчийн хэрэгцээг ихэсгэх хүчин зүйл болдог.
- 82.Уушгины үрэвслээс уушгины цуллаг болон завсрын эд үрэвсэж агаарын сэлгэлцэл хийх чадвар хязгаарлагдан хүчилтөрөгч хомсдоно. Иймээс амьсгал, зүрх судас, цусны эргэлтийн дутагдалд хүргэдэг.

83. Никотин нь адреналин, норадреналины ялгаралтыг нэмэгдүүлдэг. Яагаад гэвэл хэм алдагдал, зүрхний цохилтын тоо, артерийн даралт, зүрхний агшилтын эзэлхүүн, хүчилтөрөгчийн хэрэглээ, титэм судасны цусны урсгал зэргийг багасгадаг.

84. Ходоодны шүүрэл ихэссэн үед цээж хорсох, амархан өлсөх шинж тэмдэг илэрдэг бөгөөд биж хам шинжид хамаарахгүй.

85. Хеликобактерийн халдвар нь ходоодны үрэвсэл үүсгэдэг бөгөөд ходоодны хавдрын шалтгаан болохгүй.

86. Пиелонефрит нь бөөрний аяганцар тэвшинцэр завсрын эдийг хамарсан халдварын шалтгаант үрэвсэлт өвчин Учир нь эрэгтэйчүүд их өвчилдөг

87. Зүрхний шигдээсийн үед зүрхний булчингийн эс үхжих бөгөөд үргэлжилсэн ишемийн уламаас үүсдэг.

88. Өлөн үеийн цусны сахар нь 6,9 мм моль/л байх хэвийн бөгөөд чихрийн шижингийн оношилгоонд ач холбогдолгүй үзүүлэлт юм.

89. Чихрийн шижингийн үед глюкозжсон гемоглобин нэмэгддэг. Учир нь чихрийн шижингийн үед цусан дахь глюкозын түвшин удаан хугацаагаар өндөр байдаг.

90. Бодисын солилцооны хам шинжийг оношилох үндсэн шалгуур нь төвийн таргалалт юм. Яагаад гэвэл төвийн таргалалтын үед инсулины дөжрөл үүсдэг учраас чихрийн шижингээр өвчлөх эрсдэл өндөр байдаг.

91. Доорх хам шинжүүдийг уялдуулан сонгоно уу.

1. Биж хам шинж

2. Цөс зогсонгишлын шинж

3. Хавагнах асцит үүсэх шинж

4. Цусархагшлын шинж

5. Мэдрэл сульдлын шинж

А. Ядрах, ажлын чадвар алдагдах

В. Хэвлий томрох, амьсгаадах

С. Арьс салст шарлах, шээсний өтгөн шар болох

Д. Гэдэс дүүрэх, аюулхайд эвгүй оргих

Е. Хамар буйлнаас цус гарах

A. 1D, 2C, 3B, 4E, 5A

B. 1C, 2A, 3E, 4D, 5C

C. 1A, 2E, 3D, 4C, 5B

D. 1B, 2C, 3A, 4E, 5D

E. 1E, 2B, 3C, 4D, 5A

92. Эмийн нэрийг бүлэгтэй нь харгалзуулан сонгоно уу.

1. Нитратын бүлгийн эм

2. Кальцийн сувгийн хориглогч

3. Цус шингэлэх эм

4. Холестрин бууруулах эм

5. АХФС бүлгийн эм

А. Аспирин

В. Лансорбид

С. Аторвастатин

Д. Энап

Е. Амлодипин

A. 1A, 2D, 3B, 4E, 5C

B. 1D, 2B, 3C, 4A, 5E

C. 1B, 2E, 3A, 4C, 5D

D. 1C, 2A, 3E, 4D, 5B

E. 1E, 2C, 3D, 4B, 5A

93. Тохируулан сонгоно уу.

- нэрлэ
- 1.Зүрхний шигдээсийн үндсэн шинжийг нэрлэ
 - 2.Зүрхний шигдээсийн үеийн хэв шинжит бус хэлбэрийг сонгох
 - 3.Хоёрдогч артерийн даралт ихсэлтийн эмнэлзүйн сэжүүр шинжийг нэрлэ
 - 4.Артерийн даралт ихдэлтийн архаг хүндрэлийг нэрлэ
 - 5.Зүрхний ишеми өвчний эрсдэлт хүчин зүйлийг нэрлэ
 - A.Аюулхай орчим өвдөх, бөөлжис цутгах
 - B.Зүрхний архаг дутагдал
 - C.Цээжний хүчтэй өвдөлт
 - D.Артерийн даралт ихсэлт
 - E.< 35 насанд АД ихсэх

- A. 1A, 2C, 3D, 4E, 5B
- B. 1C, 2A, 3E, 4B, 5D
- C. 1E, 2D, 3B, 4C, 5E
- D. 1D, 2B, 3C, 4A, 5E
- E. 1B, 2E, 3D, 4C, 5A

94.Тохируулан сонгоно уу.

- нэрлэ
- 1.Бөөрний тэвшинцэрийн үрэвсэл үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэ
 - 2.Бөөрний түүдгэнцрийн үрэвсэл үүсэх шалтгааныг нэрлэ
 - 3.Шээсний хам шинжид хамаарах шинжийг нэрлэ
 - 4.Хавагнах шинжийг нэрлэ
 - 5.Бөөрний түүдгэнцрийн үрэвслийн үед илрэх шинж тэмдгийг нэрлэ
 - A.Системийн коллагены өвчин
 - B.Цустай шээх
 - C.Шээсний хэмжээ багасах
 - D.Артерийн даралт ихсэх, хавагнах
 - E.Шээс дамжуулах замын саатал

- A.1A, 2B, 3E, 4D, 5C
- B.1B, 2E, 3C, 4A, 5D
- C.1D, 2C, 3B, 4E, 5A
- D.1E, 2A, 3B, 4C, 5D
- E.1C, 2D, 3A, 4B, 5E

95.Доорх шинж тэмдгүүдийг уялдуулан сонгоно уу.

- 1.Ходоодны шүүрэл ихэссэн шинж
 - 2.Ходоодны шүүрэл багассан шинж
 - 3.Тэжээл дутагдлын шинж
 - 4.Ходоодны цус алдалтын шинж
 - 5.Цөсний сөөргөө урсгалын шинж
 - A.Махан хоолны шингэц муудах, гэдэс дүүрч цанхайх
 - B.Турах, арьс хуурайших
 - C.Ам гашуу оргих гашуунаар гулгих
 - D.Цээж хорсох, амархан өлсөх
 - E.Баас хар гарах, бор хүрнээр бөөлжих
- A.1B, 2C, 3D, 4E, 5A
 - B.1E, 2D, 3C, 4A, 5B
 - C.1C, 2E, 3A, 4D, 5B
 - D.1A, 2B, 3E, 4C, 5D
 - E. 1D, 2A, 3B, 4E, 5C

96.Тохируулан сонгоно уу

- 1.Элэгний бага шинж
- 2.Элэгний их шинж
- 3.Уургийн солилцооны өөрчлөлтийн шинж
- 4.Иммун үрэвслийн шинж
- 5.Дэлүү идэвхжих
 - A.Элэг томрох, арьс салст шарлах
 - B.Дэлүү томрох
 - C.Халуурах, үе мөч өвдөх, дэлүү томрох
 - D.Хэл улаан гилгэр болох, алга улайх
 - E.Хавагнах, жин буурах

- A.1A, 2C, 3D, 4E, 5B
B.1D, 2A, 3E, 4C, 5B
C.1B, 2E, 3A, 4D, 5C
D.1E, 2B, 3C, 4A, 5D
E.1C, 2D, 3B, 4B, 5E

97.Доорх шинжүүдийг харгалзуулан сонгоно уу.

- 1.Керагийн шинж
- 2.Мерфийн шинж
- 3.Ортнерийн шинж
- 4.Менделийн шинж
- 5.Мюсси-Георгиевскийн шинж

- A.Баруун гарын ирмэгээр баруун хавирганы нумын дагуу доргиоход өвдөх
B. Амьсгал гүнзгий авах үе цөсний хүүдийн цэг дээр дарахад өвдөлтөөс болж амьсгал тасалдах
C.Цөсний гэрийн цэг дээр дарахад эмзэглэлтэй
D. Өвчүү хөхлөг сэртэнгийн булчингийн 2 хөлийн завсар дарахад цөсний хүүдийн цэг дээр эмзэглэлтэй
E.Аюулхайд тэмтэрхэд эмзэглэлтэй
- A.1C, 2B, 3A, 4E, 5D
B.1A, 2C, 3D, 4B, 5E
C.1E, 2D, 3E, 4A, 5C
D.1B, 2A, 3C, 4D, 5E
E.1D, 2E, 3B, 4C, 5A

98.Доорх эрсдэлт хүчин зүйлүүдийг уялдуулан сонгоно уу.

- 1.Чихрийн шижингийн эрсдэлт хүчин зүйл
- 2.Нийгэм сэтгэл зүйн эрсдэлт хүчин зүйл
- 3.Бодисын солилцооны эрсдэлт хүчин зүйл
- 4.Зан үйлийн эрсдэлт хүчин зүйл
- 5.Өөрчилж болохгүй эрсдэлт хүчин зүйл
 - A.Удамшил
 - B.Артерийн даралт ихсэлт
 - C.Архи тамхи
 - D.Таргалалт
 - E.Сэтгэл түгшил,айдас

- A.1B, 2C, 3D, 4A, 5E
B.1A, 2B, 3C, 4E, 5D
C.1D, 2E, 3B, 4C, 5A
D.1C, 2A, 3E, 4D, 5B
E. 1E, 2D, 3A, 4B, 5C

99.Тохируулан сонгоно уу.

- 1.Бөөрний гэмтэл
- 2.Чихрийн шижингийн илрэл
- 3.Бөөрний дутагдлын илрэл
- 4.Зүрх судасны өвчний эрсдэл
- 5.Хоёрдогч артерийн даралтыг сэжиглэх эмнэлзүйн сэжүүр шинж
 - A.Кератинин ихсэх
 - B.Гипергликеми
 - C.Диастолын даралт > 110 мм муб байх
 - D.Протейнури
 - E.Гиперхолестринемии

- A.1C, 2A, 3D, 4B, 5E
B.1D, 2B, 3A, 4E, 5C
C.1A, 2C, 3B, 4D, 5E
D.1E, 2D, 3E, 4A, 5B
E.1B, 2E, 3C, 4D, 5A

100.Тохируулан сонгоно уу.

- 1.Ходоодны архаг үрэвслийн шалтгаан
- 2.Нойр булчирхайн үрэвсэл үүсгэх шалтгаан
- 3.Цөсний хүүдийн архаг үрэвслийн шалтгаан
- 4.Элэгний архаг үрэвсэл үүсгэх шалтгаан
- 5.Чихрийн шижингийн эрсдэлт хүчин зүйл
 - A.Элэг цөсний замын өвчнүүд
 - B.Таргалалт
 - C.Хеликобактерийн халдвар
 - D.Бактерийн халдвар
 - E. B, D, C вирус

- A.1C, 2A, 3D, 4E, 5B
B.1E, 2B, 3C, 4A, 5D
C.1A, 2C, 3E, 4D, 5B
D.1B, 2D, 3A, 4C, 5E
E.1D, 2E, 3C, 4B, 5A

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛ

1. Халдварт өвчний нууц үе гэж юу вэ?

- A. Үүсгэгч орсноос хойш эмнэл зүйн онцлог шинж илрэх хүртэлх хугацаа
- B. Үүсгэгч орсноос хойш оношлогдох хүртэлх хугацаа
- C. Үүсгэгч орсноос хойш эмнэл зүйн анхны шинж илрэх хүртэл хугацаа
- D. Үүсгэгч орсноос хойш эмнэл зүйн ид үе хүртэлх хугацаа
- E. Үүсгэгч орсноос хойш эдгэрэлийн үе хүртэл

2. Халдварын гаралтай шарлах хам шинж бүхий, биеийн байдал хүнд байгаа үйлчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлсэн.

Ямар заалтаар ямар өрөөнд тусгаарлан хэвтүүлэх вэ?

- A. Эмнэлзүйн заалтаар энгийн өрөөнд
- B. Халдвар судлалын заалтаар бүтэн боксын өрөөнд
- C. Эмнэл зүй, халдвар судлалын заалтаар хагас боксын өрөөнд
- D. Эмнэл зүй халдвар судлалын заалтаар бүтэн боксын өрөөнд
- E. Халдвар судлалын заалтаар хагас боксын өрөөнд

3. Халдвартай үе гэж юу вэ?
- A. Нууц үеэс эдгэрлийн үе хүртэлх хугацаа
 - B. Халдвар авснаас хойш оношлогдох хүртэлх хугацаа
 - C. Халдвар үүсгэгч халдвартай хүнээс эрүүл хүнд ямар нэгэн замаар дамжин тархах нөхцөл бүрдсэн үе
 - D. Халдвар авснаас хойш үүсгэгчийн эсрэг эмчилгээ хийж эхлэх үе
 - E. Халдвар авснаас хойш халдвар дамжих боломжтой үе.
4. Халдварын гаралтай суулгах хам шинжээр илэрдэг өвчний үүсгэгч илрүүлэх сорьцыг нэрлэнэ үү
- A. Цус
 - B. Шээс
 - C. Өтгөн
 - D. Цэс
 - E. Бөөлжис
5. Гуравдагч сэргийлэлтийн чиглэл юу вэ?
- A. Шалтгааныг тогтоох
 - B. Эрт оношлох
 - C. Эрт илрүүлэх
 - D. Үр дагавар, хүндрэлийг бууруулах
 - E. Эрт илрүүлж, оношлох
6. Бороо орж их хэмжээний үер буусан газар нутагт ямар халварт өвчин гарах магадлал ихсэх вэ?
- A. Риновирусийн халдвар
 - B. Сахуу
 - C. Улаан бурхан
 - D. Гэдэсний халдварт өвчин
 - E. Томуу
7. Шарлалт гэж юу вэ?
- A. Элэгний үйл ажиллагаа алдагдах
 - B. Цусан дахь Алат, асат ихсэх
 - C. Цусан дахь билирубины хэмжээ ихсэн арьс салст шарлах
 - D. Цусан дахь уураг багасах
 - E. Цусан дахь ферментүүд ихсэх
8. Элэгний вирусийг илрүүлэх шинжилгээний сорьцыг ямар таглаатай хуруу шилэнд авах вэ?
- A. Улаан таглаатай хуруу шил
 - B. Ягаан таглаатай хуруу шил .
 - C. Цэнхэр таглаатай хуруу шил.
 - D. Шар таглаатай хуруу шил.
 - E. Хар таглаатай хуруу шил
9. Гахайн хавдрын халдвар дамжих гол замыг нэрлэнэ үү
- A. Хоол хүнсээр
 - B. Усаар

- C. Агаар дуслaar
 - D. Шавьжаар
 - E. Шууд хавьтлаар
10. Вирусийн эсрэг эмүүдийг нэрлэ
- A. Тамифлю, ацикловир, ламивудин
 - B. Ацикловир, ампициллин, септрин
 - C. Анаферон, ацикловир, эритромицин
 - D. Амоксициллин, ацикловир, виферон
 - E. Ципрофлоксацин, котримесазол, амоксициллин
11. Коагулограммын шинжилгээний сорьц авах хуруу шилээ сонгоно уу
- A. Улаан таглаатай хуруу шил
 - B. Ягаан таглаатай хуруу шил.
 - C. Цэнхэр таглаатай хуруу шил.
 - D. Шар таглаатай хуруу шил.
 - E. Хар таглаатай хуруу шил
12. Цусан суулгатай хүнд халдвар тараах боломжтой сувилгааны оношийг тавих хамгийн чухал үнэлгээ аль нь вэ?
- A. Өндөр халуурч байгаа
 - B. Цустай зүйлээр суулгах
 - C. Гэдсээр өвдөх
 - D. Өтгөнд шигелл илрэх
 - E. Бөөлжих
13. Галзуугийн халдвар дамжих замыг нэрлэнэ үү
- A. Агаар дуслaar
 - B. Усаар
 - C. Ахуйн замаар
 - D. Шууд хавьтлаар
 - E. Хоол хүнсээр
14. Тэлмэн 42 настай эрэгтэй. Сар гаруй ханиалган, сүүлийн 2 долоо хоног халуурах болсон, хоолондоо муу гэсэн зовиуртай өрхийн эмчдээ хандсан. Тэлмэнгийн цэрний түрхцийн шинжилгээнд ХТН илэрсэн. Өрхийн эмч уг тохиолдлыг сүрьеэгийн илрүүлэлтийн ямар аргаар илрүүлсэн вэ?
- A. Идэвхтэй
 - B. Хагас идэвхтэй
 - C. Идэвхгүй
 - D. Зориудын урьдчилан сэргийлэх үзлэг
 - E. Урьдчилан сэргийлэх үзлэг
15. Түрхэц эерэг хүн жилд хэдэн тохиолдлыг халдварлуулах магадлалтай вэ?
- A. 5 тохиолдол
 - B. 55- 65 тохиолдол
 - C. 85-100 тохиолдол
 - D. 15-20 тохиолдол
 - E. 5-10 тохиолдол
16. Сүрьеэгийн халдвар дамжих гол замыг нэрлэнэ үү
- A. Хоол хүнсээр

- В. Гэмтсэн арьс салстаар
 - С. Амьсгалын замаар
 - Д. Бэлгийн замаар
 - Е. Ихсээр
17. Сүрьеэгийн халдварын гол эх уурхайг нэрлэнэ үү
- А. Сүрьеэгийн нянгаар халдварлагдсан тохиолдол
 - В. Уушгины сүрьеэ түрхэц эерэг оноштой хүн
 - С. Уушгины сүрьеэ түрхэц сөрөг оноштой хүн
 - Д. Булчирхайн сүрьеэ оноштой хүн
 - Е. Ясны сүрьеэ оноштой хүн
18. Өвчний олон улсын ангилал 10 –р хэвлэлийн дагуух сүрьеэгийн ангилал аль нь вэ?
- А. А 01-03
 - В. А 09
 - С. А23
 - Д. А15-19
 - Е. А53
19. Халуураад татаж байгаа хүүхдэд авах хамгийн чухал арга хэмжээ аль нь вэ?
- А. Хүчилтөрөгч эмчилгээ
 - В. Толгойд хүйтэн жин тавих
 - С. Таталтын эсрэг эм хэрэглэх
 - Д. Халуун бууруулах эм хэрэглэх
 - Е. Гар хөлд хүйтэн жин тавих
20. Архаг бруцеллезын хамгийн элбэг тохиолддог эмнэл зүйн хэлбэр аль нь вэ?
- А. Мэдрэлтйн хэлбэр
 - В. Дотор эрхтэний хэлбэр
 - С. Үе мөчний хэлбэр
 - Д. Хавсарсан хэлбэр
 - Е. Шээс – бэлэг эрхтэний хэлбэр
21. Цусан суулгын үүсгэгч хоол боловсруулах замын аль хэсгийг сонгомлоор гэмтээдэг вэ?
- А. Бүдүүн гэдэс
 - В. Ходоод нарийн гэдэс
 - С. Ходоод нарийн бүдүүн гэдэс
 - Д. Нарийн гэдэс
 - Е. Нарийн бүдүүн гэдэс
22. Гахайн хавдраар аль насныхан хамгийн их өвчилдэг вэ?
- А. 1- 5 насныхан
 - В. 2- 10 насныхан
 - С. 5-16 насныхан
 - Д. 4- 12 насныхан
 - Е. 5 хүртэлх насныхан
23. Элэгний В вирус хамгийн их агуулагддаг биологийн шингэнийг нэрлэнэ үү
- А. Үрийн шингэн
 - В. Цус
 - С. Хөхний сүү
 - Д. Үтрээний шүүрэл
 - Е. Шүлс
24. ЭТҮХХ –с сэргийлэх хамгийн энгийн бөгөөд үр дүнтэй аргыг нэрлэнэ үү
- А. Тусгаарлалт
 - В. Ариутгал
 - С. Гадаргуугийн халдваргүйжүүлэлт

- D. Гар угаах, халдваргүйжүүлэх
E. Антибиотикийн зохистой хэрэглээ
25. Галзуугийн сэжигтэй амьтанд хазуулсан тохиолдолд ,өвчлөхөөс сэргийлэх хамгийн үр дүнтэй арга хэмжээ аль нь вэ?
A. Галзуугийн эсрэг вакцин хийх
B. Шархны анхны цэгцлэлт хийх
C. Галзуугийн эсрэг вакцин, иммуноглобулин хийх
D. Антибиотик эмчилгээ хийх
E. Өвдөлт намдаах эм хэрэглэх
26. Бүдүүн гэдэс үрэвсэж гэмтэж байгааг илэрхийлэх хамгийн гол шинж аль нь вэ?
A. Цустай зүйлээр суулгах
B. Халуурах
C. Хэвлийн доод хэсгээр өвдөх
D. Их дүлүүлэх
E. Суулгах
27. Хамгийн элбэг тохиолддог сүрьеэгийн эмнэл зүйн хэлбэрийг нэрлэнэ үү
A. Эмэнд дасалтай сүрьеэ
B. Булчирхайн сүрьеэ
C. Ясны сүрьеэ
D. Уушгины сүрьеэ
E. Нүдний сүрьеэ
28. Баяр 7 настай Халтвартын тасагт Гэдэсний цочмог халдвар нарийн бүдүүн гэдэсний үрэвсэл ид үедээ оноштой эмчлэгдэж байгаа . Өтгөний шинжилгээнд : Эмгэг төрүүлэгч *Esherichi coli* илэрсэн.Үүн дээр үндэслэн сувилгааны ямар онош тавих вэ?
A. Халдварт өндөр өртөмтгий
B. Халууралт
C. Шингэний дутагдалд өртөмтгий
D.Халдвар тараах боломжтой
E.Мэдлэгийн хомсдол
29. ЭМА Д –д сүрьеэгийн вакцины сорвийг шалгахад 2 мм хэмжээтэй бүдэг сорви байв. Сүрьеэгийн вакцин нь ямар хугацаагаар хүүхдийг сүрьеэгийн хүнд хэлбэрээр өвчлөхөөс сэргийлдэг вэ?
A. 5 нас хүртэл
B. 7-8 нас хүртэл
C.1 нас хүртэл
D. 15 нас хүртэл
E. 18 нас хүртэл
30. Герпесийн халдвар . салхин цэцгийн эмчилгээнд хэрэглэх хамгийн үр дүнтэй бэлдмэлийг нэрлэнэ үү
A. Виферон
B. Рибавирин
C. Ацикловир
D. Анаферон
E. Ремантидин
31. Салхин цэцгээр өвдсөн тохиолдолд хэзээ халдваргүй болох вэ?
A. Тууралт гарсан өдрөөс
B. Тууралт арилснаас хойш
C. Өвчний ид үеэс хойш

- D. Сүүлийн тууралт гарснаас хойш 5 хоногийн дараа
E. Тууралт тавших үеэс
32. Тавилан таагүй, үхлээр төгсдөг халдвар аль нь вэ?
A. Бруцеллез
B. Томуу
C. Галзуу
D. Улаанбурхан
E. Гахайн хавдар
33. Хүний биеийн өвөрмөц, өвөрмөц бус хамгаалах урвалд оролцдог эсийг нэрлэнэ үү
A. Т эс
B. Макрофаг
C. Ялтаст эс
D. В эс
E. Нейтрофил
34. Монголд оронд хамгийн элбэг тохиолддог зоонозын халдварыг нэрлэ.
A. Тарваган тахал
B. Шүлхий
C. Галзуу
D. Бруцеллез
E. Татран
35. Халдварт өвчний санаа авахуулах хамгийн чухал шинжийг нэрлэ.
A. Ядрах
B. Хоолонд дургүйлхэх
C. Халуурах
D. Нойр хямрах
E. Сульдах
36. Уушгины сүрьеэг сэжиглэх хамгийн чухал шинжийг нэрлэнэ үү
A. Халуурах
B. 14 хоногоос дээш хугацаагаар ханиалгах
C. Турах
D. Хоолондоо муудах
E. Хөлрөх
37. Галзуугийн хамгийн гол халдварын эх уурхай нь ямар амьтан болдог вэ?
A. Үнэг
B. Чоно
C. Нохой
D. Муур
E. Сарьсан багваахай
38. Менингококцемийн үндсэн шинж аль нь вэ?
A. Өндөр халуурах
B. Хоол унданд дургүйлхэх
C. Цусархаг тууралт
D. Царай цонхийх
E. Бие сулрах
39. Үйлчлүүлэгч Э.53 настай ЯТТ үзүүлэхээр ирсэн. Үзлэгээр: Биенийн халуун 38 хэм, SpO₂-80% -тай байна.
Энэ тохиолдолд хамгийн түрүүнд ямар тусламж үзүүлэх вэ?
A. Хүчилтөрөгч эмчилгээ хийнэ

- В. Цээжийг өндөрлөх
 - С. Эмийн эмчилгээ хийх
 - Д. Шинжилгээ авах
 - Е. Гар хөлд бүлээн жин тавих
40. Зоонозын халдварын эх уурхайг заана уу
- А. Халдварлагдсан үе хөлтөн , шавьж
 - В. Хөрс ,ус
 - С. Амьтдын үс ноос арьс шир
 - Д. Өвчтэй мал амьтад
 - Е.Өвчтэй малын мах сүү
41. Халдвартын эмнэлгийн бүтэн боксонд ямар өвчтөнг хэвтүүлэх вэ?
- 1. Онош тодорхойгүй өвчтөн
 - 2. Амьсгалын замын халдварт өвчтэй
 - 3. Коронавирусийн халдвартай хүн
 - 4. Гэдэсний халдварт өвчтэй
 - 5. Бруцеллез өвчтэй
42. Сапроноз халдваруудыг нэрлэ.
- 1. С гепатит
 - 2. Шүлхий.
 - 3. Улаан бурхан
 - 4. Татран
 - 5. Боом
43. Халдварт өвчний ид үеийг юу гэж ангилдаг вэ?
- 1. Шинж тэмдэг ахих балчир үе
 - 2. Идэр үе
 - 3. Шинж тэмдэг буурах үе
 - 4. Шинж тэмдэг ужигарах үе
 - 5. Шинж тэмдэг арилах үе
44. Халдвар өвчний эдгэрэлтийг нэрлэ.
- 1. Эмнэл зүйн эдгэрэлт
 - 2. Морфологийн эдгэрэлт
 - 3. Нян судлалын эдгэрэлт
 - 4. Биологийн эдгэрэлт
 - 5. Физиологийн эдгэрэлт
45. Халдвар судлалын заалтаар дархлаажуулалт хийгддэг халдварыг нэрлэнэ үү
- 1. Менингококкийн халдвар
 - 3. Галзуу
 - 2. Хачигт энцефалит
 - 4. Тарваган тахал
 - 5. Томуу
46. Өвчилсний дараа удаан хугацааны дархлаа тогтдог халдваруудыг нэрлэнэ үү
- 1. Тарваган тахал
 - 2. Салхин цэцэг
 - 3. Улаан бурхан
 - 4. Томуу
 - 5. Цусан суулга
47. Халдварт өвчний эх уурхайд чиглэсэн арга хэмжээ аль нь вэ
- 1. Өвчтөнийг тусгаарлах
 - 2. Эмнэлгээс гарсны дараа хяналтанд авах
 - 3. Үүсгэгчийн эсрэг эмчилгээ хийх
 - 4. Голомтын байнгын халдваргүйтгэл хийх

48. Халдварт өвчний үүсгэгчийг илрүүлэх шинжилгээг нэрлэнэ үү
1. Цусны ерөнхий шинжилгээ
 2. ПГУ
 3. Рентген шиншилгээ
 4. Нянг өсгөвөрлөх
 5. Эс судлалын
49. Товлолын дагуу вакцинжуулалт хийгддэг халдваруудыг нэрлэ.
1. Томуу
 2. Халдварт саа
 3. Улаан эсэргэнэ
 4. Сүрьеэ
 5. Салхин цэцэг
50. УГУ вакцины товлолыг нэрлэ
1. Төрсний дараах 24 цагийн дотор
 2. 9 сартайд
 3. 2 сартайд
 4. 2 настайд
 5. 3 сартайд
51. Гэдэсний халдвар үүсгэгч нянгийн эсрэг эмүүдийг нэрлэ
1. Гентамицин
 2. Ципрофлаксацин
 3. Ампициллин
 4. Фунголон
 5. Котримексазол
52. Халдварын гаралтай суулгах хамшинжтэй хүнээс халдвар судлалын асуумж авахад
- дараахь асуултуудын аль нь ач холбогдолтой вэ?
1. Сүүлийн 7 хоног ойр хавьд нь өвчтэй хүн байсан уу?
 2. Ундны усаа хаанаас авдаг, түүхий ус уудаг уу?
 3. Өвчин эхлэхээс өмнө ямар хоол унд идсэн вэ?
 4. Сүүлийн 2 сар амьтанд хазуулсан уу?
 5. Сүүлийн 3 сар хагалгаанд орсон уу?
53. Суулгаж байгаа хүүхдэд ямар шинжүүд илэрвэл шингэн алдалттай гэх вэ?
1. Баас цустай гарах
 2. Арьсны хуниас удаан, арилах
 3. Бөөлжих
 4. Нүд хонхойх
 5. Гэдсээр өвдөх.
54. Гэдэсний халдварт өвчний эх уурхайд чиглэсэн арга хэмжээг нэрлэнэ үү
1. Өвчтэй хүнийг тусгаарлах \гэрт нь зарим тохиолдолд эмнэлэг\
 2. Нян тээгчдийг илрүүлэн , эмчлэх
 3. Төгс эмчлэх
 4. Халдваргүйтгэл хийх
 5. Вакцин хийх
55. Цусан суулга өвчний онцлогийг нэрлэнэ үү
1. Өвчлөл сэрүүний улиралд их гардаг
 2. Голчлон бүдүүн гэдэс гэмтдэг
 3. Тавилан таагүй, 90 % архагшдаг
 - 4 Үүсгэгч нь шигелл
 - 5.Товлолын дагуу вакцин хийгддэг

56. 15 настай охин суулгана , халуурна гэсэн зовиуртой . Суулгалтыг тодруулахын тулд

охиноос юу гэж асуух вэ?

1. Хоногт хэдэн удаа суулгаж байна
2. Хэр удаан?
3. Баасны өнгө , үнэр
4. Баасанд цус байна уу?
- 5.1 удаагийн баасны хэмжээ ямар байна вэ?

57. Гэдэсний халдварын дэгдэлтийн үед ЭМА хүмүүст ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Гарын ариун цэврээ сахих
2. Түүхий ус ууж болохгүй .
3. Суулгах , халуурах , гэдсээр өвдөх шинж илэрвэл яаралтай эмчид хандах
4. Амны хаалт хэрэглэх
- 5.Урьдчилан сэргийлэх зорилгоор антибиотик уух

58. Тусгаарлах өрөөний бүтцийн онцлогийг нэрлэ

1. Гадаад орчинтой харьцах хэсэг
- 2.Ариун цэврийн өрөө
- 3.Үйчлүүлэгчийн өрөө
4. Эмнэлгийн эмч ажилчдад зориулагдсан хэсэг
5. Халдваргүйтгэлийн хэсэг

59. Цочмог вируст гепатитын үед зайлшгүй шаардлагатай шинжилгээнүүдийг нэрлэнэ үү

- 1.Биохимийн шинжилгээ \ элэгний үйл ажиллагааг тодорхойлох\
2. Шээсний ерөнхий шинжилгээ
3. Вирусын маркерийн шинжилгээ
4. Өтгөнд .нян судлалын шинжилгээ
5. Эс судлалын шинжилгээ

60. Цочмог вируст гепатитын эмнэл зүйн эхлэл үед ямар хам шинжүүд илэрдэг вэ?

1. Томуу төст хам шинж
2. Мэдрэл сульдлын хам шинж
3. Ходоод гэдэсний хямралын хам шинж
4. Цусархагшлын хам шинж
5. Цөс саатлын хам шинж

61. Цочмог вируст гепатитын шартай хэлбэрийн үед илрэх шинжүүдийг нэрлэнэ үү

1. Арьс салст шарлана
2. Баас цагаан гарна
3. Шээс өтгөрч , бараан өнгөтэй
4. Бие загаднах
- 5.Элэг томрох

62. Гепатитийн В вирус хүний биеийн ямар шингэнд агуулагдаж байдаг вэ?

1. Үрийн шингэн
2. Хөхний сүү
3. Цус ,ийлдэс
4. Шүлс
5. Салс

63. А гепатит ямар замаар дамжин халдварладаг вэ?

1. Эмнэлгийн нөхцөлд багаж хэрэгслээр
2. Ахуйн замаар
3. Шууд хавьтлаар
4. Хоол хүнсээр
5. Бэлгийн замаар

64. В гепатитын халдвар авах эрсдлүүдийг нэрлэнэ үү

- 1.Түүхий ус уух
2. Бэлгийн олон хавьтагчтай байх
3. Гарын ариун цэвэр муу сахих
4. Мансууруулах бодис судсаар хэрэглэх
5. Хоносон хоол идэх

Эмнэл зүйн тохиолдол

Дөлгөөн 5 настай эрэгтэй , халуурна, хоол огт идэхгүй, шингэн уухдаа дургүй, бөөлжнө, аюулхайд өвдөнө, ноомой, Өнөөдрөөс шээс шар , баас нь цагаан гарч арьс салст шарласныг ажигласан гэсэн асуумжтай . Үзлэгт: Арьс салст тод шар , уруул хуурай, хэл өнгөртэй, хамраас цус гарна. Эмч Цочмог вируст гепатит гэж сэжиглэн , биохими, цусны ерөнхий , шээсний , элэгний А, В, С вирус илрүүлэх шинжилгээг маргааш өглөө хийхээр төлөвлөсөн.

65. Дөлгөөнд цочмог гепатитын эмнэл зүйн ямар хам шинжүүд илэрсэн вэ?

1. Томуу төст хам шинж
2. Ходоод гэдэсний хямралын хам шинж
3. Шарлалт, цөс саатлын хам шинж
4. Цусархагшлын хам шинж
5. Суулгах хам шинж

66. ЭМА та Дөлгөөнийг шинжилгээнд бэлтгэхийн тулд эхэд ямар мэдээлэл зөвлөгөө өгөх вэ?

1. Шинжилгээнд өлөн үеийн цус авна,
2. Иймээс өглөө шинжилгээ автал хоол идэх, шингэн уухыг хориглоно
3. Өглөөний шээсийг шинжилгээнд авна
4. Шинжилгээ нь элэгний үйл ажиллагааг тодорхойлох зорилготой
5. Шинжилгээг өглөө 9 цагт авна

67. Дөлгөөний вирусийн шинжилгээнд аHAV Ig M эерэг гарсан . Ямар гепатитаар өвчилсөн вэ?

- A. Цочмог В гепатит
- B. Цочмог С гепатит
- C. Цочмог D гепатит
- D. Цочмог E гепатит
- E. Цочмог А гепатит

68. Цочмог А гепатитын онцлогийг нэрлэнэ үү.

1. Голчлон бага насныхан өвчилнө
2. Бохир гараар дамждаг
3. Товлолын дагуу дархлаажуулалт хийгддэг
4. Ихэнх тохиолдолд хүнд хэлбэрээр явагддаг
5. Дархлаа тогтдоггүй

69 . ЭМА халуурна ,туурна гэсэн зовиуртай 2 настай хүүг үзэхэд: Хуйх, амны хөндийн салст ,арьсаар толбо , гүвдрүү, дотроо тунгалаг шингэн эгуулсан цэврүүт тууралт гарсан 39 хэмийн халуунтай , хордлогын шинжүүд тод

илэрсэн .ЭМА та ямар өвчнийг сэжиглэх вэ?

1. Халдварын гаралтай толбо ,гүвдрүүт тууралтат хам шинж
2. Харшлын гаралтай тууралт
3. Халдварын гаралтай цусархаг тууралтат хам шинж
4. Халдварын гаралтай цэврүүт тууралтат хам шинж
5. Харшил хордлогын гаралтай тууралт

70. Товлолын вакцинжуулалт хийгддэг өвчнүүдийг нэрлэнэ үү

1. Пневмококкийн халдвар
2. Хөхүүл ханиад

- 3.Татран
- 4.Сүрьеэ
5. А гепатит

71. Цогт 36 настай эрэгтэй. Эмнэл зүйн онош: Цочмог вируст гепатит В хэлбэр ид үедээ халдвартын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа . Цогтод хязгаарлах, хориглох хоол хүнсийг нэрлэнэ үү

1. Хоол амтлагч халуун ногоо
2. Амьтны гаралтай өөх төс
3. Согтууруулах ундаа
4. Сахар
5. Оливийн тос

72. ЭМА өндөр халуурч байгаа хүнд халууралт гэсэн сувилгааны онош тавьсан. Оношийн дагуу авах

арга хэмжээг нэрлэнэ үү

1. Шингэн алдалтын шинжийг үнэлэх
2. Эмчийн заалтаар халуун бууруулах эм өгөх
3. Амин үзүүлэлтийг 2 цаг тутам үзэж үнэлэх
4. Хүйтэн жин тавина
5. Шингэн илүү уухыг зөвлөх

73. 10 настай хүү халуурна, хоногт 10-д удаа шингэн шар ногоон зүйлээр суулгана , гэдсээр өвдөнө , өвчин

эхлээд 2 хонож байгаа . Эмч үзээд халдварын шалтгаант ходоод гэдэсний цочмог үрэвсэл гэж оношлов.

Ходоод гэдэсний цочмог үрэвслийг үүсгэгч бичил биетнийг нэрлэнэ үү

1. Ротовирус
2. Сальмонелл
3. Шигелл
4. Эширихи коли
5. А вирус

74. Үйлчлүүлэгч Өрнөл 28 настай эрэгтэй. Эмнэл зүйн онош : Цочмог вируст гепатит В шартай хэлбэр хүнд ид үедээ . халдвартын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа . Хамраас цус гоожно тариа хийсэн газар хөхрөлт үүссэн. ЭМА цус алдах эрсдэлтэй гэсэн сувилгааны онош тавив. Дараах эмчилгээний заалтаас цус тогтоох эмийг нэрлэнэ үү

1. Sol. Drotoverini 2 мл хураагуур судсанд тарих
2. Tab. Dicinoni 250 mg 1 ширхгээр 3 удаа уух
3. Sol. Metoclopramidi 2 мл 12 цагаар хураагуур судсанд тарих
4. Sol. Menodioni bisulfatis 2 мл 12 цагаар булчинд тарих
5. Ampicillini 1,0 натри хлоридийн ,0,9 % 4 мл уусмалаар найруулан 8 цагаар

хураагуур

судсанд тарих

75. ЭМА тууралттай өвчтөний арьсыг харж ажиглахдаа тууралтын ямар онцлогийг илрүүлэх боломжтой вэ?

- 1.Тууралтын элемент
2. Тууралтын өнгө
3. Тууралтын хэлбэр, хэмжээ
4. Тууралтын байршил
5. Арьсны суурин өнгө

76. ЭМА томуу томуу төст өвчний дэгдэлтийн үед хүмүүст ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Халуурах, ханиах шинж илэрвэл эмчид хандах

2. Томуугийн вакцин хийлгэх .

3. Амны хаалт хэрэглэх
 4. Гарын ариун цэврээ сахих
 5. Урьдчилан сэргийлэх зорилгоор вирусийн эсрэг эм уух
77. Сүрьеэгээр өвчлөхөд нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү
1. Хоол тэжээлийн дутагдал
 2. Хорт зуршил
 3. ХДХВ -н халдвар
 4. Хорт хавдар
 5. Чихрийн шижин
78. Уушгины сүрьеэгийн сэжигтэй шинжүүдийг нэрлэнэ үү
1. Удаан хугацаагаар халуурах
 2. 2 долоо хоногоос дээш ханиалгах
 3. Турах
 4. Хоолой сөөх
 5. Туберкулины сорил сөрөг
79. Улаанууд өвчин эмнэл зүйн ямар хэлбэрээр явагддаг вэ?
1. Анхдагч улаанууд
 2. Олдмол улаанууд
 3. Далд улаанууд
 4. Төрөлхийн улаанууд
 5. Хоёрдогч улаанууд
- Эмнэл зүйн тохиолдол
80. Сүрьеэгийн сэжигтэй тохиолдолд халдвар судлалын асуумжаар юуг тодруулах вэ?
1. Гэр бүлд нь сүрьеэгээр өвчилсэн хүн байсан эсэх
 2. Садан төрөлд нь сүрьеэгээр өвчилсэн хүн байсан эсэх
 3. Найз нөхөд , сургууль , ангид нь сүрьеэгээр өвчилсэн хүн байсан эсэх
 4. Ханиад томуугаар өвчилсөн эсэх
 5. Сүүлийн 6 сар эмнэлэгт хэвтсэн эсэх
81. Салхин цэцгийн үед халдварын эрсдэл гэсэн сувилгааны онош тавигдана учир нь.арьс салстаар цэврүүт тууралт гарч , хагараад шалбархай үүсдэг.
82. Халдварт өвчний эмнэл зүйн анхны шинж халууралт , яагаад гэвэл шалтгаан нь аллергэн юм.
83. Цочмог вируст гепатитын үед арьс салст шарлан, шээс өтгөрч шар гардаг учир нь цусан дахь шууд билирубины хэмжээ ихэсдэгтэй холбоотой. .
- 84 . Цочмог С гепатитын үед aHDV IgM тодорхойлох шаардлагатай яагаад гэвэл D .вирус С вирустэй хамтарч элгийг гэмтээх онцлогтой .
85. Түрхэц эерэг уушгины сүрьеэтэй хүн халдварын гол эх уурхай болдог Учир нь тухайн хүнийг ханиах, найтаах үед үүсгэгч ялгарч гардаг.
86. ХДХВ –н халдвар, ДОХ –той хүнийг сүрьеэгийн илрүүлэлт оношилгоонд заавал хамруулна, Учир нь дархлаа дутал нь сүрьеэгээр өвчлөх боломжийг бүрдүүлдэг
87. 14 хоногоос дээш хугацаагаар ханиалгасан тохиолдолд сүрьеэгийн сэжигтэй гэж цэрийг шинжлэх шаардлагатай учир нь сүрьеэ вирусээр үүсгэгддэг.
88. УГУ вакцины эхний тунг 9 сартайд хийдэг яагаад гэвэл хүүхэд 9 сар хүртэл эхээс авсан дархлаатай холбоотой

- улаанууд, улаан бурхан, гахайн хавдар өвчнөөр өвчилдөггүй.
89. Томуугийн эмнэл зүйн аль ч хэлбэрийн үед антибиотик эмчилгээ хийгдэнэ яагаад гэвэл томуу нянгаар үүсгэгддэг өвчин.
90. Хүний халдварт өвчний үед өвчтэй хүнийг эрт илрүүлж түсгаарлах нь их чухал Учир нь уг өвчнүүд зөвхөн амьсгалын замаар дамждаг.
91. Дараах халдварт өвчнүүдийн үүсгэгчийг тохируулан сонгоно уу
- | | |
|---------------------|-------------------|
| 1. Улаан бурхан | A . HIV |
| 2. Улаанууд | B.Morbillivirus |
| 3. Салхин цэцэг | C. HAV |
| 4. Цочмог А гепатит | D. Rubivirus |
| 5. ДОХ | E . Herpes zoster |
- A.1A2D3B4C5E
B.1B2D3E4C5A
C. 1E2C3D4A5B
D. 1D2E3C4B5A
E. 1C2B3A4D5E
92. Дараах халдварт өвчнүүдийн нууц үеийг тохируулан сонгоно уу
- | | |
|-----------------|---------------------------|
| 1. Салхин цэцэг | A. 1-7 хоног |
| 2. Томуу | B. 11-21 хоног |
| 3. Цусан суулга | C. Хэдэн цагаас – 2 хоног |
| 4. В гепатит | D.50-180 хоног |
| 5. С гепатит | E .2 -26 долоо хоног |
- A.1B2C3A4D5E
B.1E2D3C4B5A
C.1C2B3A4E5D
D.1A2E3D4B5C
E.1D2C3A4E5D
93. Томуугийн вирусийн гадаад орчинд амьдрах хугацааг тохируулан сонгоно уу
- | | |
|-------------------------------|--------------------|
| 1. Өрөө тасалгаанд | A. 8-12 цаг |
| 2. Металл, хуванцар гадаргууд | B.10 хоног |
| 3. Цаасан эд дээр | C. 24-48 цаг |
| 4. Шилний гадаргууд | D. 2-3 долоо хоног |
| 5. Цэрэнд | E. 2-9 цаг |
- A. 1E2C3A4 D5B
B. 1E2C3A4B5D
C. 1C2E3A4B5D
D.1E2A3C4B5D
E. 1E2C3A4B5D
94. Дараах халдварт өвчнүүдийн халдвар дамжих замыг тохируулан сонгоно уу
- | | |
|-------------------------------|------------------------------|
| 1. Тарваган тахал | A. Хоол хүнс, усаар |
| 2.Шинэ Коронавирусийн халдвар | B. Бэлгийн замаар |
| 3. Эшерихи колийн халдвар | C. Агаар дуслаар |
| 4. ДОХ | D. Агаараар |
| 5. Сүрьеэ | E. Дамжуулагчаар / бүүргээр/ |
- A. 1E2C3A4 D5B
B. 1A2C3E4B5D
C. 1E2C3A4B5D
D.1E2A3C4B5D
E. 1E2C3D4B5A

95. Дараах халдварт өвчнүүдийн үед голлон гэмтдэг эрхтнүүдийг тохируулан сонгоно уу

- | | |
|-------------------------|---------------------------------------|
| 1. Ротавирусийн халдвар | A. Уушги |
| 2. Гахайн хавдар | B. Ходоод гэдэс |
| 3. Сүрьеэ | C. Үе мөч |
| 4. Бруцеллез | D. Арьс салст |
| 5. Гар хөл амны өвчин | E. Чихний ойролцоох шүлсний булчирхай |
- A. 1E2C3A4 D5B
B. 1E2C3A4B5D
C. 1B2A3E4C5D
D. 1A2E3C4B5D
E. 1B2E3A4C5D

96. Дараах халдварт өвчнүүдийн вакцины товыг тохируулан сонгоно уу

- | | |
|--|-----------------------------------|
| 1. А гепатит | A. Төрсний дараах 24 цагийн дотор |
| 2. Улаанууд, гахайн хавдар, улаан бурхан | B. 2,3,4 5 сартайд |
| 3. Халдварт саа | C. 7, 15 настайд |
| 4. Сахуу, татран | D. 1 нас 2сар, 2 настайд |
| 5. Сүрьеэ | E. 9 сар, 2 настайд |
- A. 1E2C3A4 D5B
B. 1D2E3B4C5A
C. 1C2E3D4B5A
D. 1E2A3C4B5D
E. 1D2C3A4B5E

97. Дараах өвчнүүдийн тууралтын элемент, байршлын онцлогийг тохируулан сонгоно уу

- | | |
|--|--|
| 1. Улаан бурхан биеийг хамарна | A. Цусархаг тууралт, доод мөчдөөс эхлэн гарч бүх |
| 2. Улаанууд гарна | B. Гар, хөл амны хөндийн салстаар цэврүүт тууралт |
| 3. Салхин цэцэг мөчдийг хамран 3 хоног гарна | C. Толбот гүвдрүүт тууралт нүүрээс эхлэн их бие |
| 4. Гар хөл амны өвчин эхлэн 10-12 цагийн | D. Толбот гүдрүүт тууралт нүүр, хуйх, чихний араас |
| 5. Менингококцеми гарна | E. Цэврүүт тууралт бүх биеийн арьс, салст, хуйхаар |
- дотор бүх биеийг хамран гарна

- A. 1C2E3A4D5B
B. 1E2C3 D 4B5A
C. 1C2D3E4B5A
D. 1E2D 3C4B5A
E. 1E2C3 D4B5A

98. Дараах халдварт өвчнүүдийн халдварын гол эх уурхайг тохируулан сонгоно уу6.

- | | |
|-------------------|------------------|
| 1. Галзуу | A. Бог мал, үхэр |
| 2. Бруцеллез | B. Нохой |
| 3. Боом | C. Үхэр, гахай |
| 4. Шүлхий | D. Тарвага |
| 5. Тарваган тахал | E. Бод мал |
- A. 1B2A3E4C5D
B. 1A2C3E4B5D
C. 1C2E3A4B5D
D. 1E2A3C4B5D
E. 1B2C3A4E5D

99. Дараах халдварт өвчнүүдийн эмнэл зүйд илрэх гол хам шинжийг тохируулан сонгоно уу.

- | | |
|--------------------------------|---------------------------------------|
| 1. Эшерихиколийн халдвар | A. Булчирхай томрох хам шинж |
| 2. Гар хөл амны өвчин | B. Шарлах хам шинж |
| 3. Цочмог C гепатит | C. Амьсгалын замын үрэвслийн хам шинж |
| 4. Шинэ коронавирусийн халдвар | D. Тууралт |
| 5. ДОХ. | E. Суулгах хам шинж |
- A. 1E2C3A4 D5B
B. 1E2C3A4B5D
C. 1E2C3D4B5A
D. 1E2A3C4B5D
E. 1E2D3B4C5A

100. Дараах халдварт өвчнүүдийн үүсгэгчийн эсрэг эмүүдийг тохируулан сонгоно уу.

- | | |
|------------------------|----------------|
| 1. Сүрьеэ | A. Флуконазол |
| 2. Салхин цэцэг | B. Ацикловир |
| 3. Цусан суулга | C. Левомецитин |
| 4. Хялгасан хорхой | D. Изониазид |
| 5. Мөөгөнцрийн халдвар | E. Вермокс |
- A. 1E2C3A4D5B
B. 1D2C3E4B5A
C. 1C2E3A4B5D
D. 1D2B3C4E5A
E. 1D2C3E4B5A

НҮД СУДЛАЛ

- Харааны мэдрэлийн хөхлөг ямар эсийн урт сэртэнгүүдээс үүсэх вэ?
 - хоёр туйлт эсүүдийн сэртэн
 - лонхонцор эсүүдийн урт сэртэн
 - зангилаат эсүүдийн урт сэртэн
 - савханцар эсүүдийн урт сэртэн
 - Мөхлөгт эсийн урт сэртэн
- Шар толбо гэж ямар эсүүдийн бөөгнөрлийг хэлэх вэ?
 - лонхонцор
 - хоёр туйлт эс
 - зангилаат эс
 - мөхлөгт эс
 - кератоцит
- Нүдний өнгийг тодорхойлогч бүрхүүлийг нэрлэнэ үү.
 - сормослог бие
 - солонгон бүрхүүл
 - жинхэнэ судас бүрхүүл
 - эвэрлэг бүрхүүл
 - уураг бүрхүүл
- Торон бүрхүүлд хэдэн сая лонхонцор эсүүд байрладаг вэ?
 - 1-2 сая
 - 2-3 сая
 - 3-4 сая
 - 5-6 сая
 - 7-8 сая
- Нүдний дотоод шингэн хаанаас үүсдэг вэ?

- A. солонгон бүрхүүл
 - B. торон бүрхүүл
 - C. уураг бүрхүүл
 - D. сормослог биеийн сэртэн
 - E. жинхэнэ судас бүрхүүл
6. Глаукомын давшлыг ямар өвчнөөс ялган оношлох вэ?
- A. иридоциклит
 - B. хориодит
 - C. дакроаденит
 - D. кератит
 - E. катаракт
7. Хүүхэн хараа ямар үүрэгтэй вэ?
- A. нүдэнд гаднаас орох гэрлийг тохируулах
 - B. нүдэнд гаднаас орох гэрлийг хугалах
 - C. нүдийг хамгаалах
 - D. нүдний даралтыг хэвийн байлгах
 - E. нүдийг хамгаалах
8. Хүүхэн хараа хэдэн мм хэмжээтэй вэ?
- A. 1 мм
 - B. 2 мм
 - C. 3 мм
 - D. 4мм
 - E. 5 мм
9. Нүдний дотоод шингэн хаанаас үүсдэг вэ?
- A. солонгос бүрхүүлээс
 - B. нулимсны булчирхайнаас
 - C. салст бүрхүүлийн нулимсны нэмэлт булчирхайнаас
 - D. сормослог биеийн сэртэнгийн хялгасан судаснаас
 - E. сормослог биеийн хавтгай хэсгийн хялгасан судаснаас
10. Нүдний даралтын хэвийн хэмжээ хэд вэ?
- A. 1-5 мммуб
 - B. 5-9 мммуб
 - C. 9- 21мммуб
 - D. 26-30 мммуб
 - E. 31- 45 мммуб
11. Төвийн харааны үүргийг аль нь гүйцэтгэх вэ?
- A. харааны мэдрэлийн хөхлөг
 - B. торлогийн бүх хэсэг
 - C. харааны мэдрэлийн хөхлөг орчим
 - D. шар толбо
 - E. Жинхэнэ судас бүрхүүл
12. Харааны талбай хэвийн үед хүн шанаа талдаа цагаан өнгөнд хэдэн градусаар хардаг вэ?
- A. 50 градус
 - B. 60 градус
 - C. 70 градус
 - D. 80 градус
 - E.90 градус
13. Родопсины нийлэгжилтэнд ямар витамин оролцох вэ?
- A. Витамин А
 - B. Витамин Д

- С.витамин К
- D. Витамин Д
- Е. Витамин С

14. Ямар өнгийг ялгахгүй байхыг протанопа гэх вэ?
- A. ногоон
 - B. Хөх
 - C. ягаан
 - D. улаан
 - E. шар
16. Эвэрлэг бүрхүүлийн хугарлын хүч хэд вэ?
- A. 16 Д
 - B. 18 Д
 - C. 20 Д
 - D. 30Д
 - E. 40 Д
17. Өнгөний харааны үүргийг аль нь гүйцэтгэх вэ?
- A. харааны мэдрэлийн хөхлөг
 - B. торлогийн бүх хэсэг
 - C. харааны мэдрэлийн хөхлөг орчим
 - D. шар толбо
 - E. Жинхэнэ судас бүрхүүл
18. Төвийн харааг шалгахад 2,5 метр зайд хуруу тоолж байвал харах чадлыг хэд гэж үнэлэх вэ?
- A. 0,01
 - B. 0,02
 - C. 0,03
 - D.0,04
 - E. 0,05
19. Нярай хүүхдийн рефракци ямар байх вэ?
- A. эмметропи
 - B. миопи
 - C. гиперметропи
 - D. астигматизм
 - E. пресбиопи
20. 40өөс дээш насанд ойрын хараа муудахыг юу гэж нэрлэдэг вэ?
- A. эмметропи
 - B. миопи
 - C. гиперметропи
 - D. астигматизм
 - E. пресбиопи
21. Миопийн үед нүдний гэрлийн системийн хугарал ямар байдаг вэ?
- A. хэвийн
 - B. сул
 - C. дунд зэрэг
 - D. хүчтэй
 - E. хэт хүчтэй
22. Гиперметропийг ямар шилээр засах вэ?
- A. хамелеон
 - B. сарниулагч
 - C. цуглуулагч

- D. цилиндр
 - E. призм
23. Маклаковын тонометрийн 10 гр туухайгаар хэмжихэд нүдний дотоод даралтын хэвийн хэмжээ хэд байдаг вэ?
- A. 18-26 мм муб
 - B. 26-28 мм муб
 - C. 28-30 мм муб
 - D. 30-36 мм муб
 - E. 36-38 мм муб
24. Мейбомын булчирхай хаана байрлах вэ?
- A. зовхины салстад
 - B. сормослог биед
 - C. уураг бүрхүүлд
 - D. зовхины мөгөөрсөнд
 - E. зовхины булчинд
25. Аккомодацийн сулралыг юу гэх вэ?
- A. миопи
 - B. астигматизм
 - C. пресбиопи
 - D. эмметропи
 - E. гиперметропи
26. Нүдний даралт ихсэх өвчний үед нүдний угт ямар өөрчлөлт гарах вэ?
- A. харааны мэдрэлийн үрэвсэл
 - B. торлогийн дистрофи
 - C. шар толбын дегенераци
 - D. харааны мэдрэлийн хөхлөгийн экскавац
 - E. торлогт цус харвах
27. Нүдний даралт ихсэх өвчний үед ямар эмээр хүүхэн хараа нарийсгах вэ?
- A. атропин сульфат
 - B. атенолол
 - C. анузол
 - D. адерналин
 - E. пилокарпин
28. Анхдагч глаукомыг өнцгөөр нь хэд ангилах вэ?
- A. 1
 - B. 2
 - C. 3
 - D. 4
 - E. 5
29. Дээд зовхи буухыг юу гэж нэрлэдэг вэ?
- A. блефарохалазис
 - B. птоз
 - C. миоз
 - D. эпикантус
 - E. колобом
30. Хөгшрөлтийн катарактыг хэдэн үе шатанд ангилдаг вэ?
- A. 1
 - B. 2
 - C. 3
 - D. 4
 - E. 5

31. 50 настай эмметропи хараатай хүнд пресбиопийг засах шил аль нь вэ?
A. 1.00 Д
B. 1.50 Д
C. 2.00Д
D. 2.50Д
E. 3.00 Д
32. Нүдний алимын дайвар эрхтнүүдэд аль нь хамаарах вэ?
1. салст бүрхүүл
2. зовхи
3. нулимсны эрхтэн
4. нүд хөдөлгөгч булчин
5. ухархай
33. Нүдний алимын хамгийн гадна бүрхүүл аль нь вэ?
1. солонгон бүрхүүл
2. эвэрлэг бүрхүүл
3. сормослог бүрхүүл
4. уураг бүрхүүл
5. торон бүрхүүл
34. Торон бүрхүүл дээр байрладаг мэдрэлийн эсүүд аль вэ?
1. лонхонцор
2. хоёр туйлт эс
3. зангилаат эс
4. мөхлөгт эс
5. кератоцит
35. Нүдний алимын доторх тунгалаг хэсгүүдийг нэрлэнэ үү.
1. арын тасалгааны шингэн
2. болор
3. өмнөд тасалгааны шингэн
4. шилэнцэр
5. нулимс
36. Нулимсны эрхтэнд аль нь хамаарах вэ?
1. нулимсны цэг
2. нулимсны сувгууд
3. хамар нулимсны суваг
4. хүүдий
5. нүдний дотоод шингэн
37. Нулимс боловсруулах хэсгийг нэрлэ.
1. нулимсны цэг
2. нулимсны сувгууд
3. хамар нулимсны суваг
4. нулимсны үндсэн булчирхай
5. нүдний дотоод шингэн
38. Нулимс дамжуулах замд аль нь хамаарах вэ?
1. нулимсны цэг
2. дээд доод суваг
3. хамар нулимсны суваг
4. нулимсны хүүдий
5. нулимсны нуур
39. Эвэрлэг бүрхүүлийн онцлог шинжүүд юу вэ?
1. тунгалаг
2. өнгөгүй

3. цусны судасгүй
 4. мэдрэлийн судлаар баялаг
 5. толирхог
40. Аль бүтцүүд цусны судасгүй вэ?
1. эвэрлэг бүрхүүл
 2. болор
 3. шилэнцэр
 4. торон бүрхүүл
 5. нулимсны эрхтэн
41. Сормослог биеийн үүрэг юу вэ?
1. нүдийг гадны нөлөөнөөс хамгаалах
 2. аккомодацид оролцох
 3. нүдийг чийглэх
 4. нүдний дотоод шингэнийг үүсгэх
 5. нүдний өнгийг тодорхойлох
42. Сормослог бие ямар хэсгүүдээс тогтдог вэ?
1. сэртэнгүй хэсэг
 2. сэртэнтэй хэсэг
 - 3 дугуй хэсэг
 4. хавтгай хэсэг
 5. бөөрөнхий хэсэг
43. Нүдний шингэн урсах шүүгдлийн системд юу юу хамаарах вэ?
1. нулимсны суваг
 2. трабекул
 3. нулимсны цэг
 4. цуглуулах сувгууд
 5. хамар нулимсны сувгууд
44. Өмнөд хорго ямар бүтцүүдээр үүсгэгдэх вэ?
1. сормослог бие
 2. солонгон бүрхүүл
 3. уураг бүрхүүл
 4. эвэрлэг бүрхүүл
 5. торон бүрхүүл
45. Нүд хөдөлгөгч булчинд аль нь хамаарахгүй вэ?
1. дээд ташуу булчин
 2. доод ташуу булчин
 3. гадна ташуу булчин
 4. нүд тойрсон цагираг булчин
 5. зовхи өргөгч булчин
46. Харах эрхтний үүргийг нэрлэнэ үү.
1. төвийн хараа
 2. өнгөний хараа
 3. хос хараа
 4. захын хараа
 5. гэрэл мэдрэхүй
47. Өнгө таних үйл ажиллагааг ямар таблицаар илрүүлэх вэ?
1. Сивцевийн таблиц
 2. Ишихарагийн таблиц
 3. Снеллений таблиц
 4. Рабкины таблиц
 5. Амслерын тор

48. Төвийн харааг ямар таблицаар шалгах вэ?
1. Ишихарагийн таблиц
 2. Сивцевийн таблиц
 3. Рабкины таблиц
 4. Снеллений таблиц
 5. Голдманы таблиц
49. Хос харааг шалгах аргуудыг нэрлэнэ үү.
1. Вортын аппарат
 2. стерео тест
 3. харандааны цаанаас унших
 4. алга цоорхойн шинж
 5. бүдүүвчилсэн арга
50. Савханцар эс ямар үүрэгтэй вэ?
1. төвийн хараа
 2. бүрэнхийн хараа
 3. өнгөний хараа
 4. захын хараа
 5. хос хараа
51. Торон бүрхүүл дээр ямар эсүүд байрладаг вэ?
1. зангилаат эс
 2. савханцар
 3. лонхонцор
 4. хоёр туйлт холбоос эс
 5. кератоцит
52. Бактерийн гаралтай салст бүрхүүлийн үрэвслийн үед гарах шинжүүдийг нэрлэнэ үү.
1. нулимс гоожих
 2. идээ нуух гарах
 3. нүд улайх
 4. нүдээр хүчтэй хатгаж өвдөх
 5. гэрэлд гялбах
53. Гонобленнорейя-н хүндрэлийг олно уу?
1. эвэрлэг бүрхүүлийн идээт шарх
 2. эвэрлэг бүрхүүл цоорох
 3. панофтальмит
 4. эндофтальмит
 5. торон бүрхүүл хуурах
54. Эвэрлэг бүрхүүлийн үрэвслийн үед илэрдэг субъектив шинж
1. толгой өвдөх
 2. нүдээр хатгаж өвдөх
 3. юм хоёрлож харагдах
 4. гэрэлд гялбах
 5. нүд загатнах
55. эвэрлэг бүрхүүлийн үрэвслийн дотоод шалтгаан юу вэ?
1. герпес вирус
 2. тэмбүү
 3. сүрьеэ
 4. мөөгөнцөр
 5. стрептококк
56. эвэрлэг бүрхүүлийн өвчний төгсгөлийг нэрлэнэ үү.
1. үүл
 2. толбо

3. цагаа
 4. птоз
 5. нүд ширгэх
57. Аккомодацийн үед нүдэнд ямар процесс явагдах вэ?
- 1.болор гүдийх
 2. цинний холбоос сулрах
 3. сормослог булчин агших
 4. болор хугарлын хүчээ нэмэгдүүлэх
 - 5.болор нимгэрэх
58. Олдмол катарактийн ангилал
1. гэмтлийн
 2. хордлогын
 3. хүндрэлийн
 4. цацраг туяаны
 5. бие махбодын ерөнхий өвчний
59. Хөгшрөлтийн катарактыг үе шатаар нь хэрхэн ангилдаг вэ?
1. эхэлсэн үе
 2. гүйцэд боловсроогүй үе
 3. бүрэн боловсорсон үе
 4. хэт боловсорсон үе
 5. төгсгөл үе
60. Анхдагч глаукомын ангилал
1. төрөлхийн
 2. нээлттэй өнцөгт
 3. хоёрдогч
 4. хаалттай өнцөгт
 5. удамшлын
61. Глаукомын хурц давшлын үед илрэх субъектив шинжүүдийг нэрлэнэ үү.
1. хүүхэн хараа өргөсөх
 2. нүдээр хатгаж өвдөх
 3. гэрлийн тойрон солонгон хүрээ харагдах
 4. утаа манантай харагдах
 5. хараа муудах
62. Салст бүрхүүлийн дистрофийн өөрчлөлтийг нэрлэнэ үү.
1. эпикантус
 2. өөхөнцөр
 3. халазион
 4. далавч хальс
 5. птоз
63. Ямар өвчнүүдийн үед бактерийн эсрэг эмчилгээ шаардлагатай вэ?
1. глаукома
 2. өвдөг
 3. птоз
 4. гонобленнорея
 5. катаракт
64. Салст бүрхүүлийн үрэвслийн гадаад шалтгаан юу вэ?
1. бактери
 2. вирус
 3. харшил
 4. физик химийн шалтгаан
 5. ерөнхий өвчин

65. Салст бүрхүүлийн өвчнийг хэрхэн ангилах вэ?
1. салст бүрхүүлийн үрэвсэл
 2. дистрофийн өөрчлөлт
 3. хавдар
 4. төрөлхийн гажиг
 5. салст бүрхүүлийн хэлбэрийн өөрчлөлт
66. Нүдний дотоод даралт ихсэх өвчний давшилтын үед илрэх бодит шинжүүд
1. хүүхэн хараа өргөсөх
 2. нүд тэмтрэхэд чулуу мэт хатуу
 3. эвэрлэг бүдэгших
 4. хараа эрс муудсан
 5. нүд томорсон
67. Нүдний нэвт гэмтлийн үед зайлшгүй гарах шинж
1. Ил харагдах шарх
 2. Солонгон бүрхүүлийн цоорхой
 3. Судаслаг хавчуулагдах
 4. Нүдэнд гадны биет тодорхойлогдох
 5. гипотони
68. Эвэрлэг бүрхүүлийн үрэвслийн үед түгээмэл тохиолдох субъектив шинжийг нэрлэнэ үү.
1. Гэрэлд гялбах
 2. Нулимс гоожих
 3. Нүдээр хатгаж өвдөх
 4. Нүд загатнах
 5. юм хоёрлож харагдах
69. Салст бүрхүүлийн өвчнийг хэрхэн ангилдаг вэ?
1. Салст бүрхүүлийн үрэвсэл
 2. салст бүрхүүлийн дистрофийн өөрчлөлт
 3. салст бүрхүүлийн хавдар
 4. салст бүрхүүлийн гэмтэл
 5. салст бүрхүүлийн гажиг хөгжил
70. Аль нь дотоод шалтгаант кератит вэ?
1. Сүрьеэгийн кератит
 2. Тэмбүүгийн кератит
 3. Мэдрэл саажлын
 4. Херпес вирусын
 5. Мөөгөнцөрт кератит
71. Гаднын шалтгаант халдварт конъюнктивитийн үүсгэгчдийг нэрлэнэ үү.
1. пневмококк
 2. Кох Уиксын савханцарт бактери
 3. гонококк
 4. аденовирус
 5. мөөгөнцөр
72. Гаднын шалтгаант халдварт конъюнктивитийн үед ямар шинжүүд илэрдэг вэ?
1. Нүд улайх
 2. Нулимс гоожих
 3. Нуух гоожих
 4. Гэрэлд гялбах
 5. салстад олон тооны цус харвалт үүсэх
73. Зовхины өвчинд аль нь хамаарах вэ?
1. цус хурах

2. зовхины хаван
 3. арьсанд агаар хурах
 4. зовхин ирмэгийн үрэвсэл
 5. өвдөг
74. Зовхины ирмэгийн үрэвслийг эмнэлзүйн хувьд хэрхэн ангилдаг вэ?
1. шархлаат
 2. хайрст
 3. энгийн
 4. бижрүүт
 5. наалдацтай
75. Өвдөг гэж юу вэ?
1. салст бүрхүүлийн үрэвсэл
 2. сормуусны угийн тослогийн булчирхайн идээт үрэвсэл
 3. эвэрлэгийн үрэвсэл
 4. мейбомийн булчирхайн хурц идээт үрэвсэл
 5. мейбомийн булчирхайн архаг үрэвсэл
76. Далавч хальс буюу птериgium үүсэх шалтгаан юу вэ?
1. бактери
 2. вирус
 3. мөөгөнцөр
 4. салхи, шороо, агаарын бохирдол
 5. харшил
77. Эвэрлэг бүрхүүлийн үрэвслийн үед илрэх бодит шинжүүдийг олно уу.
1. перикореаль улайлт
 2. эвэрлэг бүрхүүл тунгалаг шинжээ алдах
 3. цусны судас ургах
 4. үрэвслийн нэвчдэс үүсэх
 5. цус хурах
78. Эвэрлэг бүрхүүлийн бактерийн гаралтай үрэвслийн үед эмчилгээнд ямар эмүүдийг хэрэглэж болох вэ?
1. эритромицин
 2. сульфацил натри
 3. атропин
 4. пилокарпин
 5. диакарб
79. Эвэрлэг бүрхүүлийн үрэвсэл хэрхэн төгсөж болох вэ?
1. үүл
 2. толбо
 3. цагаа
 4. гүвдрүү
 5. цэврүү
80. Нүдний заг хүйтнийг ямар бактери үүсгэдэг вэ?
1. пневмококк
 2. Кох Уиксын савханцарт бактери
 3. стафилакокк
 4. гонококк
 5. стрептококк
81. Олдмол катарактыг хэрхэн ангилдаг вэ?
1. хүндрэлийн
 2. хөгшрөлтийн
 3. гэмтлийн

4. бие махбодын ерөнхий өвчний үеийн
 5. харшлын
82. Хөгшрөлтийн катаракт ямар үе шатаар явагддаг вэ?
1. бүрэн боловсорсон үе
 2. хэт боловсорсон үе
 3. эхлэх үе
 4. гүйцэд боловсроогүй үе
 5. боловсорч дууссан үе
83. Анхдагч глаукомыг юу гэж ангилдаг вэ?
1. хаалттай өнцөгт
 2. холимог өнцөгт
 3. нээлтэй өнцөгт
 4. ургийн
 5. удамшлын
84. Хаалттай өнцөгт глаукомыг давшилтанд хүргэхэд нөлөөлдөг хүчин зүйлүүд
1. хэт даарах
 2. толгойгоо бөхийлгөж удаан суух
 3. харанхуйд удаан суух
 4. сэтгэл санааны хямрал
 5. зарим эм хэрэглэх
85. Нүдний алимын нэвтэрсэн гэмтлийн зайлшгүй шинжүүдийг нэрлэнэ үү.
1. нүдний алим зөөлөн болсон
 2. нүдний дотоод даралт буурсан
 3. хүүхэн харааны хэлбэр өөрчлөгдөж шархны зүг татсан
 4. шархаар солонгон бүрхүүл цухуйсан
 5. нүдэнд халдвар орсон
86. Нүдний алимын нэвтэрсэн гэмтлийн болзошгүй шинжүүдийг нэрлэнэ үү.
1. нүдний алим зөөлөн болсон
 2. нүдний дотоод даралт буурсан
 3. хүүхэн харааны хэлбэр өөрчлөгдөж шархны зүг татсан
 4. шархаар солонгон бүрхүүл цухуйсан
 5. нүдэнд халдвар орсон
87. Нээлтэй өнцөгт глаукома давшилтанд шилждэг. Яагаад гэвэл нүдний дотоод шингэн урсах замд дистофийн өөрчлөлт үүссэн байдаг.
88. Нүдний далавч хальсанд мэс засал эмчилгээ хийдэггүй. Яагаад гэвэл энэ нь нүдний хараанд нөлөөлдөггүй.
89. Глаукомын давшилтын үед нүд чулуу мэт хатуу болдог. Учир нь нүдний дотоод даралт 60-80 мм муб болсон байдаг.
90. Нүдний заг хүйтнээр зөвхөн нярай хүүхэд өвчилдөг. Учир нь тэд эхээс халдвар авдаг.
91. Цэцэг, ургамлын гаралтай нүдний үрэвслийн үед хараа мууддаг. Учир нь нүдний салст бүрхүүл хөөж хавагнадаг.
92. Хөдөө аж ахуйд ажилладаг хүмүүс хамгаалалтын шил байнга зүүх нь тустай. Учир нь нүдний эвэрлэг бүрхүүлийн дистрофи үүсдэг.
93. Нүд шинжлэх аргуудыг зөв холбоно уу.
1. Нүдний дотоод даралт хэмжих арга
 2. Өмнөд тасалгааны өнцгийг дурандах арга
 3. торон бүрхүүлийн цахилгаан бичлэг
 4. нүдний хугарлын гажгийг илрүүлэх шинжилгээний арга
 5. нүдний уг дурандах арга
- A. ретиноскопи
- B. гониоскопи

- C. офтальмоскопи
 - D. Маклаковын тонометр
 - E. Электроретинографи
 - A. 1D, 2B, 3E, 4D, 5A
 - B. 1B, 2A, 3C, 4E, 5D
 - C. 1C, 2E, 3A, 4D, 5B
 - D. 1D, 2B, 3C, 4E, 5A
 - E. 1E, 2D, 3C, 4B, 5A
94. Рефракцийн хэлбэрүүдийг зөв холбо.
1. Миопи гэж юу вэ?
 2. гиперметропи гэж юу вэ?
 3. эмметропи
 4. аккомодаци
 5. пресбиопи
- A. 40 өөс дээш насанд ойрын хараа муудах
 - B. ойр хараат хугарал
 - C. хол хараат хугарал
 - D. хол, ойрын зайд тохируулан харах үйл зүй
 - E. зөв харьцаат хугарал
 - A. 1D, 2B, 3E, 4D, 5A
 - B. 1B, 2A, 3C, 4E, 5D
 - C. 1B, 2C, 3E, 4D, 5A
 - D. 1D, 2B, 3C, 4E, 5A
 - E. 1E, 2D, 3C, 4B, 5A
95. Тодорхойлолтуудыг зөв холбо
1. өвдөг
 2. мейбомит
 3. халазион
 4. далавч хальс
 5. өөхөнцөр
- A. Нүдний алимны дотор хэсэгт шаравтар өнгөтэй өөх мэт овгор үүсэхийг хэлнэ.
 - B. Сормуусны угийн тосны булчирхайн цочмог идээт үрэвсэл
 - C. Мейбомийн булчирхайн архаг үрэвсэл
 - D. Мейбомийн булчирхайн цочмог идээт үрэвсэл
 - E. Нүдний дотор булангаас улбар өнгөтэй гурвалжин хальс гадагшаа түрж ургахыг хэлнэ.
 - A. 1B, 2D, 3C, 4E, 5A
 - B. 1B, 2A, 3C, 4E, 5D
 - C. 1C, 2E, 3A, 4D, 5B
 - D. 1D, 2B, 3C, 4E, 5A
 - E. 1E, 2D, 3C, 4B, 5A
96. Эмүүдийн үйлдлийг зөв холбо.
1. M- холинорецепторыг хориглогч
 2. M холинорецепторыг сэргээгч
 3. Холин эстеразын эсрэг
 4. Бактерийг эсрэг үйлдэлтэй
 5. Карбоангидраза ферментийг хориглогч
- A. пилокарпин
 - B. атропин
 - C. ампициллин
 - D. диакарб

- Е. прозерин
- А.1В, 2А,3Е, 4С, 5D
- В.1В, 2А, 3Е, 4С, 5D
- С. 1С, 2Е, 3А, 4D, 5В
- D. 1D, 2В, 3С, 4Е, 5А
- Е. 1Е, 2D, 3А, 4С, 5В

97. Нүдний бүрхүүлүүдийн үрэвслийг зөв холбо.

- 1. кератит
- 2. иридоциклит
- 3. дакроцистит
- 4. конъюктивит
- 5. хориодит
- А. жинхэнэ судас бүрхүүлийн үрэвсэл
- В. нулимсны хүүдийн үрэвсэл
- С. салст бүрхүүлийн үрэвсэл
- Д. эвэрлэг бүрхүүлийн үрэвсэл
- Е. сормослог бие, солонгон бүрхүүлийн үрэвсэл
- А.1D, 2В,3Е, 4D, 5А
- В.1D, 2Е, 3В, 4С, 5А
- С. 1С, 2Е, 3А, 4D, 5В
- Д. 1D, 2В, 3С, 4Е, 5А
- Е. 1Е, 2D, 3С, 4В, 5А

98. Дараах эмгэгүүдийг зөв холбо.

- 1. Гипопион
- 2. Гифема
- 3. Преципитат
- 4. Артифакия
- 5. афакия
- А. болоргүй нүд
- В. эвэрлэг бүрхүүлийн эндотельд үүссэн эсийн бөөгнөрөл
- С. өмнөд тасалгаанд идээ хурах
- Д. хиймэл болортой нүд
- Е. өмнөд тасалгаанд цус хурах
- А.1D, 2В,3Е, 4D, 5А
- В.1D, 2Е, 3В, 4С, 5А
- С. 1С, 2Е, 3В, 4D, 5А
- Д. 1D, 2В, 3С, 4Е, 5А
- Е. 1Е, 2D, 3С, 4В, 5А

99. Харах эрхтний үйл ажиллагааг тодорхойлох шинжилгээний аргуудыг зөв холбо.

- 1. Алга цоорхойн шинж
- 2. Ферстерийн периметр
- 3. Рабкины хүснэгт
- 4. Снеллений хүснэгт
- 5. Нагелийн адаптометр
- А. гэрэл мэдрэхүй
- В. өнгөний хараа
- С. хос хараа
- Д. төвийн хараа
- Е. захын хараа
- А.1С, 2Е,3В, 4А, 5D
- В.1D, 2Е, 3В, 4С, 5А

- C. 1C, 2E, 3D, 4A, 5B
- D. 1D, 2B, 3C, 4E, 5A
- E. 1C, 2E, 3B, 4D, 5A

100. Дараах эмгэгүүдийг ямар шилээр засах вэ?

- 1. Миопи
- 2. Гиперметропи
- 3. астигматизм
- 4. Пресбиопи
- 5. косоглазие
- A. цилиндр
- B. ойр харааны + шил
- C. цуглуулагч +
- D. сарниулагч -
- E. призм
- A. 1C, 2D, 3A, 4B, 5E
- B. 1D, 2E, 3B, 4C, 5A
- C. 1C, 2E, 3D, 4A, 5B
- D. 1D, 2B, 3C, 4E, 5A
- E. 1C, 2E, 3B, 4D, 5A

ЧИХ ХАМАР ХООЛОЙ СУДЛАЛ

1. Орофарингоскопи хийхдээ хэл дарагчийг хаана байрлуулах вэ?

- A. Хэлний уг дээр
- B. Хэлний өмнөд 2/3 хэсэгт
- C. Хэлний үзүүрт
- D. Хэлний өмнөд 1/3 хэсэгт
- E. Хэлийг дарахгүйгээр ам залгиурыг шинжилсэн ч болно.

2. "Гэрлийн рефлекс" гэж юу вэ?

- A. Хэнгэргэн хальсанд байнга байдаг, гэрэлтдэг хэсэг
- B. Отоскопи хийх үед илэрдэг, алхны богино сэртэнд оройтой, хэнгэргэн хальс дээрхи конус хэлбэртэй гэрэл
- C. Отоскопи хийх үед алхны богино сэртэнд ойсон конус хэлбэртэй гэрэл
- D. Отоскопи хийх үед гэрэл үүсгэгчээс гарч байгаа конус хэлбэртэй гэрэл
- E. Отоскопи хийх үед алхны богино сэртэнд ойсон конус хэлбэртэй гэрэл

3. Тоглоомын аудиометрийг хэдэн нас хүртэл хийх вэ?

- A. 0-3 насанд
- B. 3-аас дээш насанд
- C. 16 хүртэл насанд
- D. Том хүнд ч хэрэглэж болно.
- E. Тоглоом ашиглан сонсгол шалгах нь буруу

4. Tinnitus буюу "чих шуугих" гэдэг ойлголтыг зөв тодорхойлно уу.

- A. Гадаад орчинтой холбоогүй, чихэн дотор үүсч байгаа шуугиан
- B. Гадаад орчинтой холбоогүй толгой дотор үүсч байгаа дуу чимээний мэдрэмж
- C. Гадаад орчны дуу чимээг чихэнд зовиуртайгаар хүлээн авах мэдрэмж
- D. Толгой өвдөлтөөс үүдэлтэй шуугиан

- Е. Чихнээс гаралтай шуугиан
5. Хэнгэргэн хальсны хөдөлгөөнийг шалгах ямар шинжилгээнүүд байна вэ?
- А. Тимпанометр, Зиглийн хийлэгч лүүз
 - В. Аудиометр, ABR
 - С. Тоглоомын аудиометр, тимпанометр
 - Д. Зиглийн хийлэгч лүүз, отоакустик эмиссион
 - Е. Аудиометр, тимпанометр
6. Эрүүл чихтэй хүн шивнээ яриаг хэдэн м зайнаас сонсох вэ?
- А. 0,5 м
 - В. 1 м
 - С. 4 м
 - Д. 6 м
 - Е. 8 м
7. Ринне-гийн сорилыг ямар зорилгоор хийдэг вэ?
- А. Сонсгол буурсан эсэхийг тодорхойлох
 - В. Сонсгол бууралтын хэлбэрийг тодорхойлох
 - С. Сонсгол бууралтын зэргийг тодорхойлох
 - Д. Дуу дамжуулах замын үйл ажиллагааг шалгахын тулд
 - Е. Дөрөөний рефлексийг үзэхийн тулд
8. Хэнгэргэн хальсны хөдөлгөөнийг шалгах ямар шинжилгээнүүд байна вэ?
- А. Тимпанометр, Зиглийн хийлэгч лүүз
 - В. Аудиометр, ABR
 - С. Тоглоомын аудиометр, тимпанометр
 - Д. Зиглийн хийлэгч лүүз, отоакустик эмиссион
 - Е. Аудиометр, тимпанометр
9. Tinnitus буюу “чих шуугих” гэдэг ойлголтыг зөв тодорхойлно уу.
- А. Гадаад орчинтой холбоогүй, чихэн дотор үүсч байгаа шуугиан
 - В. Гадаад орчинтой холбоогүй толгой дотор үүсч байгаа дуу чимээний мэдрэмж
 - С. Гадаад орчны дуу чимээг чихэнд зовиуртайгаар хүлээн авах мэдрэмж
 - Д. Толгой өвдөлтөөс үүдэлтэй шуугиан
 - Е. Чихнээс гаралтай шуугиан
10. Чихний гаралтай зөөлөн эдийн хүндрэлийг оношлох хамгийн оновчтой шинжилгээ юу вэ?
- А. КТ
 - В. MRI
 - С. Биопси
 - Д. Чихний рентген зураг
 - Е. Бактериолог шинжилгээ
11. 0-1 насны хүүхдийн чихийг шинжлэх хамгийн тохиромжтой рентген шинжилгээ аль нь вэ?
- А. Шюллерийн арга
 - В. Майерийн арга
 - С. Стенверсийн арга
 - Д. Гинзбургийн арга

Е. КТ

12. “Дуу сөөх” гэдэг ойлголтыг зөв тодорхойлно уу

- А. Дууны өнгө өөрчлөгдөх үйл явц
- В. Дуу үүсэх үйл ажиллагааны алдагдал
- С. Дууны чанга сул байдлын ээлжлэлт
- Д. Төвөнхийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой хямрал
- Е. Дууны хөвчийн чичирхийлэл өөрчлөгдөх үйл явцаар илэрч буй төвөнхийн үйл

ажиллагааны хямрал

13. Төвөнхөд хамгийн элбэг тохиолддог хорт хавдар юу вэ?

- А. Папиллома
- В. Карцинома
- С. Рабдомиосаркома
- Д. Хавтгай эст өмөн
- Е. Хондрома

14. Нойрон дунд амьсгал зогсох хам шинж ямар хугацаагаар үргэлжилдэг вэ?

- А. 5 секунд орчим
- В. 5-10 секунд
- С. 10 секунд орчим
- Д. 1 минут орчим
- Е. 1-2 минут орчим

15. Үнэрлэхүйн бүс хаана байдаг вэ?

- А. Хамрын таславчид
- В. Хамрын самалдгуудад
- С. Хамрын дайварт
- Д. Хамрын хөндийн дээвэрт, хамрын ерөнхий жимийн дээд 1/3 хэсгийг хамран

оршино.

- Е. Хамрын хөндийн ёроолд, хамрын ерөнхий жимийн доод 1/3 хэсгийг хамран

оршино.

16. Дисосмия гэж юу вэ?

- А. Үнэрлэхүйн өөрчлөлтгүй байх
- В. Үнэрлэхүй нь хэт ихсэх
- С. Үнэрлэхүй арилах, алга болох
- Д. Үнэрлэхүй нь бодит байдалтай тохирохгүй байх
- Е. Үнэрлэхүй багасах

17. Аносмия гэж юу вэ?

- А. Үнэрлэхүйн өөрчлөлтгүй байх
- В. Үнэрлэхүй нь хэт ихсэх
- С. Үнэрлэхүй арилах, алга болох
- Д. Үнэрлэхүй нь бодит байдалтай тохирохгүй байх
- Е. Үнэрлэхүй багасах

18. Хамрын дайвар хөндийнүүд ямар хучуур эдээр хучигддаг вэ?

- А. Шоо эпители
- В. Холбох эпители
- С. Бортгон эпители

- D. Хавтгай эпителий
 - E. Янз бүрийн эпителий
- 19.Хамрын цэвэрлэх үйл ажиллагааг гүйцэтгэдэг бүтэц юу вэ?
- A. Хамрын хөндийн тараагуур, хураагуур судсуудын сүлжээ
 - B. Салст бүрхүүлийн намираа хучуур эд
 - C. Салст бүрхүүлийн хундган эсүүд 8
 - D. Хамрын хөндийн зай болон дайвар хөндийнүүд
 - E. Үнэрлэхүйн мэдрэхүйн эсүүд
- 20.Хамрын бүлээсгэх үйл ажиллагааг гүйцэтгэдэг бүтэц юу вэ?
- A. Хамрын хөндийн тараагуур, хураагуур судсуудын сүлжээ
 - B. Салст бүрхүүлийн намираа хучуур эд
 - C. Салст бүрхүүлийн хундган эсүүд
 - D. Хамрын хөндийн зай болон дайвар хөндийнүүд
 - E. Үнэрлэхүйн мэдрэхүйн эсүүд
- 21.Хамрын чийглэх үйл ажиллагааг гүйцэтгэдэг бүтэц юу вэ?
- A. Хамрын хөндийн тараагуур, хураагуур судсуудын сүлжээ
 - B. Салст бүрхүүлийн намираа хучуур эд
 - C. Салст бүрхүүлийн хундган эсүүд
 - D. Хамрын хөндийн зай болон дайвар хөндийнүүд
 - E. Үнэрлэхүйн мэдрэхүйн эсүүд
- 22.Хамрын гаралтай тархины буглааг юунаас ялган оношлох вэ?
- A. Энцефалит
 - B. Этmoidит
 - C. Тархины анхдагч мэнэн, буглаа
 - D. Ретробульбар буглаа
 - E. Мастоидит
- 23.Нистагм гэж юу вэ?
- A. Нүдний эмгэгийн үед илрэх тэнцвэрийн өөрчлөлт
 - B. Дотор чих цочирсныг илтгэх нүдний замбараагүй хөдөлгөөн
 - C. Дотор чихний эмгэгийн үеийн түгээмэл шинж
 - D. Тэнцвэрийн эмгэгийн улмаас үүссэн нүдний хүндрэл
 - E.Тэнцвэрийн анализаторын эмгэгийн үед нүдний алимд үүссэн чичирхийлэх хөдөлгөөн
- 24.Нистагмын ангиллыг хэлнэ үү
- A. Эрт илрэх ба хожуу илрэх
 - B. Гэнэтийн ба аажим үүсэх
 - C. Төвийн ба захын
 - D. Хурдан ба удаан
 - E. Түр зуурын ба байнгын
- 25.Дунд чихний цочмог үрэвсэл үүсэх хамгийн түгээмэд зам юу вэ?
- A. Тимпаногенный
 - B. Тубогенный
 - C. Контактный
 - D. Агаар дуслын
 - E. Хавьтлын

26. Гадна чихний сувгийн нарийсал хаана тохиолдох вэ?
- A. Сувгийн ясан хэсэгт
 - B. Сувгийн мөгөөрсөн хэсэгт
 - C. Хэнгэрэг бэхлэгдэх цагирагт
 - D. Мөгөөрсөн ба ясан хэсэгт
 - E. Сувгийн орох амсарт
27. Хэнгэргэн хальсны цооролтыг юу гэж ангилдаг вэ?
- A. Төвийн, захын
 - B. Эпитимпанумын, гипотимпанумын
 - C. Эпитимпанумын, мезотимпанумын
 - D. Хэнгэргийн төвийн
 - E. Хэнгэргийн захын
28. Холестеатомтай хавсран тохиолддог нь ямар хэлбэрийн цооролт вэ?
- A. Төвийн, захын
 - B. Эпитимпанумын, гипотимпанумын
 - C. Эпитимпанумын, мезотимпанумын
 - D. Хэнгэргийн төвийн
 - E. Хэнгэргийн захын
29. Нярайн хэнгэргэн хөндийн онцлог юу вэ?
- A. Агааржилт сайтай
 - B. Миксоид эдээр баялаг
 - C. Мөгөөрсөн эдтэй
 - D. Хөвсгөр холбогч эдээр баялаг
 - E. Амьсгалын замын намираа хучуур эдтэй
30. Зөв хариултыг ол.
- A. Хэнгэргэн хальс даралтыг тэсвэрлэдэггүй тул цоордог.
 - B. Хэнгэргэн хальс 100 мм м.у.б-ын даралтыг тэсвэрлэж чадна.
 - C. Хэнгэргэн хальс даралтыг тэсвэрлэх чадвар сайтай.
 - D. Хэнгэргэн хальс 1000 мм м.у.б-ын даралтыг тэсвэрлэж чадна.
 - E. Хэнгэргэн хальс 800 мм м.у.б-ын даралтыг тэсвэрлэж чадна.
31. Дуу дамжуулах хэлбэрийн сонсгол бууралт гэж юу вэ?
- A. Гадна чихний сувагт бөглөрөл үүссэнээс дүлийрэх
 - B. Гадна чихнээс зууван цонх хүртэл замд дуу дамжуулалт алдагдах
 - C. Сонсголын яснуудын дуу дамжуулах үйл алдагдах
 - D. Зууван цонхноос цаашхи замд үйл ажиллагаа алдагдах
 - E. Гадна чихнээс хэнгэргэн хальс хүртэлх замд дуу дамжуулалт алдагдах
32. Сонсох мэдрэлийн дүлийрэлт гэж юу вэ?
- A. Гадна чихний сувагт бөглөрөл үүссэнээс дүлийрэх
 - B. Гадна чихнээс зууван цонх хүртэл замд дуу дамжуулалт алдагдах
 - C. Сонсголын яснуудын дуу дамжуулах үйл алдагдах
 - D. Зууван цонхноос цаашхи замд үйл ажиллагаа алдагдах
 - E. Гадна чихнээс хэнгэргэн хальс хүртэлх замд дуу дамжуулалт алдагдах
33. Дунд чихний шүүдэст үрэвслийн дахилтат хэлбэрийн үед дараахь эмчилгээг хийнэ.
- A. Тимпанопластик мэс засал

- B. Хэнгэргэн хальсанд агааржуулагч гуурс тавих
 - C. Антибиотик эмчилгээ
 - D. Кортикостероид эмийн бэлдмэл тарих
 - E. Дегидратац хийх
34. Чихний хүндрэлийн ангиллыг нэрлэнэ үү
- A. Чамархайн ба гавал тархины
 - B. Гавал тархины ба нүдний
 - C. Тархины буглаа ба мэнэн
 - D. Анхдагч ба хоёрдогч
 - E. Ерөнхий ба хэсэг газрын
35. Чихний сүрьеэгийн ангиллыг хэлнэ үү
- A. Мөхлөгөнгөрт ба эвдрэлтэт
 - B. Уушигны ба чихний
 - C. Идээт ба шүүдэст
 - D. Анхдагч ба хоёрдогч
 - E. Эвдрэлтэт ба эвдрэлтэт бус
36. Гадна хамар хаана оршдог эрхтэн бэ?
- A. Гавлын дунд ба өмнөд хотгорын дор
 - B. Нүүрэн дээр
 - C. Гавлын өмнөд болон дунд хотгор, хатуу тагнайн дунд
 - D. Нүүрний төв хэсэгт
 - E. Гавлын өмнөд болон дунд хотгор, ухархайнуудын дунд
37. Аль нь хамрын өмнөд тольдолтын шинжилгээ вэ?
- A. Хамраар дуран оруулж шинжлэх
 - B. Хамраар жижиг толь оруулж хамрын хөндийг толинд тусган шинжлэх
 - C. Хамрын ясыг тэмтрэн шалгах
 - D. Нармайн толиор харж өөрчлөлтийг илрүүлэх
 - E. Хамрын толь ашиглан үүдэвчийг өргөсгөж хамрын хөндийн бүх ханыг харж өөрчлөлтийг илрүүлэх
38. Хамрын хатгийн үед үзүүлэх анхны тусламж юу вэ?
- A. Хэвтрийн дэглэм сахиулж антибиотикийг өндөр тунгаар авна.
 - B. Хэсгийн мэдээгүйжүүлгээр хатгийг нээнэ
 - C. Ерөнхий мэдээгүйжүүлгээр хатгийг нээнэ.
 - D. Хатуу нэвчдэсийг шахаж антибиотик тарина
 - E. Буглааг нээгээд орхих нь хангалтта
39. Хамрын цус алдалтын үед авах хамгийн анхны арга хэмжээ юу вэ?
- A. Цус тогтоох эмүүдийг яаралтай тарина.
 - B. Өвдөлт намдаана.
 - C. Хамрын өмнөд чихээс хийнэ.
 - D. Хамрын арын чихээс хийнэ.
 - E. Суугаа байрлалд толгойг бөхийлгөн, үүдэвчийг таславч руу дарж чимхүүлэн амаар амьсгалуулна.
40. Нармайн гүйлсний томролтын ангиллыг хэлнэ үү
- A. Жижиг, дунд зэрэг, том
 - B. Ээнэгшилтэй, ээнэгшилгүй,

- C. Хөөнгөшилт ба хатингаршилт
 - D. 1, 2, 3-р зэрэг
 - E. Хэвийн ба эмгэг томролт
41. Ангина гэж юу вэ?
- A. Залгиурын лимфойд эд үрэвсэлт өөрчлөлтөд нэрвэгдэх хэсэг газрын шинжээр илрэх бүх биеийг хамарсан хурц халдвар.
 - B. Хөөмийн гүйлсний хурц үрэвсэл
 - C. Хөөмийн гүйлсний архаг үрэвсэл
 - D. Хөөмий-нармайн гүйлсний хавсарсан халдвар
 - E. Залгиурын лимфойд эд үрэвсэлт өөрчлөлтөд нэрвэгдэх хэсэг газрын шинжээр илрэх бүх биеийг хамарсан архаг халдвар.
42. Зөв хариултыг ол
- A. Цагаан мөгөөрсөн хоолойн урт нь- 8 см, 15-19 мөгөөрсөн тал цагирагаас бүтнэ.
 - B. Цагаан мөгөөрсөн хоолойн урт нь- 11 см, 18-22 мөгөөрсөн тал цагирагаас бүтнэ.
 - C. Цагаан мөгөөрсөн хоолойн урт нь- 15 см, 19-24 мөгөөрсөн тал цагирагаас бүтнэ.
 - D. Цагаан мөгөөрсөн хоолойн урт нь- 19 см, 19-24 мөгөөрсөн тал цагирагаас бүтнэ.
 - E. Цагаан мөгөөрсөн хоолойн урт нь- 24 см, 19-24 мөгөөрсөн тал цагирагаас бүтнэ.
43. Стридор гэж юу вэ?
- A. Амьсгал бачуурах
 - B. Амьсгал бачуурч дуу сөөх
 - C. Төвөнхийн хөндий гэнэт нарийсах
 - D. Төвөнхийн хөндий нарийссанаас болж амьсгалах үндсэн үйл ажиллагаа алдагдах
 - E. Дууны хөвч гэнэт саажих
44. Чихийг шинжилдэг рентгений аргуудыг нэрлэнэ үү
1. Шюллерийн арга
 2. Майерийн арга
 3. Стенверсийн арга
 4. Гинзбургийн арга
 5. КТ
45. Хамрын цус тогтоох хэсэг газрын эмчилгээнүүдийг нэрлэнэ үү
1. Хамарт хүйтэн жин тавих
 2. Хамрын өмнөд чихээс хийх
 3. Хамрын арын чихээс хийх
 4. Азотоор хөлдөөх
 5. Цахилгаан төөнүүрээр түлэх (E)
46. Дараах эмүүдээс сонголт хортой нөлөөтэй эмийг ол
1. Аминогликозид
 2. Диуретик
 3. Макролид
 4. Цэр ховхлох, шингэлэх
 5. Гуурсан хоолой тэлэх
47. Доорхи эмгэгүүдээс дуу сөөдөг эмгэгүүдийг ол
1. Вирусийн шалтгаант цочмог ларингит

2. Дууны хөвчийн зангилаа
 3. Папилломатоз
 4. Төвөнхийн гаж хөгжил
 5. Дууны хөвчүүдийн саа
48. Хүүхдэд нойрон дунд амьсгал зогсоход нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү
1. Аденойд булчирхайн томрол
 2. Хөөмийн булчирхайн томрол
 3. Илүү жин
 4. Хоаны атреси
 5. Нармайн киста
49. Хамрын хөндийн архаг, хөөнгөт үрэвслийн үед хийх эмчилгээнүүдийг нэрлэ
1. Хамрын самалдгуудад кальци хлорид тарих
 2. Электрокоагуляци хийх
 3. Крио ба лазер деструкци
 4. Мукотомии мэс засал
 5. Конхотомии мэс засал
50. Хамрын хавсарсан гэмтлийг юу гэж ангилдаг вэ?
1. Ле-Фортын 1
 2. Ле-Фортын 2
 3. Ле-Фортын 3
 4. Ле-Фортын 4
 5. Ле-Фортын 5
51. Хамрын хөндийн чихээснээс үүсэх хүндрэл аль нь вэ?
1. Аносми
 2. Хамрын чихээс унаж цус алдалт үргэлжлэх
 3. Амьсгалахад бэрхшээлтэй, ам хатах
 4. Хамрын чихээс нармай руу унжиж механик асфикси үүсгэх
 5. Таславчид цус хурах, буглах
52. Залгиурын хэсгүүдийг нэрлэнэ үү
1. Нармай
 2. Амны хэсэг
 3. Багалзуур
 4. Хүзүүний хэсэг
 5. Хоолойн хэсэг
53. Аль эмгэгийн үед үнэрлэхүй алдагдах вэ?
1. Чихрийн шижин
 2. Гипотирозидизм
 3. Turner-ийн хам шинж
 4. Kallmann-ий хамшинж
 5. Псевдопаратирозидизм
54. Гадна чих ямар үүрэгтэй вэ?
1. Дуу цуглуулах
 2. Дууны байрлал тогтоох
 3. Гоо сайхны
 4. Орон зайд тэнцвэрийг зохицуулах

5. Сонсох
55. Дунд чих ямар үүрэгтэй вэ?
1. Дуу цуглуулах
 2. Дууны байрлал тогтоох
 3. Гоо сайхны
 4. Гадна чихнээс дотор чих рүү дууг дамжуулах
 5. Орон зайд тэнцвэрийг зохицуулах
56. Дэлбээний өөрчлөлтийг нэрлэнэ үү
1. Микротия
 2. Макротия
 3. Анотия
 4. Полиотия
 5. Дизотия
57. Чихэнд гадны биет байхад илрэх шинжүүд эль нь вэ?
1. Чихээр өвдөх
 2. Чихэнд юм байгаа мэт мэдрэмж төрөх
 3. Сонсгол буурах
 4. Амтлахуй алдагдах
 5. Дайвалзах
58. Сонсгол бууралтын өндөр эрсдэлт хүчин зүйлс юу вэ?
1. Төрөхөөс өмнө ба төрсний дараахь халдвар (цитомегаловирус, улаанууд, токсоплазмоз, тэмбүү)
 2. Хүзүү толгойд байрласан гаж хөгжил
 3. 1500 гр-аас бага жинтэй төрөх
 4. Бактерийн гаралтай менингит
59. Чихийг дайрдаг нүүрний мэдрэлийн хэсгүүдийг нэрлэнэ үү
1. Дотор чихний хэсэг
 2. Хэнгэрэгийн хэсэг
 3. Хөхөнцрийн хэсэг
 4. Чамархайн хэсэг
 5. Гадна чихний хэсэг
60. Сонсгол бууралтын хэлбэрүүдийг нэрлэнэ үү
1. Дуу дамжуулах хэлбэрийн
 2. Дуу хүлээн авах хэлбэрийн буюу мэдрэл-мэдрэхүйн
 3. Холимог хэлбэрийн
 4. Хүнд хэлбэрийн
 5. Хөнгөн хэлбэрийн
61. Чихний мэнэнгийн шинж аль нь вэ?
1. Толгой өвдөх, огиж бөөлжих
 2. Хүзүүний хөшингө
 3. Албадмал байдалд орох
 4. Нугасны усанд эс 200-аас дээш илрэх, уураг ихсэх
 5. Чихнээс өтгөн ногоон идээ гоожих, чихний араар хөндүүр хавдсан
62. Дунд чихний хурц, архаг үрэвслүүдийн хүндрэлийн шинж аль нь вэ?

1. Толгой хүчтэй өвдөх
 2. Толгой эргэх, тэнцвэр алдах
 3. Нүүрний мэдрэл саажих
 4. Ухамсарт ухаан балартах
 5. Халууралт нэмэгдэх
- 63.Хамрын хатигны хүндрэлийг нэрлэнэ үү
1. Хамрын гаралтай гавал тархины хүндрэл
 2. Хамрын гоо сайхан алдагдах
 3. Үжил
 4. Хамрын үүдэвч сорвижих
 5. Нүүр нүд хавдах
- 64.Хамрын харшил илрүүлэх сорилын хэлбэрүүдийг нэрлэнэ үү
1. Хамрын хөндийн сорил
 2. Арьсан дээрхи сорил
 3. Арьсан доорхи сорил
 4. Хэлний доор дусааж сорил хийх
 5. Нүдэнд дусааж сорил хийх
- 65.Дайвар хөндийн гаралтай ухархайн хүндрэлүүдийг нэрлэнэ үү
1. Зовхины буглаа, ухархайн ясны хальсны буглаа
 2. Доод зовхины буглаа, дээд зовхины буглаа
 3. Нүдний алимын арын буглаа, ухархайн нэвчдэс
 4. Алимын доторхи буглаа
 5. Ухархайн буглаа
- 66.Хамрын цус тогтоох хэсэг газрын эмчилгээнүүдийг нэрлэнэ үү
1. Хамарт хүйтэн жин тавих
 2. Хамрын өмнөд чихээс хийх
 3. Хамрын арын чихээс хийх
 4. Азотоор хөлдөөх
 5. Цахилгаан төөнүүрээр түлэх
- 67.Хамрын цочмог үрэвслүүдийн хэлбэрийг нэрлэнэ үү
1. Цочмог улайх үрэвсэл
 2. Цочмог шүүдэст үрэвсэл
 3. Цочмог идээт үрэвсэл
 4. Цочмог хавант үрэвсэл
 5. Хамрын хөндийн арын үрэвсэл
- 68.Хамрын хөндийн хэсэг газрын эмчилгээнүүдийг нэрлэнэ үү
1. Хамрын хөндийгөөс ялгадсыг соруулах
 2. Хамрыг хуурай цэвэрлэх
 3. Хамрыг ариун уусмалаар угаах
 4. Хамарт халуун жин тавих
 5. Хамарт хүйтэн жин тавих
- 69.Хамраас цус алдах хэсэг газрын шалтгаануудыг нэрлэнэ үү
1. Хамрын гэмтэл
 2. Хамраа хуруугаар ухах

3. Хамрын таславчийн мурийлт
 4. Гадны биет
 5. Хамрын хөндийн хавдрууд, хавдар төст үүсгэвэр
- 70.Хамрын таславч цоорох шалтгаануудыг нэрлэнэ үү
1. Хамрын гэмтэл
 2. Мэс засал
 3. Кокаин хэрэглэх
 4. Вегенерийн өвчин
 5. Стероид цацлага
- 71.Гүйлсний нянгийн бүтцийг хэлнэ үү
1. Гүйлсний гүнд монофлор
 2. Сапрофит нянгууд
 3. Гүйлсний гадаргууд микробын ассоциаци
 4. Эмгэг төрөгч нянгууд
 5. Гүйлсэнд нян байхгүй ариун орчинтой
- 72.Залгиурын хэсгүүдийг нэрлэнэ үү
1. Нармай
 2. Амны хэсэг
 3. Багалзуур
 4. Хүзүүний хэсэг
 5. Хоолойн хэсэг
- 73.Залгиур ямар мэдрэлүүдээр мэдрэлжүүлэгдэх вэ?
1. Хөдөлгөөний
 2. Вегетатив
 3. Мэдрэхүйн
 4. Гурвалсан
 5. Тэнэгч
- 74.Ангины үед илрэх шинжийг ол
1. Хурц эхэлнэ
 2. Өндөр халуурна
 3. Толгой өвдөнө
 4. Бие суларна, ядарна
 5. Хоолой хөндүүр, залгихад хөндүүрлэнэ.
- 75.Ангины алсын хүндрэл аль нь вэ?
1. Үжил
 2. Ревмокардит
 3. Артриты
 4. Псориаз
 5. Гломерулонефрит
- 76.Хоншоор ясны хорт хавдрын үед илэрч болох шинжүүдийг ол
1. Тризм
 2. Диплопи
 3. Зөөлөн тагнайн саажилт
 4. Өвдөлт

5. Хамрын цус алдалт
- 77.Цагаан мөгөөрсөн хоолойг цусаар хангадаг судсуудыг нэрлэ.
1. Бамбайн доод артери
 2. Эгмийн доод артери
 3. Хавирга завсрын дээд артери
 4. Гуурсан хоолойн дээд артери
 5. Гуурсан хоолойн дунд артери
- 78.Төвөнхийн сахуугийн үед илрэх гурвал шинжийг хэлнэ үү.
1. Стеноз
 2. Дисфони
 3. Ханиалга
 4. Хаван
 5. Дуу гунших
- 79.Хүүхдийн төвөнхийн папилломатоз өвчний үед илрэх шинжийг ол
1. Амьсгал аажим бачуурна
 2. Амьсгал гэнэт бачуурч амь тэнссэн байдалд оруулна.
 3. Дуу аажим сөөнө.
 4. Дуу гэнэт сөөж афони болно.
 5. Хоолойд торж өвдөнө.
- 80.Төвөнхийн дотор булчингууд ямар үүрэгтэй вэ?
1. Дууны хөвчийн зайг тэлнэ.
 2. Дууны хөвчийн зайг нарийсгана.
 3. Дууг чангаруулна
 4. Амьсгалахад оролцоно.
 5. Дуу үүсэх үйл ажиллагаанд оролцоно
- 81.Төвөнхийн хөндийг юу гэж хуваадаг вэ?
1. Дээд хэсэг
 2. Дунд хэсэг
 3. Доод хэсэг
 4. Арын хэсэг
 5. Өмнөд хэсэг
- 82.Төвөнхийн шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү
- 1.Акустик анализ
 - 2.Фотоглоттографи
 - 3.Электромиографи
 - 4.Рентгенографи
 - 5.Амьсгалын тестүүд
- 83.Шарх аних үе шатуудыг нэрлэнэ үү
1. Субстрат үе шат
 2. Пролифератив үе шат
 3. Шарх аних үе шат
 4. Шарх үхжих үе шат
 5. Шарх идээлэх үе шат

84. Нармайн гүйлсний томролт нь хамрын дайвар хөндийн архаг үрэвсэл, сонсголын гуурс, дунд чихний архаг үрэвсэл, архаг трахеобронхит, хатгаагаар өвдөхөд нөлөөлдөг (1). Эдгээр өвчнийг нармайн судаслаг хавдар, хортой, хоргүй хавдар, хоаны битүүрлээс ялган оношлоно (2).

85. Улаанууд өвчин нь чих сонсголын талын өөрчлөлтөөр илэрдэг (1), энэ нь мэдрэл-мэдрэхүйн гаралтай нэг ба хоёр талын дүлийрэлт, хэл ярианы өөрчлөлт байдаг (2) тул амьдралын чанарт нэг их нөлөөгүй.

86. Бага насны хүүхдэд хамрын таславч дахь өсөлтийн бүс хөгжөөгүй байдаг (1) тул нүүрний өсөлт зогсохоос сэргийлж таславчийн хагалгаанаас зайлсхийдэг (2).

87. Нармайд тэмтрэх аргыг бага насны хүүхдэд өргөн хэрэглэдэг (1). Нармайн дээвэрт барзгар гадаргуутай, зөөлөн ургацаг голдуу тэмтрэгдэх (2) бөгөөд энэ нь хавдар байх магадлалтай.

88. Бага насны хүүхдийн төвөнх бүтэц, үйлийн хувьд онцлогтой (1). Бөгж мөгөөрсний эргэн тойронд судасжилтаар баялаг, хөвсгөр холбогч эд ихтэй (2). Ийм тул бага насны хүүхэд бачуурлаар амархан хүндэрдэг.

89. Нярай хүүхдэд хөхлөг сэртэн хөгжөөгүй байдаг (1). Хүүхэд өсөхийн хирээр хүзүү толгойн булчин хөгжиж, толгойгоо дааж ирэхэд хөхлөг сэртэн хөгжиж ирнэ.

90. Чих орчмын төрөлхийн цоргоны нүхээр халдвар орж идээлж бугласнаар удаан хугацааны архаг идээт үрэвсэл үүсч чих орчмын зөөлөн эдийг гэмтээдэг (1). Иймд зөөлөн эд сорвижихоос өмнө мэс засал хийж цоргыг амсар, хүүдийн хамт авна (2).

91. Хөхлөг сэртэн нь чамархайн ясны ар хэсэг бөгөөд дотроо хийтэй олон сархиагт хөндийнөөс тогтдог (1), уг сархиагт хөндийнүүд нь хэнгэргэн хөндийтэй холбогдож сонсголын үйл ажиллагааг дэмждэг (2).

92. Хамрын арын нүхний төрөлхийн битүүрэлт нь нэг ба хоёр талынх, мөн хагас ба таг битүү гэж байдаг (1) бөгөөд битүүрэлтийн зайнаас хамаарч амьсгал саадтай байх, хамраас салсархаг ялгадас гоожих шинж тод илэрдэг (2).

93. Хамрын хатгийг шахсаны улмаас хамар-уруулын хураагуур судсаар дамжин ухархайн хураагуурт халдвар орж улмаар тархины торлог бүрхэвчид нэвтэрнэ (1). Энэ нь идээт мэнэн өвчин үүсэх зам болно (2).

94. Дурдсан өгүүлэмж, шинж тэмдгүүдээр өвчний урьдчилсан оношийг тогтоо

1. 6 настай хүүхэд, хурц үзүүртэй пластмассан тоглоомын хэсгийг залгисан. Одоо толгой хөдөлгөх, хүзүүг тэмтрэхэд өвдөнө, халуурна, цусархаг хольцтой бага зэргийн зүйлээр гулгина.

2. 6 настай хүүхэд, пластмассан тоглоомын хэсгийг залгисан, амьсгалахад бэрхшээлтэй, үе үе хөхүүлж ханиана, ханиалга эхэлбэл намдах нь удаан, хоолой сөөнгө.

3. Эмнэлэгт эмчлүүлж байгаа 3 сартай хүүхэд, төвөнхийн шинжилгээний үед гэнэт хөхөрч амнаас цагаан хөөс сахарч амьсгал өнгөц тасалданги болж татсан.

4. 2 настай хүүхэд, ханиадтай 3 хонож байгаа, хоолой гэнэт паргиж сөөсөн, одоо халуурна, хуцуулж ханиана, юм залгихад өвдөнө, хоолонд муу.

5. 1 сартай хүүхэд, “тагтаа шиг” дуугарна гэнэ, амаа ангайж унтана, амьсгал авалт шуугиантай боловч уйлах дуу цээл.

А. Ларингоспазм

В. Төвөнхийн шийхнээ

- C. Залгиурын гадны биет
- D. Цочмог ларингит
- E. Төвөнхийн гадны биет
- A. 1C, 2E, 3D, 4C, 5B
- B. 1C, 2E, 3A, 4D, 5B.
- C. 1A, 2B, 3C, 4D, 5E
- D. 1D, 2A, 3C, 4E, 5D
- E. 1B, 2D, 3B, 4A, 5E

95. Доорхи бүтцүүдэд тохиолдож болох эмгэгүүдийг тохируул.

1. Гадна чихний сувагт
 2. Хэнгэргэн хальсанд
 3. Хэнгэргэн хөндийд
 4. Хэнгэргийн дээвэр хөндийд
 5. Нүүрний мэдрэлд
- A. Грануляц
 - B. Саа, саажилт
 - C. Холестеатома
 - D. Чулуужсан хулхи
 - E. Цэврүү
 - A. 1D, 2A, 3E, 4C, 5B
 - B. 1A, 2C, 3E, 4B, 5D
 - C. 1D, 2E, 3A, 4C, 5B
 - D. 1C, 2B, 3A, 4E, 5D
 - E. 1B, 2D, 3B, 4A, 5E

96. Сонсгол бууралтын зэргүүдийг дБ-д нь тохируул

1. Сонсголын бэрхшээлгүй
 2. Хөнгөн (1-р) зэрэг
 3. Дунд (2-р) зэрэг
 4. Хүнд (3-р) зэрэг
 5. Дүлий
- A. 25дБ, түүнээс бага
 - B. 81дБ, түүнээс дээш
 - C. 61-80 дБ
 - D. 41-60дБ
 - E. 26-40дБ
 - A. 1A, 2E, 3D, 4C, 5B

- B. 1A, 2C, 3E, 4B, 5D
- C. 1D, 2E, 3A, 4C, 5B
- D. 1C, 2B, 3A, 4E, 5D
- E. 1B, 2D, 3B, 4A, 5E

97. Дараахь эмчилгээнүүдийг эмгэгүүдэд тохируул

1. Хэнгэргийн цооролттой дунд чихний хуурай үрэвсэл
2. Гадна чихний сувгийн төрөлхийн битүүрэлт
3. Дунд чихний шүүдэст дахилтат үрэвсэл

4. Хөхлөг сэртэнгийн идээт архаг үрэвсэл
5. Төрөлхийн таг дүлий
- A. Кохлеар имплант
- B. Тимпаноластик мэс засал
- C. Меатотимпаноластик мэс засал
- D. Мастоидэктоми мэс засал
- E. Хэнгэргэн хальсанд агааржуулах гуурс байрлуулах
- A. 1D, 2A, 3E, 4C, 5B
- B. 1A, 2C, 3E, 4B, 5D
- C. 1B, 2C, 3E, 4D, 5A
- D. 1C, 2B, 3A, 4E, 5D
- E. 1B, 2D, 3B, 4A, 5E

98. Дараахь эмгэгүүдийн тодорхойлолтыг тохируул

1. Үнэрлэхүй хэт ихсэх
2. Үнэрийг мэдэрч чадаж байвч үгээр илэрхийлж чадахгүй байх
3. Үнэрлэхүй нь бодит байдалтай тохирохгүй байх.
4. Үнэрийн эх үүсвэр үгүй байхад үнэр мэдрэх
5. Үнэрлэхүй арилах, алга болох.
- A. Аносими
- B. Дизосми
- C. Фантосми
- D. Үнэрлэхүйн агнози
- E. Гиперосми

- A. 1B, 2E, 3D, 4C, 5A
- B. 1A, 2D, 3E, 4B, 5C.
- C. 1E, 2D, 3B, 4A, 5C
- D. 1A, 2C, 3E, 4D, 5B
- E. 1E, 2D, 3B, 4C, 5A

99. Хамар дайврын хорт хавдар тохиолдох магадлалыг бүтцүүдэд тохируул.

1. 55%
2. 35%
3. 9%
4. 5%
5. Бараг тохиолддоггүй
- A. Хамрын хөндий
- B. Зажуурын хөндий
- C. Суурийн хөндий
- D. Элхэгийн хөндий
- E. Таславч
- A. 1B, 2A, 3D, 4C, 5E.

- B. 1D, 2A, 3E, 4B, 5C.
- C. 1E, 2D, 3B, 4A, 5C

D. 1B, 2A, 3D, 4E, 5C

E. 1E, 2D, 3B, 4C, 5A

100. Дурдсан өгүүлэмж, шинж тэмдгүүдээр өвчний урьдчилсан оношийг тогтоо

1. 6 настай хүүхэд, хурц үзүүртэй пластмассан тоглоомын хэсгийг залгисан. Одоо толгой хөдөлгөх, хүзүүг тэмтрэхэд өвдөнө, халуурна, цусархаг хольцтой бага зэргийн зүйлээр гулгина.

2. 6 настай хүүхэд, пластмассан тоглоомын хэсгийг залгисан, амьсгалахад бэрхшээлтэй, үе үе хөхүүлж ханиана, ханиалга эхэлбэл намдах нь удаан, хоолой сөөнгө. 3. Эмнэлэгт эмчлүүлж байгаа 3 сартай хүүхэд, төвөнхийн шинжилгээний үед гэнэт хөхөрч амнаас цагаан хөөс сахарч амьсгал өнгөц тасалданги болж татсан.

4. 2 настай хүүхэд, ханиадтай 3 хонож байгаа, хоолой гэнэт паргиж сөөсөн, одоо халуурна, хуцуулж ханиана, юм залгихад өвдөнө, хоолонд муу.

5. 1 сартай хүүхэд, “тагтаа шиг” дуугарна гэнэ, амаа ангайж унтана, амьсгал авалт шуугиантай боловч уйлах дуу цээл.

A. Ларингоспазм

B. Төвөнхийн шийхнээ

C. Залгиурын гадны биет

D. Цочмог ларингит

E. Төвөнхийн гадны биет

A. 1C, 2E, 3A, 4B, 5A.

B. 1D, 2A, 3E, 4B, 5C.

C. 1C, 2E, 3A, 4D, 5B.

D. 1B, 2A, 3D, 4E, 5C

E. 1C, 2A, 3B, 4E, 5D

МЭДРЭЛ, СЭТГЭЦИЙН ӨВЧИН

1. Гавал тархины 5-р хос мэдрэлийг нэрлэ.

- A. Үнэрлэх мэдрэл
- B. Сонсгол тэнцвэрийн мэдрэл
- C. Гурвалсан мэдрэл
- D. Тэнэгч мэдрэл
- E. Нэмэгдэл мэдрэл

2. Өвчтөн ухаан гүн алдсан, хүчтэй сэдээлтэд ч үл хариулах, сэрэхгүй байдлыг юу гэж нэрлэх вэ?

- A. Ухаан дөжрөн балартах
- B. Сопор
- C. Кома
- D. Шок
- E. Коллапс

3. Парестези гэж юу вэ?

- A. Мэдрэхүй ихсэх
- B. Мэдрэхүй буурах
- C. Өвдөлт
- D. Бадайралт
- E. Мэдрэхүй олшрох.

4. Ухаан санааны өөрчлөлттэй үйлчлүүлэгчийг ямар үнэлгээгээр оношлох вэ?

- A. Асуумжын аргаар
- B. Ажиглалтын аргаар
- C. Глазго үнэлгээний аргаар
- D. Толгойд КТГ хийх
- E. Лабораторийн шинжилгээ хийх

5. Цус харвалтын үед яаралтай хийгдэх шинжилгээ аль нь вэ?

- A. Тархины цахилгаан бичлэг
- B. Нугасны ус авах
- C. Цээжний рентген зураг
- D. Цээж гэрэлд харах
- E. Цусны бүлэг тодорхойлох

6. Уналт таталтын хамшинжийн яаралтай тусламжийг дурьдана уу?

- A. Бүсэлхийн хатгалт
- B. Агаар оруулах
- C. Хиймэл амьсгал хийх
- D. Амьсгалын замыг чөлөөлөх
- E. Ерөнхий унтуулга

7. Гавлын дотоод даралт ихдэлттэй үйлчлүүлэгчийг сувилахад хориглох заалтыг тоочно уу.

- A. Толгойг хагас өндөрлөх
- B. Өвчтөний байралыг хурдан өөрчлөх
- C. Чийглэсэн хүчилтөрөгчөөр амьсгалуулах
- D. Хүзүүг аажим эргүүлэх, бөхийлгөх
- E. Хүзүүг аажим эргүүлэх

8. Уналт таталттай үйлчлүүлэгчид үл илрэх шинжийг нэрлэ.

- A. Чангарсан таталт илэрнэ
- B. Чичирхийлсэн таталт илэрнэ

- С. Ухаан алдана D. .Ёр дохио илэрнэ
 E. Невропатийн шинж илэрнэ
9. Ухаан балартах байдлын ерөнхий шинжүүдийн үед үл илрэх шинжийг нэрлэнэ үү.
 A. Үйлчлүүлэгч нойрмогдуу байдалтай
 B. Үйлчлүүлэгчийн анхаарал амархан сарнина
 C. Орон зай, цаг хугацааны баримжаалал алдагдана.
 D. Үйлдэл оновчтой, түргэн бус болох
 E. Асуултанд үнэн зөв хариулна.
10. Уналт, таталттай үйлчлүүлэгчид үзүүлэх сувилахуйн тусламжинд үзүүлж болохгүй үйлчилгээг нэрлэнэ үү.
 A. Үйлчлүүлэгчийг ганцааранг нь орхиж болохгүй
 B. Уналтын үед хэл хазахаас сэргийлэх
 C. Өвчтөний аманд хуруугаа хэрхэвч хийж болохгүй
 D. Уналтын үед бэртэж, гэмтэхээс хамгаална
 E. Өвчтөний ор дэр нам, дор байх
11. Гурвалсан мэдрэлийн өвдөлтийн үед тохиолдох боломжгүй шинжийг нэрлэнэ үү.
 A. Эрүү рүү дамжиж өвдөх
 B. Хатгаж, цоргиж, төөнөсөн маягтай хүчтэй өвдөх
 C. Үе үе дахиж, хөдлөх маягаар өвдөх
 D. Дагз хүзүүний булчин чангарч өвдөх
 E. Хацар, ам, завьж руу дамжиж өвдөх
12. Хурц харвалттай үйлчлүүлэгчийн сувилгаанд хориглох заалтыг дурьдана уу.
 A. Өвчний хурц үед хэвтрийн дэглэм сахиулах
 B. Толгойг өндөрлөхгүй, нам дор байлгах
 C. Байрлалыг 2-3 цаг тутамд зөөлөн солих
 D. Үе мөчдийг физиологийн хэвийн байрлалд байлгана
 E. Ясны төвгөр хэсгүүдэд зөөлөвч хийнэ.
13. Цус харвалтын сэргэлтийн үед ямар сувилгаа шаардлагатай вэ?
 A. Саатай гар хөлийг эхлээд хөдөлгөх
 B. Сэргэлтийн үеэс тэргэнцэр, таягийг ашиглах
 C. Идэвхитэй хөдөлгөөн, дасгал хийх
 D. Хагас суугаа байдалд суулгах
 E. Бусдын тусламжтайгаар явуулж сургах
14. Параплеги гэдэг нь.....юм.
 A. Тал саажил
 B. Хос саажил
 C. Гурвалсан саажил
 D. Дөрвөл саажил
 E. Талласан саажил
15. Өгүүлэх эрхтэний булчингийн агшилт, сонсголын үйл ажиллагаа хэвийн байхад бодол санаагаа илэрхийлж чадахгүй болох
 A. Ярихын хэлгүйдэл
 B. Ойлгохын хэлгүйдэл
 C. Утгын хэлгүйдэл
 D. Нэрлэхийн хэлгүйдэл
 E. Уншихгүйдэл
16. Артерийн даралт ихсэлтийн үеийн толгой өвдөлт аль ангилалд хамаарах вэ?
 A. Анхдагч толгой өвдөлт
 B. Хоёрдогч толгой өвдөлт

- C. Дохиот мигрень
D. Толгойн кластер өвдөлт
E. Хүчдэлийн толгой өвдөлт
17. Захын цусан дахь хүчилтөрөгчийн хангамжийн хэмжих нэгж
A. Процент
B. Мммуб
C. Цельс
D. Муб
E. Нэгж үгүй
18. Комын глазго үнэлгээгээр үйлчлүүлэгч өвдөлтын цочролд мөчөө чангаран нугалах хэлбэрээр хариу үйлдэл үзүүлвэл хэдэн оноо өгөх вэ?
A. 1
B. 2
C. 3
D. 4
E. 5
19. Комын глазго үнэлгээгээр үйлчлүүлэгч асуултанд тод, үнэн зөв хариулт үзүүлвэл хэдэн оноо өгөх вэ?
A. 1
B. 2
C. 3
D. 4
E. 5
20. Комын глазго үнэлгээгээр үйлчлүүлэгч өвдөлтын цочролд мөчөө чангаран тэнийх хэлбэрээр хариу үйлдэл үзүүлвэл хэдэн оноо өгөх вэ?
A. 1
B. 2
C. 3
D. 4
E. 5
21. Саа саажилттай үйлчлүүлэгчийг хэрхэн оношлох вэ?
1. Үйлчлүүлэгчээр дөрвөн мөчийг өөрөөр нь хөдөлгөх
2. Саа саажилт байгаа эсэхийг ажиглах
3. Булчингийн хүчдэлийг сувилагч өөрөө хөдөлгөж шалгах
4. Үйлчлүүлэгчийн дөрвөн мөчийг өөрөөр нь хөдөлгөж шалгах
5. Булчингийн хүчдэлийг өөрөөр нь хөдөлгөж шалгах.
22. Гавлын дотоод даралт ихдэлтийн шинж тэмдгийг нэрлэнэ үү.
1. Ухаан санаа саруул бус
2. Цочромтгой болох
3. Нүдэнд юм хоёрлож харагдах
4. Уналт таталтын хамшинж илрэхгүй
5. Артерийн даралт хэвийн байх.
23. Бүсэлхийгээр өвдөх өвдөлт ямар тохиолдолд сэдэрдэг вэ?
1. Хүнд юм өргөх
2. Эвгүй огцом хөдлөх
3. Даарч хөрөх
4. Эвтэй байдалд удаан суухад
5. Нойргүйдэх үед
24. Ухаангүй үйлчлүүлэгчийн сувилгаанд аль нь багтах вэ?

1. Үйлчлүүлэгчийн байрлалыг 2 цаг тутамд солих
 2. Төвгөр ястай хэсгүүдэд эвээс, зөөлөвч хийх
 3. Үе мөчдийг физиологийн зөв байрлалд оруулах
 4. Цээжийг хагас өндөрлөх
 5. Толгойг их биеийн хагас хажуугаар байрлуулах
25. Уналт таталттай үйлчлүүлэгчийн орчинг ямар байлгах ёстой вэ?
1. Өрөө нь аюулгүй түүнд гэмтэл учруулахгүй байх
 2. Ор дэр нам дор байх
 3. Өрөөнд тамхи татахыг хориглох
 4. Үйлчлүүлэгчийг ганцаар орхиж болохгүй
 5. Уналтын сэдэрээх хүчин зүйлсээс зайлсхийх.
26. Цус харвалттай үйлчлүүлэгчид ямар сувилгаа шаардлагатай вэ?
1. Өвчний эхэн үед хаймсуураар шингэн хоол өгөх
 2. Давс, өөх тосыг хязгаарлах
 3. Хоолыг хэт халуун өгөхгүй байх
 4. Хоолыг бага багаар бэлтгэх
 5. Эслэг ихтэй хоол хүнс хэрэглэх
27. Цус харвалтын үеийн үндсэн шинж тэмдгийг нэрлэнэ үү.
1. Гэнэт ухаан алдах
 2. Олон дахин огиулж, бөөлжих
 3. Мөчдөд талласан саа үүсэх
 4. Хэлгүйдлийн шинж тэмдэг илрэх
 5. Хэл ам муруйх
28. Менингитийн үед илэрдэг шинж тэмдэгүүдийг нэрлэнэ үү.
1. Ерөнхий халдварын шинж
 2. Менингийн шинж
 3. Тархины ерөнхий шинж тэмдэг
 4. Тархи нугасны шингэний үрэвсэлт өөрчлөлт
 5. Хүзүүний хөшингө
29. Цус харвалт ямар шалтгаанаар үүсэх вэ?
1. Артерийн даралт ихсэх өвчин
 2. Бөөрний шалтгаантай даралт ихдэлт
 3. Тархины судасны төрөлхийн гажиг
 4. Халдвар, харшлын гаралтай судасны үрэвсэл
 5. Цусны зарим өвчнүүдийн үед
30. Харвалтын дараах байдалтай үйлчлүүлэгчийн хувцаслалт дээр юуг анхаарах вэ?
1. Хувцас бие барихааргүй, холголт үүсгэхгүй
 2. Өмд нь ардаа оёдол, кармаагүй байх
 3. Хувцас өмсөх, тайлахад сувилагч туслах
 4. Хувцасыг саатай талаас нь эхэлж өмсгөх
 5. Цаг агаарт тохируулж хувцаслах
31. Нугасны эмгэгтэй үйлчлүүлэгчийн сувилахуйн үнэлгээг нэрлэнэ үү.
1. Хөдөлгөөн хязгаарлагдах
 2. Үе мөчдөд саа үүсэх
 3. Мэдрэхүйн өөрчлөлт илрэх
 4. Шээс өтгөн хаагдах, задгайрах
 5. Мэдрэлийн ёзоор дарагдлын шинжүүд илрэх
32. Бүсэлхий ууцны радикулитын үед хийх асаргаа сувилгааны дэглэм аль нь вэ?
1. Хатуу орон дээр хэвтрийн дэглэм сахих

2. Хэсэг газрын дулаан эмчилгээ-банк, корчичник
3. Шавар, лаа эмчилгээ
 4. Зүү эмчилгээ
 5. Татлага эмчилгээ
33. Экстрарецепторуудыг нэрлэ
 1. Терморекцептор
 2. Ноцицептор
 3. Механорецептор
 4. Проприорецептор
 5. Интерарецептор
34. Олон улсын хувьд зөвшөөрөгдсөн номхотгох аргуудыг нэрлэ.
 1. Оронд нь өлгийдөх
 2. Гав гинж
 3. Номхотгох цамц
 4. Бороохойдох
 5. Цаазлах
35. Тархины судасны өвчинд аль нь хамаарах вэ?
 1. Эпилепси
 2. Тархины инсульт
 3. Менингит
 4. Тархинд цус тасалдах дайралт
 5. Артерийн даралт ихсэх өвчин
36. Беллийн саагийн үед илрэх шинжүүдийг нэрлэ.
 1. Монопарез
 2. Духны атираа үүсгэгдэхгүй
 3. Нүд гүйцэт анигдана
 4. Хамар уруулын нугалаас тэнийх
 5. Амны өнцөг унжих
37. Тархины харвалтын үнэлгээний аргуудаас нэрлэ
 1. Befast үнэлгээ
 2. Fast үнэлгээ
 3. ХААХ арга
 4. 5 ха шинж
 5. Дагзны булчингийн хөшингө
38. Комын глазго үнэлгээгээр үйлчлүүлэгч дуудахад нүдээ нээвэл хэдэн оноогоор үнэлэх вэ?
 1. 6
 2. 1
 3. 4
 4. 2
 5. 3
39. Нугалмайн шалтгаант суудлын мэдрэлийн ёзоорын эмгэгтэй жирэмсэн эхэд ямар зөвлөгөө өгөх вэ?
 1. Хэвтрийн дэглэм сахих
 2. Дулаан байх
 3. Бөмбөлөг дээр суух
 4. Нэг байрлалд удаан суухгүй байх
 5. Мэс засал эмчилгээ
40. Тархины харвалтын эрсдэлт хүчин зүйлсийг нэрлэ.

1. Архины зохимжгүй хэрэглээ
2. Артерийн даралт ихсэх өвчин
3. Таргалалт
4. Тархины судасны хатуурал
5. Тосгуурын жирвэгнээ

41.Эпилепси өвчин нь ухаан алдалт, уналт таталтаар илэрдэг эмгэг. Учир нь тархины эсэд хэт цэнэгжилтийн байдал үүссэнтэй холбоотой .

42.Беллийн саа нь 7-р хос мэдрэлийн захын саа бөгөөд жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд тохиолдох нь элбэг байна.

43.Төв мэдрэлийн тогтолцоонд гүний мэдрэхүйн сэрлийг дамжуулагч резептор нь проприорезептор. Энэ нь дотор эрхтэний хананд байрлана.

44.Тархины цус харвалтын үед беллийн саа үүсэх бөгөөд энэ үед туулайн нүдний шинж илрэхгүй

45.Жирэмсэн үед үүсэж буй толгой өвдөлтийг анзаарахгүй орхиж болохгүй, учир нь тархины цусан хангамж, судасжилттай холбоотой өвдөлт байж болно.

46. Дараах хариултуудыг харгалзуулан сонгоно уу.

- 1.Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах
- 2.Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих
3. Эрүүл сэтгэцтэй хүн
4. Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүн
5. Сэтгэцийн эмгэгтэй хүн

6.Сэтгэцийн эрүүл мэндийн анхдагч урьдчилан сэргийлэлт

А. Нийгмийн сэргийлэлт гэдэг нь хүн амын СЭМ-ийг хамгаалахын тулд нийгмээс явуулж буй цогц арга хэмжээ юм.

В. Сэтгэцийн өвчингүй байхын сацуу хүрээлэн байгаа орчинтойгоо зөв дасан зохицох чадвартай хүн

С. Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд" хэмээх бүлэгт заасан оношлолтын шалгууруудаар оношлогдож болох өвчнөөр өвчилсэн хүн.

Д. Нийгэм сэтгэлзүйн сөрөг асуудлаас болж сэтгэцийн түр зуурын хямралд өртсөн хүн.

Е. Хүн амд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулж сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн анагаах ухаан, нийгэм, сэтгэлзүй, эдийн засгийн цогц арга хэмжээ

Ф. Хүн өөрөө болон бусадтай хамтран сэтгэцийн эрүүл мэндээ хянах, сайжруулах боломж олгох, эрүүл зан үйлийг дэмжихэд чиглэгдсэн арга хэмжээг

- A.1e2f3b4d5c6a
- B.1e2b3f4d5c6a
- C.1a2f3b4d5c6e
- D.1f2e3b4d5c6a
- E.1e2f3a4d5c6b

47.Зөв хариултыг харгалзуул.

1. Бусдын хэл ярианы утга агуулгыг тусган ойлгох чадвар алдагдах
2. Өөрийн бодол санаа, хүсэл эрмээлзэлийг хэл яриагаар илэрхийлэх чадвар алдагдах
3. Юмс үзэгдлийн нэрийг хэлэх чадвар алдагдах
4. Бичвэрийг уншиж чадахгүй буюу уншсан өгүүлбэрийн утгыг ойлгох чадвар алдагдах.
5. Бичих чадвар алдагдах

А.Аграфи В. Амнестик афази С.Сенсор афази D.Мотор афази тал Е. Алекси

- A. 1C 2D 3B 4E 5A
- B. 1D 2C 3B 4E 5A
- C. 1C 2D 3E 4B 5A

D. 1A 2D 3B 4E 5C

E. 1C 2D 3B 4A 5E

48. Зөв хариултыг харгалзуул.

1. Аграфи А. Зүүн тал бөмбөлөгийн чамархайн дээд атирааны арын талбар

2. Амнестик афази В. Брокын төв

3. Сенсор афази С. Зүүн тал бөмбөлөгийн зулай-чамархай-дагзны уулзвар хэсэг.

4. Мотор афази D. Зулайн зүүн доод хэсгийн өнцгөн атираа

5. Алекси E. Духны зүүн дунд атирааны арын талбай.

A. 1C 2D 3B 4E 5A

B. 1D 2C 3B 4E 5A

C. 1E 2C 3A 4B 5D

D. 1A 2D 3B 4E 5C

E. 1C 2D 3B 4A 5E

49. Зөв хариултыг харгалзуул.

1. ТНШ-ний шинжилгээнд уургийн хэмжээг тодорхойлох арга А. Эс-уургийн зөрүү

2. ТНШ-д уургийн хэмжээ ихсэж, эсийн тоо хэвийн байх үзэгдэл В. Уураг-эсийн зөрүү

3. ТНШ-д эсийн олшрол уургийн ихсэлтээс давамгайлах үзэгдэл С. Пандын урвал

A. 1C 2D 3B

B. 1D 2C 3B

C. 1C 2D 3E

D. 1A 2D 3B

E. 1C 2B 3A

50. Зөв хариултыг харгалзуул.

1. Өвчтөн унтаа байдалтай, үгээр харилцах боломж хязгаарлагдмал, эмчийн хэлсэн энгийн зааврыг олон дахин шаардуулж хагас дутуу гүйцэтгэнэ, гадаад орчин, цаг хугацааны баримжаалал алдсан, харин өөрийн хувийн тухай баримжаатай байна.

2. Өвчтөн утга учиргүй хөдөлгөөн хийнэ, үгээр харилцах боломжгүй, гадаад орчин, цаг хугацааны хийгээд өөрийн хувийн тухай баримжаалал алдсан, зөвхөн хүчтэй өвдөлтийн цочруулд хөдөлгөөний тохирсон урвалаар хариулна.

3. Ухаан гүн алдсан, хүчтэй сэдээлтэнд ч үл хариулах, сэрэхгүй байдал.

4. Тархины цусны эргэлтийн түр зуурын хямрал

5. Сэтгэлийн шалтгаант уналт

A. Истери

B. Кома

C. Ухаан дөжрөл

D. Сопор

E. ТИА

A. 1C 2D 3B 4E 5A

B. 1D 2C 3B 4E 5A

C. 1C 2D 3B 4E 5A

D. 1A 2D 3B 4E 5C

E. 1C 2D 3B 4A 5E

ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ

1. Амьсгал зогссон гэдэг нь дараах үйл ажиллагаа бүрэн алдагдахыг хэлнэ.

A. Амьсгалах

B. Зүрх агших

C. Амьсгалах ба зүрх агших

D. Судас цохилох

E. Нүдээ нээ

2. Хүзүүний нугалам гэмтсэн байх эрсдэлтэй тохиолдолд амьсгалын замыг ямар аргаар чөлөөлөх вэ?
- A. Толгойг гэдийлгэн байрлуулж, эрүүний шонтонгоос өргөх
 - B. Эрүүний өнцгөөс түлхэх
 - C. Эрүүний шонтон дээр дарах
 - D. Хүзүүний чиг хийх
 - E. Хөдөлгөхгүй
3. Амьсгалын замыг чөлөөлсний дараа та юу хийх вэ?
- A. Ажиглах, сонсох, мэдрэх аргаар амьсгал зогссон эсэхийг тогтооно
 - B. Хоёр удаа амьсгалуулна
 - C. Судасны лугшилтыг шалгана
 - D. Дефибриллятораар цохиулах
 - E. Цээж шахалт хийх
4. Ухаангүй өвчтөний амьсгалын зам бөглөрөх хамгийн түгээмэл шалтгаан юу вэ.
- A. Чихэрний хэлтэрхий
 - B. Ус амьсгалын замруу орсноос
 - C. Нэг удаа хэт их хоол залгихыг оролдсоноос
 - D. Зоос
 - E. Хэлээрээ
5. Тусламж үзүүлэгч насанд хүрэгчдэд АСТ-ыг хийхдээ цээжийг шахах, амьсгалуулах үйлдлийн хоорондын харьцаа хэд байх вэ?
- A. 5 шахалт 1 амьсгалуулалт
 - B. 15 шахалт 4 амьсгалуулалт
 - C. 10 шахалт 2 амьсгалуулалт
 - D. 30 шахалт 2 амьсгалуулалт
 - E. 15 шахалт 1 амьсгалуулалт
6. Цээжийг шахах үйлдлийг хийсний дараа цээж бүрэн тэлэгдэх нөхцлийг бүрдүүлэх аргчлалыг сонгоно уу.
- A. Шахалт бүрийн хооронд өвчтөний цээжнээс гараа авах
 - B. Өвчтөний цээжин дээр гараараа тасралтгүй зөөлөн дарж байх, ингэснээр цээж ямагт үл мэдэг даралттай байх
 - C. Шахалт бүрийн хооронд гараа цээжнээс салгалгүй даралтыг бүрэн сулруулж цээжийг чөлөөтэй тэлэгдэх нөхцлийг бүрдүүлэх
 - D. Шахалт болон түүний завсар хооронд цээжийг 1см хотолзтол дарна
 - E. Өнгөцхөн хурдан хийх
7. Таны хийсэн аврах амьсгал хэр зэрэг үр дүнтэй болсныг ямар аргаар үнэлэх вэ.
- A. Цээж өргөгдөх хөдөлгөөнийг ажиглах
 - B. Ходоод хийлэгдэхийг ажиглах
 - C. Амьсгалуулсан агаарын оролтыг мэдрэх
 - D. Ямар ч аргаар мэдрэх бололцоогүй
 - E. Амьсгал гарч байгааг сонсох
8. Насанд хүрэгсдэд амнаас ам руу амьсгалуулалт хийх хамгийн зөв арга нь:
- A. Аврагч уруулаараа өвчтөний ам, хамрыг бүрхэн 10 секундийн турш үлээж амьсгал оруулна
 - B. Аврагч уруулаараа өвчтөний амыг бүрхэн 5 секундийн хугацаанд 2 удаа зөөлөн үлээнэ
 - C. Аврагч уруулаараа өвчтөний ам, хамрыг бүрхэн өөрийн амьсгалыг шавхан хүчтэй үлээнэ
 - D. Аврагч хэвийн амьсгал аваад уруулаараа өвчтөний амыг бүрхэн зайгүй нийлүүлж тус бүр 1 секундийн турш 2 удаа өвчтөний цээж өргөгдөхийг ажиглан амьсгал оруулна, амьсгалуулалт бүрийн хооронд цээж нь буцаж намстал хүлээнэ.
 - E. Аврагч хамрыг чимхэн уруулаараа өвчтөний амыг бүрхэн зайгүй нийлүүлж тус бүр 1 секундийн турш 2 удаа өвчтөний цээж өргөгдөхийг ажиглан амьсгал оруулна, амьсгалуулалт бүрийн хооронд цээж нь буцаж намстал хүлээнэ.
9. Насанд хүрэгсдийн АСТ-ийн явцад дефибрилляцийг эрт хийх шаардлага нь:
- A. Дефибрилляци хийлгэх заалттай өвчтөний зүрхний хэм сэргэх магадлал алдсан хором тутамд огцом буурч байдаг

- В. Тосгуурын жирвэлзэл нь насанд хүрэгсдийн зүрх зогсолтын зонхилон тохиолдох шалтгаан юм
- С. Зүрх гэнэт зогсох тохиолдолд тохируулагт кардиоверси эмчилгээ хамгийн үр дүнтэй
- Д. Өвчтөний зүрх зогсох үед гол төлөв зүрх агшилтгүй болох (асистоли_____)
- хэлбэрийн бичлэг гарна
- Е. Дефибрилляцийг АСТ хийсний дараа аль болох эрт хийснээр зүрхний хэм сэргэх магадлал нэмэгддэг
10. Насанд хүрсэн өвчтөн хахсан тохиолдолд хэрэглэх аргачлалыг сонгоно уу.
- А. Цээжийг бүслүүрдэн шахах аргыг хэрэглэнэ
- В. Сээрэн дээр нь 5 удаа дэлсэж амжилтгүй бол хэвлийг бүслүүрдэн шахах аргыг үргэлжлүүлэн хийнэ
- С. Сээрэн дээр нь дэлсэх аргыг 2 минутын турш үргэжлүүлэн хийнэ
- Д. Амьсгалын замыг чөлөөлж 2 удаа амьсгалуулна
- Е. Төвөнхийг нээх
11. АТД-аар цохиулах үед та өвчтөнд яагаад гар хүрч болохгүй вэ?
- А. Та өвчтөнөөр дамжуулан цэнэгэн цохилтонд нэрвэгдэж болно
- В. Таны гар өвчтөнийг хөдөлгөсний улмаас АТД өвчтөний зүрхний агшилт байна гэж дүгнэж болно
- С. Таны судасны лугшилтыг АТД мэдэрч өвчтөнийг цахилгаан цэнэгээр сэдээхгүй
- Д. Таны гар АТД-т хүрэлцвэл дээрх аппарат автоматаар унтарна
- Е. Цохиулах үед өвчтөнд хүрснээр цэнэгийн хүчийг бууруулна
12. АТД цахилгаанаар сэдээх заалтгүй байна гэж хэлвэл та цаашид ямар арга хэмжээ авах вэ?
- А. Өвчтөнд зөвхөн аврах амьсгал хийнэ
- В. АТД буруу хариу өгсөн байх гэж таамаглаад зүрхний хэмийг дахин шалгах
- С. Өвчтөний цээжин дээр АТД-ийн туйлт электродыг наалттай хэвэнд нь үлдээж амилуулах суурь тусламжийг үргэлжлүүлнэ
- Д. Зөвхөн амьсгалын зам чөлөөлнө
- Е. Тусламж иртэл хүлээнэ
13. Насанд хүрэгсдэд АСТ-ийг хэзээ эхлэх заалттай вэ?
- А. Өвчтөн цээжний өвдөлт болон хоол шингэхгүй байгаа талаар гомдол мэдүүлэх үед
- В. Өвчтөн хүчлэн амьсгалсан, судасны лугшилт тэмтрэгдэж байвал
- С. Ухаангүй боловч амьсгалтай өвчтөнд
- Д. Өвчтөн ухаангүй, амьсгалахгүй бол
- Е. Амьсгалын зам бөглөрсөн бол
14. АТД-ийг асааж туйлт электродуудыг цээжин дээр нааж бэхэлсний дараа та юу хийх вэ?
- А. “Өвчтөнөөс холд” гэж анхааруулаад өвчтөний зүрхийг цэнэгэн цохиулалт хийж сэдээнэ.
- В. Шууд цэнэгэн цохиулалт хийнэ
- С. Өвчтөнд гар хүрэхгүй байлгаснаар АТД зүрхний хэмнэлийг үнэлэх боломж олгоно.
- Д. АТД зүрхний хэмнэлийг үнэлэхээс өмнө 2 минутын турш АСТ хийнэ
- Е. Цээжний шахалт 30 удаа хийнэ
15. АТД-ийг зөв дарааллаар ажиллуулах аргыг сонгон авна уу.
- А. АТД-ийг асаа, цээжин дээр туйлт электродуудыг наа, өвчтөнөөс гараа холдуул, дээрх аппарат зүрхний хэмийг үнэлнэ, цэнэгээр цохиулах дохио өгмөгц өвчтөнөөс холд, цохиулалт хийнэ
- В. АТД-ийг асаа, цээжний дээр туйлт электродуудыг наа, цохиулалт хийнэ, өвчтөнөөс холд
- С. АТД-ийг асаа, цэнэгэн цохиулалт хий
- Д. АТД-ийг асаа, өвчтөний цээжний үсийг хус, электродуудыг наа, өвчтөнөөс холд, цохиулалт хийнэ
- Е. Электродуудыг наа, хэмийг үнэл, цэнэгээр цохиул
16. Цээж шахах үйлдлийг хийхдээ гараа цээжний аль хэсэгт байрлуулах вэ?
- А. Өвчүүний дээд хагаст
- В. Хөхний шугамаар цээжний зүүн талд
- С. Өвчүүний доод ирмэг, аюулхай мөгөөрсөн дээр

- D. Өвчүүний доод хагаст, хөхний шугамаар цээжний дунд хэсэгт
E. Хөхний шугамаар цээжний баруун талд
17. Зүрх гэнэт зогссон насанд хүрэгсдийн цээжний шахалтыг хийх зохистой хурд хэд вэ?
A. Нэг минутад 60 удаа
B. Нэг минутад 80 удаа
C. Нэг минутад 120 удаа
D. Нэг минутад 90 удаа
E. Нэг минутад 130 удаа
18. АСТ-ын явцад цээжийг шахах, амьсгалуулах үйлдлүүдийг хийх зорилго нь:
A. Титэм судасны мэс засал хийх шаардлагыг бууруулах
B. Ховдлын жирвэлзлийг үүсгэж хэвийн хэм сэргээх
C. Зүрхний ажиллагаа зогсохоос сэргийлэх
D. Хүчилтөрөгчөөр баяжсан цусны урсгалаар зүрх, тархийг хангаж дефибриллятор авчиртал цаг хожих
E. Хялгасан судасны эргэн дүүрэлтийг хэвийн болгох
19. Цээж шахах, амьсгалуулах үйлдлүүдийг хэдийд хийж эхлэх вэ?
A. Өвчтөн ухаангүй, амьсгал зогссоныг тогтоосны дараа
B. Өвчтөн ухаангүй байгааг тогтоосны дараа
C. Хохирогч ухаантай боловч хэвийн амьсгалахгүй байгааг тогтоосны дараа
D. Амьсгалын замыг шалгаж дууссаны дараа
E. Зөвхөн 2 минутын турш амьсгалуулсны дараа
20. Хоёр тусламж үзүүлэгч насанд хүрэгсдэд АСТ хийхдээ:
A. Нэг нь цээжийг 30 удаа шахсаны дараа нөгөө нь 2 удаа амьсгалуулна.
B. Нэг нь өвчтөнийг ажиглаж байх зуур нөгөө нь тусламж дуудна
C. Нэг нь өвчтөний судасны лугшилтыг тэмтэрч нөгөө нь амьсгал зогссон эсэхийг тогтооно
D. Нэг нь цээжийг 30 удаа шахаж хоёр удаа амьсгалуулсны дараа нөгөө нь ээлжлэн цээжийг 30 удаа шахаж хоёр удаа амьсгалуулна
E. Нэг нь АТД-ийг авч ирнэ
21. Таны дэргэд 45 настай нэгэн эрэгтэй хүн үхэтхийн унахыг харжээ. Та хэн нэгнийг яаралтай тусламж дуудуулахаар явуулсаны дараа АСТ хийж амилуулах гинжин дарааллын эхний хоёр хэсгийг хэрэгжүүлжээ. Энэ гинжин дарааллын гуравдах хэсэгт хамгийн нь юу вэ, тухайн хүний амьсгал авагдах боломжид аль нь илүү нөлөө үзүүлэх вэ?
A. Эмийн эмчилгээ хийх эмнэлгийн ЯТБ хүрэлцэн ирэх
B. Өвчтөнийг эмнэлэг рүү тээвэрлэх
C. АТД-аар хангагдсан ЯТБ хүрэлцэн ирэх
D. АСТ-ийг хийх чадвартай эмч хүрэлцэн ирэх
E. Тогтвортой байрлалд оруулах
22. Ухаангүй өвчтөний амьсгалын зам саатахад хүргэдэг гол шалтгаан юу вэ?
A. Цээжний гэмтэл
B. Амьсгалын замд гадны биет орох
C. Хэл арагш унжих
D. Төвөнх хугарах
E. Цээжний хөндийд хий хурах
23. Дунд чөмөгний хугарлын үед алдах цусны хэмжээ хэд вэ?
A. <750 мл
B. 750-1000 мл
C. 1500-2000 мл
D. 2500-3000 мл
E. >3000 мл
24. Гэмтлийн үед тохиолдох шокийн хэлбэр аль нь вэ?
A. Зүрхний гаралтай
B. Цус алдалтын гаралтай
C. Сепсисийн гаралтай
D. Анафилаксийн гаралтай
E. Мэдрэлийн гаралтай
25. Судсаар сэлбэхэд хамгийн тохиромжтой уусмалыг нэрлэнэ үү.
A. Хлорт натрийн уусмал (0.9%)

- В. 5%-ийн глюкозын уусмал
 - С. Ижил бүлгийн цус
 - D. Полиглюкин
 - Е. Декстран
26. Амьсгалын замыг чөлөөлөх хамгийн найдвартай арга юу вэ?
- A. Ам залгиурын гуурс хэрэглэх
 - В. Хамар залгиурын гуурс хэрэглэх
 - С. Хүчилтөрөгчийн хошуувч хэрэглэх
 - D. Интубаци тавих
 - Е. Төвөнхийн углавч хийх
27. Амь тэнссэн байдалд хүргэхгүй эмгэг аль нь вэ?
- A. Амьсгалын зам саатах
 - В. Үений мултрал
 - С. Чихэлдсэн пневмоторакс
 - D. Ил цус алдалт
 - Е. Хэвийн бус амьсгалах
28. 2-догч үнэлгээг хэзээ хийх вэ?
- A. Гэмтэлд нэрвэгдснээс хойш 30 минутын дараа
 - В. 3-р зэрэглэлийн эмнэлэгт тээвэрлэхээр шийдсэний дараа
 - С. Өвчтөний толгой хүзүүг бэхэлсний дараа
 - D. ABCDE үнэлгээ хийсний дараа
 - Е. Анхдагч үнэлгээг хийж дууссаны дараа үнэлнэ
29. Анхдагч үнэлгээний явцад чихэлдсэн пневмотораксын шинж илэрчээ, авах арга хэмжээг нь олно уу.
- A. Рентгенд харуулна
 - В. Цагаан хоолой хажуу тийш түлхэгдсэн үед л арга хэмжээ авна
 - С. Бүдүүн зүүгээр хий орсон талд эгэмний дунд шугамаар 2, 3-р хавирганы завсар хатгаж хийг гаргана
 - D. 7, 8-р хавирганы завсраар хатгаж гуурс тавина
 - Е. Цээжний хөндийд хий хурах
30. Өвчтөний амин эрхтэний үйл ажиллагаа гэнэт муудах үед ямар арга хэмжээ авах вэ?
- A. Дараагийн шатны эмнэлэгт хурдан шилжүүлнэ
 - В. Анхдагч үнэлгээг давтан хийнэ
 - С. Шингэн сэлбэнэ
 - D. 2-догч үнэлгээг хийнэ
 - Е. Хүчилтөрөгч өгнө
31. Цул эрхтэний гэмтлийн үед нас баралтанд хүргэх гол шалтгаан юу вэ?
- A. Цус алдалт
 - В. Халдвар
 - С. Перитонит
 - D. Гэмтсэн эрхтэний үйл ажиллагааны алдагдал
 - Е. Мөчдийн хугарал
32. Хүзүүний хэсэгт ямар мөгөөрсөн дээр дарахад улаан хоолойг шахаж бөөлжилт, аспирац болохоос хамгаалах вэ?
- A. Доод эрүү
 - В. Бамбай мөгөөрс
 - С. Цагираг мөгөөрс
 - D. Бөгж мөгөөрс
 - Е. Таглаа мөгөөрс
33. Нугасны гэмтлийн шинж тэмдэгт хамаарахгүйг нь олно уу.
- A. Гипотони
 - В. Мөчид халуун байх
 - С. Өрцний амьсгал илрэх
 - D. Шулуун гэдэсний хуних булчингийн тонус чангарах
 - Е. Нурууны сэртэн овойж зөрсөн байх
34. Гэмтсэн өвчтөнийг эмнэлэг рүү тээвэрлэхээс өмнө дараах арга хэмжээний аль нь нэн шаардлагагүй вэ?


- A. Шилбэний ясны ил хугаралд гипсэн боолт хийх
 - B. Амьсгалын замын саадыг арилгах
 - C. Шокийн байдалтай өвчтөний хураагуур судсыг хатгах
 - D. Цээжний хөндийд хий хурсаныг гаргах
 - E. Хүзүүнд чиг тавих
35. Өдрийн хоолны үеэр таны найз гэнэт ханиалгаж, дуу нь суларч, хяхтнах чимээ сонсогдов. Та ямар тусламж үзүүлэх вэ?
- A. Шалан дээр хэвтүүлээд, амыг ангайлгаж хуруугаараа гадны биетийг гогдож гаргахыг оролдоно
 - B. Шалан дээр хэвтүүлээд 2 удаа амьсгалуулж, 5 удаа аюулхай дээр нь дэлсэнэ
 - C. Сайн ханиалгаж, уртаар амьсгалахыг зөвлөнө
 - D. Сээрэн дээр дэлсэх, аюулхайг бүслэн шахах ажилбарыг хэрэгжүүлнэ
 - E. Толгойг гэдийлгэж, оочийг өргөж ажилбар хийнэ
36. Тухайн өвчтөнд зүрхний шигдээс өвчинтэй гэж та оношилбол хэнийг эхэлж дуудах вэ?
- A. Гэр орныхон
 - B. Өрхийн эмч
 - C. Зүрхний эмч
 - D. Яаралтай тусламжийн эмч (103)
 - E. Ангиографийн эмч
37. Өвчтөний зүрхний ажиллагаа зогссоныг үнэлгээ хийх явцад хэрхэн мэдэх вэ?
- A. Арьсны өнгөөр
 - B. Артерийн даралт хэмжиж
 - C. Өвчтөнийг нэрээр нь дуудаж
 - D. Амьсгал зогссон бол
 - E. Чагнуураар зүрхийг нь чагнаж
38. Амилуулах суурь тусламж биеийн ямар амин эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг орлуулан дэмждэг вэ?
- A. Мэдрэл-амьсгалын тогтолцоо
 - B. Цус эргэлт-мэдрэлийн тогтолцоо
 - C. Мэдрэл-булчингийн тогтолцоо
 - D. Амьсгал-цус эргэлтийн тогтолцоо
 - E. Амьсгалын зам-цус эргэлтийн тогтолцоо
39. Ил цус алдалтыг тогтоох аргачлалд хамрагдахгүй аргыг нь тэмдэглэнэ үү.
- A. Цус алдаж буй шархан дээр ариун самбай, цэвэр даавуу тавьж хамгаалах бээлий өмсөж, алгаараа дарж цус тогтоох
 - B. Даралтат, уян боолт хийх
 - C. Шархыг бүлээн усаар угаах
 - D. Иод агуулсан ариутгагч бодисоор (тамедин) шархыг угаана
 - E. Чихээстэй боолт
40. Шокийн байдалд ороход организм зарим эрхтэний цусан хангамжийг хэвийн байлгахгаар тэмүүлнэ, энэ тохиолдолд ямар эрхтэнийг цусаар илүүтэй хангадаг вэ?
- A. Мөчдийг
 - B. Элэг, бөөрийг
 - C. Нуруу, нугасыг
 - D. Тархи, зүрх, уушиг
 - E. Арьс, өөхөн эдийг
41. Шокийн байдал яагаад амь тэнссэн байдалд хүргэдэг вэ?
- A. Өвдөлтийн улмаас
 - B. Мөчид хөхөрч хөрдөг тул
 - C. Шээсний ялгаралт нэмэгддэг
 - D. Амин эрхтэний цус эргэлт алдагдаж, хүчилтөрөгчийн өлсгөлөнд орох
 - E. Дулааны зохицуулалт алдагддаг
42. Шокийн анхны тусламжийн хүрээнд хөлийг 40-50 см өргөдөг шалтгаан юу вэ?
- A. Амьсгалын тогтолцооны үйл ажиллагааг дэмжинэ
 - B. Хөлийн хаван бууруулна
 - C. Захын мэдрэлийн үйл ажиллагааг сэргээнэ
 - D. Амин эрхтэний цусан хангамжийг нэмэгдүүлнэ

- Е. Дотор муухайрах, бөөлжихөөс сэргийлнэ
43. Түлэгдэл үүсгэх шалтгаанд хамаарахгүйг нь олно уу.
- Химийн бодис
 - Цацраг (radiation)
 - Цахилгаан цэнэг
 - Бүлээн шингэн
 - Халуун биет
44. Гэмтлийн улмаас үүссэн жижиг шархыг халдвараас сэргийлэхийн тулд:
- Даралттай боолт хийх
 - Уян боолт хийх
 - Бөгж, бугуйвч, цагийг тайлж авах
 - Усаар угаах, шүрших
 - Норгосон самбайгаар ороох
45. Гэмтлээс үүссэн шарх халдварлагдсан шинжүүдэд хамаарахгүйг нь заана уу.
- Шархны тойрноос зүрх рүү чигэлсэн улаан судал үүсэх
 - Шархны тойронд хавдах, улайх
 - Шархны тойронд дарж үзэхэд өвдөж байх
 - Шархны тойронд дарж үзэхэд хүйтэн байх
 - Шархнаас шүүс гоожих
46. Төрөл бүрийн хэлбэрийн шарханд хамаарах нийтлэг шинж чанарыг олно уу.
- Бүгд цус их хэмжээтэй алдана
 - Бүгдийг нь усаар угаах шаардлагатай
 - Бүгд амь тэнссэн байдалд хүргэнэ
 - Бүгд халдварлагдах эрсдэлтэй
 - Бүгд улайлттай байна
47. Осолдогчийн мөчдийн зарим хэсэг биеэс тасарч салсан үед ямар арга хэмжээ авах вэ?
- Тухайн хэсгийг (хуруу) мөстэй усанд хийнэ
 - Тухайн хэсгийг биеийн хэсэгт буцааж байрлуулаад дарж бооно
 - Тухайн хэсгийг савантай усаар угааж цэвэрлэнэ
 - Тухайн хэсгийг ариун самбайгаар ороож, пластик уутанд дүрж мөстэй усанд хийнэ
 - Тухайн хэсгийг устгах заалттай
48. Татрангийн эсрэг вакцинийг 10 жил тутам хийлгэх заалттай, учир нь:
- Татрангийн эсрэг вакцин насан туршийн дархлал үүсгэнэ
 - Цусны төлжилтийг сайжруулна
 - Дээрх вакцинийг тариулсан тохиолдолд шархыг цэвэрлэх, цэгцлэх шаардлаггүй болно
 - Татрангийн эсрэг дархлал тодорхой хугацаанд үүсгэнэ
 - Шархны бүх төрлийн халдвараас сэргийлнэ
49. Барилгачин өндрөөс унаж хурц үзүүртэй төмрөөр хөлрүүгээ сүлбүүлжээ, гадны биетийг яах заалттай вэ?
- Цус алдалтыг өөрөө тогттол нь ажиглана
 - Гадны биетийг сугалж аваад, цус алдалтыг тогтооно
 - Шархыг савантай усаар угаана
 - Гадны биетийг хөдөлгөөнгүй бэхэлж боолт хийнэ
 - Гадны биетийг тойруулж антибиотикийн тосон түрхлэг хийнэ
50. Гэмтлийн улмаас үүссэн жижиг шархны цус алдалтыг хэрхэн тогтоох вэ?
- Шархтай хэсгийг өргөж байрлуулснаар
 - Шархнаас дээш хэсэгт цусны судсыг дарж
 - Чангалуур тавьж
 - Шархан дээр ариун самбай тавьж дарах
 - Чихээс хийх

Тохиолдол 1

Эрчимт эмчилгээний тасагт зүүн сүвэргэндээ (цээж) хутгалуулсан өвчтөн иржээ. Ирэх үеийн биеийн байдал: амьсгал давхацсан, өнгөц, олширсон, цусны хүчилтөрөгчийн ханамж SpO_2 -76%, ухаан самуурсан, зүрхний хэм 1 минутанд 140 удаа, Артерийн даралт 80/40 мм/Нг байна. Цээжний зүүн тал тогшилтоор хэнгэргэн чимээтэй, чагнахад зүүн талын амьсгал баруун талынхаас сул.

51. Өвчтөний эмнэлзүйн урдчилсан оношийг сонгоно уу.
1. Зүрхний шигдээс
 2. Цээжний нэвтэрсэн гэмтэл
 3. Амьсгалын дээд замын саад
 4. Пневмоторакс
 5. Уушигны артерийн бүлэнт бөглөрөл
52. Өвчтөнд яаралтай тусламж үзүүлэх заалттай ажилбаруудыг сонгоно уу.
1. Цээжний хөндийг зүүгээр хатгах эсвэл цээжинд гуурс тавих
 2. Хүчилтөрөгчөөр амьсгалуулах
 3. Хураагуур судсыг хатгах, шингэн сэлбэх
 4. Цус сэлбэх
 5. Трахеостоми хийх
53. Энэ өвчтөнийг зүрхний эхокардиографийн аппаратын тусламжаар харахад үнхэлцгэний хөндийд шингэн байгаа нь тогтоогдов (Зураг 1). Энэ шингэн үүссэн байх хамгийн өндөр магадлалтай шалтгааныг сонгоно уу.
1. Сүрээгийн
 2. Хэрх өвчний
 3. Зүрхний дутагдлын
 4. Зүрхний ханын гэмтэл
 5. Үнхэлцгийн хавдар



Тохиолдол 2

4 настай хүүхэд машинд дайруулсан, хүлээн авах тасагт ухаангүй, хариу урвал байхгүй. Анхдагч үзлэгээр цээжний хөдөлгөөнгүй, амьсгалын чимээ, шуугиан сонсогдохгүй байдалтай иржээ.

54. Энэ хүүхдэд ямар тусламжийг эхлэн үзүүлэх вэ?
1. Хүүүний хамгаалалт өмсүүлнэ
 2. Доод эрүүг өргөж амьсгалын замыг чөлөөлнө
 3. Өөрөө тэлэгч хөөргөөр (Амбу) амьсгалуулна
 4. Хэймлихийн аргачлалыг хэрэглэнэ
 5. Цээжин дээр хүчтэй цохих аргыг хэрэглэнэ
55. Ухаангүй өвчтөний амьсгалын замыг саатуулдаг хамгийн олонтаа тохиолдох шалтгааныг дурдана уу.
1. Амьсгалын замд гадны биет орж хахах
 2. Бронх спазм болох
 3. Ларинго спазм болох
 4. Хэл арагш унаж, амьсгалын зам хэлээр бөглөрч саатах
 5. Хүүхэн хэл унжиж бөглөх
56. Амилуулах суурь тусламж үзүүлсний дараа хүүхдийн судасны лугшилт 130 бөгөөд артерийн даралтыг хэмжиж үзэхэд 60/50 мм Hg байжээ. Хураагуур судсыг хатгахаар оролдоод олохгүй байна. Дараах арга хэмжээнээс алийг нь сонгон авах вэ?
1. Артерийн судсыг хатгахаар оролдоно
 2. Хүүхдийн ясны хэмд шингэн сэлбэж артерийн даралтыг нэмэгдүүлнэ
 3. Арьсан доор шингэн сэлбэх эмчилгээ хийнэ
 4. Тойгноос доош нэг хуруу орчимд шилбэний ясны хэмд бүдүүн зүүгээр хатгана

5. Зүрхийг гаднаас хатгаж шингэн сэлбэх аргыг хэрэглэнэ

57. Хүүхдийн цээжийг чагнаж үзэхэд баруун талдаа амьсгал сонсогдохгүй, тогшилтоор тэр талдаа хэнгэргэн чимээтэй, цагаан хоолой зүүн тийш түлхэгдсэн байдалтай, дараах ажилбаруудаас нэн шаардлагатайг нь сонгоно уу.

1. Интубаци хийж амьсгалын дээд замыг чөлөөлнө
2. Цээжний хөндийг хатгаж чихэлдсэн хийг гадагшлуулах
3. Хаймлихийн аргачлалыг хэрэглэх
4. Шаардлагатай бол цээжинд гуурс байрлуулах
5. Цээжин дээр хүчтэй цохих аргыг хэрэглэх

58. Энэ хүүхдэд дараах хүндрэлүүдийн аль нь илэрсэн тохиолдолд цээжний хөндийд хатгалт хийх вэ?

1. Уушигны цочмог үрэвсэл
2. Уушигны артерийн тромбэмболи
3. Уушиг атлеткетаз болсон
4. Цээжний хөндийд хий хуралдах
5. Гэмтлийн улмаас уушиг няцарсан

Тохиолдол 3

70 настай эрэгтэй, артерийн даралт тогтмол өндөртэй байдаг, өвчтөн гэнэт ухаан алдаж, гүн комын байдалд орсон, хүүхэн хараа хоёр талдаа адилгүй, өрөөсөн гар хөлийн мэдэрхүй, хөдөлгөөн суларсан байна.

59. Ямар эмгэгийн үед эмнэл зүйн дээрх шинж тэмдгүүд олонтаа тохиолдох вэ?

1. Эпилепси
2. Гипогликеми
3. Манас таталт
4. Тархины дайрлага (инсульт)
5. Зүрхний шигдээс

60. Энэ өвчтөний артерийн даралтыг яаралтай бууруулахын тулд ямар эмийн бодисыг сонгох вэ?

1. Никардипин (Нифедипин)
2. Гидролазин
3. Нитроглицерин
4. Хлортиазид
5. Кордарон

61. Энэ өвчтөний даралтыг стандартын дагуу хурдан бууруулахгүй бол цаашид гарах хүндрэлийг нэрлэнэ үү?

1. Цусан дахь сахарын хэмжээ буурах
2. Тархины цусан хураа үүсэх
3. Элэгний үйл ажиллагааны дутагдал үүсэх
4. Нүдний торлогт цусан хураа үүсэх
5. Цусны бүлэгнэлтийн алдагдалд хүргэх

62. Тухайн өвчтөнд артерийн гипертензийн ямар шинж тэмдэг илрэх вэ?


1. Дотор муухайрах, бөөлжүүлэх
2. Толгой өвдөх
3. Торлогийн хаван
4. Ухаан балартах
5. Диастолын даралт өндөрссөн байх

Тохиолдол 4

Сумын эмнэлэгт гар нь хавдсан өвчтөн иржээ. Эцэг эхийн өгүүлэмж: гэрийн гадаа тоглож байсан 3 настай хүүхэд гэнэт хашгирч уйлахад эцэг, эх нь гүйж очжээ. Хүүхдийн гар дээр амьтан хазсан шүд, хоёр соёоны мөр үлдсэн, нилээд хавдсан байна (Зураг2).

63. Хүүхэд ямар амьтанд хазуулсан байна вэ?

1. Нохой
2. Зөгий
3. Муур
4. Могой
5. Хүн



Зураг 2

64. Анхны арга хэмжээг сонгоно уу.

1. Чангалуур тавина
2. Даралтат боолт хийнэ
3. Бүлээн жин тавина
4. Мөчний хөдөлгөөнийг хориглоно
5. Преднизолон тарина

65. Энэ хүүхдийг эмнэлэг хүртэл тээвэрлэхдээ анхаарах зүйлсийг сонгоно уу.

1. Хазуулсан мөчинд чиг тавина
2. Өвчтөнийг дамнуурган дээр хэвтүүлж зөөвөл ашигтай
3. Хазуулсан мөчийг зүрхний түвшинд байрлуулна
4. Хазуулсан мөчийг унжуулж байрлуулна
5. Хазуулсан мөчөнд иллэг хийж хаванг бууруулна

66. Хэрэв хортой могойд хатгуулсан бол бусад эрхтэн системийн зүгээс ямар хүндрэл гарах вэ?

1. Толгой эргэнэ
2. Мөчдийн болон амьсгалын булчин саажна
3. Цусны бүлэгнэлт алдагдана
4. Дотор муухайрна, бөөлжнө
5. Юм давхарлаж харагдана, ухаан санаа самуурна

Тохиолдол 5

24 настай эрэгтэй, малчин хаврын хүйтэн бороо, салхинд малаа дагаж салхи уруудаж яваад осгож, ухаан алдсан байдалтай олджээ.

67. Осголтын эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү.

1. Шээс хүрэх
2. Чичрэх
3. Хүчилтөрөгчийн хэрэгцээ буурах
4. Зүрхний цохилтын тоо цөөрөх, артерийн даралт буурах
5. Ухаан санаа самуурах

68. Энэ өвчтөнд болгоомжтой хүрч, доргиохгүй байх шаардлагатай. Учир нь:

1. Таталт үүсэх осолтой
2. Бөөлжилт үүсэх осолтой
3. Булчин зангирна
4. Ховдлын жирвэлзэл үүсэх осолтой
5. Хөөрлийн байдалд орох осолтой

69. Осгосон өвчтөний цулын халуун хэдэн градусаас доош бол чичрэх шинж арилах вэ?

1. 30⁰с
2. 32⁰с
3. 33⁰с

4. 34⁰с
 5. 35⁰с
70. Осголтод нэрвэгдэх эрсдэл өндөртэй бүлгийг сонгон авна уу.
1. Хүүхэд
 2. Өндөр настан
 3. Согтуу хүн
 4. Тураалтай хүн
 5. Мэдрэл, булчингийн тогтолцооны эмгэгтэй
71. Энэ хүнд авах яаралтай тусламжийн арга хэмжээг дурьдана уу.
1. Нойтон хувцасыг тайлж, дулаан орчинд оруулах, дулаан хучлагаар хучих
 2. Судсаар бүлээн уусмал сэлбэх (40-42⁰с)
 3. Халуун агаараар үлээлгэх (дулаацуулах хөнжил)
 4. Том артери дээр бүлээн жин тавих
 5. Ходоодыг бүлээн усаар угаах
72. Осолдогчид анхны тусламж үзүүлэхдээ халдвар авахаас хамгаалах арга хэрэгслэлүүдийг нэрлэнэ үү.
1. Хамгаалалтын бээлий өмсөх
 2. Хамгаалалтын нүдний шил зүүх
 3. Бээлий өмсхөөс өмнө бөгж, бугуйвч, цагаа тайлах
 4. Амны хаалт зүүх
 5. Гарын шарх, шалбархайд тусламж үзүүлж эхлэхээс өмнө наалдамхай (шархны) тууз нааж хамгаалах
73. Ерөнхий мэргэжлийн эмч амилуулах суурь тусламжаа зогсоох заалтууд
1. Тусламж үзүүлэгчид ослын орчны байдал аюултай болох
 2. Осолдогчийн амьсгалын үйл ажиллагаа сэргэх
 3. Дефибриллятортой аврах багийнхан хүрэлцэн ирэх
 4. Тусламж үзүүлэгч бүрэн цуцаж туйлдах
 5. Амилуулах тусламж үзүүлээд 30 минутаас илүү болох, хамтын шийдвэрийг үндэслэх
74. Зүрх зогсоход хүргэдэг осол гэмтлийн үндсэн шалтгаануудыг тэмдэглэнэ үү.
1. Зам тээврийн осол
 2. Живэх
 3. Угаартах
 4. Хордох
 5. Хахах
75. Зүрхний шигдээс өвчний эмнэлзүйн шинжүүдийг сонгоно уу.
1. Гар хөлийн үзүүр хөрөх
 2. Хөлрөх
 3. Цээжээр өвдөх
 4. Арьс цайрах
 5. Амьсгал давчдах
76. Зүрхний гаралтай цээжээр өвдөх эмнэлзүйн онцлогуудыг тэмдэглэнэ үү.
1. Өвчүү, цээжний тус газар дарж байгаа мэт
 2. Өвдөлт мөр, гарлуу дамжина
 3. Өвдөлт хүзүү, багалзуур, доод эрүүрүү дамжина
 4. Өвдөлт хавирганы завсарт зөвхөн нэг цэгт хүчтэй илэрнэ
 5. Өвдөлт амьсгал авах үед нэмэгдэнэ
77. Зүрхний шигдээсийн улмаас ямар хүндрэл тохиолдох вэ?
1. Зүрхний үйл ажиллагааны дутагдал
 2. Зүрх зогсох
 3. Зүрхний булчингийн зарим хэсэг үхжих
 4. Тархины голомтлог шинжүүд илрэх
 5. Гиповолеми
78. Шокийн байдалд хүргэж болох хүчин зүйлсийг сонгоно уу.
1. Цус алдалт
 2. Зөгийд хатгуулах (зарим тохиолдолд)
 3. Зүрхний шигдээс

4. Элэгний үйл ажиллагааны дутагдал
5. Шээс хаагдах
79. Шокийн үед арьсний өнгө яагаад цайвар харагддаг вэ?
 1. Хөлөрсний улмаас
 2. Эргэлдэх цусны ихэнх амин эрхтэнд хувиарлагдснаас
 3. Биеийн дулаан нэмэгдсний улмаас
 4. Арьс, арсан доорх өөхөн эдийн судас нарийссаны улмаас
 5. Арьсний хүчилтөрөгчийн хангамж дутагдсаны улмаас
80. Шокийн үед ямар эрхтэн тогтолцооны цусан хангамж алдагдах вэ?
 1. Амьсгалын тогтолцоо
 2. Цус эргэлтийн тогтолцоо
 3. Мэдрэлийн тогтолцоо
 4. Бүх эрхтэн, тогтолцоо
 5. Бөөр, шээс ялгаруулах эрхтэн
82. Шарханд боолт хийх зорилго нь:
 1. Хөдөлгөөнгүй болгох
 2. Ариун самбайг тогтоох
 3. Өвдөлгүй болгох
 4. Шархыг гадны халдвараас сэргийлэх
 5. Дарагдлын хам шинжээс сэргийлэх
83. Халдварлагдсан шархтай хүнд үзүүлэх анхны тусламж:
 1. Шархны эргэн тойрныг цэвэрлэх
 2. Шархыг бүлээн усаар норгосон самбайгаар ороох
 3. Шарханд антибиотиктой тосон түрхлэг хийх
 4. Шархтай мөчийг өргөж байрлуулах
 5. Шарханд орсон гадны биетийг түүж цэвэрлэх
84. Ясны хугарлын үед илрэх шинж
 1. Хугарсан хэсэгт хөдөлгөөн чөлөөтэй байх
 2. Хугарсан хэсэгт ясны үзүүр цухуйж харагдах
 3. Хугарсан хэсэгт өвдөлтгүй байх
 4. Хугарсан мөчний хэлбэр алдагдсан байх
 5. Хугарсан хэсэгт арьс цайрсан хүйтэн байх
85. Мөчдийн гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжийн заалтуудыг сонгоно уу.
 1. Осолдогчийг гэмтсэн газраас холдуулна
 2. Гэмтсэн хэсэгт хүйтэн жин тавина
 3. Чиг тавихаас өмнө гэмтсэн мөчдийг шулуун байдалд засаж оруулна
 4. Гэмтсэн мөчдийн хөдөлгөөнийг хязгаарлана
 5. Гэмтсэн мөчийг зүрхний төвшингөөс доош байрлуулна
86. Чихний гэмтлийн шинж тэмдгүүдийг олно уу.
 1. Сонсголын алдагдал
 2. Тэнцвэрийн алдагдал
 3. Чихэн дотор өвдөх
 4. Чихний хэнгэрэг хагарах
 5. Чих шуугих
87. Зөгийд хатгуулсан үед ямар арга хэмжээ авах вэ?
 1. Хатгалтын шархыг усаар угаана
 2. Арьсанд шигдэж үлдсэн зөгийн хошууг хусаж авна
 3. Хүйтэн жин тавина
 4. Арьсанд шигдэж үлдсэн зөгийн хошууг чимхэж авна
 5. Хатгалтын шархыг спиртээр арчина
88. Хачиг, шавжид хатгуулахаас сэргийлж авах арга хэмжээг тэмдэглэнэ үү.
 1. Шумуулын (шавжийн) тос түрхэх
 2. Шуумгаа гутлын түрий, оймсондоо чихэх
 3. Урт ханцуйтай цамц өмсөх
 4. Тод өнгийн хувцас өмсөх
 5. Малгай өмсөх, алчуур зангидах
89. Усанд цацаж, живж байгаа хүнд туслах аюулгүй аргыг сонгоно уу.

1. Усанд шумбаж ороод татаж гаргах
 2. Усанд шумбаж ороод хөвдөг биет (аврах цагираг) атгуулах
 3. Хүчтэй сэлж эрэгт ойртохыг зөвлөж хашгирах
 4. Эрэг дээр зогсоод хөвдөг биет (аврах цагираг) шидэх, урт мод, мөчирний үзүүрээс бариулж татаж гаргах
 5. Усанд шумбаж ороод үснээс нь татаж гаргах
90. Цагаан хоолойд гуурс тавих (интубаци хийх) аргыг хэрэглэх нь:
1. Нарийн мэргэжлийн эмчийн ажил
 2. Дадлага хийсэн бүх эмч хийж болно
 3. Тусгай багаж шаардагдахгүй.
 4. Амьсгалын зам чөлөөлөх найдвартай арга мөн
 5. Ихээхэн осолтой тул оролдохгүй байх нь зөв
91. Тархины үхлийн баталгаатай шинж тэмдэг юу вэ?
1. Тархины цахилгаан бичлэгт шулуун зураас гарах
 2. Ухаан алдах.
 3. Өвчтөний амьсгал зогссон байх
 4. Хүүхэн хараа өргөсөх.
 5. Хөхрөх ба цонхийх
92. Зүрхний булчингийн цочмог дутмагшлын эмчилгээний гол зорилт:
1. Зүрхний булчингийн агших чадлыг сайжруулах
 2. Бага эргэлтийн даралтыг бууруулах
 3. Захын судасны эсэргүүцлийг бууруулах
 4. Эргэлдэх цусны хэмжээг бууруулах
 5. Хөлийн хаванг бууруулах
93. Хаврын мөстэй усанд живсэн хүүхдийг 5 минут орчмын дараа гарган авчээ. Эмнэлзүйн ямар шинжүүд илэрсэн байж болох вэ?
1. Зүрх зогссон
 2. Биеийн дулаан буурсан
 3. Амьсгал зогссон
 4. Тархинд цус харвасан
 5. Уушгины хаван
94. Өндөр хүчдэлийн цахилгаан гүйдэлд цохиулахад гарах хүндрэлүүд юу вэ?
1. Гадаргуугийн түлэгдэл
 2. Дотоод эрхтэний гэмтэл, ясны хугарал
 3. Ховдлын жирвэлзэл
 4. Их өвдөх
 5. Булчин татах
95. Гэрт түймэр гарахад хувцас нь шатаж байгаа хүүхэд гүйн гарч иржээ. Доорх арга хэмжээнээс алийг нь авах вэ?
1. Салхи сөргүүлэн гүйлгэнэ
 2. Газарт унагаад хөнжлөөр битүү хучна
 3. Хойноос нь гүйж ус цацна
 4. Газарт унаж хөлбөр гэж заана
 5. Барьж аваад хувцсыг нь тайлж авна
96. 50 настай эрэгтэй цээжээр үе үе өвддөг өгүүлэмжтэй эмнэлэгт ирж үзүүлсэн. Учир нь их халуурдаг тул цусны дэлгэрэнгүй шинжилгээ хийх шаардлагатай.
97. Амилуулах суурь тусламж нь цочсон сандарсан хүнд үзүүлдэг. Учир нь амьсгал зүрх судасны үйл ажиллагаа алдагдсан байдаг.
98. Цээж шахалтыг 30:2 гэсэн харьцаагаар хийдэг. Тиймээс 1 минутанд 30 удаа цээж шахна гэсэн үг.
99. Цээжний гэмтлийн үед хий хурах бөгөөд хий хурсан хэсэгт тогшиход дүлий чимээ сонсогдоно.
100. Гэмтлийн үед цээжний хөндийд шингэн хурдаг. Шингэн хурсан талд эгэмний дунд шугамаар 2, 3-р хавирганы завсар хатгалт хийнэ.

ЭХ БАРИХУЙ

1. Леопольдын 1-р барилаар юуг тодорхойлох вэ?
 - А. Умайн ёроолын өндрөөр жирэмсний хугацааг тодорхойлно.
 - В. Ургийн байрлал
 - С. Түрүүлсэн хэсэг
 - Д. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
 - Е. Ургийн жин
2. Зурагт үзүүлсэн арга Өгзөг түрүүлэлтийг төрүүлэх аль аргыг нэрлэнэ үү?



А. Толгой төрүүлэх Мориссо-Леврейн арга

- В. Цовъяновын 2- арга
- С. Гар гаргах сонгомол арга
- Д. Цовъяновын 1- арга
- Е. Мөр төрүүлэх арга

3. Ихэнх тохиолдолд төрлөг удирдах сонгомол арга?

- А. Хүлээж төрөх замаар төрүүлэх
- В. Кесар хагалгаа хийх
- С. Ургийн шингэний хальс цоолох
- Д. Окситоцин тарих
- Е. Төрөлтийг эмээр сэдээх

4. Ураг орчмын шингэн хэдийд гарвал хэвийн гэж үзэх вэ?

- А. Төрөлтийн 1-р үе эхэлснээс хойш умайн амсарт 4 см нээлттэй байхад ургийн шингэн гарвал
- В. Төрөлтийн 1үе дуусч умайн амсар бүрэн нээгдэхэд шингэн гарах
- С Төрөлтийн үйл ажиллагаа эхлээгүй байхад ургийн шингэн гарах
- Д. Төрөлтийн 2-р үе эхэлж дүлэлт өгснөөс хойш
- Е. Төрөлтийн үйл ажиллагаа

5. Анхан төрөгчийн төрлөгийн 1 үеийн үргэлжлэх дундаж хугацаа хэд вэ?

- А. 3-5 цаг
- В. 6-9цаг
- С. 10-12 цаг
- Д. 13-18 цаг
- Е. 16-18 цаг

6. Анхан төрөгчийн төрлөгийн 2 үеийн үргэлжлэх дундаж хугацаа хэд вэ?

- А. 0.5цаг
- В. 0.5-1цаг
- С. 1-2 цаг
- Д. 2-3 цаг
- Е. 1 цаг

- 7 . Давтан төрөгчид төрлөгийн 2-р үе хэдэн цаг үргэлжлэх вэ?

- А. 0.5 цаг
- В. 0.5-1 цаг
- С. 1-1.5 цаг

- D. 1.5-2 цаг
E. 1 цаг
8. Давтан төрөгчийн төрлөгийн 1-р үеийн үргэлжлэх дундаж хугацаа хэд байх вэ?
A. 3-5цаг
B. 6-9цаг
C. 8-12цаг
D. 13-16цаг
E. 16-18
9. Цус алдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ургийн толгой төрсөн үед ямар эм хэрэглэх вэ?
A. Окситоцин
B. Мизопростол
C. Метилэргометрин
D. Синтоцинон
E. Простагландин
10. Хэвийн жирэмсний хяналтыг хэдэн удаа, сайдын хэддүгээр тушаалаар хянаж байгаа вэ?
A. 392-р тоот тушаал, 6 удаа
B. 318-р тоот тушаал, 6 удаа
C. 39-р тоот тушаал 6 удаа
D. 338-р тоот тушаал, 6 удаа
E. 392-р тоот тушаал, 8 удаа
11. Аарцгийн хэмжээ 24-26-28-16- 9 бол ямар хэлбэрийн уйтан аарцаг болохыг тодорхойлно уу?
A. Жигд уйтарсан аарцаг
B. Хөндлөн уйтарсан аарцаг
C. Жигд уйтарсан хавтгай аарцаг
D. Энгийн хавтгай аарцаг
E. Сульдаагийн үеийн хавтгай аарцаг
12. Ургийн толгойн ямар тавилтын үед шулуун хэмжээгээр төрдөг болохыг нэрлэнэ үү
A. Өврийн янзтай дагз түрүүлэлт
B. Арын янзтай дагз түрүүлэлт
C. Толгойн оройн түрүүлэлт
D. Дух түрүүлэлт
E. Арын тэнхлэгийн бус тавилт
13. Ургийн зүрхний цохилтын норм 1 минутанд хэд байх вэ?
A. 140-160 удаа
B. 120-160 удаа
C. 100-140 удаа
D. 90-140 удаа
E. Аль нь ч биш
14. Сүүлийн биений юм 11 сарын 11нд ирсэн. Негелийн томьёогоор төрөх хугацааг тодорхойл
A. 8 сарын 18
B. 8 сарын 20
C. 2 сарын 4
D. 5 сарын 25
E. 8 сарын 31
15. Жирэмсний хугацаа буюу эх барихын 10 сар нь:
A. 365 хоног буюу 50 долоо хоног үргэлжилдэг
B. 280 хоног буюу 40 долоо хоног үргэлжилдэг
C. 300 хоног буюу 50 долоо хоног үргэлжилдэг
D. 280 хоног буюу 37 долоо хоног үргэлжилдэг
16. Хэдийд партограммыг хөтөлж эхлэх вэ?
A. Төрөлтийн нэгдүгээр үеийн идэвхтэй шатанд
B. Төрөлтийн өмнөх үед

- C. Төрөлтийн. 2-р үед
 D Төрөлтийн 3-р үед
 E.Төрсний дараахүед
- 17.Биений юмны мөчлөг хэвийн үед сувгийн салианы сунах шинж 5-6 см байхад сарын тэмдгийн мөчлөгийн аль үетэй тохирох вэ?
 A. Сарын тэмдгийн мөчлөгийн 1-5дахь өдөр
 B. Сарын тэмдгийм мөчлөгийн 6-10 дахь өдөр
 C Сарын тэмдгийн мөчлөгийн 12-14 дэхь өдөр
 D Сарын тэмдгийн мөчлөгийн 16-20 дахь өдөр
 E Сарын тэдгийн мөчлөгийн 22-24 дэхь өдөр
- 18.Хүүхэн харааны шинж /+++/, хүзүүний сувгийн нээгдлийн диаметр 0,3 .см хүрсэн /гадна хөөмий дугираг хэлбэртэй/ бол ,сарын тэмдгийн мөчлөгийн аль үетэй тохирох вэ?
 A. Сарын тэмдгийн мөчлөгийн 5-6 дахь өдөр
 B.Сарын тэмдгийн мөчлөгийн 7-8 дахь өдөр
 C. Сарын тэмдгийн мөчлөгийн 9-10дахьөдөр
 D. Сарын тэмдгийн мөчлөгийн 11-12 дахь өдөр
 E Сарын тэмдгийн мөчлөгийн 13-14 дэхь өдөр
19. Жирэмсний хяналтын чанарыг гаргах томъёо аль нь вэ?
 A. Жирэмсний эхний 3 сарын дотор.хяналтанд,авсан жирэмсний тоог 100-р үржүүлж хяналтанд авсан бүх жирэмсний тоонд хуваана
 B. Жирэмсний эхний 3,сарын дотор хяналтанд авсан жирэмсний тоог 1000-р үржүүлж хяналтанд авсан бүх жирэмсний тоонд хуваана
 C. Жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд авсан жирэмсний тоог 10000-р үржүүлж хяналтанд авсан бүх жирэмсний тоонд хуваана
 D. Жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд авсан жирэмсний тоог 100000-р үржүүлж хяналтанд авсан бүх жирэмсний тоонд хуваана
 E. Жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд авсан жирэмсний тоог 100000-р үржүүлж хяналтанд авсан бүх тулгар жирэмсний тоонд хуваана
- 20.Нэг удаагийн биений юм ирэх үед гарах цусны хэмжээ хэдэн мл байдаг вэ?
 A. 40-50 мл
 B. 50-60 мл
 C. 60-70 мл
 D.50-150 мл
 E. 70-100 мл
21. Distantio cristarum хэмжээнх?
 A. Ташаа ясны дэлбээний алслагдсан зай
 B. Дунд чөмөгний том төвгөрүүдийн хоорондох зай
 C. Ташаа ясны урд дээд сэртэнгийн хоорондох зай
 D. Умдагны доод ирмэгээс бүсэлхийн 5-р нугалмын арын сэртэн хүртэлх хэмжээ
 E. Умдагны доод ирмэгээс хонцог хүртэлх хэмжээ
- 21.Conjugata externa хэмжээ нь?
 A. Умдагны доод ирмэгээс бүсэлхийн 5-р нугалмын арын сэртэн хүртэлх хэмжээ
 B. Умдагаы доод ирмэгээс ууцны төвгөр хүртэлх хэмжээ
 C. Умдагаы дээд ирмэгээс ууц ахар сүүлний нийлэх хэсэг
 D. Умдагны дээд ирмэгээс бүсэлхийн 5-р нугалмын ар сэртэн хүртэлх хэмжээ
 E. Умдагаы доод ирмэгээс бүсэлхий ууцны нийлэх хүртэлх хэмжээ
- 22.Distantio spinarum нь хэдэн см вэ?
 A. 24-25 см
 B. 26-27 см
 C 25-27 см
 D 25-26 см
 E 28-29 см
23. 20-21 см нь аарцгийн ямар хэмжээс вэ?
 A. Distantio spinarum
 B Conjugata externa
 C Distantio cristarum
 D Conjugata interna

- E Conjugata diognalis
24. Distantio trochanterica гэж юу вэ?
- A. Дунд чөмөгний том төвгөрүүдийн хорондох зай
 B. Ташаа ясны дэлбээний алслагдсан зай
 C. Ташаа ясны урд дээд сэртэнгүүдийн хоорондох зай
 D. Умдагны дээд ирмэгээс бүсэлхийн 5-р нугалмийн арын сэртэн хүртлэх хэмжээ
 E. Умдагны доод ирмэгээс хонцог хүртлэх хэмжээ
25. Ураг өгзгөөр түрүүлсэн 1-р нуруулалт УЗЦ хаана тод сонсогдох вэ ?
- A. Хүйснээс доош зүүн талд
 B. Хүйснээс дээш баруун талд
 C. Хүйсний хажуу талд
 D. Хүйснээс дээш зүүн талд
 E. Хүйснээс доош баруун талд
26. Ургийн толгойн их хөндлөн хэмжээг дурьдна уу?
- A. 13 B. 9.25 C. 10.5 D. 13.5 E. 8
27. Леопольдийн 3-р байрлаар юуг тодорхойлох вэ?
- A. Түрүүлсэн хэсэг
 B. Ургийн нуруулалт
 C. Ургийн байрлал
 D. ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгт тавигдсан эсэх
 E. Ургийн янз
28. Хэвийн үед УЗЦ-ын тоо 1 хоромд хэд байх вэ?
- A. 80-90 B. 100-110 C. 120-140 D. 170-180
 E. 110-120
29. Дагз түрүүлсэн өвөр янзтай 1-р нуруулалтийн үед УЗЦ хаана хамгийн тод сонсогдох вэ?
- A. Хүйсний баруун доор
 B. Хүйсний зүүн доор
 C. Хүйсний зүүн дээр
 D. Хүйсний түвшинд зүүн талдаа
 E. Хүйсний баруун дээр
30. Ургийн дагз түрүүлсэн байхад хөтлөх цэг нь юу вэ ?
- A. Бага зулай
 B. Их зулай
 C. Их бага зулайн дунд хэсэг
 D. Шилний хонхор
 E. Духны үстэй хэсэг
31. Эмэгтэйчүүдийн хамгийн тохиромжтой төрөх нас аль вэ?
- A. 18-20 нас B. 20-35 нас C. 21-25 нас D. 26-30 нас E. 30-35 нас
32. Манай улсад хэдэн хүүхэдтэй байх нь хамгийн тохиромжтой гэж үздэг вэ?
- A. 1-2 хүүхэд B. 2-3 хүүхэд C. 3-4 хүүхэд D. 4-5 хүүхэд E. 5 –аас дээш
32. Амаржих газрын 1 эхийн оронд ноогдох талбай хэд байдаг вэ?
- A. 3м² B. 5м² C. 7м² D. 9м² E. 10м²
33. Жирэмсний төгсгөл дэх умайн уртын хэмжээ хэд байдаг вэ?
- A. 34-35см B. 35-36см C. 37-38см D. 39-40см
 E. 40-42см
34. жирэмсний төгсгөл дэх умайн жин
- A. 700-800г B. 801-900г C. 901-1000г D. 1001-1100г
 E. 1200г
35. Дагз түрүүлсэн урд янз байхад төрлөгийн биомеханизмын эхний шат ямар байх вэ?
- A. Толгойн бөхийлт
 B. Толгойн гэдийлт
 C. Толгойн доошлолт
 D. Толгойн хамгийн дээд гэдийлт
 E. Толгой умдаг руу дагзаар эргэх

- 36.Өвөр янзтай дагз түрүүлсэн байхад ургийн толгой бага аарцгийн орох хэсгийн ямар хэмжээнд тавигддаг вэ?
- Шулуун хэмжээнд
 - Баруун ташуу хэмжээнд
 - Хөндлөн хэмжээнд
 - Ташуу ба хөндлөн хэмжээнд
 - Зүүн ташуу хэмжээнд
37. Хамгийн олон тохиолддог ургийн түрүүлэлт аль нь вэ?
- Цэвэр өгзөг
 - Хөл өгзөг
 - Хөл түрүүлэлт
 - Дагз түрүүлэлт
 - Нүүр түрүүлэлт
38. Ихэнх тохиолдолд төрлөг удирдах ашигтай арга юу вэ?
- Хүлээж төрөх замаар төрүүлэх
 - Кесар хагалгаа хийх
 - Ургийн шиигэний хальс цоолох
 - Окситоцин тарих
 - Төрөлтийг эмээр сэдээх
- 39.Төрөх үед 1-1,5 см-аар уртсан 10,5-11 см болдог аарцгийн хэмжээг олно уу?
- Бага аарцгийн орох хэсгийн шулуун хэмжээ
 - Бага аарцгийн гарах хэсгийн шулуун хэмжээ
 - Бага аарцгийн өргөн хэсгийн шулуун хэмжээ
 - Бага аарцгийн нарийн хэсгийн шулуун хэмжээ
 - Их аарцгийн гадна шулуун хэмжээ
- 40.Суман заадас аарцгийн орох хэсгийн аль нэг ташууд юмуу хөндлөн хэмжээнд байна. Төрлөгийн биомеханизмын хэддүгээр момент вэ?
- I момент
 - II момен.
 - III момент
 - IV момент
 - V момент
41. Манай улсад эх барихын тусламжийг хэдэн шатлалаар үзүүлдэг болохыг нэрлэнэ үү?
- Шатлал хамаарахгүй
 - 1 шатлалаар
 - 2 шатлалаар
 - 3 шатлалаар
 - 4 шатлалаар
42. “Перинаталь үе” –д хамаарахыг нэрлэнэ үү?
- Антенаталь болон интранаталь үеийг хэлнэ
 - Жирэмсний 22 долоо хоногтойгоос төрсний дараах эхний 7 өдөр (168 цаг)
 - Жирэмсний 28 долоо хоногтойгоос төрсний дараа 7 өдөр
 - Үр хөврөл бүрэлдэн тогтсоноос төрөх хугацаа хүртэл
 - Жирэмсний 22 долоо хоногтойгоос ураг төрж гарах хүртэл
43. Ургийн зүрхний цохилтыг чагнахад зайлшгүй хамааралтайг нэрлэнэ үү?
- Жирэмсний 12 долоо хоногтойгоос чагнана
 - Төрөлтийн 1- үед цаг тутамд чагнана
 - Хүйн баруун дээр тод сонсогдоно
 - Фонендоскопоор илүү сайн сонсогдоно
 - Дүлэлт болгоны дараа чагнана
44. Дутуу төрөлт гэдэгт аль хугацаа хамаарах вэ?
- Жирэмсний 20 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
 - Жирэмсний 22 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
 - Жирэмсний 24 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
 - Жирэмсний 26 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
 - Жирэмсний 28 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
45. Ихэр жирэмсэн үед хамгийн элбэг тохиолддог хүндрэлийг нэрлэнэ үү?

- A. Илүү тээлт
 - B. Ургаас урагт цус юүлэгдэх
 - C. Дотоод халдвар
 - D. Умай урагдах
 - E. Эмнэл зүйн уйтан аарцаг үүсэх
46. Ихэр жирэмсэн үед кесар хагалгаа хийх заалтыг нэрлэнэ үү?
- A. Хоёр ураг хоёулаа толгойгоороо түрүүлсэн бол
 - B. 3 ихэр бол,эхний ураг жирэмсний хугацаанд хөндлөн байх
 - C. Хоёр ургийн урьдчилсан жин 6 кг
 - D. Дихориан болон диамнион бүрхүүлтэй
 - E. Ургийн шингэн цагаас урьтаж гарсан
- 47.Эх барихын хярзанд аль хэсэг хамрах вэ?
- A. Ахар сүүл арын заадасны хоорондох хэсэг
 - B. Хошног ахар сүүлний хооронд
 - C. Бэлгийн уруулын арын заадас болон хошногоны амсарын хооронд
 - D. Умдагны доод ирмэгээс хошногоны амсар хүртэл
 - E.Шээсний сүвнээс хошногоны амсар хүртэл
48. Жирэмснийг оношлох Горвиц-Гегарын шинж
- A. Жирэмсэлснээс умай зөөлөрнө
 - B. Дотуур үзлэгээр умай амархан агшиж хатуурна
 - C. Умайн хүзүүвч орчим илүү зөөлөрнө
 - D. Умай урагш нугаларна
 - E. Жирэмсний хожуу үед илэрнэ
49. Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?
- A. Биений юм ирсэн 3 дахь өдөр.
 - B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 - C. 12 долоон хоног буюу 3 сар тутамд 1 удаа булчинд тарина.
 - D. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 - E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.
50. Жирэмснээс хамгаалах депо-провераг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?
- A. Биений юм ирсэн 3 дахь өдөр.
 - B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 - C. 12 долоон хоног буюу 3 сар тутамд 1 удаа булчинд тарина.
 - D. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 - E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.
51. Умайн ерөндөгийг хэдийд тавих нь тохиромжтой вэ?
- A. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 - B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 - C. 12 долоон хоног буюу 3 сар тутамд 1 удаа булчинд тарина.
 - D. Биений юм ирсэн 3 дахь өдөр..
 - E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.
52. Жирэмслэлтээс хамгаалахын тулд бэлгэвчийг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?
- A. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 - B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 - C. 12 долоон хоног буюу 3 сар тутамд 1 удаа булчинд тарина.
 - D. Биений юм ирсэн 3 дахь өдөр..
 - E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.
53. Леопольдын 2-р барилаар юуг тодорхойлох вэ?
- A. Ургийн байрлал
 - B. Ургийн түрүүлсэн хэсэг
 - C.Ургийн нуруулалт
 - D.Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийг орох хэсэгт тавигдсан эсэх
 - E.Ургийн зүрхний цохилт

Тохиолдол

25 настай давтан төрөгч эмэгтэй 3650 гр хүү төрүүлсэн, төрөлтийн 1 үе 6 цаг 2-р үе 30 хором үргэлжилсэн, хойтохийг идэвхитэй аргаар гаргасан. Ихэс шалгахад бүтэн байсан. Төсрний дараа иллэг хийхэд доош цус гарч 500 мл болсон.

3.Төрсөн эмэгтэйд ямар асуудал тохиолдсон байж болох вэ?

- A. Ихэс үлдсэн.
- B. Умайн агшилт суларсан
- C. Умай урагдсан
- D. ДВС
- E. Умайн хүзүү урагдсан

4.Дээрхи эмэгтэйд ямар арга хэмжээ авах вэ?

- A. Умайд чихээс хийнэ
- B. Умайн хөндийг багажаар хусна
- C. Умайн хөндийг гараар шалгаж иллэг хийнэ
- D. Цус сэлбэнэ
- E. Ажиглана

5. Жирэмсний эргэлзээ төрүүлэх шинжүүдийг нэрлэ?

- 1.Огиулж бөөлжих, хоолонд дургүй болох
- 2.Нүүр хөхний товч тойроод, хэвлийн гол шугамаар нөсөөжинө
- 3.Амт үнэрийн мэдрэхүй өөрчлөгдөнө.

4.Хөх томорно

5.Биений юм ирэхгүй болно

6.Жирэмсэн байж магадгүй шинжүүд нэрлэ?

- 1.Биений юм ирэхгүй болох
- 2.Үтрээний үүдэвчийн салст зузаарч хөхрөнө
- 3.Хөх томорно

4.Амт үнэрийн мэдрэхүй өөрчлөгдөнө

5.Огиулж бөөлжих, хоолонд дургүй болох

7. Анхлан төрөгчдөд умайн хүзүү нээгдэх хурдыг заана уу

- A. Цагт 0,5 см
- B. Цагт 1 см
- C. Цагт 1,2 см
- D. Цагт 1,5см
- E. Цагт 2 см

Тохиолдол 11-12. Үтрээний үзлэгээр: умайн хүзүү бүрэн нээгдсэн, ургийн бүрхүүл халсыггүй, түрүүлсэн хэсэг толгой, бага аарцагт 2/5 тавигдсан, суман заадас баруун ташууд, бага зулай умдагны зүүн талд, мысд хуруу хүрэхгүй байна.

11.Дээрхи тохиололд ямар толгойн тавилт байгааг тодорхойл:

- A.Өвөр янз дагз түрүүлэлт
- B.Арын янз дагз түрүүлэлт
- C.Толгойн оройн түрүүлэлт
- D.Дух түрүүлэлт
- E.Тэнхлэгийн бус тавилт

12.Дээрхи тохиололд төрөлт хэвийн явагдах боломжтой юу?

- A.Боломжтой
- B.Боломжгүй
- C.Окситоцины дэмжлэгтэй бол болно
- D.Вакуум таталтаар бол болно
- E.Зөвхөн кесар хагалгаагаар болно

13. Эмнэл зүйн уйтан аарцгийг оношлох аргуудыг нэрлэнэ үү

- 1.Ургийн байдлаар
- 2.Эмнэл зүйн илрэлээр
- 3.Умайн базлалтын хүчээр
- 4.Вастены шинжээр
- 5.Эхийн аарцгийн хэмжээгээр
- E.Дээрхийн аль аль нь байж болно үргэлжилдэг

24. Эх барихын тусгайлсан асуумжаар юуг тодруулах вэ?

1. Жирэмслэлт, төрөлтийн тоо
2. Түрүүчийн жирэмслэлт, төрөлтийн явц хүндрэл
3. Сүүлчийн сарын тэмдэг
4. Төрүүлсэн хүүхдийн жин, амьд эсэх, гарсан хүндрэл
5. Эх барихын ба эмэгтэйчүүдийн ямар нэг мэс ажилбар хийлгэж байсан эсэх

25. Төрөлтийн 1-р үеийн сувилгааны тусламжийг нэрлэнэ үү?

1. Цэвэрлэх клизм тавих
2. Ургийн зүрхний цохилтыг 30 мин тутамд хянана
3. Давсгийг 2 цаг тутамд суллаж байхыг төрөгч эхэд зөвлөнө
4. Төрөгч эмэгтэй бүрийг халдвараас сэргийлж шүршүүрт оруулна
5. Хувийн ариун цэврийг сахиулна.

26. Хэвийн төрөлтийн 1-р үед дараах үзүүлэлтийг заавал хянаж тэмдэглэнэ

1. Умайн базалтыг 10 хором тутамд үзэх
2. Ургийн зүрхний цохилтыг 30 хором тутамд сонсох
3. Артерийн даралт, пульсыг 2 цаг тутамд үзэж тэмдэглэх
4. Умайн хүзүүний байдлыг үнэлэхийн тулд үтрээний үзлэгийг 4 цаг тутамд хийнэ
5. Биеийн халууныг 2 цаг тутамд үзэх

27. Төрөх үед үтрээний үзлэг хийх заалтуудыг нэрлэ?

1. Базлалт бүрийн дараа хийнэ
2. Амаржихаар хүлээн авахад ирэхэд
3. Төрөгч эхийн хүссэнээр нь хийнэ
4. Ургийн шингэн гарсны дараа
5. Төрөлтийн явцад 2 цаг тутамд

28. Төрөлтийн 2-р үеийн асаргаа сувилгаанд юу хамаарах вэ?

1. Орны дэрийг өндөрлөнө
2. Дүлэлт бүрийн дараа УЗЦ-г чагнана
3. Артерийн даралтыг тогтмол хянана
4. Зөв дүлүүлнэ
5. Гадна бэлэг эрхтэнг ариутга

29. Төрөлтийн 3-р үеийн асаргаа:

1. Давсгийг суллана
2. Хэвлийд хүйтэн жин тавина
3. Умайд иллэг хийнэ
4. Нярайг амлуулна
5. Алдсан цусыг хэмжинэ


30. Жирэмсний хожуу гестозын бодит шинж юу болохыг нэрлэнэ үү.

1. А/Д ихсэлт
2. Шингэн баригдах
3. Шээсний гарц багасах
4. Рефлекс нэмэгдэх
5. Ургийн хөгжил баригдах

31. Төрөлтийн 2-р үеийн шинжүүдийг нэрлэ?

1. УОШ гарна
2. Умайн хүзүү бүрэн нээгдэнэ
3. Ургийн толгой цухуйснаас ураг төрснөөр төгсөнө.
4. Умай базлалт тасралтгүй болно
5. Үтрээнээс салсархаг салиа гарна

32. Зурагт үзүүлж буй тусламжыг нэрлэнэ үү?



- A. Цовъяновын 1- арга
- B. Цовъяновын 2- арга
- C. Гар гаргах сонгомол арга
- D. Толгой төрүүлэх Мориссо-Леврейн арга
- E. Мөр төрүүлэх арга

33. Умайн хүзүүг шалгах заалт

1. Давтан төрөгч
2. Төрсний дараа үтрээгээр цус гарсан, умайн агшилт сайн
3. Төрсний дараа үтрээгээр цус гарсан тохиолдол бүрт
4. Тулгар төрөгч бүрт
5. Умайн агшилт сул бол

42. Зуршсан зулбалт дараах тохиолдлуудын алинд нь үүсэх эрсдэлтэй болохыг нэрлэнэ үү

1. Салаа умай
2. Дааврын өөрчлөлт
3. Хромсомын эмгэг
4. Умайн хүзүүний дутмагшил
5. Умайн гялтангийн доороос түрж ургасан хоргүй хавдар

43. Умайн гүйцэтгэх үүргийг тодорхойл?

1. Биений юмны мөчлөгт оролцох
2. Ураг хэвийн өсөлтийг хангах
3. Төрөх үед ургийг хөөх
4. Үр тогтох
5. Өндгөн эс боловсруулах

44. Умайн гуурсны гүйцэтгэх үүргийг тодорхойл?

1. Хамгаалах
2. Үр тогтолт
3. Өндгөн эс боловсуулах
4. Үр тогтсон өндгөн эсийг зөөх
5. Биений юмны мөчлөгт оролцох

46. Төрсөн эхийг үзэхэд үтрээний үзлэгээр үзэхэд үтрээ уужим, умайн хүзүү 1,5 см нээлттэй, умайн ёроолын өндөр хүйснээс доош 3 см байсан бөгөөд учир нь төрсний дараах 3 дахь хоногт үзлэг хийгдсэн.

47. Төрсөн эхийг төрсний дараах 10 дахь хоногт дотуур үзэхэд умай хүзүү хаалттай, бүрэн хэлбэршсэн, умайн ёроолын өндөр умдагны дээд ирмэгт, умайд эмзэглэлгүй байсан бөгөөд тухайн эхийн биеийн байдал хэвийн бус байна.


48. Төрсний дараа аюултай шинжүүдийг нэрлэ?

1. Толгой өвдөж, нүд бүрэлзэх, хүзүү хөших
2. Шавхарга ихээр гарах /цус алдах/
3. Шавхарга эвгүй үнэртэй болох
4. Шавхарга өнгөтэй, бохир ногоовтор болох
5. Чичрүүдэс хүрэх, өндөр халуурах

49. Ураг орчмын шингэн урьтаж гарах гэдэг нь:

- A. Төрөлтийн үйл ажиллагаа эхэлсний дараа
- B. Төрөлтийн үйл ажиллагаа эхлээгүй байхад

- C. Умайн хүзүү 4-5 см нээгдсэн үед
 - D. Умайн хүзүү 5-6 см нээгдсэн үед
 - E. Умайн хүзүү бүрэн нээгдэхээс өмнө
50. Хярзан хамгаалахад хийгдэх үйлдлийг тодорхойл?
1. Толгой цухалзах үеэс эхлэн үзүүлнэ
 2. Гарын алгаар урагдахаас сэргийлж хярзанг аажим сунгана
 3. Үтрээний ханыг 2 хуруугаар сунгаж тэлнэ
 4. Толгой цухуйх үеэс эхлэн үзүүлнэ
 5. Зулайн төвгөр төрөхөд огцом дүлүүлнэ
51. Хярзан сэтлэх заалтыг нэрлэ?
1. Суналт муутай өндөр хярзан
 2. Хярзан урагдахаар завдсан
 3. Дутуу төрөлт
 4. Ураг бүтэлт үүсэж байгаа
 5. Том ураг
52. Өвдөлтгүй төрүүлэх аргын давуу тал юу вэ?
1. Базлалтын хүч сулруулахгүй
 2. Төрөлт удаашруулдаггүй
 3. Хойтох ба төрсний дараах хэвийн явцад нөлөөлөхгүй
 4. Урагт харш нөлөө үзүүлэхгүй
 5. Бүх жирэмсэн эмэгтэйд хэрэглэж болох энгийн байх
63. Хэвийн явцтай давтан төрөлтийн 1-р үед умайн хүзүүний нээлтийн хурд цагт дунджаар хэдэн см байх вэ?
- A. 3с
 - B. 1см
 - C. 1.5см
 - D. 0.5см
 - E. 0.5-1см
64. Төрсний дараа умай хэд дэх хоногт умдагны цаагуур орох вэ?
- A. 7-8 дахь хоногт
 - B. 5-6 дахь хоногт
 - C. 13-15 дахь хоног
 - D. 10-12 дахь хоногт
 - E. 12-14 хоногт
65. Умайн хүзүүний бэлтгэлийн зэргийг дараах шинж чанараар илэрхийлдэг
1. Умайн хүзүүний байрлал
 2. Умайн хүзүүний сувгийн урт
 3. Умайн хүзүүний амсрын хатуу зөөлөн
 4. Умайн хүзүүний нээгдлийн хэмжээ
 5. Умайн хүзүүний толийлт
66. Жирэмсний 2-р хагасаас хойш хугацаанд чанд авиан шинжилгээнд юуг анхаарах вэ?
1. Тархины гол шугамаар Зулай ясны алслагдсан зай
 2. D.biparietalis
 3. Дунд чөмөгний урт
 4. Ихсийн хөгжил
 5. Жирэмслэлтийг оношлох
67. Аль төрлийн биомеханизм бэ? Толгойн ямар тавилт болохыг нэрлэнэ үү, Зурагт ургийн толгой үстэй хэсгийн заагаар умдагт тулсан байна.



- A. Өврийн янзтай дагз түрүүлэлт
- B. Арын янзтай дагз түрүүлэлт
- C. Толгойн оройн түрүүлэлт
- D. Дух түрүүлэлт
- E. Нүүр түрүүлэлт

68. Хэвлийн эргэн тойрон 100 см, умайн ёроолын өндөр 37 см, биеийн өндөр 162 см бол ургийн урьдчилсан жинг тодорхойл:

- A. 2900
- B. 3000
- C. 3200
- D. 3500
- E. 3700

69. Хэвийн төрөлтийн үед физиологи цус алдалт биеийн жингийн хэдэн хувьтай тэнцэх вэ?

- A. 0,3 %
- B. 0,7 %
- C. 0,8%
- D. 0,5 %
- E. 1%

70. Төрөлтийн үйл ажиллагаа сайн байгааг илтгэх шинжийг нэрлэнэ үү

- A. Умайн базлалт 10 хоромд 1-2 удаа базлалт 25 сек үргэлжилж байвал
- B. Умайн базлалт 10 хоромд 3 удаа 20-25 сек үргэлжилж байвал
- C. Умайн базлалт 10 хоромд 3 удаа 40-60 сек үргэлжилж байвал
- D. Умайн базлалт 10 хоромд 4 удаа 80- секундээс илүү үргэлжилж байвал
- E. Умайн базлалт 10 хоромд 5-6 удаа 60-80 сек үргэлжилж байвал

71. Жирэмсэн эхийн зүрх судасны тогтолцоонд гарах физиологийн өөрчлөлтийг нэрлэ?

- A. Органик өөрчлөлт гарна
- B. Зүрхний II цагт диастолын шуугиан илрэнэ
- C. Зүрхний оройд сулавтар агшилтын шуугиан 30%-д нь илрэнэ
- D. Артерийн даралт 20 мм МУБӨ-өөс ихээр ихсэнэ
- E. Зүрхний агшилт 100 удаа болж хурдасна

72. Индекс Соловьевын мөн чанар юу вэ?

- A. Төрөлтөнд бэлтгэгдсэн байдлыг үзнэ
- B. Ясны зузаан, нимгэн байдлыг тодорхойлно
- C. Жирэмсний хугацааг тодорхойлох
- D. Ургийн хөдөлгөөнийг тогтоох арга
- E. Ургийн зүрхний цохилтыг чагнах арга

73. Жирэмсэн эмэгтэйд төмрийн бэлдмэл /60-100 мг /, фолийн хүчлийг /400-800 мкг/ уулгадаг. Учир нь цус багадалтаас сэргийлэх болон ургийн мэдрэлийн гажгаас сэргийлдэг.

74. Жирэмсний хяналтын явцад хэвийн бол 3 удаа, эрсдэлтэй бол 4 удаа зайлшгүй үзэж хянах шаардлагатай. Учир нь ЭМС-ын 338-р тоот тушаалын дагуу хянадаг.

75. Жирэмсний эрт үеийн цус алдалтанд зулбалт хамаардаг бөгөөд зулбалтыг эмнэлзүйгээр нь өөрөө аяндаа, зориудын гэх зэргээр ангилдаг.

76. Манас таталтын урьдлын хүнд хэлбэрийн үед магнийн сульфатыг цохилтын тунгаар хэрэглэх ёстой. Яагаад гэвэл манас таталтын хүнд хэлбэр нь цааш даамжирвал эклампси буюу таталт үүсэх аюултай.

77. Жирэмсний тээлтийн 41-42 долоо хоног нь илүү тээлтэнд хамаардаг бөгөөд илүү тээх тусам урагт сайн, төрөлтийн хүндрэл гарах нь багасдаг.

78. Пре-эклампсийн хөнгөн хэлбэрийн үед артерийн даралтыг бууруулах шаардлагагүй бөгөөд АД бууруулах зорилгоор жирэмсэн эхэд нифедипин эмчийн зөвлөснөөр уулгах хэрэгтэй.

79. Ургийн зүрхний цохилт хүйснээс дээш сонсогдох нь ураг буруу байрлалтай байж болно. Яагаад гэвэл энэ үед түрүүлсэн хэсэг нь өгзөг байдаг.

80. Умайн хүзүүг төрөх замаар төрсөн эх бүрт шалгах ёстой. Учир нь давтан төрөгч эхэд төрөх замаас цус алдаж байвал төрөх замыг багажаар шалгах заалттай.

81. Ургийн хөгжил баригдах хам шинжийн үндсэн шалтгааныг нэрлэнэ үү?

1.Жирэмсэн эхийн артерийн даралт ихсэх эмгэг

2.Архи хэрэглэх

3.Мансууруулах бодис хэрэглэх

4.Тамхидалт

5.Бүгд зөв

82. Жирэмсэн ба төрөлтийн үед хэдийд зүрхэнд ачаалал учруулах вэ?

1. Жирэмсэн болмогц зүрхэнд ачаалал учирна

2. Жирэмсний 2-32 долоо хоногтойд

3. Төрсний дараах 7 хоногт

4. Төрлөгийн 3-р үед

5. Төрснөөс хойш 10 хоногт

83 Жирэмсний хожуу хугацаанд хэрлэгийн идэвхжилээс хамаарч жирэмсэнг таслах заалт

1. Зүүн ховдол тосгуурын нүхний III, IV зэргийн нарийсал

2. Мерцаль хэм алдагдалтай

3. Стенокардийн байнгын хурцдал

4. Зүрхний оройд үйл ажиллагааны агшилтын шуугиантай

5. Артерын даралт 1,33 кПа-гаар ихсэх

84. Пиелонефритийн үед гарах лабораторийн шинжилгээний өөрчлөлтийг заана уу?

1. Шээсний нягтрал /Зимницкийн сорил/ багасна эсвэл хэвийн байна

2. Нечипоренкогийн аргаар шээсний шинжилгээ хийхэд цагаан цогцосны тоо олширно

3. Бортгон эс маш олноор ялгарна

4. Бортгон эс ялгарах нь ховор

5. Шээсэнд улаан бөөм ялгарна

85. Гломерулонефритийг үүсгэдэг голлох өвчин юу вэ?

1. Бахлуур /ангина/

2. Улаан эсэргэнэ

3. Арьсны идээт өвчин

4. Вирус гепатит

5. Дайварын архаг үрэвсэл

86. Төмрийн шимэгдэлтийг сайжруулдаг хоол хүнсний бүтээгдэхүүнийг тооч ?

1. Үхэр загасны мах, өндөг

2. Амин дэм E,C,

3. Зарим хоол амтлагч /цуу/

4. Аскорбины хүчил, ногоо жимс

5. Фитат агуулсан бүтээгдэхүүн /дээд гурил, вандуй гэх мэт /

87. Төрсний дараа умайд 2 цагийн турш, Эхний 1 цагт 15 мин тутамд, дараагийн 1 цагт 30 мин тутамд массаж хийх ёстой. Учир нь төрөлтийн 2-р үед УЗЦ-ыг дүлэлт бүрийн дараа чагнадаг.

88. Алдсан цусыг хэмжих шаардлагагүй бөгөөд хэр хэмжээний цус алдсаныг зөв тооцоолвол цаашдын эмчилгээ, оношлогоонд чухал ач холбогдолтой.

89. Хойтохын үеийг идэвхитэй удирдах нь төрлөгийн 3-р үеийг богиносгодог. Учир нь энэ арга нь цус алдалтаас сэргийлдэг.

90. Магнийн сульфатын цохилтын тун хийгдсэний дараа эхийг хянах шаардлагагүй АД буурдаг. Учир нь магнийн сульфатын хордлого үүсвэл антидот болох кальци глюконат хэрэглэнэ.

91. Бага аарцгийн хөндийн өргөн хэсгийн хэмжээнүүд аль нь вэ?

1.Нэргүй шугамын алслагдсан зай 13см

- 2.2 талын сүүжний хонхоруудын дотор зай 12,5см
3.Хоёр талын суудлын төвгөрүүдийн хоорондох зай 11см
4.Умдагны үений дунд дотор голоос ууцны 2,3 үеийн зааг хүртэл 12,5см
5. Умдагны үений дунд дотор голоос ууц ахар сүүлний үе хүртэл 11,5см
92. Хүй унжих шалтгааныг нэрлэ?
A.Ургийн бүтэлт
B.Шүргэлцэх бүслүүр үүсээгүй байх
C.Төрөх хүчний сулрал
D.Уйтан аарцаг
E.Ихэс ховхрох
93. Дутуу төрөлт гэдэгт аль хугацаа хамаарах вэ?
A.Жирэмсний 20 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
B.Жирэмсний 22 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
C.Жирэмсний 24 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
D.Жирэмсний 26 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
E.Жирэмсний 28 долоо хоногтойгоос 37 долоо хоног хүртэл
94. Жирэмсний эрт хугацаанд аяндаа зулбах үндсэн шалтгааныг нэрлэнэ үү?:
A.Цусны бүлгийн үл тохироо
B.Хүнд юм өргөх
C.Умайд соривтой байх
D.Хромосомын гажиг
E.Умайн хүзүүний дутмагшил
95. Жирэмсэн магадгүй байхад толины шинжилгээгээр ямар өөрчлөлт илэрх вэ?
1. Үтрээний салст хөхөлбий болох
2.Умайн хүзүүнээс салиархаг ялгадас элбэг гарах
3.Умайн хүзүүний салст хөхөлбий
4.Үтрээний ялгарлын хэмжээ нэмэгдэх
5. Үтрээний үүдэвчний салст ягаан болох
96. Ихэс түрүүлэлтийн үед илрэх эмнэл зүйн гол шинжийг нэрлэнэ үү?:
A.Умай чангарч, хоёр тал жигд биш, эмзэглэлтэй
B.Удаан хугацаагаар их хэмжээтэй цус алдах
C.УЗЦ байхгүй болох
D.Умай чангаралгүй, шалтгаангүйгээр улаан ягаан цус гарах
E.Дотор муухай оргиж бөөлжих
97. Хэвийн байрласан ихэс цагаас өмнө ховхрох үед илрэх онцлог шинжийг нэрлэнэ үү?:
A.Умай чангарч, тэмтэрхэд эмзэглэлтэй болно
B.Ургийн байдалд өөрчлөлт илрэхгүй
C.Амьсгал авахад төвөгтэй амьсгаадна
D.Ургийн буруу байрлал үүснэ
E.АД ихдэнэ
?
- A.Умайг багажаар хусаж цэвэрлэнэ;
B.Антибиотик эмчилгээ хийнэ
C.Эмнэлэгт хэвтүүлнэ
D.Гэрээр хяналтанд байлгана.
E.Мизопростол уулгана
99. Хэвийн байрласан ихэс цагаас өмнө ховхролтыг оношлох хамгийн ач холбогдолтой арга аль нь вэ?
A.Эх барихын гадуур үзлэг
B.Үтрээний үзлэг
C.Хэт авиан оношилгоо
D.Ургийн зүрхний үйл ажиллагааг үнэлэх
E.Цусны бүлэгнэлтийг тодорхойлох
100. Ураг бөгсөөр түрүүлсэн үед ургийн зүрхний цохилт хаана тод сонсогдох вэ?
A. Эхийн хүйсний баруун эсвэл зүүн талд
B. Эхийн хүйсний баруун талд

- С. Эхийн хүйсний зүүн талд
 D. Эхийн хүйснээс дээр
 E. Эхийн хүйснээс доор
101. Өмнөх төрөлтөндөө Кесар хагалгаа хийлгэсэн жирэмсэн эхийг хэзээ хэвтүүлэх вэ?
 A. Төрөлтийн үйл ажиллагаа эхлэнгүүт
 B. Ургийн шингэн гарангуут
 C. Төрөхөөс өмнө 1 сарын өмнө
 D. Төрөхөөс өмнө 7-10 хоногийн өмнө
 E. Төрөхөөс өмнө хэвтүүлэх шаардлагагүй
102. Умайн гадуурх гуурсан хоолойн жирэмсний үед хоолой хэдэн долоо хоногтой байхад ихэвчлэн хагарах вэ?
 A. Жирэмсний 10-11 долоо хоногтой
 B. Жирэмсний 9-10 долоо хоногтой
 C. Жирэмсний 6-7 долоо хоногтой
 D. Жирэмсний 3-4 долоо хоногтой
 E. Жирэмсний 1-2 долоо хоногтой
103. Умайн гадуурх жирэмсний үед хамгийн эрт илрэх шинж тэмдэг юу вэ?
 A. Цус багадалт шинжүүд
 B. Бөөлжилт илрэх
 C. Сарын тэмдэг хоригдох
 D. Сарын тэмдэг хоригдоогүй
 E. Артерийн даралт багасах
104. Ургийн толгой бага аарцгийн гарах хэсэгт байгааг илтгэх шинжийг заа?
 1. Гадуур үзэлгээр барьж үзэхэд ургийн толгой баригдахгүй -0/5%
 2. Суудал ясны сэртэнд хуруу хүрэхгүй
 3. Умдаг ясны дотор бүх гадаргууг толгой эзэлсэн
 4. Суман заадас гарах хэсгийн шулуун хэмжээнд давхацсан
 5. Умайн хүзүү бүрэн нээгдсэн
105. Жирэмсний хожуу хордлогын үед үүсэх эмгэг жам хэрхэн явагдах вэ?
 A. Судсууд тархмал өргөсч, нэвчимтгий чанар нь нэмэгдэнэ.
 B. Тараагуур судас нь агшиж, нэвчимтгий болж, эрхтнүүдийн үйл ажиллагааны дутагдал илэрнэ.
 C. Судсуудын агшилтанд өөрчлөлт орохгүй нэвчимтгий болно.
 D. Цусны бүлэгнүүлэх систем эхлээд өөрчлөгдөж тромб үүснэ.
 E. Судсуудад ямарч эмгэг илрэхгүй
106. Ургийн уушигны хөгжлийг сайжруулах зорилгоор хийх эмчилгээнд аль нь хамаарах вэ?
 A. Сульфат магни
 B. Агчил тавиулах
 C. Глюкокортикоид
 D. Кальц хлорид
 E. Даралт бууруулах эм
107. Умайн хүзүүний II зэргийн урагдалд тооцохыг заа?
 A. 2 талдаа 1 см хүртэл урагдсан
 B. 1 талдаа 3 см хүртэл урагдсан
 C. Хүнхрээ хүртэл урагдсан
 D. Умайн хүзүү язарсан
 E. 2 талдаа хүнхрээ хүртэл урагдсан
108. Умайн агшилт суларч цус алдахад доорхи шалтгаануудын аль нь нөлөөтэй вэ?
 1. Олон төрөлт
 2. Төрөх хүчний эмгэг
 3. Умайн хана хэт сунах
 4. Жирэмсний хожуу хордлого
 5. Дутуу төрөх
109. Дайрлагын индексийг тодорхойлно уу?
 A. Судасны цохилтыг агшилтын даралтанд харьцуулна
 B. Судасны цохилтыг сулралтын даралтанд харьцуулна
 C. Судасны цохилтыг даралтын их, багын зөрөөний даралтанд харьцуулна

- D. Судасны цохилтыг чамархайн артерийн даралтаар харьцуулна
 E. Артерийн даралтаар тодорхойлно
110. Төмөр дутагдлын цус багадлыг лабораториор батлахад юуг анхаарах вэ?
 A. Гемоглобин 110 г/л-ээс доош бууна
 B. Цусан дахь төмрийн хэмжээ 10,7 ммоль/л хүртэл багасна
 C. Гематокрит 33 хувиас доош багасна
 D. Өнгө илтгэгч 0,85-аас бага байна
 E. Эритроцитын тоо цөөрнө
111. Төмрийн бэлдмэлийг хэвийн явцтай жирэмсэнд яаж уулгах вэ?
 A. Жирэмсний турш өдөрт хагас шахмалыг ууна.
 B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын туршууна.
 C. Жирэмсний турш өдөрт 1 шахмалыг ууна
 D. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсний туршууна.
 E. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш, залгаад жирэмсний турш 1 шахмалаар ууна.
112. Төрөлтийн 2-р үеийн шинж:
 1. УОШ гарна
 2. Умайн хүзүү бүрэн нээгдэнэ
 3. Базлалт тасралтгүй болно
 4. Умай базлалт жигдэрнэ
 5. Үтрээнээс салсархаг салиа гарна
113. Ихэр жирэмсэн үед хамгийн элбэг тохиолддог хүндрэлийг нэрлэнэ үү:
 A. Илүү тээлт
 B. Ургаас урагт цус юүлэгдэх
 C. Дотоод халдвар
 D. Умай урагдах
 E. Эмнэл зүйн уйтан аарцаг үүсэх
114. Амниоцинтес хийх заалтыг нэрлэ?
 1. 35- аас дээш насны эмэгтэйчүүд
 2. Гэр бүлд нь сэтгэцийн эмгэгтэй хүүхэдтэй бол
 3. 3 болон түүнээс олон үр аяндаа зулбаж байсан бол
 4. Өмнөх жирэмсний үед ургийн ус их болон бага байсан
 5. Ихэр жирэмсний удамтай бол
115. Ихэс түрүүлэлтийн үед илрэх эмнэл зүйн гол шинжийг нэрлэнэ үү.
 A. Умай чангарч, хоёр тал жигд биш, эмзэглэлтэй
 B. Удаан хугацаагаар их хэмжээтэй цус алдах
 C. УЗЦ байхгүй болох
 D. Умай чангаралгүй, улаан ягаан цус гарах
 E. Дотор муухай оргиж бөөлжих
116. Дутуу төрөлтөнд хүргэж болох эрсдэлийг нэрлэнэ үү
 1. Өдөрт 10 түүнээс олон ширхэг тамхи татдаг
 2. Ихэр жирэмсэн
 3. Умайн бүтцийн өөрчлөлт нь оношилогдсон
 4. 30 –аас дээш настай эмэгтэй
 5. 4 < удаа төрсөн эх.
117. Өвдөлтгүй төрүүлэх аргад тавигдах шаардлага юу вэ?
 1. Базлалтын хүч сулруулахгүй
 2. Төрөлт удаашруулдаггүй
 3. Хойтох ба төрсний дараах хэвийн явцад нөлөөлөхгүй
 4. Урагт харш нөлөө үзүүлэхгүй
 5. Бүх жирэмсэн эмэгтэйд хэрэглэж болох энгийн байх
118. Удам зүйн зөвлөгөө авах заалтыг нэрлэнэ үү:
 1. 35 ба түүнээс дээш нас
 2. Цусан төрлийн ахан дүүс
 3. Зуршсан дутуу тээлт
 4. Ургийн гаж хөгжилтэй хүүхэд төрүүлсэн
 5. Тамхи татдаг эмэгтэйчүүд

119. Бүтцийн уйтан аарцгийг тодорхойлох аргыг нэрлэнэ үү:

1. Аарцгийн хэлбэр
2. Ясны зузаан
3. Уйтралын зэрэг
4. Ууцны байдал
5. Ургийн толгой эхийн аарцгийн харьцаа

120. Төрсний дараах умайн агшилтыг сайжруулах эмийн бэлдмэлийг нэрлэнэ үү.

1. Окситоцин
2. Метилэргометрин
3. Мизопростол
4. Динопрост
5. Мифепристон

121. Урагт бүтэлт үүссэн шинжийг нэрлэ.

1. Ургийн ус зунгагтай гарах
2. Ургийн хөдөлгөөн буурах
3. УЗЦ 1 хоромд 170 удаа
4. КТГ хожуу децелераци
5. КТГ д түргэсэл байхгүй байх

122. Умайн хүзүүг шалгах заалтад юу хамаарах вэ?

1. Төрсний дараа үтрээгээр цус гарсан, умайн агшилт сайн
2. Давтан төрөгч
3. Тулгар төрөгч бүрт
4. Төрсний дараа үтрээгээр цус гарсан тохиолдол бүрт
5. Умайн агшилт сул бол

123. Дутуу төрөлтийн үед тохиолдох хүндрэлийг нэрлэ.

1. Ургийн шингэн гарах
2. Төрөх хүч сулрах
3. Дутуу төрөлт
4. Хорионамнионит
5. Ургийн буруу байрлал

124. Ургийн нуруулалтын янзыг нь юу гэж ангилах вэ?

1. Зүүн
2. Өврийн
3. Баруун
4. Арын
5. Хажуугийн

125. Илүү тээлтийн эмнэлзүйн шинжийг нэрлэнэ үү.

1. Ургийн шингэнд зунгаг гарах
2. Толгойн яс хатуурах
3. Ургийн тосон бүрхүүл арилах
4. Ургийн толгойд хавдар үүсэх
5. Ихэс зузаарах

126. Өгзөг түрүүлэлтийн үед үүсэж болох хүндрэлүүдийг нэрлэ.

1. Ургийн шингэн хугацаанаас өмнө гарах
2. Төрөлтийн үйл ажиллагаа хямрах
3. Хүй унжих
4. Гар гэдийх
5. Ихэс цагаас өмнө ховхрох

127. Хожуу хордлого үүсэх механизмыг тайлбарлана уу.

1. Олон эрхтний дутмагшил
2. Тархи хавагнах
3. Цусны бичил алдагдах
4. Судасны эндотелийн үйл ажиллагаа хямрах
5. ДВС

128. Өртөмтгийн хүчин зүйлүүдийг нэрлэнэ үү?

1. Эрхтэн тогтолцооны эмгэгийн өчил
 2. Эх барихын ужиг дурьдатгал
 3. Нийгэм биологийн хүчин зүйлийн дурьдатгал
 4. Тухайн жирэмсний хүндрэл
 5. Хожуу анхан төрөгч
129. Хожуу хордлогын үндсэн шинжүүдийг нэрлэ.
- 1.Хаван
 - 2.Шээсээр уураг ялгарах
 - 3.Даралт ихсэх
 - 4.Таталт
 - 5.Нойргүйдэл
130. Төрсний дараа умайн салстын үрэвсэлүүсэх шалтгааныг нэрлэнэ үү.
- 1.Архаг халдварын голомт
 - 2.Кесар хагалгаа
 - 3.Төрөлт 24 цагаас дээш хугацаагаар үргэлжилсэн
 - 4.Үтрээний үзлэгийг 5 ба түүнээс олон хийсэн
 - 5.Олон удаа үр хөндүүлж байсан
131. Хожуу зулбах шалтгаан юу вэ?
- 1.Умайн хүзүүний сувгийн дутмагшил
 - 2.Умайн дутуу хөгжил;
 - 3.Андроген дааврын ихсэл
 - 4.Хромосомын гажиг.
 - 5.Үтрээний үрэвсэл
132. Зулбах шалтгааныг нэрлэнэ үү.
- 1.Халдвар
 - 2.Умайн хүзүүний дутмагшил
 - 3.Гэмтэл
 - 4.Цацраг туяа
 - 5.Хромосомын гажиг
133. Манас таталтын эсрэг магни сульфатыг ямар байдалд хэрэглэх вэ?
- 1.Хуурай бодис 14,0
 - 2.Барих тун 10,0 –аар 4 цаг тутамд
 - 3.Амьсгал 1 хоромд 14 өөс цөөрвөл зогсооно
 - 4.Сүүлийн таталтаас хойш 48 цаг үргэжлүүлнэ
 - 5.Тархи хавагнасан үед
134. Үтрээний арын хүнхрээгээр хатгалт хийх заалтыг нэрлэнэ үү.
- 1.Хожуу хордлого
 - 2.Өндгөвчийн идээт үрэвсэл
 - 3.Ихэс түрүүлэлт
 - 4.Умайн гаднах жирэмсэн
 - 5.Умайн хоргүй хавдар
135. Умайн хөндийг гараар шалгах заалтыг нэрлэнэ үү.
- 1.Төрөлтийг простогландинаар сэдээсэн үед
 - 2.Төрөлт удаан үргэлжилсэн үед
 - 3.Ураг өгзгөөр төрсөн үед
 - 4.Соривтой умай төрөх замаар төрсөн үед
 - 5.Том ураг төрүүлсэн үед
136. Төрсний дараа умайн агшилтын байдлыг хэрхэн хянах вэ?
- 1.Хэт авиан оношилгоогоор
 - 2.Үтрээний үзлэгээр
 - 3.Умайн ёроолын өндрийг хэмжих замаар
 - 4.Шавхарганы байдлаар
 - 5.Төрсний дараах хоногоор
137. Хэвийн байрласан ихэс цагаас өмнө ховхроход илрэх шинжийг нэрлэнэ үү.
- 1.Умайн булчинд цус хурах
 - 2.Цус алдалтын дайрлага
 - 3.Ураг амьгүй болох

4.ДВС үүсэх

5.Умай агшилтгүй болох

138. Окситоцины эрчимжүүлэг хийж байхад базлалт 80 секундээс илүү хугацаагаар үргэлжилж, 10 хоромд 5-өөс илүү базалбал юу гэж үзэх вэ?

1.Эрчимжүүлэг үр дүнтэй сайн байгааг илтгэнэ.

2.Хэт цочрол үүссэний шинж.

3.Цаашид тунг нэмэлгүйгээр үргэлжлүүлнэ

4.250 мкг тербуталиныг 5 хормын туршид судсаар аажим тарина

5.Онцгой хяналтанд байлгана

139. Ураг хөндлөн байрласан үед ургийн зүрхний цохилт хаана тод сонсогдох вэ?

A. Эхийн хүйнээс доор

B. Эхийн хүйнээс дээр

C. Эхийн хүйн баруун эсвэл зүүн талд

D. Эхийн аюулхай орчим

E. Умдаг ясны орчим

140.Төрсний дараа цус алдалтанд хүргэж болох шалтгааныг нэрлэнэ үү.

1.Биеийн хүчний хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүд.

2.Төрөлт удаан үргэлжлэх

3.Харьцангуй жин багатай эх

4.Ихэр жирэмсэн

5.Ургийн хөндлөн байрлал

141. Пиелонефриттэй жирэмсэнд шээсний ерөнхий шинжилгээнд ямар өвчлөлт илрэх вэ?

1. Шээсэнд нян илрэх- Бактериури

2.шээсэнд уураг ялгарах-протейнури

3.Шээсэнд цагаан цогцос илрэх-лейкоцитури

4. Шээсэнд бортгон хучуур илрэх-Цилиндрури

5. Шээс цустай гарах- Гематури

142. Жирэмсэн эмэгтэйн биед гарах физиологийн онцлог юу вэ?

1.Зүрний ачаалал нэмэгдэнэ

2.Уушигны агааржуулалт нэмэгдэнэ

3.Хүчилтөрөгчийн хэрэгцээ нэмэгдэнэ

4.Амьсгал авах үеийн уушигны эзэлхүүн нэмэгдэнэ

5.Уушигны үйл ажиллагааны үлдэгдэл эзэлхүүн нэмэгдэнэ

143. Аарцгийн хэвийн хэмжээг нэрлэнэ үү.

A.22-25-29-18 см

B.25-28-31-20 см

C.27-27-29-18 см

D.23-25-28-17 см

E.25-28-30-17 см

144.Төрөлт эхэлсэн гэж тооцох шинжүүдийг нэрлэ.

A.Ургийн шингэн гарснаар

B.Ургийн толгой доошилсноор

C.Умайн хүзүү бэлтгэгдснээр

D.Жигд базалж эхэлснээр

E.Умайн ёроол доошилж амьсгал авахад чөлөөтэй болсноор

151-155 C. 19 настай. Жирэмсний хяналтандаа орсон, 13-14 долоо хоногтой. Төрөх газар толгой хүчтэй өвдөнө, хавагнана, дотор муухай оргино, үтрээнээс бага зэрэг цусархаг зүйл гарна гэсэн зовиуртай ирсэн. Бодит үзлэгээр: А/Д 2 гарт 150/110 мм.муб, умайн ёроол хүйснээс доош 2 хуруу тэмтрэгдэнэ.

151. Дээрхи зовиураас хамгийн эхэнд таамаглаж буй оношийг нэрлэнэ үү.


A. Ихэс түрүүлэлт

B. Эхэлсэн хожуу зулбалт

C. Архаг даралт ихсэлт

- D. Жирэмсэн үеийн даралт ихсэлт
- E. Цулцан хураа

152. Хэт авиан оношлогоо хийхэд дараах зураглал илэрсэн байна



Зургийг хараад та юу гэж таамаглаж байна вэ?

- A. Жирэмсэн, умайн хоргүй хавдартай
 - B. Цулцан хураа
 - C. Өсөлтгүй жирэмсэн
 - D. Ихэс түрүүлэлт
 - E. Бүрэн биш зулбалт
153. Дээрхи эмгэг үүсэхэд нөлөөлөх гол шалтгааныг нэрлэнэ үү.
1. Олон дахин үр хөндөлт хийлгэсэн
 2. Олон зулбасан
 3. Умайн соривжилт өөрчлөлттэй
 4. Хромосомын эмгэг
 5. Эрхтэн тогтолцооны эмгэгтэй
154. Дээрхи тиохиолдолд ямар тусламж үзүүлэх вэ?
- A. Умайн хөндийг хусаж цэвэрлэнэ
 - B. Шууд мэс засал хийнэ
 - C. Жирэмслэлтийг үргэлжлүүлэн умайн булчинг сулруулах эмчилгээ хийнэ
 - D. Умайг авах мэс засал хийнэ
 - E. Эмийн аргаар зулбуулна.
155. Цаашид ямар арга хэмжээ авах вэ?
- A. Цаашид сар тутам хэт авиан шинжилгээ хийж хянана
 - B. 7 хоног тутам ХГД түвшинг тогтооно
 - C. Сард 1 удаа ХГД тодорхойлно
 - D. Ердийн хяналтанд 3-6 сар хянана
 - E. Жирэмслэхээс хамгаалж шууд ерөндөг тавина.

Тохиолдол. 38 настай. 8 сартай жирэмсэн, сүүлийн үед Артерийн даралт 2 гарт 140/90, 150/100 хүртэл нэмэгдсэн, 2 хөлөөр бага зэрэг хавагнасан байна. Шээсний шинжилгээ хийхэд хоногийн шээсэнд уураг (+).

156. Таны урьдчилан тавих онош юу вэ?

- A. Архаг даралт ихсэлт
- B. Жирэмсэн үеийн даралт ихсэлт
- C. Манас таталтын хөнгөн хэлбэр
- D. Манас таталтын дунд хэлбэр
- E. Манас таталтын хүнд хэлбэр

157. Энэхүү жирэмсэн эмэгтэйд даралт ихсэхэд хүргэх шалтгааныг нэрлэнэ үү

1. Эрхтэн тогтолцооны архаг өвчин
2. Ихэр жирэмсэн
3. Удамшил
4. Нас
5. Ургийн хүйс

158. Нэмэлт ямар шинжилгээ хийлгэх шаардлагатай вэ?

1. Цусанд уураг

- 2.Тромбоцит
- 3.Лактодегидрогеназа
- 4.Креатинин
- 5.Билирубин

159.Дээрхи тохиолдолд жирэмсэн эмэгтэйд хэрэглэх эмийг нэрлэнэ үү.

- 1.Магний сульфат цохилтын тунгаар
- 2.Диазепам
- 3.Гидролазин
- 4.Метилдопа
- 5.Партусистен

160.Жирэмсний үед А/Д ихдэхэд урагт хамгийн элбэг тохиодох хүндрэлийг нэрлэнэ үү.

- 1.Ургийн гипотропи
- 2.Ургийн хөгжил баригдах хам шинж
- 3.Ураг амьгүй болох
- 4.Ургийн архаг бүтэлт
- 5.Ургийн цус багадалт

Тохиолдол. Х. 33 настай 2 хүүхэд төрүүлсэн өмнө нь жирэмслэхээс хамгаалах ерөндөг хэрэглэж байсан. Өрхийн эмчид ГБТ –ийн дааврын хавсарсан эм хэрэглэх хүсэлтэй тул зөвөлгөө авахаар ирсэн байна.

161.Та эмэгтэйд хэрэглэхэд тохиромжтой эсэхийг тодруулах зорилгоор ямар оновчтой асуумжууд авах вэ?

1. Хэдий хугацаагаар хамгаалах хүсэлтэй байгаа
2. Элэгний архаг үрэвсэлтэй эсэх
3. Тамхи татдаг эсэх
4. Биений юм их хэмжээтэй ирдэг
5. Нас

162.Та дааврын хавсарсан эмний гаж нөлөөлний талаар юу гэж тайлбарлах вэ?

1. 3 сарын завсарлагатай хэрэглэхгүй бол өндгөвчийн үйл ажиллагааны алдагдалд орно
2. Нүүрний арьс нөсөөжих
3. Эмийг удаан хугацаагаар хэрэглэвэл жирэмслэлт сэргэх хугацаа удаан байна
4. Дотор муухай оргих шинж илэрнэ
5. Биений юм их хэмжээтэй ирэх

163.Эмэгтэй 14 хоногийн дараа эмчид эргэж ирэхдээ 3 хоног эм уухаа мартсан цаашид хэрхэх талаар зөвөлгөө авахаар ирсэн

6. Мартсан эмүүдийг орхиод эмээ үргэлжлүүлэн уух
7. Мартсан сүүлийн эмийг санасан цагтаа уугаад, цаашид уух цагтаа эмээ үргэлжлүүлэн ууна
8. Мартсан эмүүдийг орхиод эмээ үргэлжлүүлэн уугаад давхар жирэмслэхээс сэргийлэх аргыг хэрэглэх
9. Давхар бэлгэвч болон спермецидүүд хэрэглэнэ
10. Олон хоног мартсан учир эмийг орхиод бэлгэвч хэрэглэх



164.Дээрх зурагт үзүүлснээр толгойн аль хэлбэрийн төрлөг

болохыг заана уу?

- A. Өврийн янзтай дагз түрүүлэт
- B. Арын янзтай дагз
- C. Толгойн оройн түрүүлэлт
- D. Дух түрүүлэлт
- E. Нүүр түрүүлэлт

165.Ургийн толгойн төрөх хэмжээ хөтлөх цэгийг тохируулан тавина уу?

- 1. Бага ташуу хэмжээ
- 2. Дунд ташуу хэмжээ
- 3. Шулуун хэмжээ
- 4. Их ташуу хэмжээ
- 5. Босоо хэмжээ

- A. Суман заадас
- B. Бага зулай
- C. Духны заадас
- D. Их зулай
- E. Ооч

- A. 1B, 2A,3 D, 4C, 5E
- B. 1A, 2C, 3D, 4E, 5B
- C. 1B, 2C, 3A, 4E, 5D
- D. 1D, 2A, 3C, 4E, 5B
- E. 1C, 2A, 3B, 4D, 5E

166.Дээрхи тохиолдолд төрөлтийн явцад тохиолдож болох онцлогийг нэрлэнэ үү

- 1. Хэвийн төрөлт
- 2. Төрөлтийн үйл ажиллагаа удаашрах
- 3. Толгойд хавдар кефалогематом үүсэх
- 4. Эмнэл зүйн уйтан аарцаг үүсэх
- 5. Толгойн буруу тавилт учир эмгэг төрөлт

Тохиолдол. X. 52 настай эмэгтэйчүүдийн эмчид сүүлийн 3 сар доошоо үе үе цусархаг зүйл гарна, биений юм сүүлийн үед тогтворгүй болсон сүүлийн долоо хоногт хэмжээ нь ихсээд байна гэсэн зовиуртай иржээ.

167.Эмэгтэйд хамгийн эхэнд хийгдэх шинжилгээг нэрлэнэ үү

- A. Цусанд СА-125 тодорхойлно
- B. Умайн хөндийг хусаж эдийн шинжилгээ авна
- C. MRI шинжилгээ хийлгэнэ
- D. Умайг дурандана
- E. Даавар цус тогтоолт хийнэ

168.Умайгаас мөчлөггүй цус гарах ямар эмгэгүүд байж болох вэ?

- 1. Умайн салстын өмөнгийн урьдал
- 2. Элэгний архаг үрэвсэл
- 3. Умайн салстын өмөн

4. Умайн хоргүй хавдар
5. Умайн салстын үрэвсэл

169. Умайн салстын хучуурууд олон янзын хэлбэршилтэй болсон, бөөм нь хромоор хэт будагдсан, эсийн хуваагдал эрчимтэй явагдсан бол ямар эмгэг өөрчлөлт байж болох вэ?

- A. Умайн хоргүй хавдар
- B. Умайн салстын булчирхайлаг зузаарал
- C. Умайн салстын өмөнгийн урьдал
- D. Умайн салстын өмөн
- E. Умайн салстын үрэвсэл

170. Умайн салстын эмгэг өөрчлөлт үүсэхэд нөлөөлөх шалтгаан эрсдэлт хүчин зүйлийг нэрлэнэ үү.

1. Өндгөвчийн олон уйланхайжих хам шинж
2. Артерийн даралт ихтэй эмэгтэйчүүд
3. Архаг ановуляци
4. Таргалалт
5. Удаан хугацаагаар биений юм өвдөлттэй ирдэг байсан

171. Дараах эмгэг өөрчлөлтөөс аль нь илүү умайн салстын өмөн үүсгэх эрсдэлтэй вэ?

1. Умайн салстын ургацаг
2. Булчирхайлаг уйланхайцарт хэт зузаарал
3. Умайн салстын булчирхайлаг зузааралт
4. Аденоматоз зузааралт
5. Булчирхайлаг холбогч эдийн ургацаг

Тохиолдол. Т... 23 настай, 2 дахь төрөлт, төрсний дараах 7 хоногт үтрээнэс цус гарлаа гэж ирсэн.

172. Төрсний дараа цуслаг шавхарга хэдэн хоног үргэлжилдэг вэ?

- A. 3-5 хоног
- B. 6-13 хоног
- C. 14-12 хоног
- D. 12-15 хоног
- E. 15-21 хоног

173. Төрснөөс хойш цус алдах ямар шалтгаанууд байж болох вэ?

1. Төрсний дараа умайн агшилт муутай байх
2. Ихсийн хэсэг үлдэх
3. Ихсийн хэсэг үлдэх
4. Шавхарга хуримтлагдах
5. Ихэс шигдэж ургах

174. Шавхарга хуримтлагдсан тохиололд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Мезопростол 400-600 мг шулуун гэдсээр хийх
2. Умайн хөндийг хусаж цэвэрлэх
3. Умайн хөндийг гар соруурын аргаар сорох
4. Үрэвслийн эсрэг эмчилгээ хийнэ
5. Умайд хүйтэн жин тавьж хянах

Тохиолдол. Эмэгтэй Б., 34 настай, 9 сартай жирэмсэн, хэвлийн доод хэсгээр өвдөж, үтрээнээс цус гарна гэсэн зовуурьтай эмчид ханджээ. Нийт 7 удаа жирэмсэлсэн, 3 удаа хэвийн төрсөн, 2 удаа үр хөндүүлж, 1 удаа зулбасан. Бодит үзлэгээр: арьс салст цайсан, айж сандарсан байдалтай байна. Артерийн даралт 150/100 мм. МУБӨ, судасны цохилт 1 хоромд 86 удаа, хүчдэл дүүрэлт хэвийн, бүх биеэр хавантай, умай булчин тонустай, тэмтэрхэд эмзэглэлтэй УЗЦ тод, жигд 1 хоромд 132 удаа байв.

175. Ихэс ховхроход хүргэх шууд шалтгааныг тэмдэглэнэ үү?

1. Жирэмсний хожуу гестоз
2. Гэмтэл
3. Ихсийн хэмжээ хэт том байх
4. Ихэр ургийн нэг нь төрсний дараа
5. Умайн хөндийд мэс ажилбар хийлгэж байсан

176. Хүүхэд төрөхөөс өмнө хэвийн байрласан ихэс умайн хананаас ховхрохыг ихэс ховхролт гэнэ. Ихэс төвөөсөө ховхрох үед үтрээнээс их хэмжээний цус гарна. Үүний улмаас Кувлерийн умай үүснэ.

177.Дээрх тохиолдолд илэрсэн ихэс ховхролтын шинжийг тэмдэглэнэ үү?

1. Хэвлийгээр өвдөх
2. Үтрээнээс цус гарах
3. Умай чангаралтай
4. Артерийн даралт 130/90 мм.МУБӨ
5. Бүх биеэр хавантай

178.Дээрх тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?

1. Эхо шинжилгээ хийж ихсийн арын цус хуралтын хэмжээг тодорхойлно.
2. Цусны ерөнхий шинжилгээ хийж цус багадалтын зэргийг тогтооно.
3. Ургийн байдлыг монитороор үнэлнэ.
4. Яаралтай кесар мэс засал хийж төрүүлнэ.
5. Төрөлтийг сэдээж төрүүлнэ.

179.Ихэс ховхролт нь ямар хүндрэлд хүргэх вэ?

- 1.Цус алдалтын дайрлага
- 2.Судсанд цус түгээмлээр бүлэгнэх хам шинж
- 3.Ураг эндэх
- 4.Умай агшилтгүй болох
- 5.Шеханий хам шинж

Тохиолдол. Давтан төрөгч эх Т. 20 минутын өмнө окситоцын сэдээлтээр 4200 грамм жинтэй, 53 см урттай, Апгарын 8 баллтай хүүхэд төрүүлэв. Хүүхэд төрмөгц 450 мл орчим цус гарч, хүйнээс татаж ихсийг гадагшлуулан шалгахад бүрэн бус байв. Эмч умайн хөндийг гараар шалган умайд 2 гарын хавсарсан иллэг хийв. Умай агшилт тур хугацаанд сайжирсан боловч дахин 350 мл цус алдав.

180.Төрсний дараа эрт үед алдсан цусыг хэмжих аргыг нэрлэнэ үү.

1. Жингийн арга
2. Эзэлхүүний арга
3. Процентын арга
4. Гематокритыг үнэлэх
5. Цусны биохимийн шинжилгээ

181.Умайн хүзүүний урагдлыг оношлох аргыг нэрлэ

1. Хүүхэд төрмөгц шинэ цус гарах
2. Умай агшилт сайн байхад цус гарах
3. Үртээнд толь өргөгч тавьж умайн хүзүүг шалгах
4. Үтрээнд үзлэг хийх
5. Умайн хөндийг гараар шалгах

182.Дээрх тохиолдолд төрсний дараах эрт үед цус алдсан шалтгааныг нэрлэнэ үү.

1. Том ураг
2. Ихсийн эд үлдэх
3. Умайн хүзүүний урагдал
4. Давтан төрөгч
5. Ураг орчмын шингэн эрт гарах

183.Умайн хөндийг гараар шалгах ажилбарын үед эмчийн зайлшгүй хийх үйлдлийг нэрлэнэ үү.

1. Умайн хананы бүрэн бүтэн байдлыг шалгах
2. Умайн хөндийг байгаа ихсийн эдийг гадагшлуулах
3. Умайд хавсарсан иллэг хийх
4. Умайн хүзүүний бүрэн бүтэн байдлыг шалгана
5. Умайн хэмжээг тодорхойлно

Тохиолдол. С., 23 настай тулгар төрөгч эх өрхийн эмнэлэгт жирэмсний 42 *7 хоногийн хугацаанд ургийн хөдөлгөөн багассан гэсэн зовиуртай хандан үзүүлсэн. Үзлэгээр: умай тэмтрэлтээр цочролгүй. Умайн ёроол 38 см, хэвлийн эргэн тойрон 102 см. Ургийн толгой аарцгийн орох хэсгийн дээр хөдөлгөөнтэй. Ургийн зүрхний цохилт 1 минутанд 135 удаа, хүйсний зүүн дор тод сонсогдоно.

PV: Гадна бэлэг эрхтэний хөгжилт зөв, үтрээ уйтан, умайн хүзүү 1 см орчим урт, голлосон, нэг хуруу орох төдий нээлттэй, ургийн түрүүлсэн хэсэг толгой, дээш түлхэгдэнэ, толгойн

ясжилт хатуурсан. Ураг орчмын шингэний хальс бүтэн. Чанд авиан оношлогоонд илэрсэн өөрчлөлтүүд: Ургийн хүй нь хүзүүгээ 1 ороосон. Ураг орчмын шингэний индекс 8 см, ихсийн зузаан 2 см, ясжилтын цэг 0,8, ихсийн зузаан 20мм, Амниоскопи: Ураг орчмын шингэн багассан, хөвдөстэй, ногоон өнгийн туяатай, окситоциний сорил: сөрөг

185. Илүү тээлтийн хугацааг сонгоно уу

1. 286 хоног
2. 294 хоног
3. 41 долоо хоног
4. 42 долоо хоног
5. 40 долоо хоног

186. Илүү тээлтийн үед тохиолдох хүндрэлүүдийг сонгоно уу ?

1. Ургийн бүтэлт
2. Төрөх хүчний сулрал
3. Төрсний дараах үеийн цус алдалт
4. Эмнэл зүйн уйтан аарцаг
5. Ихэс цагаас өмнө ховхрох

187. Окситоциний сорил эерэг гэж юу вэ ?

1. 10 минут тутамд хамгийн багадаа 3 удаа базлах
2. Окситоцинийг шингэлж уулгахад умай агшилт өгөх
3. Окситоциний нөлөөгөөр ургийн хөдөлгөөн идэвхижих
4. Окситоциний нөлөөгөөр умайн булчин агших хариу урвал юм
5. Окситоциний нөлөөгөөр цусан дахь эстриолийн хэмжээ ихсэх

Тохиолдол. С..., 27 настай тулгар төрөгч эмэгтэй жирэмсний 30 * 7 хоногийн хугацаанд базалж өвдөнө гэсэн зовиуртай эмнэлэгт хэвтсэн. Энэ тохиолдолд эмчилгээний ямар удирдамжийг баримтлах хэрэгтэй вэ ?

188. Үтрээнээс болон умайн хүзүүний сувгаас наацын шинжилгээ аван, антибиотик эмчилгээ хийлгэх шаардлагатай эсэхийг тодорхойлно. Эхийн биеийн байдлыг тогтмол ажиглан, пульс, артерийн даралт, цусны шинжилгээнд цагаан эс, С идэвхит уургийн хэмжээг хянан, чанд авиан оношлогоогоор ураг орчмын шингэний хэмжээг тогтооно. Хэрэв фибронектиний сорил сөрөг гарвал төрөлтийг яаралтай шийдвэрлэн, төрөх замаар нь төрүүлнэ.

189. Жирэмсний хугацаанд ураг орчмын шингэн цагаас урьтаж гаран, ураг орчмын шингэний индекс 10 мм-с бага байгаа эхчүүдэд хорионамниотит үүсэх, төрсний дараа цус алдах өндөр эрсдэл хүлээгдэж байдаг. Ийм учраас урьдчилан сэргийлэх зорилгоор антибиотик эмчилгээг хийх хэрэгтэй. Хэрэв урагт бүтэлтийн шинж илрээгүй байвал тээлтийг цааш үргэлжлүүлнэ.

190. Жирэмсний 22-37 долоо хоногоос өмнө төрөлт эхэлбэл УЗЦ-ыг КТГ-р хянан, бүтэлт байгаа эсэхийг илрүүлэн төрөлтийн асуудлыг яаралтай шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Хэрэв ураг орчмын шингэн гарсныг үгүйсгэсэн нөхцөлд чанд авиан шинжилгээгээр ураг орчмын шингэний индекс, умайн хүзүүний байдлыг тодорхойлно.

Тохиолдол. О..., 27 настай. Амаржих газарт базлалт эхлээд 3 цаг болж байна, одоо 10 хоромд 2 удаа 20 сек-ын зайтай базлана, доош цусархаг салиархаг ялгарал гарна гэсэн зовиуртай 2012-11-9 нд ирсэн. Асуумжаар: Сүүлийн биений юм 2012-02-02-нд ирсэн, 4 дэх жирэмслэлт, 2 удаа үр хөндүүлсэн, 2009 онд 3.200 охин төрүүлсэн, жирэмслэлт төрөлт хэвийн явагдсан... Эх барихын үзлэгээр: Умайн ёроол хүйс аюулхайн дунд, ХЭТ-96 см. Ураг дагуу байрлалтай, түрүүлсэн хэсэг толгой аарцгийн орох хэсгийн дээр хөдөлгөөнтэй. УЗЦ тод, жигд 1 хоромд 136 удаа, аарцгийн хэмжээ 25-28-30-20. Үтрээн үзлэгээр: үтрээ уужим, умайн хүзүү 3 см нээлтэй, голлож, зөөлөрсөн, ураг орчмын шингэний бүрхүүл бүтэн.

191. Онош тавина уу

- A Gr IV-II 40 долоо хоногтой жирэмсэн төрөлтөнд бэлтгэгдэх үе
- B Gr IV-II 40 долоо хоногтой жирэмсэн, дунших үе
- C Gr IV-II 40 долоо хоногтой жирэмсэн, төрөлтийн 1-р үеийн далд шат

D Gr IV-II 40 долоо хоногтой жирэмсэн, төрөлтийн 1-р үеийн идэвхитэй шат

E Gr II 40 долоо хоногтой жирэмсэн, төрөх хүчний анхдагч сулрал

192. Умайн хүзүү төрөлтөнд бэлтгэгдсэн эсэхийг ямар үзүүлэлтүүдээр үнэлдэг вэ?

1. Умайн хүзүүний хэлбэр
2. Умайн хүзүүний байрлал
3. Базлалт жигдэрсэн
4. Умайн хүзүүний нээлт
5. Умайн хүзүүний ялгарал

193. Умайн булчингийн агшил дистракци гэж юу вэ?

- A. Умайн булчингийн ширхгүүд дангаараа агшина.
- B. Умайн хүзүүний цагираг булчин татагдах
- C. Умайн булчингийн ширхгүүдийн агшилт давхцана.
- D. Умайн хүзүүний дагуу булчин дээш татагдана.
- E. Умайн булчин зузаарч уртсана.

Тохиолдол. Эмэгтэй М 25 настай, жирэмслэлт 2, төрөлт анхных. Жирэмсний 38-39 долоон хоногтой, базлалт 10 минутанд 2 удаа 35 секунд үргэлжилнэ. АД 110/70, 120/80 мммуб, пульс 84, ургийн зүрхний цохилт минутанд 136 удаа, ургийн толгой бага аарцгийн орох хэсэгт 3/5 үтрээний үзлэгээр умайн хүзүү 5 см нээлттэй, зөөлөн, голлосон. Ураг орчмын шингэний бүрхүүл бүтэн.

194. Партограммыг ямар зорилгоор төрөгч эмэгтэйд хөтөлдөг вэ?

1. Төрөлт хэвийн явагдаж буйг хянах
2. Ургийн байдлыг хянах
3. Төрөлтийн явцад эхийн биеийн байдлыг хянах
4. Умайн хүзүүний нээлтийг хянах
5. Умайн базлалтыг хянах

195. Умайн базлалтыг ямар үзүүлэлтээр хянах вэ?

1. Умайн базлалтыг давтамж
2. Базлалтын хүч
3. Базлалтын үргэлжлэх хугацаа
4. Умайн хүзүүний нээлт
5. Умайн хүзүүний урт

196. Ургийн зүрхний цохилтонд үнэлгээ өгнө үү?

- A. Хэвийн бус
- B. Хэвийн
- C. Бүтэлттэй
- D. Эмгэг
- E. Эргэлзээтэй

197. Умайн хүзүүний нээлтийг Бишопын үнэлгээгээр хэдэн оноо өгөх вэ?

- A. 5 оноо
- B. 6 оноо
- C. 8 оноо
- D. 7 оноо
- E. 4 оноо

Тохиолдол. Эмэгтэй Х 17 настай, 15 насандаа бэлгийн хавьталд орсон. Урьд нь заг хүйтэн өвчнөөр өвчилж, эмчилгээ хийлгэсэн. Гурав хонгийн өмнөөс хэвлийн доогуур өвдөнө, үтрээнээс үнэртэй ногоон ялгадас гарна.

Үзлэг: Биеийн жин 54 кг, өндөр 152 см, АД 110/70, 120/80 ммуб, пульс

105, биеийн халуун 37.8°C, хэвлийн доод хэсгээр үзлэгээр Щеткин-Блюмбергын шинж сул илэрнэ. Үтрээний үзлэгээр умай дайвар эмзэглэл ихтэй, ялгадас үнэртэй, цайвар ногоон гарна.

198. Эмч та онош тавина уу?

- A. Үтрээний үрэвсэл
- B. Умайн дайврын үрэвсэл
- C. Өндгөвчийн үрэвсэл
- D. Бага аарцгийн гялтангын үрэвсэл
- E. Умайн хүзүүний үрэвсэл

199. Оношийн үндэслэлийг гаргаж ирнэ үү?
1. Умай дайвар эмзэглэлтэй
 2. Үтрээгээр үнэртэй ялгадас гарах
 3. Халуурна
 4. Щеткин-Блюмбергын шинж илэрнэ.
 5. Бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсөн.
200. Эрсдэлт хүчин зүйлсийг тодруулна уу?
1. Нас
 2. Бэлгийн хавьталд эрт орох
 3. Бэлгийн замын халдварт өвчнөөр өвчлөх
 4. Үтрээнээс эвгүй үнэртэй ялгадас гарах
 5. Хэвлийн доогуур өвдөнө.
201. Цаашид онош тодруулах зорилгоор ямар шинжилгээ бүрдүүлэх вэ?
1. Хэт авиан шинжилгээ
 2. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
 3. Үтрээний наацын шинжилгээ
 4. Цусны ариун чанар
 5. Умайн хүзүүний эсийн шинжилгээ
202. Эмчилгээний тактикийг хэрхэн боловсруулах вэ?
- А. Халдварын эсрэг антибиотик, үрэвслийн эсрэг стеройд бус дааврын эм, эсийн түвшинд бодисын солилцоо сайжруулах, үтрээний үрэвслийн эсрэг эмчилгээ хийх, хордлого тайлах эмчилгээ
- В. Халдварын эсрэг антибиотик, үрэвслийн эсрэг стеройд бус дааврын эм, умай агшаах, эсийн түвшинд бодисын солилцоо сайжруулах, үтрээний үрэвслийн эсрэг эмчилгээ хийх
- С. Халдварын эсрэг антибиотик, үрэвслийн эсрэг стеройд бус дааврын эм, эсийн түвшинд бодисын солилцоо сайжруулах, эмийн бус эмчилгээ, үтрээний үрэвслийн эсрэг эмчилгээ хийх
- Д. Халдварын эсрэг антибиотик, үрэвслийн эсрэг стеройд бус дааврын эм, эсийн түвшинд бодисын солилцоо сайжруулах, үтрээний үрэвслийн эсрэг эмчилгээ
203. Жирэмснээс хамгаалах дааврын хавсарсан эмийг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?
1. Биений юм ирсэн 3 дахь өдөр.
 2. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 3. 12 долоон хоног буюу 3 сар тутамд 1 удаа булчинд тарина.
 4. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр 1 шахмалыг ууна.
 5. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.
208. Жирэмслэлтээс хамгаалах дааврын хавсарсан эмийн ашигтай тал юу вэ?
1. Зөв хэргэлсэн тохиолдолд 99% үр дүнтэй.
 2. Бэлгийн хавьталд нөлөө үзүүлэхгүй, саад учруулахгүй.
 3. Биений юмны мөчлөг тогтмолжиж, бага хэмжээгээр, цөөн хоног, өвдөлтгүй ирдэг болно.
 4. Эмийг зогсооход жирэмслэх чадвар хурдан сэргэнэ.
 5. Умайн салстын болон өндгөвчний хорт хавдараас сэргийлнэ.
209. Жирэмслэлтээс хамгаалах дааврын хавсарсан эмийн сул тал юу вэ?
1. Дотор эвгүүрхэх, толгой өвдөх гаж нөлөө илэрч болно.
 2. Хөхөөр хөндүүрлэж болно.
 3. Биеийн жин бага зэрэг нэмэгдэж болно.
 4. Эмийг өдөр бүр уух нь түвэгтэй.
 5. Бэлгийн замын халдвараас хамгаалахгүй.
210. Жирэмслэлтээс хамгаалах дааврын хавсарсан эмийг хэргэлэхийг хоргилох заалт.
1. Жирэмсэн
 2. Хөхүүл эмэгтэй төрсний дараах эхний 6 сарын дотор, хөхүүл биш нь төрсний дараа эхний 3 сарын дотор.
 3. Элэгний эмгэг
 4. Хөхний хорт хавдар
 5. Цусны даралт ихтэй ба цус өтгөрөх эмгэгтэй.
211. Жирэмслэлтээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийн ашигтай тал юу вэ?
1. Зөв хэргэлсэн тохиолдолд 99% үр дүнтэй.

2. Бэлгийн хавьталд нөлөө үзүүлэхгүй, саад учруулахгүй.
 3. Биений юмны мөчлөг тогтмолжиж, бага хэмжээгээр, цөөн хоног,өвдөлтгүй ирдэг болно.
 4. Эмийг зогсооход жирэмслэх чадвар хурдан сэргэнэ.
 5. Умайн салстын болон өндгөвчний хорт хавдараас сэргийлнэ.
212. Жирэмслэлтээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийн сул тал юу вэ?
1. Дотор эвгүүрхэх, толгой өвдөх гаж нөлөө илэрч болно.
 2. Хөхөөр хөндүүрлэж болно.
 3. Биеийн жин бага зэрэг нэмэгдэж болно.
 4. Эмийг өдөр бүр уух нь түвэгтэй.
 5. Бэлгийн замын халдвараас хамгаалахгүй
213. Жирэмслэлтээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийн хоргилох заалт юу вэ?
1. Жирэмсэн
 2. Тамхи татдаг эмэгтэй
 3. Элэгний эмгэг ба хөхний хорт хавдар
 4. Зүрхний цус хомсдох эмгэгтэй
 5. Цусны даралт ихтэй ба цус өтгөрөх эмгэгтэй.
214. Депо-проверагийн ашигтай тал юу вэ?
1. 3 сараас дээш жирэмслэлтээс хамгаална.
 2. Бэлгийн хавьталд саад учруулахгүй.
 3. Хөхний сүүний гарц, чанарт нөлөөлөхгүй.
 4. Аль ч насны эмэгтэйд тохиромжтой.
 5. Хөх, умай, өндгөвчний хорт хавдар,цус багадалтаас сэргийлнэ.
215. Депо-проверагийн сул тал юу вэ?
1. Толгой өвдөх, хөхөөр хөндүүрлэх гаж нөлөө илэрч болно.
 2. Биений юмгүйдэл эсвэл биений юмны хооронд цусархаг ялгадас гарч болно.
 3. Биеийн жин бага зэрэг нэмэгдэж болно.
 4. Үс унах, нүүрэнд батга гарах,бэлгийн дуршил буурах
 5. Бэлгийн замын халдвараас хамгаалахгүй гаж нөлөө илэрч болно.
216. Депо-провераг хоргилох заалт юу вэ?
1. Жирэмсэн
 2. Шалтгаан тодорхой бус үтрээний цус алдалт
 3. Элэгний эмгэг ба хөхний хорт хавдар
 4. Зүрхний цус хомсдох эмгэгтэй
 5. Цусны даралт ихтэй ба цус өтгөрөх эмгэгтэй.
217. Умайн ерөндөгийн ашигтай тал юу вэ?
1. Удаан хугацаагаар /10жил/ жирэмслэлтээс хамгаална.
 2. Бэлгийн хавьталд саад учруулахгүй.
 3. Хөхний сүүний гарц, чанарт нөлөөлөхгүй
 4. Төрсний болон үр хөндүүлсний дараа шууд тавьж болно
 5. Цэвэрших хүртэл хэрэглэж болно.
218. Умайн ерөндөгийн сул тал юу вэ?
1. Биений юм элбэгших, удаан хугацаагаар өвдөлттэй ирэх магадлалтай.
 2. Бэлгийн замын халдвараас хамгаалахгүй.
 3. Бага аарцгийн үрэвсэл үүсгэж болзошгүй.
 4. Үргүйдэл, умай гаднах жирэмслэлт үүсч болзошгүй.
 5. Ерөндөг тавих ба авахад эмнэлгийн байгууллагад заавал очих шаардлагатай
219. Умайн ерөндөгийг хэрэглэхийг хориглох заалт юу вэ?
1. Жирэмсэн
 2. Шалтгаан тодорхой бус үтрээний цус алдалт
 3. Үтрээ, умайн хүзүүн үрэвсэл,шарх,бага аарцгийн үрэвсэл, бэлгийн замын халдвар.
 4. Умайн хоргүй хавдар.
 5. Хүнд хэлбэрийн цус багадалт.
220. Бэлгэвч хэрэглэх ашигтай тал юу вэ?
1. Бэлгийн замын халдвараас хамгаална.
 2. Аль ч насны эмэгтэйд тохиромжтой.

3. Хөхний сүүний гарц, чанарт нөлөөлөхгүй.
 4. Жирэмсэн үед мөн төрөлт, зулбалт, үр хөндөлтийн дараа шууд хэрэглэх боломжтой.
 5. Хүссэн үедээ хэрэглэх, зогсоох боломжтой
221. Бэлгэвч хэрэглэх сул тал юу вэ?
1. Резинд харшил үүсч болно.
 2. Бэлгийн хавьтлын үед бэлгэвч мултрах, урагдах эрсдэлтэй.
 3. Бэлгийн дур буурч болно.
 4. Бага аарцгийн үрэвсэл үүсгэж болзошгүй.
 5. Үргүйдэл, умайн гаднах жирэмслэлт үүсч болзошгүй.
222. Бэлгэвч хэрэглэхийг хориглох заалт юу вэ?
1. Жирэмсэн
 2. Шалтгаан тодорхой бус үтрээний цус алдалт
 3. Үтрээ, умайн хүзүүн үрэвсэл, шарх, бэлгийн замын халдвар
 4. Резинд харшилтай
 5. Хүнд хэлбэрийн цус багадалт
223. Умай ерөндөг ямар үйлчилгээ үзүүлдэг тул жирэмслэлтээс хамгаалдаг вэ?
1. Умайн хөндийд эр бэлгийн эсийн хөдөлгөөнийг саатуулдаг.
 2. Эр бэлгийн эсийг өндгөн эстэй нийлэхээс сэргийлдэг.
 3. Үр тогтоогүй өндгөн эсийг устгадаг.
 4. Эр бэлгийн эсийг үтрээнд оруулдаггүй.
 5. Өндгөн эсийн боловсролтыг удаашруулдаг.
224. Бэлгэвч ямар үйлчилгээ үзүүлдэг тул жирэмслэлтээс хамгаалдаг вэ?
1. Умайн хөндийд эр бэлгийн эсийн хөдөлгөөнийг саатуулдаг.
 2. Эр бэлгийн эсийг устгадаг.
 3. Үр тогтоогүй өндгөн эсийг устгадаг.
 4. Эр бэлгийн эсийг үтрээнд оруулдаггүй.
 5. Өндгөн эсийн боловсролтыг удаашруулдаг
225. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр бага эмч ямар ажил хийх ёстой вэ?
1. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн жирэмслэлт, төрөлт, тазний төгсгөл, нярай хүүхдийн эрүүл мэндийн бүртгэл хийх
 2. Жирэмснийг эрт илрүүлэх
 3. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 2-оос доошгүй удаа оруулах
 4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг эрүүлжүүлэх ажил хийх
 5. Үйлчлэх хүрээний нутаг дэвсгэртээ эрүүл мэндийн идэвхтэнг сургаж, үйл ажиллагаандаа туслуулах
226. Хэвийн явцтай жирэмсэнг жирэмсний хугацаанд эмзэг байдал илрээгүй бол хэдэн удаа заавал үзсэн байх шаардлагатай вэ?
1. 2-3 удаа
 2. 3-4 удаа
 3. 4 удаа
 4. 6 удаа
 5. 8 удаа
227. Жирэмсэнг 12 долоо хоногоос дотогш үзэх эсвэл анхны үзлэг хийх зорилго нь юу вэ?
1. Жирэмсний хугацааг тодорхойлох
 2. Ургийн өсөлт, хөгжлийг үнэлэх
 3. Жирэмснийг тээлгэх эсэх асуудалыг шийдвэрлэх
 4. Төрөлтийн бэлтгэлийг үнэлэх
 5. Төрөх газрыг товлох
228. 12 долоо хоногтой жирэмсэнд анхны үзлэгээр юу хийх ёстой вэ?
1. Эрүүл мэндийн талаар асуумж авах, биеийн үзлэг хийх
 2. Эх барихын тусгайлан үзлэг хийх
 3. Нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх
 4. Ургийн байрлал, түрүүлсэн хэсгийг тодорхойлох
 5. Ургийн зүрхний цохилтыг сонсох
229. 12 долоо хоногтой жирэмсэнд анхны үзлэгээр ямар шинжилгээ хийх ёстой вэ?

1. Цус, шээсний ерөнхий шинжилгээ
 2. Чанд авианы шинжилгээ
 3. Үтрээний наац шинжилгээ
 4. Тэмбүү, ХДХВ-ийн шинжилгээ
 5. Флюорографи
230. 12 долоо хоногтой жирэмсэнд анхны үзлэгээр ямар зөвөлгө өгөх ёстой вэ?
1. Жирэмсний хяналтын ач холбогдол
 2. Хооллолт
 3. Хорт зуршлын хор уршиг
 4. Бэлгийн замын халдвараас сэргийлэх тухай
 5. Жирэмсний эмзэг байдлын тухай
231. 20 долоо хоногтой жирэмсний үзлэг хийх зорилго юу вэ?
1. Жирэмсний хугацааг тодорхойлох
 2. Ургийн өсөлт, хөгжлийг үнэлэх
 3. Жирэмснийг тээлгэх эсэх асуудалыг шийдвэрлэх
 4. Жирэмсний явц, эмгэг байдлыг үнэлэх
 5. Төрөх газрыг товлох
232. 20 долоо хоногтой жирэмсний үзлэгээр юу хийх ёстой вэ?
1. Эрүүл мэндийн талаар асуумж авах.
 2. Эх барихын тусгайлан үзлэг хийх
 3. Биеийн үзлэг хийх
 4. Ургийн байрлал, түрүүлсэн хэсгийг тодорхойлох
 5. Ургийн зүрхний цохилтыг сонсох
233. 20 долоо хоногтой жирэмсэнд ямар шинжилгээнүүд хийх ёстой вэ?
1. Цус, шээсний ерөнхий шинжилгээ
 2. Чанд авианы шинжилгээ
 3. Шаардлагаар холбогдох шинжилгээг хийнэ
 4. Үтрээний наац шинжилгээ
 5. Флюорографи
234. 20 долоо хоногтой жирэмсэнд үзлэгээр ямар зөвөлгөө өгөх ёстой вэ?
1. Жирэмслэлттэй холбоотой хууль зүйн ойлголт
 2. Төмрийн бэлдмэл, фолийн хүчил уух ач холбогдол
 3. Зулбалтаас сэргийлэх
 4. Төрөлтийн тухай
 5. Жирэмсний эмзэг байдлын тухай
235. 28 долоо хоногтой жирэмсний үзлэг хийх зорилго юу вэ?
1. Шаардлагатай бол нарийн мэргэжлийн эмч нарын зөвөлгөө авах
 2. Жирэмсний явц, эмгэг байдлыг үнэлэх
 3. Төрөх газрыг товлох
 4. Ургийн өсөлт, хөгжлийг үнэлэх
 5. Жирэмснийг тээлгэх эсэх асуудалыг шийдвэрлэх
236. 28 долоо хоногтой жирэмсний үзлэгээр юу хийх ёстой вэ?
1. Эрүүл мэндийн талаар асуумж авах.
 2. Эх барихын тусгайлан үзлэг хийх
 3. Ургийн зүрхний цохилтыг сонсох
 4. Ургийн байрлал, түрүүлсэн хэсгийг тодорхойлох
 5. ЭКГ хийлгэх
237. 28 долоо хоногтой жирэмсэнд ямар шинжилгээнүүд хийх ёстой вэ?
1. Чанд авианы шинжилгээ
 2. Шаардлагаар холбогдох шинжилгээг хийнэ
 3. Үтрээний наац шинжилгээ
 4. Глюкозын ачаалалтай шинжилгээ
 5. Флюорографи
238. 28 долоо хоногтой жирэмсэнд анхны үзлэгээр ямар зөвөлгөө өгөх ёстой вэ?
1. Төмрийн бэлдмэл, фолийн хүчил уухын ач холбогдол цус багадалт үүсч болох тухай
 2. Эрхтэн тогтолцооны эмгэг ба жирэмслэлт

3. Дутуу төрөлтөөс сэргийлэх тухай
 4. Төрөлтийн тухай
 5. Жирэмслэлттэй холбоотой хууль зүйн ойлголт
239. 32 долоо хоногтой жирэмсний үзлэг хийх зорилго юу вэ?
1. Жирэмсний явц, эмгэг байдлыг үнэлэх
 2. Ургийн өсөлт, хөгжлийг үнэлэх
 3. Төрөхийн өмнөх амралт олгох
 4. Шаардлагатай бол нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөө авах
 5. Эх барихын мэргэжлийн эмчийн зөвлөлгөө авах
240. 32 долоо хоногтой жирэмсний үзлэгээр юу хийх ёстой вэ?
1. Эрүүл мэндийн талаар асуумж авах, биеийн үзлэг хийх
 2. Ургийн байрлал, түрүүлсэн хэсэг, янзыг тогтоох
 3. Ургийн зүрхний цохилтыг сонсох
 4. Дотуур үзлэг хийх
 5. Дотуур ЭХО хийх
241. 32 долоо хоногтой жирэмсэнд ямар шинжилгээнүүд хийх ёстой вэ?
1. Цусны ерөнхий шинжилгээ, гемоглобины хэмжээ
 2. Үтрээний наац шинжилгээ
 3. Шаардлагаар холбогдох шинжилгээг хийнэ
 4. Шээсний ерөнхий шинжилгээ
 5. Тэмбүүгийн сорил
242. 32 долоо хоногтой жирэмсэнд ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?
1. Төмрийн бэлдмэл, фолийн хүчил уухын ач холбогдол, цус багадалт үүсч болох тухай
 2. Төрөлтийн тухай
 3. Зулбалтаас сэргийлэх тухай
 4. Жирэмсний аюултай шинжийн тухай
 5. Жирэмслэлттэй холбоотой хууль зүйн ойлголт
243. 36 долоо хоногтой жирэмсний үзлэг хийх зорилго юу вэ?
1. Жирэмсний явц, эмгэг байдлыг үнэлэх
 2. Жирэмсний өндөр эрсдлийг илрүүлэх
 3. Ургийн өсөлт, хөгжлийг үнэлэх
 4. Төрөх газрыг товлох
 5. Төрөхийн өмнөх амралт олгох
244. 36 долоо хоногтой жирэмсний үзлэгээр юу хийх ёстой вэ?
1. Эрүүл мэндийн талаар асуумж авах, биеийн үзлэг хийх
 2. Ургийн байрлал, түрүүлсэн хэсэг, янзыг тогтоох
 3. Ургийн зүрхний цохилтыг сонсох
 4. Дотуур үзлэг хийх
 5. Дотуур ЭХО хийх
245. 36 долоо хоногтой жирэмсэнд ямар шинжилгээнүүд хийх ёстой вэ?
1. Цусны ерөнхий шинжилгээ, гемоглобины хэмжээ
 2. Шаардлагаар холбогдох шинжилгээг хийнэ
 3. Шээсний ерөнхий шинжилгээ
 4. Хэт авиан шинжилгээ
 5. Үтрээний наац шинжилгээ
246. 36 долоо хоногтой жирэмсэнд ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?
1. Төмрийн бэлдмэл, фолийн хүчил уухын ач холбогдол, цус багадалт үүсч болох тухай
 2. Хөх арчлах тухай
 3. Зулбалтаас сэргийлэх тухай
 4. Төрлөгийн үеийн тухай зөвлөгөө
 5. Жирэмслэлттэй холбоотой хууль зүйн ойлголт
247. 38 долоо хоногтой жирэмсний үзлэг хийх зорилго юу вэ?
1. Төрөлтийн бэлтгэлийг хангах
 2. Ургийн жинг тодорхойлох
 3. Төрлөгийн урьдчилсан төлөвлөгөө гаргах

4. Төрөх газрыг товлох
 5. Нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх
248. 38 долоо хоногтой жирэмсний үзлэгээр юу хийх ёстой вэ?
1. Эрүүл мэндийн талаар асуумж авах, биеийн үзлэг хийх
 2. Ургийн байрлал, түрүүлсэн хэсэг, янзыг тогтоох
 3. Ургийн зүрхний цохилтыг сонсох
 4. Дотуур үзлэг хийх
 5. Дотуур ЭХО хийх
249. 38 долоо хоногтой жирэмсэнд ямар шинжилгээнүүд хийх ёстой вэ?
1. Цусны ерөнхий шинжилгээ, гемоглобины хэмжээ
 2. Чанд авианы шинжилгээ
 3. Шээсний ерөнхий шинжилгээ
 4. Шаардлагаар холбогдох шинжилгээг хийнэ
 5. Тэмбүүгийн сорил
250. 38 долоо хоногтой жирэмсэнд ямар зөвөлгөө өгөх ёстой вэ?
1. Төрөх үйл ажиллагааны тухай
 2. Төрөлтөнд бэлтгэх тухай
 3. Төрөх үеийн өвдөлт бууруулах аргуудын тухай
 4. Илүү тээлтийн тухай
 5. Төрсний дараах үеийн тухай
251. Асуумжаар ямар эрсдэлт хүчин зүйл илэрсэн жирэмсэн эмэгтэйг эх баригч дараах шатны эмнэлэг рүү шилжүүлэх вэ?
1. Анхны төрөлт
 2. 18-аас доош настай
 3. Өмнө нь 5-аас олон удаа төрсөн
 4. Өмнөх хүүхэд амьгүй төрсөн
 5. Өмнө нь кесар хагалгаагаар төрсөн эсвэл өмнөх төрөлтөнд цус их алдсан
252. Жирэмсний явцад ямар эмгэг илэрвэл жирэмсэн эмэгтэйг эх баригч дараах шатны эмнэлэг рүү шилжүүлэх вэ?
1. Жирэмсэнтэй хавсарсан эмгэгтэй
 2. Онош тодорсон олон урагт жирэмсэн
 3. Төрөх хугацаанаас 1 сарын өмнө ураг хөндлөн эсвэл буруу байрлалтай нь тодорхой байгаа
 4. Энэ жирэмслэлтийн явцад үтрээгээр цус гарч байсан өгүүлэлтэй эсвэл одоо цус гарч байгаа
 5. Төрсний дараа үрийн хоолой боолгох эсвэл ерөндөг тавиулах хүсэлтэй.
253. Төмрийн фолатыг хүнд цус багадалтай эмэгтэйд төрсний болон үр хөндүүлсний дараа яаж уулгах вэ?
- A. Өдөрт хагас шахмалыг уулгана
 - B. Өдөрт хагас шахмалаар 3 сарын турш уулгана
 - C. Өдөрт 1 шахмалыг уулгана
 - D. Өдөрт 2 шахмалаар 3 сарын турш уулгана
 - E. Өдөрт 2 удаа 1 шахмалаар жирэмсэний турш уулгана
254. Төмрийн бэлдмэлийг эмэгтэйд уулгахдаа ямар зөвөлгөө өгөх вэ?
1. Төмрийн бэлдмэл нь цус багадалтыг эмчилдэг тул эрүүл мэндэд хэрэгтэй
 2. Төмрийн бэлдмэлийг хоол идсэний дараа орой бүр ууж байх хэрэгтэй
 3. Баас хар гарвал санаа зовох хэрэггүй
 4. Төмрийн бэлдмэлийг ууснаар аргах шинж илэрвэл шингэн уух хэрэгтэй
 5. Шээсэнд лейкоцит их
255. Жирэмсэн эмэгтэйд хүнд хэлбэрийн цус багадалт ямар шинжээр илрэх вэ?
1. Гемоглибин 70г/л-ээс бага
 2. Гарын алга, нүдний салст хэт цайвар байх
 3. Арьс, салст цайсан ба минутанд 30-аас дээш амьсгалах
 4. Арьс, салст цайсан ба амархан ядрах
 5. Арьс, салст цайсан ба тайван байдалд амьсгаадах
256. Хүнд хэлбэрийн цус багадалттай жирэмсэн эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Цус сэлбэх боломжтой газар төрүүлнэ

2. Төмрийн фолатыг 2 шахмалаар 3 сар уулгана
 3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 4. Төмрийн фолатыг 1 шахмалаар жирэмсний турш уулгана
 5. Төмрийн фолатыг 1 шахмалаар 3 сар уулгана
257. Ураг амьгүй байж болзошгүй ямар шинжүүдээр илрэх вэ?
1. Ураг хөдлөхгүй болох
 2. Ургийн байрлал хөндлөн болох
 3. Ургийн зүрхний цохилт сонсогдохгүй болох
 4. Төрөх үйл ажиллагаа эхлэхгүй байх
 5. Үтрээгээр цус гарах
258. Ураг амьгүй байж болзошгүй тохиолдолд эх баригч нар ямар арга хэмжээ авах вэ?
1. Эмэгтэй болон нөхөрт нь хүүхэд амьгүй байж болзошгүйг мэдээлнэ
 2. Цус тогтоох эмчилгээ хийнэ
 3. Эмнэлэгт шилжүүлнэ
 4. Антибиотик тарина
 5. Өвдөлт намдаахаар морфин уулгана
259. Умайн ба ургийн халдварын эрсдэлтэй гэсэн оношийг юуг үндэслэж тавих вэ?
1. Ураг орчмын шингэн хугацаанаасаа өмнө гарах
 2. Ураг орчмын шингэний хальс жирэмсний 9-өөс дээш сартайд хагарах
 3. Ураг орчмын шингэний хальс жирэмсний 8-аас доош сартайд хагарах
 4. 38 хэм халуурах
 5. Үтрээнээс эвгүй үнэртэй ялгадастай
260. Умайн ба ургийн халдвар гэсэн оношийг юуг үндэслэж тавих вэ?
1. Ураг орчмын шингэн хугацаанаасаа өмнө гарах
 2. 38 хэм халуурах
 3. Үтрээнээс эвгүй үнэртэй ялгадастай
 4. Ураг орчмын шингэний хальс жирэмсний 8-аас дээш сартайд хагарах
 5. Ураг орчмын шингэний хальс жирэмсний 9-аас дээш сартайд хагарах
261. Умайн ба ургийн халдварын эрсдэлтэй гэсэн оноштой эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Тохирох антибиотикийг тарина
 2. Антибиотик уулгана
 3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 4. Төрөх үйл ажиллагаа эхэлсэн эмэгтэйтэй адил арга хэмжээ авна
 5. Ношпа уулгана
262. Умайн ба ургийн халдвар гэсэн оноштой эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Тохирох антибиотикийг тарина
 2. Антибиотик уулгана
 3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 4. Төрөх үйл ажиллагаа эхэлсэн эмэгтэйтэй адил арга хэмжээ авна
 5. Ношпа уулгана
263. Ураг орчмын шингэний хальс жирэмсний 8-аас дээш сартайд хагарсан эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Тохирох антибиотикийг тарина
 2. Антибиотик уулгана
 3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 4. Төрөх үйл ажиллагаа эхэлсэн эмэгтэйтэй адил арга хэмжээ авна
 5. Ношпа уулгана
264. Заг хүйтэн эсвэл хламидийн халдвар байж болзошгүй гэсэн оношийг ямар шинжийг үндэслэн тавих вэ?
1. Үтрээнээс идээрхэг, хэвийн бус ялгадас гарах
 2. Хавьтагчийн шээсний сүвнээс идээ гарч байсан
 3. Хавьтагч шээхэд хорсож байсан
 4. Үтрээнээс ээдэм төст ялгадас гарах
 5. Бэлэг эрхтэн их загатнах
265. Мөөгөнцөрийн халдвар байж болзошгүй гэсэн оношийг ямар шинжийг үндэслэн тавих вэ?

1. Үтрээнээс ээдэм төст ялгадас гарах
 2. Хавьтагчийн шээсний сүвнээс идээ гарч байсан
 3. Бэлэг эрхтэн их загатнах
 4. Үтрээнээс идээрхэг, хэвийн бус ялгадас гарах
 5. Хавьтагч шээхэд хорсож байсан
266. Тэмбүү өвчин эмэгтэйд ямар шинжүүдээр илэрч болох вэ?
1. Бэлэг эрхтний орчим шарх гарна
 2. Цавины булчирхай томорно
 3. Хэрвээ эмэгтэй жирэмсэн бол зулбах, дутуу төрөх, амьгүй хүүхэд төрөх хүндрэл тохиолдоно
 4. Үтрээнээс ээдэм төст ялгадас гарах
 5. Бэлэг эрхтэн их загатнах
267. Тэмбүүтэй эмэгтэйд ямар эмчилгээ хийх вэ?
1. Бензоатилпенициллин G 2,6 саяаар тарина
 2. Ципрофлоксацин 500 мг нэг удаа уух
 3. Доксациклин 100 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух эсвэл Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух
 4. Цефтриаксон 250 мг булчинд нэг удаа тарих
 5. Метронидазол 2 гр нэг удаа уулгах эсвэл Метронидазол 400-500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух
268. Заг хүйтний эмчилгээнд юуг хэрэглэх вэ?
1. Бензоатилпенициллин G 2,6 саяаар тарина
 2. Ципрофлоксацин 500 мг нэг удаа уух
 3. Доксациклин 100 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух эсвэл Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух
 4. Цефтриаксон 250 мг булчинд нэг удаа тарих
 5. Метронидазол 2 гр нэг удаа уулгах эсвэл Метронидазол 400-500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух
269. Трихомоназын эмчилгээнд юуг хэрэглэх вэ?
1. Бензоатилпенициллин G 2,6 саяаар тарина
 2. Ципрофлоксацин 500 мг нэг удаа уух
 3. Доксациклин 100 мг-аар өдөрт 2 удаа 7 хоног уух эсвэл Эритромицин 500 мг-аар өдөрт 4 удаа уух
 4. Метронидазол 2 гр нэг удаа уулгах эсвэл Метронидазол 400-500 мг өдөрт 2 удаа 7 хоног уух
 5. Цефтриаксон 250 мг булчинд нэг удаа тарих
270. Манас таталттай эмэгтэйд тусламж үзүүлэхэд анхаарах зүйл юу вэ?
1. Эмэгтэйг ганцаар нь үлдээж болохгүй
 2. Зүүн хажуугаар нь хэвтүүлж, унах, гэмтэхээс хамгаална
 3. Хэлээ хазахаас сэргийлэх зорилгоор шүдний хооронд зөөлөвчтэй хэл дарагч хавчуулна. Амьсгалын замыг бөглөхгүй байхаар бэхлэнэ. Үүнийг таталтын үед хийхгүй
 4. Судсанд Магнийн сульфат 20 хормын турш аажим тарина
 5. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
271. Манас таталттай эмэгтэйд Магнийн Сульфатыг яаж хэрэглэх вэ?
1. Магнийн сульфатын уусмал 20%-ийн 20 мл буюу 4гр-ыг судсанд аажмаар 20 хормын турш тарина
 2. Магнийн сульфатын уусмал 50%-ийн 10 мл буюу 5 гр-ыг 2%-ийн лигнокаины 1мл уусмалтай нэг тариурт хольж хоёр өгзөгний гадна дээд хэсэгт гүн тарина
 3. Магнийн сульфатыг судсанд тарих боломжгүй бол зөвхөн булчинд тарина
 4. Магнийн сульфат хийсний дараа амьсгал хоромд 16-аас цөөн бол дараагийн тунг хийхгүй
 5. Эмэгтэй дахин татвал Магнийн сульфатын уусмал 20%-ийн 10 мл буюу 2 гр-ыг нэмж судсанд аажим 20 хормын турш тарина
272. Манас таталттай эмэгтэйд ямар шинж илэрч байвал Магнийн сульфатын дараагийн тунг хийж болохгүй вэ?
1. Өвдөгний чичиргээ илрэхгүй
 2. Шээсний гаралт 4 цагт 100 мл-ээс бага

3. Амьсгалын тоо хоромд 16-аас цөөн
 4. Таталт үргэлжилсэн хэвээр
 5. Толгой өвдөх, дотор муухай оргих, бөөлжих
273. Манас таталттай эмэгтэйд диазепамийг хэдийд, яаж хэрэглэх вэ?
1. Магнийн сульфатын давтан тунг авсан хэрнээ таталт үргэлжилсэн хэвээр бол диазепам хийнэ
 2. Магнийн сульфатын хордлого илэрсэн бол диазепам хийнэ
 3. Магнийн сульфат байхгүй бол диазепам хийнэ
 4. Диазепамыг цохилтын тунгаар хэрэглэхдээ 10мг-ыг 2 хормын турш судсанд аажим тарина
 5. Диазепамыг барих тунгаар хэрэглэхдээ 40 мг-ыг 500мл Рингер Лактатын уусмалд найруулж эмэгтэйг унтаа боловч сэрээж болохуйц байдалд 6-8 цаг дусаана
274. Манас таталттай эмэгтэйд диазепамыг шулуун гэдсээр хэдийд, яаж хэрэглэх вэ?
1. Судас олдохгүй үед диазепамг шулуун гэдсээр хэрэглэнэ
 2. Диазепамыг шулуун гэдсээр хэрэглэх эхний буюу цохилтын тун нь 20 мг 4 мл байна
 3. Диазепамыг шулуун гэдсээр хэрэглэх хоёр дах буюу барих тун нь 10 мг 2 мл байна
 4. Диазепамыг шулуун гэдсээр хэрэглэх эхний буюу цохилтын тун нь 10 мг 2 мл байна
 5. Диазепамыг шулуун гэдсээр хэрэглэх хоёр дахь буюу барих тун нь 5 мг 1 мл байна
275. Ихэс гарсны дараа цус их алдаж байгаа эсвэл умай сайн агшаагүй бол умайд иллэг хэрхэн хийх вэ?
1. Гарын алгыг хумбайлган умайн ёроолд тавьж агшилтын байдлыг тодорхойлно
 2. Умайн агшилт сайжиртал хумбайлгасан алгаар тойрог хөдөлгөөнөөр умайн ёроолд иллэг хийнэ
 3. Сайн агшиж эхлэхэд хуруунуудаа умайн ёроолын араар байрлуулж нөжийг гаргахын тулд нэг огцом үйлдлээр доош дарна. Гадна бэлэг эрхтэнд ойр тавьсан саванд цусыг цуглуулж хэмжинэ
 4. Умайд иллэг хийснээр цус алдалт ихсэх тул хийхгүй
 5. Умайд иллэг хийхдээ үтрээнд оруулсан бээлийтэй гараар хийнэ
276. Төрсний дараа цус ихээр алдаж байвал окситоциныг хэдийд яаж хийх вэ?
1. Окситоцины эхний тунг булчинд эсвэл судсанд 10 ОУН-ээр хийнэ
 2. Окситоцины эхний тунг судсанд дуслаар 20 ОУН-ээр 1 литр шингэнд 60 дусал\хоромд хийнэ
 3. Цус их алдсан хэвээр байвал Окситоцины үргэлжлүүлэх тунг булчинд эсвэл судсанд 10 ОУН-ээр давтан хийнэ
 4. Цус их алдсан хэвээр байвал Окситоцины үргэлжлүүлэх тунг судсанд дуслаар 10 ОУН-ээр 1 литр шингэнд 30 дусал\хоромд давтан хийнэ
 5. Окситоцин агуулсан судсаар юүлэх шингэн 3 литрээс хэтэрч болохгүй
277. Төрсний дараа цус ихээр алдаж байвал ямар арга хэмжээ авах вэ?
1. Умайд иллэг хийнэ
 2. Окситоцин эргометрины эмчилгээ хийнэ
 3. Ихсийг гардана
 4. Умайг хоёр гараар дарна
 5. Гол судсыг дарна
278. Төрсний дараа цус ихээр алдсан тул умайд иллэг хийж Окситоцин, эргометрины эмчилгээ хийж, ихсийг гардсаны дараа төрсний дараах цус алдалт үргэлжилсээр байвал ямар арга хэмжээ авах вэ?
1. Умайг хоёр гараар дарна мөн гол судсыг дарна
 2. Цус алдалт зогстол даралтыг үргэлжлүүлнэ
 3. Цус гарсаар байвал эмнэлэгт хүрэгтэл даралтыг үргэлжлүүлнэ
 4. Умайд иллэг хийнэ
 5. Эмчилгээг зогсооно
279. Төрсний дараа цус ихээр алдсан тул умайд иллэг хийж Окситоцин, эргометрины эмчилгээ хийж, ихсийг гардсаны дараа төрсний дараах цус алдалт үргэлжилсээр байвал умайг хоёр гараар дарах үйлдлийг хэрхэн хийх вэ?
1. Ариун бээлий өмсөнө
 2. Баруун гараа үтрээнд оруулж зангидсан гарын ар талыг арагш харуулж урд хүнхрээнд байрлуулна

3. Нөгөө гарыг хэвлий дээр умайн араар тавьж умайг хоёр гарын хооронд чанга дарна
 4. Цус алдалт зогстол даралтыг үргэлжлүүлнэ
 5. Цус гарсаар байвал эмнэлэгт хүргэтэл даралтыг үргэлжлүүлнэ
280. Төрсний дараа цус ихээр алдсан тул умайд иллэг хийж Окситоцин, эргометрины эмчилгээ хийж, ихсийг гардсаны дараа төрсний дараах цус алдалт үргэлжилсээр байвал гол судсыг дарах үйлдлийг хэрхэн хийх вэ?
1. Цавьны судасны лугшилтыг тэмтэрнэ
 2. Хүйсний зүүн дээд талд дарна
 3. Цавины судасны лугшилт мэдэгдэхгүй болтол хангалттай дарна
 4. Цус алдалт зогстол даралтыг үргэлжлүүлнэ
 5. Цус гарсаар байвал эмнэлэгт хүргэтэл даралтыг үргэлжлүүлнэ
281. Төрсөн эмэгтэйн давсаг чинэрсэн атлаа шээж чадахгүй бол шээлгүүрийг ямар дарааллаар тавих вэ?
1. Гараа угаана. Шээсний сүв орчмыг үжилгүйжүүлэх уусмалаар арчина
 2. Цэвэр бээлий өмсөнө. Бэлгийн уруулыг ангайлгана. Үжилгүйжүүлэх уусмалаар арчина.
 3. Шээлгүүрийг 4 см орчим оруулан шээсийг цуглуулан авна
 4. Шээсийг хэмжинэ, тэмдэглэнэ
 5. Шээлгүүрийг авана
282. Төрсөн эхэд ямар шинж илэрвэл яаралтай тусламж хэрэгтэй вэ?
1. Ухаангүй эсвэл татах
 2. Цус алдаж байгаа эсвэл хэвлийгээр хүчэй өвдөх
 3. Толгой өвдсөн эсвэл нүдний харах байдал өөрчлөгдөх
 4. Маш их бэрхшээлтэй амьсгалах эсвэл халуурах
 5. Их хэмжээгээр бөөлжих
283. Ампициллин Гентомицин, Метронидазол зэрэг 3 антибиотیکیг эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?
1. Хэвлийгээр хүчтэй өвдөх эсвэл маш хүнд халууралт өвчнүүд
 2. Хүндрэлтэй зулбалт үр хөндөлт
 3. Умайн болон ургийн халдвар
 4. Төрсний дараах цус алдалт 24-өөс дээш цаг үргэлжилсэн эсвэл төрснөөс хойш 24 цагийн дараа цус алдсан
 5. Шээсний дээд замын өвчин
284. Ампициллин Гентомицин зэрэг 2 антибиотیکیг эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?
1. Маш хүнд халууралт өвчнүүд
 2. Шээсний дээд замын өвчин эсвэл уушгины хатгаа
 3. Умайн болон ургийн халдвар
 4. Төрсний дараах цус алдалт 24-өөс дээш цаг үргэлжилсэн эсвэл төрснөөс хойш 24 цагийн дараа цус алдсан
 5. Хүндрэлтэй зулбалт үр хөндөлт
285. Ампициллин эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?
1. Ихэс, ихсийн хэсгийг гараар авсан
 2. Төрөх үеийн үйл ажиллагаа эхлээд 24-өөс дээш цаг болсон
 3. Умайн болон ургийн халдварын эрсдэлтэй
 4. Маш хүнд халууралт өвчин
 5. Хүндрэлтэй зулбалт, үр хөндөлт
286. Хүндрэлтэй үр хөндөлт, зулбалт гэдэг ангиллыг ямар шинжүүдийг үндэслэн тавьдаг вэ?
1. Үтрээнээс цус гарах ба үтрээний ялгадас эвгүй үнэртэй байх
 2. Үтрээнээс цус гарах ба умайд ажилбар хийж зулбуулсан
 3. Үтрээнээс цус гарах ба хэвлийгээр өвдөх
 4. Үтрээнээс цус гарах ба 38 хэмээс дээш халуурах
 5. Үтрээнээс цус гарах ба хэвлийгээр эмзэглэлтэй байх
287. Хүндрэлтэй үр хөндөлт зулбалт гэдэг ангилалтай эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. антибиотیکیг булчинд судсанд тарина
 2. Парацетамол өгч өвдөлтийг намдаана
 3. Судсаар дусал хийнэ
 4. Эмнэлэгт хэвтүүлэх ёстойг тайлбарлана

5. Эмнэлэгт яаралтай хэвтүүлэнэ

288. Завдсан зулбалт гэдэг ангиллыг ямар шинжүүдийг үндэслэн тавьдаг вэ?

1. Үтрээнээс цус гарах ба үтрээний ялгадас эвгүй үнэртэй байх
2. Үтрээнээс цус гарах ба умайд ажилбар хийж зулбуулсан
3. Үтрээнээс цус гарах ба хэвлийгээр өвдөх
4. Үтрээнээс бага зэрэг цус гарах
5. үтрээнээс цус гарах ба 38 хэмээс дээш халуурах

289. “Тулгарсан зулбалт” гэдэг оноштой эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?

1. Тохирох антибиотیکیг булчинд, судсанд тарина
2. 4-6 цаг ажиглаад цус алдалт багасахгүй бол эмнэлэгт шилжүүлнэ
3. Судсаар дусал хийнэ
4. Цус алдалт намдвал гэрт нь хариулна, 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
5. Умайд иллэг хийнэ

290. Тээвэрлэх болон гэрийн төрөлтийн үеийн яаралтай тусламжинд ямар эмүүд зайлшгүй шаардлагатай вэ?

1. Окситоцин, эргометрин
2. Магнийн сульфат, диазепем
3. Кальцийн глюконат
4. Ампициллин, Гентамицин, Метронидазол
5. Рингериин лактат

291. Тээвэрлэх болон гэрийн төрөлтийн үеийн яаралтай тусламжинд ямар хэрэгслүүд зайлшгүй шаардлагатай вэ?

1. Судасны катетер ба систем
2. Бээлий, шээлгүүр
3. Ариун тариур, зүү, үжилгүйжүүлэх уусмал
4. Хурц зүслийн сав, хог хийх уут
5. Гар чийдэн, нөөц зай

292. Эмнэлэг хүрэх замд төрлөг явагдана гэж үзвэл юу бэлдсэн байх ёстой вэ?

1. Саван, гар угаах ус
2. Төрлөгийн нэг удаагийн тусламжийн хэрэгсэл ир, 3 боолт
3. Хүүхдийг эх барих, хатаах, өлгийдөх цэвэр даавуу 3, хүүхдийн цэвэр хувцас
4. Ихэс хийх пластик хүүдий
5. Хүүхдэд зориулсан сэхээн амьдруулах амавч, хүүдий.

293. Эх барихын тусгайлсан гадуур үзлэгээр юуг тодорхойлохгүй вэ?

1. Хэвлийн эргэн тойрон
2. Умайн ёроолын өндөр
3. Ургийн байрлал, түрүүлсэн хэсэг
4. Умайн доод таславчийн байдал
5. Ургийн зүрхний цохилт

295. Эх барихын тусгайлсан асуумжинд хамаарагдахгүй нь юу вэ?

1. Жирэмслэлтийн тоо
2. Үр хөндөлт
3. Урьд нь дутуу төрж байсан эсэх
4. Бага насандаа өвчилсөн өвчинүүд
5. Амьгүй ураг төрүүлж байсан

296. Үтрээний 2 гарын хавсарсан үзлэгээр юуг тодорхойлох вэ?

1. Умайн байрлал
2. Умайн хэлбэр
3. Умайн цуллаг
4. Дайвруудын байрлал
5. Аарцгийн эзэлхүүн

297. Жирэмсэн магадгүй байхад толины шинжилгээгээр ямар өөрчлөлт илрэх вэ?

